

С.Байгалсайхан, Б.Энхээ, Д.Цэвээндорж,  
Д.Дэнсмаа, М.Мөнхзул

# УРАН ЗОХИОЛ

## XII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
12 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын  
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

НАА 74.2  
ДАА 373  
У-457

Уран зохиол XII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 12 дугаар ангийн сурах бичиг. (Байгалсайхан С., ба бус; Ред. Энхбаяр С., Тех.ред. Мягмаржав У. УБ. 2018. -124х)

## ТАНИХ ТЭМДЭГ



УНШИХЫН ӨМНӨ



Унших чадвараа хөгжүүлье



УНШИХ ЯВЦАД



Бичих чадвараа хөгжүүлье



УНШСАНЫ ДАРАА



Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

СУДЛАЛ ШҮҮМЖ



БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтийг [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-91-7



## ГАРЧИГ

### Нэгдүгээр бүлэг. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРАГ

Б.Явуухулан “Мөнгөн хазаарын чимээ” .....	6
“Нүүдэлчний намар” .....	8
“Туулын шугуй” .....	9
П.Бадарч “Эхийн сэтгэл” .....	10
Ш.Сүрэнжав “Би тэнгэрийн хүү” .....	13
Ч.Дагвадорж “Шувуун зэл” .....	17
Ц.Чимиддорж “Сэлбэ” .....	20
Т.Галсан “Өгсүүр замын дуу” .....	23
Ц.Хулан “Эрх чөлөө” .....	25

### Хоёрдугаар бүлэг. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ

Ш.Гаадамба “Элбэг дээл” өгүүллэг .....	30
С.Эрдэнэ “Өвгөн шувуу” өгүүллэг .....	36
С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэг .....	43
Л.Өлзийтөгс “Аквариум” өгүүллэг .....	48
Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь” тууж .....	54
Ч.Галсан “Аянгат цагийн тууж” .....	61

### Гуравдугаар бүлэг. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН РОМАН

Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” .....	72
Л.Түдэв “Оройгүй сүм” .....	78

### Дөрөвдүгээр бүлэг. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЖУЖИГ

Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” .....	88
Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” .....	100
Д.Норов “Эцсийн тушаал” .....	115
Ном зүй .....	124



ЕРӨНХИЙ ЧАДВАР	СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ	БҮЛЭГ			
		II	III	IV	V
		Монголын орчин үеийн яруу найраг	Монголын орчин үеийн өгүүллэг, тууж	Монголын орчин үеийн роман	Монголын орчин үеийн жүжиг
УНШИХ	Монголын орчин үеийн уянга, туульс, жүжгийн зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгох	+	+	+	+
	Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах	+	+	+	+
	Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх		+	+	+
	Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах		+	+	+
	Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжлэх		+	+	+
	Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжлэх	+			+
	Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлэх	+	+	+	+
БИЧИХ	Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ тайлбар, нэр томъёог оновчтой хэрэглэх	+			
	Зохиолын хэлбэр бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиох		+		
СОНСОХ-ЯРИХ	Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэх			+	+
	Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэх		+		

## Нэгдүгээр бүлэг

# МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРАГ

### НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ЗОРИЛГО



“Монголын орчин үеийн яруу найраг” бүлгээр сурагчид та бүхэн яруу найргийн ертөнцөөр аялж, шүлэг, яруу найргийн тансаг сайхныг улам гүнзгий мэдрэх болно. Ингэхдээ:


Монголын орчин үеийн яруу найргийн томоохон төлөөлөгчдийн уран бүтээлээс уншиж, зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог дүгнэж, далд утгыг тайлан тайлбарлаж, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн яруу тансгийг мэдрч, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурна.



Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглан санаагаа бүрэн гүйцэд илэрхийлж төгсгөн бичиж сурна.



Шүлэг, яруу найргаас цээжлэх, түүний уран дүрслэл, уран хэрэглүүр, үг хэллэгийг нь ашиглан ярих чадварыг эзэмшиж, өөрийн үзэл бодол, байр сууриа чөлөөтэй, үндэслэлтэй илэрхийлэхдээ бусдын үзэл, санаа бодолтой харьцуулж, дүн шинжилгээ хийнэ.



## ЗОХИОЛЧ



## Бэгзийн ЯВУУХУЛАН

1929 онд Завхан аймгийн Жавхлант суманд төржээ. 1949 онд анхны шүлгээ нийтлүүлснээс хойш “Нүүдэлчний намар”, “Хар ус нуурын шагшуурга”, “Мөнгөн хазаарын чимээ”, “Монголын дорнод тал”, “Туулын шугуй”, “Харахаас ялдам хонгор бүсгүй ээ”, “Хандаа”, “Туулын урсгал шөнөдөө сайхан”, “Цэцгийн сайхныг би зөвхөн нугаасаа түүлээ”, “Би чамд хайртай”, “Шүлэг минь -хүлэг минь”, “Би чамд хайртай”, “Би хаана төрөө вэ?”, “Говь” зэрэг олон шүлэг, яруу найраг, “Алаг дэлхийд төрсөн минь учиртай”, “Тэхийн зогсоол”, “Сохор зоосны дууль”, “Дэлхий” зэрэг найраглалаа зохион Монголын яруу найргийн сан хөмрөгийг баяжуулжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Яруу найрагч Б.Явуухулангийн уран бүтээл нь Монголын уран зохиол, тэр дундаа яруу найргийн хөгжлийн түүхэнд хайр сэтгэлийн уянгын шүлгүүдээрээ томоохон байр суурь эзэлдэг юм. Тэрээр яруу найрагтаа бүсгүй хүнийг хайрлахын утгыг илэрхийлэхээс гадна байгаль, эх нутаг, эцэг эх, хүмүүний ертөнц, ан амьтныг энэрэх хайрлах үзэл санаагаа нэвт шингээж үлдээсэн найрагч билээ.



## УНШИХ ЯВЦАД

- Үг бүрийн утгыг мэдэрч уншаарай.
- “Мөнгөн хазаарын чимээ” гэж яагаад нэрлэснийг эргэцүүлж уншина уу.

## МӨНГӨН ХАЗААРЫН ЧИМЭЭ

Зорин ирэх амрагаа хүлээхэд  
 Морин төвөргөөн зүрхнээ хоногшиж  
 Шөнийн чимээгүй гадаа налайн  
 Унийн углуургаар саран гэрэлтэнэ.  
 Өнчин дэрэн дээр нойр хулжсан  
 Ухаангүй дурлалын урхинд байхад  
 Мөнгөн хазаарын бүдэг чимээ  
 Онгон зүрхийг цочоон баясгана.



## Унших чадвараа хөгжүүлье

Шүлгийн үг сонголтын тухай ярилцъя.

1. Хоногших гэдэг үгийн үндсэн утгыг юу гэж бодож байна? Үгийн тайлбар толь ашиглаарай. Зохиолч яагаад “Морин төвөргөөн зүрхнээ хоногшиж” гэж бичсэн бол?
2. “Онгон зүрх” гэсэн холбоо үгийн утгыг тайлахдаа дараах тайлбаруудаас хамгийн оновчтойг нь сонгоорой. “ариун, дархалсан, эрх танхи, хуучирсан, нандин”



### Зохиолын утга санаа, сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.

1. Хайртай дотны хүнээ хүлээн догдлон байгаа бүсгүй хүний дотоод сэтгэлийг харуулахдаа ямар, ямар үгийг сонгон бичсэн бэ?
2. Хазаарын бүдэг чимээ цочоон баясгана гэж бичсэний учир юу бол?

### Зохиолын уран дүрслэл, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэн үнэлье.

1. Өөрт таалагдсан, сэтгэлд нийцсэн, эсвэл гайхширал төрүүлсэн үг хэллэгийг ялган, түүвэрлэнэ үү. Яагаад тэдгээр үгийг түүвэрлэсэнэ тайлбарлана уу.
2. Ялгаж түүвэрлэсэн үг хэллэг, өгүүлбэр нь өөрт чинь болоод бусдад хэрхэн нөлөөлж байгааг үнэлээрэй. Тухайлбал, зохиолч ...энэ үгийг хэрэглэсэнээрээ уншигчдад ийм зүйл хэлж байна, надад ингэж нөлөөлж байна гэх мэтээр үзэл бодлоо илэрхийлнэ үү.
3. Шүлэгт урнаар дүрсэлсэн хэсэг байна уу? Өөрөөр хэлбэл, үндсэн утгаа гээж, өөр утгаар хэрэглэгдсэн үгс байгаа эсэхийг нягтална уу.

#### ••• ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО: •••••

Бодит ертөнцийн юмс үзэгдлийг шууд оноосон утгаар нь бус өөр утгаар орлуулан хэрэглэх ёсыг утга шилжүүлэх ёс буюу уран дүрслэл гэнэ.

4. “Өнчин хүн биш өнчин дэр”, “урхинд орох биш дурлалын урхи” гэж холбон бичсэн бичил дүрслэлээс зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлан дүгнээрэй.

### Яруу найргийн айзам, бадаглалын онцлогийг задлан шинжилье.

1. Шүлгийн бадаглалыг ажиглана уу. Дараах онолын тодорхойлолтыг уншаад задлан шинжилнэ үү.

#### ••• ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО: •••••

Шүлгийн бадаг хэрхэн бүтсэн, түүний бүтэц байгууламж, онцлог, үүрэг, ач холбогдол, айзам хэмнэлийн тогтцыг судалдаг шүлэг судлалын салбар ухааныг бадаглал зүй гэнэ.

2. “Мөнгөн хазаарын чимээ” шүлэг нь 2 бадгаас бүтжээ. Харин бадаг бүрийн мөрийн тоо, мөр бүрийн үгийн тоо, үг бүрийн хэл зүйн хэлбэржилтийг ажиглаад, онцлогийг тодруулж ярилцаарай.
3. Ижил авиагаар толгой, сүүл холбоогүй атлаа уншихад айзам хэмнэлтэй байгаагийн учрыг жишээ татан тайлбарлана уу.





## НҮҮДЭЛЧНИЙ НАМАР

Нарс найгаа л  
 Навчис хийсээ л  
 Уулын оройд будан суугаа л  
 Шувуу буцаа л  
 Хяруу унаа л  
 Өвсөн толгойд цан буугаа л  
 Тал шарлаа л  
 Мал холхио л

Малчны сэтгэл гэнэт догдлоо л  
 Салхи сэвээ л  
 Өрх дэвээ л  
 Өлөн тоос тэнгэрт босоо л  
 Айлууд нүүгээ л  
 Амрагууд холдоо л  
 Аяа хөөрхий, нүүдэлчний намар аа гэж!

### Яруу найргийн айзам, эгшиглэлийн онцлогийг задлан шинжилье.

1. Шүлгийн эгшиглэл зүйн онцлогийг ажиглан судлаарай. Судлахдаа онолын ойлголтыг уншина уу.

#### ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:

Шүлэглэсэн зохиолын авианы тогтолцоо, түүний загвар, зүй тогтлыг судалдаг шүлэг судлалын салбар ухааныг эгшиглэл зүй гэнэ. Эгшиглэл зүй нь яруу сонсголт чанарыг буюу уран хөг аялгууг бүрдүүлэгч гол хүчин зүйл болсон шүлгийн авианы үүргийг тусгайлан судална. Шүлэг бүр өөрийн агуулга, хэлбэрт тохирсон хөг эгшиг, аялгуу хөгжимтэй байдаг.

2. Шүлэгт буцаж буй намар цаг, тэрхүү улиралд хүний сэтгэлийг дэнсэлгэсэн, уйтай байдлыг илэрхийлэхийн тулд нэгэн хэмээр “-л” авиаг хэрэглэн тоочсон нь өвөрмөц байна. Хэрэв “-л” авиаг хэрэглээгүй байсан бол шүлгийн агуулга, хэлбэрт ямар өөрчлөлт орох бол? Эргэцүүлэн ярилцаарай.
3. Дараах судалгааг уншаад, шүлгийн утгатай холбон тайлбарлана уу.  
Дэмжлэг:

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

Хэлний авиа судлалын дорно дахины уламжлалд -л- авиаг шороон махбодтой гэжээ. Яагаад шороон махбодтой гэвэл уг авиа хэлний үзүүр шүдний орноос төрдөг ажээ. Өөрөөр хэлбэл хэл шүдтэй чигжрэн хатуурч хамжсаны үр дүнд -л- авиа дуудагдах бөгөөд юмс үзэгдлийн доош чиглэсэн, уналтын утгыг илэрхийлдэг байна. Үүнийг -р- авиатай харьцуулан үзсэнээр бүр тод харж болно. -р- авиа нь гал махбодтой учир нь орой хөдөлж төрдөг учраас тэр болой гэжээ. Тиймээс -р- авиа нь утгын хувьд юмс үзэгдлийн дээш чиглэсэн, босоо утгыг илэрхийлдэг байна. Гулзайх гэвэл унах, горзойх гэвэл босох, гулдайх гэвэл хэвтээ, горойх гэвэл босоо. Тиймээс шүлэгт буй “алслаад л, гандаад л, сүүмийгээд л” гэх мэт үгс нь хэвтээ чиглэлийн, уналтын, чамласан утга илтгэж байгаа ба шүлгийн агуулгыг эгшиглэл, хөгийн талаас нь илтгэж байгаа гол хүчин зүйл нь болно.

(Б.Мөнхбаяр “Монголын уран зохиолын тайлбар толь”.  
УБ., 2011, 183-р тал)

4. Шүлгийг гурав гурван мөрөөр нь дахин уншина уу. Юу ажиглав? Шүлгийн айзам, хэмнэлийг тодруулж байгаа зүйл нь юу байна гэж та нар бодож байна?
5. Шүлгийн айзам, хэмнэлийг дуурайн “Хотын намар” гарчиг бүхий шүлэг зохион туршаарай.



#### УНШИХ ЯВЦАД

- Үг бүрийн утгыг мэдэрч уншаарай.
- Байгалийн гоо сайхан ба хайр сэтгэлийн тухай хэрхэн дүрслэв?

### ТУУЛЫН ШУГУЙ

Туулайн гүйдэл шиг салхинд

Туулын шугуй найгана.

Уулын согоо шиг хүүхэнд

Хайрын сэтгэл дасна

Хээрийн салхинд Туул минь

Тахийн зоо шиг бидэрлэнэ.

Хайрын хүчинд сэтгэл минь

Тэнгэрийн заадас шиг гэрэлтэнэ.

#### Зохиолын уран дүрслэл, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэн үнэлье.

1. “Туулайн гүйдэл шиг салхи”-ны тухай ярилцаарай. Монголын уран зохиолд салхины хөдөлгөөнийг өөр юмс үзэгдэлтэй харьцуулан адилтган зүйрлэсэн жишээ байдаг эсэхийг эргэцүүлээрэй. Салхины хөдөлгөөнийг туулайн гүйдэлтэй харьцуулахдаа ямар шинжээр нь адилтган зүйрлэснийг тодруулна уу.
2. “Бидэр” гэдэг нь амьтны арьс үсэнд тогтсон өөр өнгийн бяцхан толбо буюу зурвасыг, мөн жижигхэн зурвас толбо мэт болгон гаргасан хээг тус тус хэлдэг аж. Туул голын салхинд үелзэн урсаж байгааг тахийн зоо шиг бидэрлэнэ гэж бичсэнийг зургаар илэрхийлж, уран дүрслэл бүхий үг хэллэг нь уншигчдад хэр нөлөөлж байгааг ярилцана уу.
3. Хайрын хүчинд гэрэлтэж байгаа сэтгэлийг адилтган зүйрлэн дүрсэлсэн нь хэр оновчтой болсон гэж бодож байна вэ?
4. Тахийн зоо, тэнгэрийн заадас, туулайн гүйдэл зэрэг байгаль, ан амьтны онцлог шинж бүхий үгийн сонголтоос зохиолчийн гярхай, ажигч байдлаас гадна бичлэгийн онцлог илэрчээ гэж үзэж болох юм. Хэрэв та нар зохиолчийн оронд байсан бол ямар үг сонгон дүрслэх бол? Туршаарай.

#### Яруу найргийн айзам, бадаглалын онцлогийг задлан шинжилье.

1. Бадаг бүрийн эхний хоёр мөр, сүүлийн хоёр мөрийн утгыг харьцуулаарай. Ижил төстэй зүйл юу ажиглагдав?
2. Мөр бүрийн үгийн тоо болон төгсгөл нь шүлгийг айзам хэмнэлтэй болгоход нөлөөлж байна уу? Хэл зүйн утгыг тодруулан жишээ татан батлаарай.

## ЗОХИОЛЧ



## Пунцагийн БАДАРЧ

1939 онд Төв аймгийн Баянжаргалан суманд төржээ. 1960 оноос уран бүтээлээ эхэлж, “Морьд” (1969), “Есөн эрдэнийн орон” (1972), “Зургаан мөнгөн мичид” (1977), “Алтан тоос” (1980), “Ширхэг цагаан сувд” (1980), “Намрын хонгор салхи” (1985), “Би энэ байна” (1995), “Бөрттэй цагаан сарны дор” (1999), “Бурхан багшийн сургаал” (2002), “Тэнгэрийн хас од” (2003) түүврүүд хэвлүүлжээ.

1981 онд Монголын Зохиолчдын Эвлэлийн шагнал, 1988 онд Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал, 1999 онд Соёлын гавьяат зүтгэлтэн, 2005 онд Ардын уран зохиолч цол тус хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Эртний дорно дахины яруу найргийн онол болох “Зохист аялгууны толь”-д шүлгийн тухай өгүүлэхдээ: “Ваальмик арш нэгэн үхсэн шувууг хараад сэтгэл ихэд гуниглан шлок (энэ нь уйтгар гашуудал гэсэн санскрид үг, хожим монголжиж шүлэг болжээ) бичсэн тухай өгүүлсэн байдаг. Үүнээс үзэхэд шүлгийн гарал нь хүний сэтгэл хөдлөлийн олон өнгө аясыг илэрхийлэн гаргахад тохиромжтой, түүнийг нь нээх арга хэрэгсэл шинжтэй байжээ.
- Ийнхүү зохиол бүтээлийн төрөл хийгээд зүйл (жанр) бүхэн өөрийн эртний сурвалж, үүсэж хөгжсөн домог түүхийн чанартай мэдээлэл, эсвэл онол туурвил зүй үүсэж хөгжих анхны үеийн онол гаргалгааны үндэс улбаатай байдаг байна.



## УНШИХ ЯВЦАД

- Эх хүний сэтгэлийн өчил ямар, ямар үед хэрхэн илэрч байгааг харуулсан хэсгийг жишээ татан ярилцаарай.
- Дүрийн мөн чанарыг илэрхийлэхийн тулд зохиолч ямар орчин, орон зайг сонгон дүрсэлсэн бэ? Үйл явдал хэзээ, хаана болж байна?

## ЭХИЙН СЭТГЭЛ

Ижий нь муу хүүгээ үхэж гэж зүүдэллээ  
Ийм аймаар зүүд ная наслахдаа  
зүүдлээгүй

Сааль сүүндээ дэвэлзсэн ч  
Санаа сэтгэл дэгэлзсэн ч  
Сарних бодлын үзүүрт үр минь торойно.  
Сайхан шүлэг бичиж гэнэ, миний хүү  
Амьтан хүн уншиж байна  
Сайхан дуу зохиож гэнэ, миний хүү

Араажаваар дуулж байна лээ.  
Сайн явна гэнэ, миний хүү  
Аяны хүн хэлж байна  
Муу явна гэнэ, миний хүү  
Амны зугаа ярьж байна  
Аль нь ч надад ялгаагүй ээ  
Амьд яваа нь л ижийдээн  
Алдар чинь шүү дээ.  
Ижий нь хүүгээ





Их санах юм даа  
Араг, савар хоёроо зөрүүлэн байж  
бодлоо

Аргал, чулуу хоёрыг  
Андууран түүж саналаа  
Алга аа, миний хүү.  
Тэмээ тэмээн цагаан үүлийг  
Тэндээ царцтал харлаа  
Тэнгэрийн ягаан хаяаг  
Цав суутал ширтлээ  
Ижийдээ ирсэнгүй ээ.  
Хүний хүү ижийдээ ирж гэнэ ээ  
Гол усаар л нэг  
Найр наадам болж байна  
Миний хүү шоронд орж гэнэ  
Голы минь гогдон хэлж байна.  
Аа яадгийм, ороо л биз гэж  
Гадагшаа би хүүгээ өмөөрлөө  
Ам нь цангаж байгаа байх даа  
Муу хүү минь гэж  
Дотогшоо би өмөлзлөө.  
Гал шиг залуу явахад  
Үсэрсэн оч минь юм сан  
Ганц бие зандан явахад  
Тасарсан навч минь юм сан.  
Алаг бөмбөл эрдэнэ  
Алган дээр байна гэж

Зөгнүүлж ирсэн  
Ганц хүү минь дээ  
Алтан бэлзэг гаднаас олоод  
Амандаа үмхтэл залгичихлаа гэж  
Зүүдлүүлж олдсон ганц үр минь дээ  
Ядаж яваа юм бол миний хүү  
Тэнд яваад юу хийх вэ  
Ижийдээ л хүрээд ир  
Ядарч яваа юм бол миний хүү  
Тэнд байгаад яах юм бэ  
Ижийдээ л хүрээд ир  
Хүний нүдэнд бол  
Хөгцтэй хад шиг  
Хөх толгойтой  
Хөгшин хүү минь  
Ижийнхээ нүдэнд бол  
Манцуйдаа тарвалзах  
Мяндас цагаан хүү минь  
Ижийдээ ир  
Хөхөөрөө чамайг даллая  
Үхэхээрээ чамайг айлгая  
Миний хүү ижийдээ ир  
Ухаантай даа миний хүү  
Хурай, хурай  
Унага шиг ижийдээн  
Давхиад ир  
Гуруй, гуруй.

(1996)

Эх сурвалж: (П.Бадарч. “Түүвэр зохиол”. УБ., 2011, 13-15-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Араажав** - радио (Зохиолч, хөдөөгийн хөгшний хэллэг дуудлагаар бичжээ)

**Араг** - аргал түүхэд зориулсан бургасаар матаж хийсэн сав

**Савар** - аргал хомоол зэргийг түүх, өвс бөөгнүүлэх зэрэгт хэрэглэдэг олон

хуруу, салаатай хамах хэрэгсэл

**Араг, савар** (хоршоо үг) - аргал хомоол түүхэд зориулсан эд хэрэгсэл

**Бэлзэг** - бөгж

**Манцуй** - нялх хүүхдийн өлгий



#### Унших чадвараа хөгжүүлье

1. Шүлгийг уншиж дууссаны дараа ямар мэдрэмж төрөв? Хүүгийн дүрийг зохиолч яагаад ийнхүү зохиомжлон илэрхийлсэн юм бол?
2. Та бүхэн шүлгээс юуг ойлгов? Юуг өөрсдөдөө тусгаж авсан бэ?
3. Яруу найрагч энэхүү шүлгийг яагаад ижийн сэтгэлээр зохиомжилж бичсэн бол?
4. “Хүний нүдэнд бол

Хөгцтэй хад шиг  
 Хөх толгойтой  
 Хөгшин хүү минь  
 Ижийнхээ нүдэнд бол  
 Манцуйдаа тарвалзах  
 Мяндас цагаан хүү минь  
 Ижийдээ ир  
 Хөхөөрөө чамайг даллая  
 Үхэхээрээ чамайг айлгая  
 Миний хүү ижийдээ ир” гэсэн хэсгийн санааг тайлбарлана уу.

5. Дээрх хэсгийн утгатай дүйх монгол ардын ямар зүйр цэцэн үг байдаг вэ?
6. Ээж нь хүүгийнхээ “муу явааг” сонсоод юу бодож шаналсан бэ?
7. Эх хүний нийтлэг дүр төрхийн талаар ярилцана уу.



#### Бичих чадвараа хөгжүүлье

1. Бичил дүрслэлийн утгыг тайлбарлаарай.

Бичил дүрслэл	Утгын тайлбар
<p><i>Араг, савар хоёроо зөрүүлэн байж бодлоо</i>  <i>Аргал, чулуу хоёрыг</i>  <i>Андууран түүж саналаа</i>  <i>Алга аа, миний хүү...</i></p>	

2. Үрээ хайрлан санах эхийн санааг илэрхийлэхдээ ямар үг сонгосон байна вэ?
3. Хосоороо ажиллаж болно.
  - Шүлгийнхээ аль нэг хэсгийг дуурайн бичих зорилгоор сонгоно уу. Ингэхдээ юуны тухай өгүүлэхээ төлөвлөж, хэлэлцээрэй.
  - Хэдэн мөртэй, хэдэн бадгаас бүтсэн байж болохыг төлөвлөөрэй.
  - Бичсэн шүлгээрээ дамжуулан уншигчдад юу хэлэхийг хүссэн бэ?
  - Зохиож бичихдээ ямар үгийг сонгож бичихээ сайтар бодоорой.
  - Эхлээд ноороглож бичээд, бусдадаа уншуулж, зөвлөж ярилцаарай.
  - Ноорогложноо засварлаж, сийрүүлэн бичээрэй.
  - Үсгийн дүрмийн болон найруулгын алдааг сайн хянаарай.



#### Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

1. Эхийн хүүгээ “өмөөрсөн” сэтгэлийг гаргасан хэсгүүдийг тоочин ярилцаарай.
2. Шүлгээс таалагдсан дүрслэлт үг, сэтгэлд нийцсэн болон содон санагдсан үг хэллэгээ түүвэрлэн цээжлээрэй.
3. “Эхийн сэтгэл” шүлгээ эмээ өвөө, ээж аавдаа уншиж, бас ярьж өгнө гэж төсөөлөн онцолж ярих хэсгээ сонгоорой.

Жишээ нь:

- Шүлгээс төрсөн сэтгэгдлээ илэрхийлнэ үү?
- Зохиолчийн үзэл бодол, мэдрэмжийн талаар ярихдаа өөрийн үзэл бодол, сэтгэгдэлтэй харьцуулмаар байна уу?

- Шүлгийн онцлог, бүтцийн талаар таньж мэдсэнээ ярина уу.
- Шүлэг дэх үг хэллэгийн талаар харилцан ярилцаарай.



## УНШСАНЫ ДАРАА

## СУДЛАЛ ШҮҮМЖ

П.Бадарч бусдаасаа эрс ялгарах дуу хоолойтой. Тэр нь, аливааг аргадан хайрласан дуу юм. Уярч учирласан, ер бусын гэмээр намуун зөөлөн шинж нь юм... П.Бадарчийн яруу найраг баялаг олон өнгөтэй. Хурдан, жороо, хатирч, найр наадмын чимэг гоё сайхан ажнайгаас эхлээд хүлгийн дээд бүхнээс бүрдсэн хийморьтой айлын адуу шиг шүлэг, дууль, найраглал, сонет, нэргүй богино шүлэг, дууны үг цөм бий...

(П.Бадарч. “Бөрттэй цагаан сарны дор”, Монголын уран зохиолын дээжис, (59-р боть), Д.Цоодол. “Чандманийн түлхүүр”. УБ., 2006, 10-р тал)



## БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. П.Бадарч. “Түүвэр зохиол”. УБ., 2011

## ЗОХИОЛЧ



## Шаравын СҮРЭНЖАВ

1939 онд Төв аймгийн Авдарбаян суманд төржээ. МУИС (1963), Москва хотноо А.М.Горькийн нэрэмжит Утга зохиолын дээд сургуулийн дэргэдэх Утга зохиолын дээд курсийг (1981) тус тус төгсчээ.

Налайх хотын утга зохиолын бүлгэмд суралцаж байв. 1960 оноос уран зохиол бичиж 1966 онд МЗЭ-д элсчээ. Тэрбээр “Ерэн баатрын дууль”, “Шөнө ургасан цэцэг” найраглал, “Гарьд магнай”, “Тод магнай”, “Цэц магнай” уран сайхны кино зохиол бичжээ. Ш.Сүрэнжавын шүлэг, найраглал нь Орос, Хятад, Япон, Чех болон бусад олон хэлээр орчуулагдан хэвлэгджээ. 1972 онд МЗЭ-ийн шагнал, 1979 онд МХЗЭ-ийн нэрэмжит шагнал, 1988 онд Монгол улсын Төрийн шагнал, 1999 онд Ардын уран зохиолч цол хүртсэн.



## УНШИХЫН ӨМНӨ

- Зохиолч Москвад сурч байхдаа “Би тэнгэрийн хүү” шүлгээ бичсэн бөгөөд энэхүү шүлэг нь анх ЗХУ-д хэвлэгдсэн байна.
- Шүлгийг унших явцдаа найрагч өөрийгөө “Тэнгэрийн хүү” гэсний учрыг эргэцүүлэн тунгаагаарай.
- Сурагчид та бүхэн өөрийгөө юутай адилтган зохиомжлон бичиж чадах вэ? Энэ шүлгийн зохиомж бүтцээс суралцан өөр өөрийн сэдвийг сонгож шүлэг, хүүрнэл хэлбэрээр эргэцүүлээрэй.

## БИ ТЭНГЭРИЙН ХҮҮ

Би  
 Тэнгэрийн хүү  
 Та нарын дунд ирсэн юм.  
 Газрын охинтой гэрлэж  
 Нарны аяганаас  
 Цай уусан  
 Гашуун дарснаас хиртэж  
 Ганихралын орон дээр  
 Хөрвөөж үзсэн  
 Цагаан цасан дээрээс будрахад  
 Хөөцөлдөн эрхэлж,  
     Үүлс сандайлан  
     Уулсаас уулсад  
     Дүүжин хийж  
     Нааддаг байсан  
 Цагийн бороо тэнгэрээс асгарахад  
 Хөхин баясаж,  
     Утас дамжих шиг  
     Усан ширхгээр нь авиран гарч  
     Оддыг сондор болгон хэлхэж  
     Цэцгийн толгойд зүүж өгч явсан.



## УНШИХ ЯВЦАД

- *Доорх онцолсон хэсгийг тогтоож уншаад, юуны тухай урнаар илэрхийлэн бичсэнийг тайлбарлаарай.*
- *Шүлгээс хамгийн их таалагдсан хэсгээ цээжилж, урнаар уншаарай.*
- *Зохиолчийн уран санааг өөрийн үзэл бодлоор баяжуулан тайлбарлаж, нөхөдтэйгөө санал бодлоо солилцоно уу.*

Би  
 Тэнгэрийн хүү  
 Та нарын дунд ирсэн юм.  
 Хурмастын аянгаас гал могой ташуур шүүрэн авч  
 Бэртэгчний нурууг шалба ороолгон залхааж явсан  
 Мунхгийн хор шингэсэн хорголжин хар нүднээс нь  
 Мугалзуур эвэрт үхэрт олиулан бэртэж явсан  
 Муугийн гайг шившин хөөж, бусдад ариуныг урин  
 Мөлхөж яваа хүүхдийн өвдөг доор  
 Цэцгийн дэлбээ ивж явсан  
 Хүний юу бодож явааг харцнаас нь уншдаг байсан  
 Үгийнх нь үзүүрээс үнэн, худал хоёрын  
 Утасны учгийг ялгадаг байсан  
 Сэрлийнхээ сувгаар хурмастын өргөөтэй харьцдаг байсан  
 Сэтгэлийнхээ рашаанаас найраг болгон нэрж, хүмүүст амсуулсан  
 Нэг нь амтархан шимж байхад  
 Нөгөө нь аяглан тамшаалж байсан,

Аанай бас тургиж ч байсан,  
Алинд нь ч би гомдоогүй...  
Би  
Тэнгэрийн хүү  
Та нарын дунд ирсэн юм.  
Тэнгэр эцгийнхээ зүүрмэглэх зуур  
Тэрхэн зуурын зүүд болж  
Газар дэлхий дээр ирсэн юм.  
Сэрэхтэй нь зэрэг би явна.  
Тэр болтол нь  
Та нартайгаа  
Уулс түшиж,  
Туульс хайлж,  
Морин толгойтой хууранд тань  
Монгол аялгууг хоршин дуулж сууна...

**Эх сурвалж:** (Ш.Сүрэнжав. “Түүвэр зохиол”. УБ., 2011, 132-134-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Сондор** - шүр, сүвд зэрэг үнэт эрдэнэсээр хийсэн хүзүүний чимэг

**Олиулах** - үхэр эврээрээ сэжлэн мөргөх  
**Аяглах** - элдэв аяг гаргах, олон ааш авир гаргах



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Шүлгийнхээ төгсгөлд:  
Газрынхан минь ээ, хүмүүс минь ээ, та нар  
Намайг явахын цагт  
Энэ морин толгойтой хуураа л өгөөрэй.  
Үүгээр чинь би тэнгэр эцгээ  
Уяруулан хайлуулан дуулуулна  
Үүлэн тансаг хур болон ивлэж  
Үргэлжид тэгвэл та нарыг ивээнэ.  
Би  
Тэнгэрийн хүү  
Та нарын дунд ирсэн юм.  
Гантиг чулуу минь, чи  
Ганцхан энэ мөрийг минь  
Гайгүй сайн тогтоож аваарай! гэсэн байдаг.

Ингэж, тэнгэр эцгийн зүүдлээд сэрэхлээр явчих “тэнгэрийн зүүдний хүү” биш, тэр нэгэн цагаас энэ нэгэн үеийг үргэлжилж иртэл газар дээрээ ирж буцаж, тэнгэрийн хүүгийн үйлсийг бүтээгээд газар дээр нь мөрөө, гантиг чулуун дээр нь нэрээ үлдээж буцах “Газрын хүү”, тэгэхдээ бүр “Монгол газрын хүү” гэдэг санаанд хүргэж, яруу найргийн тэр их холоос хэлж эхэлсэн “Би тэнгэрийн хүү” гэдэг өгүүлэмжээр “Газрын хүү”-гийн гайхамшгийг нээчхэж байгаа нь яруу найрагчийн яруу үг, уран сэтгэмжийн үлэмж мэдэл, далд зөн, дотоод сонороор нээгдэж тайлбарлагдах зүйл мөн.

(Л.Хүрэлбаатар. “Тэнгэрийн соёл” ба “Тэнгэрийн зүүдний хүү”.  
Дорно цаст. УБ., 2009, 233-246-р тал)



## Унших чадвараа хөгжүүлье

1. Зохиолч шүлгээ “Би тэнгэрийн хүү” гэж нэрлэсний учир юу вэ?
2. Шүлгийг уншаад чамд ямар мэдрэмж төрөв? (Гайхсан уу, догдолсон уу, эргэлзсэн үү, баярласан уу, биширсэн үү...)
3. “Би  
Тэнгэрийн хүү  
Та нарын дунд ирсэн юм”... үүнийг уншаад өөрт төрсөн сэтгэгдлээ хэлээрэй.
4. Найрагчийн дэвшүүлсэн санааг тунгаан бодож, гол сэдэв, утгыг тодруулаарай.  
...Сэрлийнхээ сувгаар хурмастын өргөөтэй харьцдаг байсан  
Сэтгэлийнхээ рашаанаас найраг болгон нэрж, хүмүүст амсуулсан  
Нэг нь амтархан шимж байхад  
Нөгөө нь аяглан тамшаалж байсан,  
Аанай бас тургиж ч байсан,  
Алинд нь ч би гомдоогүй... гэсэн хэсэгт “рашаан” гэж юуг далд утгаар хэлсэн бэ?
5. Шүлэгт:  
...Цагаан цасан дээрээс будрахад  
Хөөцөлдөн эрхэлж,  
                                үүлс сандайлан  
  уулсаас уулсад  
  дүүжин хийж  
  нааддаг байсан  
Цагийн бороо тэнгэрээс асгарахад  
Хөхин баясаж,  
                                утас дамжих шиг  
  усан ширхгээр нь авиран гарч  
  оддыг сондор болгон хэлхэж  
  цэцгийн толгойд зүүж өгч явсан...

гэсэн уран дүрслэлт үгсийг яруу найрагч сонгосны учир юу вэ?



## Бичих чадвараа хөгжүүлье

1. Эрдэмтэн Л.Хүрэлбаатарын “Тэнгэрийн соёл” ба “Тэнгэрийн зүүдний хүү” судалгааны өгүүллийг уншаад төрсөн сэтгэгдлээ бичнэ үү.
2. Шүлэг буюу эх зохиол, шүүмж буюу судалгааны бичвэрийн уялдаа холбоо, ялгаа заагийг сайтар тунгаан бодож, шүүмж бичээрэй. Бичсэнээ бусдадаа уншуулж, нөхөдтэйгөө зөвлөлдөн санаа бодлоо харилцан солилцоод, нарийн нягталж засварлан сайжруулаарай.
3. “Би тэнгэрийн хүү” шүлгийн хэлбэр, бүтцийг дуурайн санаагаа илэрхийлэн шүлэг зохион бичээрэй.



## Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

1. Бодит амьдралд байхгүй хийсвэр мэт санагдсан зүйлээ тоочиж, ярилцаарай.
2. Тэрхүү хэсгээ түүвэрлэн уншаад, үзэл бодлоо илэрхийлнэ үү.
3. Шүлгээс уран дүрслэлт үг, өөрт таалагдсан үг хэллэг, онцгой содон санагдсан

- үг хэллэг зэргийг түүвэрлэн, санал сэтгэгдлээ солилцоорой.
4. Ярих чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.

Шалгуур	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай
Шүлгийн тухай ярихдаа уран дүрслэл ашиглаж ярьсан уу?			
Шүлгийн тухай ярихдаа зохиолоос сонирхол татсан үг хэллэгийг ашигласан уу?			
Уран дүрслэлийг цээжилсэн үү?			
Ярихдаа өөртөө итгэлтэй, бусдын сонирхлыг татаж чадсан уу?			



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. Ш.Сүрэнжав. Хөх тэнгэрийн хур. УБ., 1980
2. Ш.Сүрэнжав. Мартаж болшгүй он жилүүд. УБ., 2000
3. Ш.Сүрэнжав. Сэтгэлийн увидас. УБ., 2006

#### ЗОХИОЛЧ



#### Чойсүрэнгийн ДАГВАДОРЖ

Хотгойд яст, “Ээж хадныхан” овогт Дагвадорж 1942 онд Хөвсгөл аймгийн Арбулаг суманд төржээ. МУИС-ийг дүүргэж, 1977-1981 онд аспирантурт суралцан Хэл бичгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

“Цэргийн албаны гоо зүй”, “Номоос төрсөн бодол”, “Утга зохиолын шүүмжлэлийн тухай”, “Монголын орчин үеийн уран зохиол дахь ажилчин ангийн дүрийн хөгжил”, “Уран утгын яруу тайлал” судлал шүүмжлэлийн ном, “Далийн цэцэг”, “Далайн цэнхэр салхи”, “Хотгойд аялгуу”, “Ээж минь дээ” зэрэг яруу найргийн 20 гаруй ном хэвлүүлсэн. Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн.



#### УНШИХЫН ӨМНӨ

- Дууны яруу найргийн томоохон төлөөлөгчийн нэг, яруу найрагч Ч.Дагвадоржийг “Ээж минь дээ” дуугаар нь хүн бүхэн сайн мэднэ. Энэхүү дууныхаа шүлгийн нэг бадгийг 1998 онд хаднаа сийлж ээжийгээ мөнхөлжээ. Түүнээс хойш Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 6-р багийн нутаг Ямаат уулын “Битүүгийн ам” хэмээх газрыг олон түмэн “Ээж хад” хэмээн нэрлэж бишрэн хүндэтгэх болжээ. Тэгвэл энэ удаа та бүхэн “Шувуун зэл” шүлгийг нь уншаад юуны тухай өгүүлснийг сайтар тунгаан эргэцүүлээрэй.





- Шүлгийн үндсэн санааг төсөөлөн бодно уу. Ижий нь хүүдээ ямар сургаалууд хэлж байна вэ?
- Хүүгээ юу руу битгий дөх гэж захив? Яагаад гэсэн асуултын хариуг бодож олоорой.

### ШУВУУН ЗЭЛ

Торойх цэг,  
 Тодорсоор, бүдгэрсээр, тодорсоор  
 Тоонон дээгүүр шувуун зэл  
 Ганганасаар, гунганасаар, ганганасаар  
 Тоймгүй холоос зорьсоор, дэвсээр...  
 Тоо ёсоороо л байгаа даа.  
 Шуугьсаар, нургилсаар  
 Тохой, тойром, нуур усандаа шувууд буулаа...  
 Эрх багахан хүү минь, эрэг рүү битгий дөхөөрэй  
 Зовлоо чиг, жаргалаа чиг өнжин, хонон тэмүүлсээр  
 Зорьж холоос ирснийх  
 Зоргоор, эх сайхан усандаа гунганаг  
 Цагаан болоход хүү минь, чи ч гэсэн ялгалгүй  
 Цаст цагаан уул, уст уудам талыг  
 Цаана, цаана орхисоор ээж рүүгээ зүтгэх нь лав  
 Бараагийн нь харахын мөрөөс болсон ижий нь  
 Балчирхан үрээ харж дотроо дэвтээх нь магад  
 Ухаант бяцхан үр минь  
 Ус гол руу битгий дөх!  
 Нуга тойрмыг нойроос сэрээсэн  
 Нугасны чуулганыг битгий цочоо  
 Тоотойхон хэдэн сард тэдэн  
 Тоглож, наадаж дураараа цэнгэг  
 Томилолт, амралтын хэдхэн хоног дуусахад үр минь, чи  
 Тоонот гэртээ хоргоддог ах, эгч нараа сана  
 Гадаад их далайг үзсэн ч гэлээ тогтоогүй  
 Газар нутгийн дулаанд амьдарсан ч гэлээ жаргаагүй  
 Үр өндгөө унагаасан сэрүүн орноо зорьж  
 Үдэш, орой,  
 Үүр цүүрээр,  
 Үүлэн цаанаас дэв дэвсээр ганганаж  
 Үргэлжлэн хошуурсан шувуун зэл  
 “Шар булан”-гийн энэ жаахан нууранд  
 Шаагьж, шуугьсаар буух нь нэг уярмаар...  
 Эрх багахан үр минь, сайн тогтоож ав!  
 Ирж яваа шувууны ганганааг сонсоход  
 Эхт хүний дотор цэлмэн уужирдаг юм  
 Эрт босож уяран зогсмоор санагддаг юм  
 Торойх цэг,





Тодорсоор, бүдгэрсээр, тодорсоор  
Тоонон дээгүүр шувуун зэл  
Ганганасаар, гунганасаар, ганганасаар  
Тоймгүй холоос зорьсоор, дэвсээр...  
Тоо ёсоороо л байгаа даа  
Шуугьсаар, нургилсаар  
Тохой, тойром, нуур усандаа шувууд буулаа. (1987)

(Ч.Дагвадорж. “Ээж дуудна”. УБ., 2009, 61-62-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Нургиллах** - амьтдын намуухан жигд дуугарах, нэг хэмээр зөөлөн явах

**Ганганаа, гунганаа** - зэллэсэн буюу нуурт чуулсан шувуудын дуугарах дуу



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Тэрбээр энэ мэт мөр бадгуудаараа хотгойд дууны эгшиг хүслийн ажнайг хөлөглүүлж, зүрхний хараацай, сэтгэлийн болжморыг үргээх торгон агшныг, сэтгэлийн утсанд сүвлэсэн бодлын оёос задрах мэт, хүсэл эрдмийн хур дэвлэн асгарах цагийн үүлс хүндрэн уулын орой зулайд хоноглон суух үеийг, нэгийг хэлэхэд нөгөө нь чирэгдэж, бодлын агаар санааны хязгаараа сэтгэлийн хүчээр буйлах хүмүүний тэрхүү хүслийн эрдмийг ийнхүү гаргаж өгүүлсэн хэрэг... Түүгээр үл барам хотгойд гэгэлгэн дууны сэтгэл гарч, дархад аман билгийн оломгой цэцэн хэллэг илэрч, монгол аман, бичгийн гаралтай дууны гүн ухааны бясалгалын санаа далд цаана нь ургаж байна.

(Л.Хүрэлбаатар. “Богд нь уулын “сүндэл” бодлын дунд “сүндэллэнэ”. Дорно цаст. УБ., 2009, 163-р тал)



#### Унших чадвараа хөгжүүлье

1. “Торойх цэг” гэж юуг төлөөлүүлэн илэрхийлсэн байна вэ? Түүний харагдах байдлыг нь ямар ур маягаар хэрхэн дүрсэлснийг давтан ажиглаарай.
2. Шувууд хүйтэн орондоо буцаж ирдгийн учрыг та нар хэрхэн төсөөлж байна вэ? Учир шалтгааныг шүлгээс олж илрүүлээрэй.



#### Бичих чадвараа хөгжүүлье

1. Тус шүлгийн хэлбэрийг дуурайн хоёр бадаг шүлэг зохион бичээрэй.
2. Сонгож бичсэн үгээ утгыг нь дэлгэрүүлж, уран санаагаар баяжуулж тайлбарлан тэмдэглэнэ үү. Шүлгийн бүтэц, зохиомжийг ажиглаад, уран дүрслэлийг түүвэрлэн бичиж тайлбарлана уу.
3. Бадаг бүрээс зөвхөн давтамж бүхий үгсийг үлдээн бичвэл өгүүлбэрийн ямар загвар үүсэх вэ?
4. Юуг нойрноос сэргээв? Нойрноос сэргээсэн амьтдыг нойрсуулан амраах гэсэн сөргүүлэлт санаа, ур маягаас суралцан 5-10 жишээ олж баяжуулан бичээрэй.


**Сонсох-ярих чадвараа хөгжүүлье**

1. “Тоо ёсоороо л байгаа даа” гэсэн зохиогчийн өчил ямар утга санаа илтгэж байна вэ? Харилцан ярилцаарай.
2. Эхт хүн гэж ямар хүнийг дүрсэлсэн бол? Тэд ямар зүйлд дотор нь цэлмэдэг болохыг өөр жишээ баримтуудаар дэлгэрүүлж харилцан ярилцаарай.
3. “Нуга тойрмыг нойроос сэрээсэн  
Нугасны чуулганыг битгий цочоо” гэсэн шатаас бид юуг ойлгож болох вэ? Эргэцүүлэн бодож хариултыг олоорой.
4. Эх нутгаа зорин, тэмцэж ирэх шувуудыг ямар уран дүрслэлүүд ашиглан бичсэн байна вэ? Энэ нь ямар үзэл санааг илтгэж буйг гүнзгийрүүлэн бодоорой.


**БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ**

1. Ч.Дагвадорж. “Сэтгэлийн эгшиглэн”. УБ., 2002


**ЗОХИОЛЧ**

**Цэндийн ЧИМИДДОРЖ**  
(1955-2011)

1955 онд Дундговь аймгийн Дэрэн суманд төржээ.

Тэрбээр “Морь буусан шагай” “Долоон бурхан”, “Хээтэй араншин”, “Ерэн есөн атаа”, “Хазаар дарсан шүлгүүд”, “Унаган зүүлт”, “Нэгэн зуун найман эрих”, “Тэнгэрийн наадам”, “Улаан тэргэл өдөр” зэрэг яруу найргийн түүврүүд хэвлүүлжээ.

“Болор цом” яруу найргийн наадмын 1989, 1999 оны тэргүүн шагнал хүртсэн бөгөөд 1996 онд “Долоон бурхан од”, “Малчин”, “Сэлбэ” шүлгээрээ Монголын Зохиолчдын Эвлэлийн шагнал, 2006 онд Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.


**УНШИХЫН ӨМНӨ**

- *Үе тэнгийнхээ охины бичсэн “Сэлбэ” шүлгийн талаарх товч бичвэртэй танилцаад, өөрсдийн санаа бодлоо харилцан ярилцаарай.*

**Сэдэв:** Сэлбэ гол

**Зорьсон санаа:** Усгүй бол цусгүй болохтой адил. Усгүй бол хатна, цусгүй бол үхнэ.

**Гол санаа:** Сэлбэ гол маань голдрилоороо урсах байтугай, хатаж ширгэхэд хүрсэн талаар харууссан санааг зохиолч илэрхийлсэн.

(Б.Халиун 12<sup>6</sup> анги)



## УНШИХ ЯВЦАД

- Шүлгийг уншаад юу мэдэрснээ эргэцүүлээрэй
- Зохиолчийн сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ? Ямар үг, дүрслэл онцгой санагдав? Яагаад?



Эх сурвалж: iKon.mn

## СЭЛБЭ

Газрын хөх судас бүдэг бадагхан цохилно  
 Гал дундуур урсах мэт бөг бөг шогшино  
 Агсал буурал Туултайгаа хатирч бэлчирлэдэг усан  
 Адуу бараадан дагах тушаатай морь шиг дэгнэ  
 ... Дүүрэн Сэлбэ биднийг ширгэтлээ сэлбэлээ  
 Дүнжингаравын хамаатан ус цусанд минь аслаа  
 Аз жаргалын диваажин сууцны чинь паалан хананы  
 Асуултын тэмдэг шиг цоргоноос нулимс болон дусалж байна  
 Улаан голоор чинь урсаж байгаа  
 Улаанбаатар дундуур чинь сажилж байгаа  
 Улаан нүүрэн дээр чинь хатаж байгаа  
 Улс амьтны хөлд гутаж байгаа  
 Уулсынхаа элгэнд хярж байгаа  
 Ухаан гуйн залбирч байгаа  
 Шидэмс шиг гол нэг л үүрээр  
 Шивнээ нь тасарч, амьсгалаа өвөр дээр чинь хураах нь ээ  
 Тогтоол зарлиг дундуур урсаж байгаа хотын номхон голыг  
 Тогтоож чадалгүй уурга чиргүүлэн алдсан байж  
 Зэм халдаамгүй Алтайн цаадах  
 Зэрэглээ залгилсан халтар говийн  
 Бидрээ гээтэл цалгилах эмнэг хуланг тогтоох юм гэнэ  
 Битгий сэрүүн зүүдэлж, сэрж мартацгаа!

(1988)

Эх сурвалж: “Монголын уран зохиолын дээжис” 108 боть (97-р боть). УБ., 2006



## УНШСАНЫ ДАРАА

## СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Ц. Чимиддорж нь “Сэлбэ” шүлэгтээ байгаль орчноо хамгаалах санааг эрс зоримог, хүчтэй агаад урнаар өгүүлсэн. Тэрбээр байгалийн сэдэвт шүлэгт зонхилж байсан магтаалын болон уянгын аясыг шинжлэх ухаан технологийн эрин үед хүн төрөлхтний анхаарлыг татаж буй байгаль орчинг хамгаалах өргөн цар хүрээтэй утга агуулгаар баяжуулж, санаагаа уран тод дүрслэлээр илэрхийлснээрээ яруу найрагт өөрчлөлт шинэчлэлтийн хандлагыг бий болгоход хувь нэмэр оруулсан юм...”

(“Монголын орчин үеийн уран зохиолын түүх”,  
 IV боть (1980-2000). ШУА, ХЗХ. УБ., 2014, 21-р тал)



### ҮГИЙН ТАЙЛБАР:

*Ширээх* - хатуу болгох

*Шидэмс* - богино, муу дээс

*Бидэр* - жижигхэн зурвас толбо мэт болон харагдах хээ

*Хярах* - амьтны эмээн болгоомжилж, нуугдан бүгж, хөдлөхгүй чимээгүй хэвтэх

*Эмнэг* - атар догшин, эдэлгээ уналганд сураагүй, онгон



### Унших чадвараа хөгжүүлье

1. Шүлэгт ямар асуудлыг хөндөж тавьсан бэ?
2. “Бөг бөг шогшино, тушаатай морь шиг дэгнэ” гэсэн дүрслэлээр ямар далд утгыг илэрхийлж байна вэ?
3. Уг шүлэгт гадаад, дотоод орчин хэрхэн дүрслэгдсэн бэ?
4. Шүлэгт хэрэглэсэн адилтгал, зүйрлэлийн жишээг олно уу.
5. “Битгий сэрүүн зүүдэлж, сэрж мартацгаа” гэсний утгыг тайлбарлаж, харилцан санаа бодлоо солилцоорой.



### Бичих чадвараа хөгжүүлье

1. Хүмүүн бидэнд байгальтайгаа буруу харьцсанаас болоод Сэлбэ гол шиг болоод байгаа тулгамдсан олон асуудал бий. Эдгээр санааг дэвшүүлэхдээ, үзэл бодлоо уран сайхнаар илэрхийлж, байгалийн бодит жишээн дээр тулгуурлан шүлэг зохион бичээрэй.
2. Шүлгийн санаанаас сэдэвлэн, эх дэлхий, байгаль орчноо хамгаалах сэдвээр эсээ бичиж болно. Ингэхдээ ямар хэлбэрээр, яаж бичихээ сайтар төлөвлөж, холбогдох нэр томъёог хэрэглэн, баримтаар нотолж, тайлбарлаарай.
3. “Гол мөрөн” ерөнхий сэдвийн хүрээнд шүлэг юм уу эсээ зохион бичээрэй.



### Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

1. Өөрсдийн мэддэг байгаль эхийн сэдэвтэй шүлэг зохиолын тухай харилцан ярилцаарай.
2. “Сэлбэ” шүлэг нь тэдгээрээс ямар ялгаатай байна вэ? Голын нэрийн утга учиртай холбон тайлбарлахдаа зохиолчийн туурвил зүйн болон шүлгийн хэмнэл, бүтцийн онцлогийг задлан шинжлээрэй.
3. Шүлгээс өөрт таалагдсан хэсгийг цээжлэн, яриандаа ашиглаарай.

Жишээ нь:

*... Дүүрэн Сэлбэ биднийг ширгэтлээ сэлбэлээ*

*Дүнжингаравын хамаатан ус цусанд минь аслаа*

*Аз жаргалын диваажин сууцны чинь паалан хананы*

*Асуултын тэмдэг шиг цоргоноос нулимс болон дусалж байна...*

гэх мэтээр сонгон цээжилсэн хэсгээ бүтээлчээр давтаарай.



### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. “Монголын уран зохиолын дээжис” 108 боть (97-р боть). УБ., 2006

## ЗОХИОЛЧ



## Тангадын ГАЛСАН

1932 онд Баянхонгор аймгийн Заг сумын нутагт төржээ. Анхны шүлгээ 1947 онд бичиж, 1962 онд “Төрсөн хүүгийн тань үг” анхны түүврээ гаргасан. Гэвч уг ном гурван жилийн дараа хураагдаж, шатаагдсан байна. Үүний дараа Б.Ринченгийн “Монгол бичгийн хэлний зүй”-н III боть, Ц.Дамдинсүрэнгийн “Орос-Монгол толь”-ийн хавсралтыг шатаажээ. Энэхүү түүврээс 10 жилийн дараа хэвлэгдсэн “Өнөр хүний зүрх” ном нь түүнийг монгол яруу найргийн гэр бүлд дахин багтаав. Тэрээр 1990 оны ардчилсан хувьсгалд ард олныг оюун санааны хувьд бэлтгэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн “Өр”, “Сталины хөшөө”, “Эсэргүү” зэрэг шүлгүүдээ “Монголын дуу хоолой”

сонинд нийтлүүлсэн байдаг. Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал, Ардын уран зохиолч цол хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- *Зохиолч Т.Галсангийн намтраас өгүүлсэн дараах хэсгийг уншаад, өөрийн бодол дүгнэлтээ нөхөдтэйгөө хуваалцаарай.*

*Зохиолчийн намтраас:* МУИС-ийн хэл уран зохиолын ангийг төгсөөд Баянхонгор аймгийн төвийн арван жилийн сургуульд багш, хичээлийн эрхлэгчээр ажиллаж байв. Энэ үед буюу 1960 оны эхээр үзэл сурталд харш, эсэргүү зохиол бичсэн хэмээн зохиол бүтээл нь хаагдаж “Эсэргүү” нэр зүүн цөлөгдсөн зохиолч юм. Ингээд тэмээчин, ямаачин, тууварчин, мужааны ажил хийж байгаад 1970 оноос мах комбинатад, хөргөх цехийн мастер, АПУ-д ачигч, МЗЭ-ийн хорооны дэргэдэх Нацагдоржийн музейд манаач, улмаар “Монгол кино” үйлдвэрт туслах ажилчин, баримтат киноны ерөнхий редактор, зургийн дарга, эдийн засагчаар ажиллажээ.



## УНШИХ ЯВЦАД

- *“Өгсүүр замын дуу” шүлгийг уншихдаа зохиогчийн намтар, түүхийг сэргээн санахын зэрэгцээ бадаглалын онцлогийг сайн ажиглаарай.*

## ӨГСҮҮР ЗАМЫН ДУУ

Онхол цонхолгүй вандан ширээ говийн  
 Оорцог тоорцог толгод минь намайг өршөө  
 Олонцог элээгээгүй дэгдээхэй насандаа би чинь  
 Оготно бор толгодоо уул...уул гэж эндүүрч явжээ  
     Оцор цацар довцгууд дундаа сүмбэр  
     Очир хэлбэрт уулс минь намайг өршөө  
     Отгонтэнгэрийн зулайг гишгэхээсээ урьд би  
     Оргил... өндөр, оргил гэж уулсаа андуурч явжээ  
 Овоо тахилга нь бэлийн чулуугаар өндөрлөсөн  
 Отгонтэнгэр их хайрхан минь намайгаа өршөө  
 Отго жинстэй Алтайг өлмийлөхөөсөө урьд би



Огторгуйн багана гэж таныг эндүүрч явжээ

Он цагийн түүхийг мөнх цасандаа ботилсон

Онгод билгийн их Алтай минь намайгаа өршөө

Од зүлгүүрддэг Хималайг давахаасаа урьд би

Орчлонгийн зулай гэж Алтайгаа андуурч явжээ

Онхол цонхолгүй вандан ширээ говийн

Оорцог тоорцог толгод минь намайгаа бүү өршөө

Оосор бүчгүй сансрын уудмаас халихад

Оргил бүхний оргил нь нутгийн минь толгод л байж шүү дээ... (1982)

**Эх сурвалж:** (Д.Хаянхяраа... нар "Монгол найргийн сувдан эрх".  
УБ., 2010, 130-131-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Онхол цонхол** - бартаа ихтэй, хотойж гүдийсэн байдал

**Вандан** - уужим, урт

**Оорцог тоорцог** - ганцаар тусгаар (хорш үг)

**Толгод** - олон жижиг толгой, дов толгод

**Олонцог** - эмээлийн суудалд хийсэн зөөлөвч

**Довцог** - ов тов өндөрхөн газар, бяцхан дов

**Отго жинс** - ноёд түшмэдийн хэргэм зэргийн ялгааг үзүүлэх малгайн тэмдэг, өд болон чулуу




#### УНШСАНЫ ДАРАА

- Шүлгийн бүтцэд уран сайхны зорилгоор хийсэн давталт, дахилт, хэмжээ тохируулах зорилгоор ашигласан нугалбар болон хөг эгшиг, айзам хэмнэл гэх мэт онолын нарийн ойлголтууд бий. Үүнийг Т.Галсангийн “Өгсүүр замын дуу” шүлгийн бадаглалын жишээн дээр багштайгаа хамтран ажиглалт хийн мэдэж аварай.

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

Зохиолчийн гар бичмэлтэй танилцаарай.



Унших чадвараа хөгжүүлэе

1. “Онхол цонхолгүй вандан ширээ говь”, “Оорцог тоорцог толгод”, “Оцор цацар довцгууд” хэмээх дүрслэлийн онцлог, үгийн утгыг тайлбарлан, дүрслэлийн өнгө аяс, хөг аялгуу, өвөрмөц болсны нууцыг тайлбарлана уу.
2. Шүлгийг цээжлээд, уран уншаарай.



## Бичих чадвараа хөгжүүлэе

1. Шүлгээс юуг ухаарсан бэ?
2. Ахиуллын уран маягийг ашигласан хэсгийг шүлгээс түүвэрлэн бичээрэй. Ихээс бага руу, багаас их рүү ахиулахын ялгаа ба онцлогийг ажиглаарай.
3. Шүлгийн хэлний онцлогийг тодорхойлж бичнэ үү.



## БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. Т.Галсан. “Жирмийн сүлжээ” (дөрвөн боть). УБ., 2001

## ЗОХИОЛЧ



## Цоодолын ХУЛАН

1969 онд Улаанбаатар хотод төрсөн. 23 дугаар дунд сургууль, УБИС төгсөж, 1990-ээд оноос уран бүтээлээ туурвиж эхэлжээ. “Гүнж аялгуу” (1997), “Гуниг тайтгарал” (1999), “Торгоны маань хээ” (2001), “Москвагийн явдал” (2000), “Цэнхэр үдэш” (2005), “Алтан зэгсний ангир” (2011) шүлгийн номоо хэвлүүлсэн байна.

1999 онд “Болор цом” яруу найргийн наадмын тэргүүн байр, 1994 онд Г.Сэр-Одын нэрэмжит шагнал, 1999 онд МЗЭ-ийн нэрэмжит шагнал, 2002 онд Д.Нацагдоржийн нэрэмжит шагнал, 2014 онд Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Шүлгийг уншихын өмнө “Эрх чөлөө” гэдэг ойлголтыг чи хэрхэн тайлбарлах вэ?
- Ардчилал, аз жаргал, эрх чөлөө, эрх мэдэл... гэдэг үгийг өөрийнхөөрөө тайлбарлаж санал бодлоо солилцоорой.

## ЭРХ ЧӨЛӨӨ

Чөлөөтэй омголон дураараа байх би дуртай  
 Чөдрөө тасдаж гүйдэг моринд адуу адуунаас хайртай  
 Талын шувууд торонд биш талдаа жиргэх дуртай  
 Тааваараа бус орчлон өөрөө Эрх чөлөөнд дуртай  
     Хязгаар үгүй эрх чөлөө хаана ч харин байдаггүй  
     Хазааргүй унаа, бүслүүргүй гэр гэж байдаггүй  
     Эрх чөлөө гэж хэчнээн ч хашхирлаа гэсэн  
     Энэхэндээ гэж хэлэхэд би хорионд байх дуртай  
 Эгэл даруу гэр, эцгийн минь голомт сэтгэлийг минь хорьдог  
 Энгэртээ тэвэрсэн үрс, насны минь хань намайг хорьдог  
 Элгэн садан ард түмэн, эх орон минь намайг хорьдог  
 Энэнээс өөр эрх чөлөөгөөр орчлонд би яах юм бэ



## СУДЛАЛ ШҮҮМЖ

“...1990-ээд оны иргэний уянгын хүчтэй дуу хоолой болсон найрагчийн нэг нь Ц.Хулан юм. “Эрх чөлөө” шүлэгт эрх чөлөө, омголон дураараа хүн бүхэн дуртай гэхдээ бүслүүргүй гэр, хазааргүй морь гэж байдаггүй шиг эх орныхоо харьяа хявцаанд би оршдог. Ингэж эх орондоо “хоригдох” минь миний эрх чөлөө юм гэжээ. Энэ нь эх орны эзэн байхын утга буюу иргэн байхын үүргийг чухалчилсан санаа юм...”

(“Монголын орчин үеийн уран зохиолын түүх”, IV боть (1980-2000). ШУА, ХЗХ. УБ., 2014, 42-р тал)



## Унших чадвараа хөгжүүлье

1. “Эрх чөлөө” шүлгийн дараах хэсгийн утга агуулга, уран дүрслэлийг онцлон тайлбарлаарай.  
*...Талын шувууд торонд биш  
 Талдаа жиргэх дуртай  
 Тааваараа бус орчлон өөрөө  
 Эрх чөлөөнд дуртай...*
2. Дээрх дөрвөн мөрийг ашиглан “хорионд” байх “эрх чөлөө”-ний тухай өгүүлсэн далд утгыг тайлан тайлбарлана уу.



## Бичих чадвараа хөгжүүлье

1. Энэхүү “Эрх чөлөө” шүлгийн гол санааг эргэцүүлэн тунгаагаад, товч бөгөөд тодорхой тайлбарламж бичээрэй.
2. Шүлгийн хэлбэр, бүтцийг дуурайлган “Эрх мэдэл” гэсэн шүлгийг зохион бичээд, дээрх шүлэгтэй харьцуулж, төсөөтэй ба ялгаатай талыг нь тайлбарлаарай.



## Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

1. Зохиолд дэвшүүлсэн асуудал, гол санааг ярилцан, ангидаа хэлэлцүүлэг хийж болно.
2. Эх орондоо “хоригдох” минь миний эрх чөлөө юм - гэсэн найрагчийн санааг баяжуулан, өөр өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, саналаа солилцоно уу.
3. Аливаа хүний эрх, үүргийн асуудлыг хувь хүний болон нийгмийн харилцааны түвшинд хэрхэн төлөөлүүлэн илэрхийлсэн бол?



## БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. Ц.Хулан. “Зүгээр л нэг амьдрах сан”. УБ., 2006
2. Ц.Хулан. “Алтан зэгсний ангир”. УБ., 2011





### **Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томъёог оновчтой хэрэглэе.**

1. Уншсан шүлгийнхээ өвөрмөц, содон, танил биш, уран үг хэллэгүүдээс сонгоорой.
2. Зохиолч ямар зорилгоор эдгээр үгсийг сонгосныг тайлбарлах, дээрх үгсийг хэрэглээгүй байсан бол ямар утга алдагдах бол гэж хэлэлцээрэй.

Яруу хэрэглүүрийг хэрхэн хэрэглэснийг судлахдаа:

- Толгой, сүүл холбохдоо ямар үгийг хэрэглэснийг ажиглах
- Бөгжин, бэлчирлүүлэх давталтыг хийхдээ үгээ хэрхэн сонгосныг ажиглах
- Яруу асуулт, яруу дуудал, яруу хандлаа илэрхийлэхдээ ямар үг сонгосныг ажиглаж, хэр оновчтой байгаа талаар хэлэлцэх
- Санааг илэрхийлэхдээ ахиуллын, харшууллын ур маяг хэрэглэсэн эсэхийг нягтлах
- Өгүүлбэр зүйн хувьд зэрэгцүүлснийг ажиглаж, зэрэгцүүлэл болж байгааг батлахдаа үгийг ажиглах

Уран дүрслэлийг боловсруулсныг судлахдаа:

- Ямар үг сонгосныг ажиглах
- Адилтгахдаа, хэтрүүлэхдээ, ёгтлохдоо, егөөдөхдөө, тойруулж \бусад ур маяг\ хэлэхдээ ямар үг сонгосныг ажиглаж, зохиолч ямар зорилгоор ийнхүү дүрсэлснийг тайлбарлах

Бичил дүрслэлийг судлахдаа:

- Тухайн зүйлээ нарийвчлан дүрслэхдээ тэмдэг нэр хэрхэн хэрэглэснийг ажиглах
3. Нэгтгэн дүгнэж бичээрэй. Нэгтгэн дүгнэхдээ “Зохиолч үгийг .... ийм зорилгоор хэрэглэсэн нь зохиолыг улам уран сайхан болгожээ. Энэ үгийг урнаар дүрслэхдээ хэрэглэсэн нь их оновчтой байна” гэх зэргээр өөрийн үзэл бодлоор дүгнэнэ.
  4. Дүгнэхдээ жишээ, тайлбар, түлхүүр нэр томъёог оновчтой хэрэглээрэй.
  5. Бичвэрээ ноороглоорой.
  6. Ноороглноо засна уу. Ингэхдээ зөв бичгийн дүрмийн болон найруулгын, логикийн, баримтын засвар хийгээрэй.
  7. Дахин сийрүүлж бичнэ үү.
  8. Хэрхэн бичсэнээ өөрөө үнэлж, бусдад илэрхийлж туршлага солилцоорой.



### ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ:

#### “Шувуун зэл” шүлэг

1. “Цагаан болоход хүү минь, чи ч гэсэн ялгалгүй  
Цаст цагаан уул, уст уудам талыг  
Цаана, цаана орхисоор ээж рүүгээ зүтгэх нь лав” гэсэн хэсэг ямар үндсэн санаа илтгэж буйг сонгоорой.
  - а Нүүдлийн шувуудыг өрөвдөн хайрлахыг сургасан.
  - б Цаг хугацааны эргэлтийг сануулсан.
  - в Ертөнцийн мөн чанарыг эргэцүүлсэн.
2. Шүлгийн давталтуудыг ажиглан бүртгээрэй. Айзам, хэмнэлийг яруу болгож буй үүргийг тодотгон ялгаж зураарай.
3. “Амьдрал бол тэмцэл” сэдвээр 200-250 үгтэй эргэцүүлэмж бичээрэй.

#### Бусад яруу найраг

4. Зохиолын баатруудын дүр төрхийг илэрхийлсэн зүйр цэцэн үг ба хэлц үгийг бичээд, өөр өөрсдийн уран санаагаар баяжуулан дэлгэрүүлж ярина уу.
  - Эхийн сэтгэл - **Ээж** .....
  - Би тэнгэрийн хүү - **Тэнгэрийн хүү** .....
  - Шувуун зэл - **Эх, үр** .....
  - Сэлбэ - **Сэлбэ гол** .....
5. Зохиолчдын шүлгийн нэр, зохиолын баатрын нэрийг нөхөж бичээрэй. Аль баатрыг нь илүү хүндэтгэж байна вэ, түүний шалтгааныг баримт жишээгээр тайлбарлан бичээрэй.

Зохиолч	Зохиолын нэр	Зохиолын баатар	Баримт, жишээ
Б.Явуухулан			
П.Бадарч			
Ш.Сүрэнжав			
Ч.Дагвадорж			
Ц.Чимиддорж			
Т.Галсан			
Ц.Хулан			









6. Ямар шүлгүүдийг цээжилсэн бэ? Хамгийн их таалагдсан шүлгүүдээ дараалуулан бичээрэй.
7. Энэ бүлэгт үзсэн шүлэг, яруу найргийн нэрс, үндсэн санааг нэг өгүүлбэр юм уу нэгэн бадаг шүлэгт багтаан найруулан зохиогоорой.
8. “Монголын орчин үеийн яруу найраг” сэдвээр эсээ бичээрэй.


## Хоёрдугаар бүлэг

# МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ

### ХОЁРДУГААР БҮЛГИЙН ЗОРИЛГО

Та бүхэн “МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ӨГҮҮЛЛЭГ, ТУУЖ” – ийн бүлгээр унших, бичих, сонсох-ярих гэсэн суралцахуйн зорилтын дагуу бүтээлчээр уншиж, сэтгэж, монголын орчин үеийн уран зохиолын төлөөлөгчдийн бүтээл, туурвилтай танилцах болно. Ингэхдээ:

-  Монголын орчин үеийн өгүүллэг, туужийг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоно.
-  Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлана.
-  Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэнэ.
-  Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлана.
-  Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилнэ.
-  Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж, үнэлнэ.
-  Зохиолын хэлбэр бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохионо.
-  Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэнэ.



## ЗОХИОЛЧ



### Шанжмятавын ГААДАМБА (1924-1993)

Булган аймгийн Могод сумын нутагт төржээ. 1942-1945 онд Дундговь, Булган аймагт багшилж байгаад МУИС-ийн багш, утга зохиолын дугуйлангийн эрхлэгчээр ажиллаж байв. “Наадамчид”, “Элбэгдээл”, “Гагнаас” өгүүллэг, туужийн түүвэр, “Хөглөгөр Алтайн бараа” шүлгийн түүвэр, “Өвийн хайрцаг”, “Тэрэгчний хүү”, “Хөдөө талын баясгалан”, “Хоёр эрдэмтэн”, “Чөдөр өвс” өгүүллэг, “Багын явдал” тууж зэрэг олон зохиол бүтээлээ туурвижээ. Монгол ардын аман зохиолыг судлахын зэрэгцээ “Монголын нууц товчоон” судлалын бүтээлээрээ 1990 онд Монгол улсын Төрийн шагнал хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Зохиолч энэхүү өгүүллэгээ бичсэн цаг үе бол манай улсад нэгдэлжих хөдөлгөөн ид өрнөж, жалга довны аминч үзлээс хамтын хөдөлмөрийн давуутайг ойлгох болж, хүн бүр өөрийн хүч бололцоогоороо хамт олны үйлст хүч хандив оруулах ёстой гэсэн нийгмийн ухамсар бүрэлдэн тогтож, төлөвшиж байсан үе ажээ.



## УНШИХ ЯВЦАД

- Өгүүллэг бичигдсэн цаг үед хөдөлмөрийн үнэ цэнийг хэрхэн үнэлж байв? Одоо үеийнхтэй харьцуулан ярилцаарай.

## ЭЛБЭГ ДЭЭЛ

(Өгүүллэгийн хэсэглэл)

Эрхэм уншигчдын дотроос хэрэв сурвалжлан бичихийн зовлонг үзсэн хүн байвал ажилд гарамгай боловч даруу бүрэг хүнтэй ярилцаад нийтлүүлэх олзгүй буцахаас гомдолтой юм орчлонд ховорхныг мэднэ байх аа. Сайн малчдын 4 дүгээр зөвлөгөөний үеэр 12 дугаар сарын нэг хүйтэн, тунгалаг өдөр би зочид буудалд очиж нэг малчин хүүхэнтэй ярилцаад яг тэгж хоосон буцах шахаж билээ...

Гэтэл би түүнтэй нь амралтын сайхан өдрийнхөө айвуухан хагасыг зарцуулж ярилцаад “Би, малаа нам засгийнхаа зааж сургаснаар хичээж зүтгэж, тэгж ингэж малладаг даа” гэхээс өөр гойд юу ч сонссонгүй. Хурган дотортой хүрэн торгон дээл нь элбэгдэж, ханцуй нь уртадсаныг эс тооцвол онцтой юм олж ажсан ч үгүй...

## Нэг.

...Худаг дээр давхин очвол, онгоцны дэргэд цангасан олон хонь үргэхийг мэдэхгүй бөөгнөрч байв. Ойролцоо чөдөртэй морь хамраа тачигнуулан дэгж эргэцнэ. Харин хонио усалж байсан хүүхэн том ховоогоо барьсан чигээрээ санд мэнд угтан гүйж ирээд зам дээрээс уургаа шүүрч аваад сая тэднийг ажиглан зогсов. Хүүхнийг үзвэл, гуалиг нуруутай, бэсрэг биетэй, эрүүл улаан царайтай, ид дунд насны хүн байв. Ногоон сатин дээлийнхээ ханцуйг сугалдаргалан, бүсэндээ хавчуулаад, бухаар савхи өмсөж, толгойдоо эрээн даавуу зангиджээ. Тохойноосоо өнгөртөл шамласан нимгэн цагаан цамцны ханцуйнаас цулдамхан чийрэг махлаг бор шуу үзэгдэж, хар бор ажилд эрэлхэг чадамгайн





### шинж бүрдсэн нь жолоочийн сэтгэлд хэчнээн таалагдсан гэх вэ?...

Тэр хоёр заасан зүгт нь хурдлан явах зуураа өнөөх хүүхний морь уургалахыг сонирхон харжээ. Ганцхан атга болтол хурааж цуглуулсан адууны дундуур хага зүсэж ороход нь адууны дундаас дүнхгэр хээр морь сум шиг суга үсрэн гарч гүрвэл мэт шалмаг хөдөлж, тоос манарган зугтаажээ. Уургачийн морь ч ороо морины сүүлнээс нь уяатай юм шиг даган хөөлөө. Уурганы үзүүр ороо морины бөгтөргөнд дөнгөж хүрэхийн хамт урагшаа бөхийн хуйв сунган шидсэнд, уурга хуйв, хүүхний гар цөм ид шидийн хүчээр сунасан мэт хэдийн морины толгойд хүрчихжээ. Хүүхэн гэдийн татаж ороо морины толгойг эргүүлээд, үсрэн бууж ногтлох нь эмнэг сургагч залуу, шаламгай шинжтэй ажээ.

- Уургандаа хар хүнээсээ илүү хайртай байхаас ч аргагүй хүүхэн юм даа гэлцэн тэр хоёр говийн хүүхнүүдийн эрэлхэг чадамгайг гайхан ярилцаар цааш хурдалжээ.

Алдарт малчныхыг олж очвол малчин гэртээ байсангүй. **Гадаа нь мушгисан зэл, зангидсан чөдөр, ац цаханд татаастай харагдана. Гэрийн эргэн тойронд таанын хурууд дэлгэцэнд хатаажээ. Гэрт арслант эрээн авдрууд, оёдлын машин зэрэг хогшилтой бас идээ будаа нь цэвэрхэн хөшиг бүтээлэгтэй, аяга шаазан нь марлиар бүрхсэн эсгий ууттай юм бүхэнд нь ажилсаг нямбай гар хүрсний шинж мэдэгдэж товчилбол, манай хотынхны хэлдгээр бол догь боловсон тохилог гэмээр, хөдөөнийхний хэлдгээр бол хөдөлгөөн сайтай эзний хүчээр өөдөлж яваа гэмээр айл байлаа.**

Гэр сахисан хазгар эмгэнээс гэрийн эзнийг асуувал,

- Хэн мэдэх вэ? Манай тэр дандаа хурал хуй, яриа хөөрөө гээд гэрт орох завгүй л амьтан байна шүү дээ гэжээ.

Эмгэн зочдыг өтгөн шаргал цай, боов боорцог, зөөхий тосоор, эмгэнийг төлөөлөгч хүүхэн элдэв олон асуултаар дайлжээ. Эднийх энэ жил төлөвлөгөөнөөсөө давуулж малаа өсгөж малчны хуралд шалгарах бүх болзлыг хангасны нь мэдэж авлаа. Эцэст нь:

Хадлан хэр зэрэг хадаж авсан бэ дээ? гэж төлөөлөгч асуужээ.

- Жаал зугаа авсан даа, хүүхэд минь. Манай муу бэр л мал хариулахын далимаар гоочилж зуны турш хулгана хөөгөөг хураадаг шиг арай л ганц нэгээр нь зөөлгүй явж хавар хурганы хөгнө, тугалын элэнд боох атга чимх ногоон өвс авдаг юм...

Хоёр зочин энэ мэтээр эмгэнтэй баахан ярилцаад, сайн малчинтайгаа уулзаж чадалгүй явжээ. Төлөөлөгч хүүхэн, тэмдэглэлийнхээ дэвтэрт баахан юм бичиж аваад нэг нэрийн доогуур зурж ард нь анхаарлын тэмдэг тавьж аваад оджээ.

#### **Хоёр.**

... Цөөхөн үхэр, олон хонь, тэмээд нь өвлийн өглөөний чалхгүй наранд ээн тавтайяа налайн хэвтэх нь эднийхэн тарган тавтай өвөлжиж байгаагийн шинж ажээ.

Хот айлын зүг нэг гавшгай хар хүн, тарган хээр мориор хатируулан айсуу. Гуч орчим насны энэ торниун эрийн тослог хүрэн царайд ширвээ хар сахал сүртэй мушгирчээ. Энгэр дээр нь сайн малчны тэмдэг, хөдөлмөрийн медаль гялалзан гавьяа зүтгэлий нь мэдүүлнэ. Хатируулсан чигээр ирж баруун урд гэрийн хаяанд буумагц цулбуурыг гэрийн оосорт хавчуулаад эсгий үүдийг сөхөн чулуудаж гэрт оров. Сайн малчин Сэнгээ чухал мэдээ дуулаад гэртээ яаран иржээ... Сэнгээ хоймор сууж хашин соруултай гаансанд тамхи татах зуураа,

- Та хоёрын гоёж гоодох ч гайгүй байна. Би малчны хуралд нүцгэн очих гэж байдаг л хэцүү байна. Хүн хэлээд байхад дээлий минь оёод орчихгүй, баларсан

юм...

...Хүүхэн хар хүнийхээ дээлийг өдөржин шөнөжин цурамхийлгүй оёод, маргааш орой нь сүүлчийн шилбийг хаджээ. Сэнгээ торгон дээлээ өмсөж үзвэл зохисон таарсан гэж жигтэй. Эхнэр нь эр нөхрийнхөө бие бялдар, хэмжээ хэрийг арван хуруу шигээ мэддэг юм байжээ...

Гэтэл гадаа нь морин төвөргөөн сонсогдож, нохой боорлосоор нэг хүн ирсэн нь ахлах ухуулагч байжээ... Сониноос малчны хуралд очих хүмүүс маргаашийн шуудангаар гарах гэнэ дээ. Өдрийн 12 цагаас хожимдохгүй суман дээр бэлэн бай гэж хэлүүлж байна даа...

- Харин энэ удаа чи биш, эхнэр чинь явах болсон шүү гэхэд Сэнгээ үнэмшсэнгүй...

- Бэр минь одоо юугаа өмсөж явна даа?... гэж ээжий нь үглэхэд:

- Ёстой баларсан юм болж байна даа. Одоо яая гэхэв, миний дээлийг л өмсөөд явахаас даа! гэж Сэнгээ хэлжээ. Маргааш нь хүүхэн мордохдоо,

- Ээжий минь ээ, би тэр олон сайд ихэстэй нь очиж хуралдаад юу ярина даа? Ёстой Сэнгээгийн хэлснээр мануухай шиг сууж байгаад ирэх байгаа даа гэж сэтгэл зовж хэлэхэд:

- Ярих нь яахав, хүүхэн минь. Малаа яаж маллаж байгаагаа л ярина биз. Ямар худлаа юм санаанаасаа гаргаад ярихаар биш нохой долоо. Харин хүү бид хоёр л чамайг эзгүйд яаж хөглөдөг улс байгаа юм бэ, би гэрт, энэ маань гадаа мануухай болоод байж дөнгөх л байгаа даа гэж эмгэний хэлэхэд хүү нь хатуу амтай ээжидээ энэ удаа эгдүүцсэнгүй.

- Нээрээ балрах байх аа. За сайн яваад түргэн шиг ирж үзээрэй гэж үдсэн ажээ. Ингэж тэр хүүхний дээл элбэгджээ...

(1956)

**Эх сурвалж:** (Ш.Гаадамба. “Элбэг дээл” түүвэр. УБ., 1957, 121-130-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Онгоц** - малд тэжээл, ус өгөх гонзгой хэлбэртэй хэрэгсэл, сав

**Эргэцэх** - байн байн эргэх, эргэлдэх

**Сугалдаргалах** - дээлийн өрөөсөн ханцуйнаас гараа сугалж гаргах, өрөөсөн ханцуйгаа

**мулталж**, сул чөлөөтэй болгох

**Бөгтөргөө** - хагас нуман хэмжээ

**Хүйе** - уурганд уях оосор

**Ховоо** - худгаас ус утган гаргах хэрэгсэл

**Сатин** - нэгэн зүйл орос бөс бараа



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Тэрэгчний хүү” (1955), “Хөдөө талын баясгалан” (1955), “Элбэг дээл” (1957) зэрэг өгүүллэг бичсэн нь хөдөлмөрийн сэдэв зонхилж, хөдөлмөрийн хүнийг гол дүрээ болгосон, дүрийн дотоод сэтгэхүйг нээсэн, уран санаа дүрслэлээр тухайн үеийн өгүүллэгийн уран чадварыг баяжуулснаараа онцлогтой, ялангуяа “Элбэг дээл” өгүүллэг нь эгэл жирийн малчин эмэгтэйн дүрийг тодруулж, өрх гэрийн доторх хөдөлмөрийн хуваарийн тэгш биш байдлыг шүүмжилж уран чадварлаг бичигдсэнээрээ ялгарч уншигчдын талархлыг хүлээснийг уг зохиолоос сэдэвлэн кино бүтээсэн явдал гэрчилнэ...”

(Х.Сампилдэндэв. “Ш.Гаадамбын эрдэм шинжилгээ, уран бүтээлийн үйл ажиллагаа”. Шанжмятавын Гаадамба: Санаа сэтгэлийн орчлонг сайхан болгох хөдөлмөр - Илтгэл дурсамжийн эмхэтгэл. УБ., 2009, 11-р тал)



### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгое.

1. Өгүүллэгийг бүрэн эхээр нь уншаарай. Уншсанаа ярилцахдаа бие биедээ асуулт тавьж, зохиолд юуны тухай өгүүлж, ямар асуудлыг хэрхэн хөндөж байгааг жишээ татан батлаарай.
  2. Зохиолын гол утга санаа аль, аль хэсгээр илэрч байгааг олж, тайлбарлаарай.
  3. Зохиолын сэдэв нь утга санаатайгаа хэрхэн холбогдож байгааг дүгнээрэй. Зохиолч ямар хам сэдэв дэвшүүлэн тавьсан бэ?
  4. Өгүүллэг бичигдсэн цаг үеийн монголын нийгмийн байгуулал ямар байсан талаар өөрсдийн санаа бодлоо ярилцаарай. Зохиогчийн гаргасан санаанд таамаглал дэвшүүлж, судлаачид юу гэж үзсэнтэй харьцуулан тайлбарлаарай.
- “...Энэхүү хамтын хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгон ухамсарлах явдал одоо ч үнэ цэнээ алдаагүй хэвээр байна. Хэдэн зууны турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж, хувиа борлуулж, довоо шарлуулж ирсэн монголчуудын сэтгэлгээнд суурин ахуйд шилжин, хот газар орчин үеийн аж үйлдвэр бүтээн байгуулалт өрнүүлж, хөдөөд хэсэг бүлгээр нэгдэн нийлж хамтын хүчээр байгаль цаг уурын болоод бусад бэрхшээлийг даван туулах үзэл бодлыг шингээх ойлгуулах явдал нэн саяхны асуудал байсан бөгөөд тодорхой бэрхшээл саадтай ч учирч байсан билээ. Энэ үеийн хүмүүсийн сэтгэлгээнд байсан зарим хоцрогдол дутагдлыг зохиолч тун аятайгаар шүүмжлэн харуулсанд “Элбэг дээл” хэмээх энэхүү өгүүллэгийн ач холбогдол орших бөгөөд энэ утгаараа тухайн цагийн нийгмийн сэтгэлгээний нэгээхэн талыг хөндсөн гэж үзэж болно...”

(Шанжмятавын Гаадамба: Санаа сэтгэлийн орчлонг сайхан болгох хөдөлмөр – Илтгэл дурсамжийн эмхэтгэл, УБ., 2009, 59-р тал)

- “...1950-аад оноос монгол өгүүллэг утга сэдэв, агуулга хэлбэрийн хувьд өргөжин нийгмийн өмнө дэвшигдэж буй гол зангилаа асуудлын учир утгад нэвтрэх, хүний ёс суртахуун, зан төлөвийн сонирхолтой, ээдрээтэй мөчлөгүүдийг сонгон дүрслэхэд зохиолчид зарим эрэл хайлт хийхийг оролдсон. Тухайлбал, гэр бүл дэх хөдөлмөрийн хуваарь, эмэгтэй хүнийг үзэх хуучинсаг үзэл бодлыг бичлэгийн өөр өөрийн арга барилаар шүүмжлэн дүрсэлсэн Ц.Дамдинсүрэнгийн “Хэлдэг гурав, хийдэг ганц”, Ш.Гаадамбын “Элбэг дээл” өгүүллэгүүдийн зохиомж, өгүүлэмж шинэлэг, дүрслэл товч тодорхой, чамбай, хэл найруулга зохистой байна...”

(МУБИС, “Утга зохиол шинжлэл”, УБ., 2005, 236-р тал)

### Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.

1. Сэвжидмаагийн дүрийн хэв шинжийг тодорхойлохдоо зохиолоос жишээ татан тайлбарлаарай.

Дүрийн нийтлэг зан чанар, онцлог	Хувь хүний өвөрмөц онцлог шинж

2. Сэвжидмаагийн дүрийн нийтлэг шинжид нийгмийн ямар асуудлыг хөндсөн бэ? Нийгмийн байдлаас шалтгаалсан дүр мөн үү? Энэ дүрээрээ зохиолч ямар утга санааг уншигчдад хэлэхийг хүссэн бол?
3. “... Одоо яая гэхэв дээ хүүхдүүд минь. Муу эртэй хүн чинь юм бүхнийг сурдаг юм шүү дээ. Эмээ нь залуудаа бас л ажилгүй танхай эртэй байсан болоод чөдөр, ногт зангидахаас аваад сураагүй ажил гэж байхгүй л дээ. Тэр үед харцуул найр наадам эргүүлж, эхнэр хүүхдээ омогдохоос өөр юм мэддэггүй байлаа шүү дээ...” гэсэн хэсэгт тухайн үеийн монгол эмэгтэйчүүдийн дүрийн ямар хэв шинжийг харуулж байгааг тайлбарлаарай.
4. Зохиолч Сэвжидмаагийн дүрээрээ дамжуулж нийгэмд, хувь хүнд юуг хэлэхийг хүссэн бэ? Сэвжидмаагийн дүр нь нийгмийн орчин, амьдралтайгаа хэрхэн уялдан дүрслэгдсэнийг тайлан тайлбарлаарай.
5. Зохиолч уншигчдыг өгүүллэгийн ямар дүрээс ямар үлгэр дуурайл авах, ямар дүрийг жигшихийг зорьсон бэ?

**Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.**

1. Зохиолын эхэнд тодруулсан хэсэгт Сэвжилмаагийн хонио усалж байгаа үйл явдал дүрслэгддэг. Ийм орчин, нөхцөл байдалд дүрийн гадаад төрх, зан чанарын ямар талыг дүрсэлсэн бэ?
2. Зохиолд тодруулан тэмдэглэсэн, гэрийн гадаах орчин, юмсын дүрслэлээр Сэвжидмаагийн зан төлөвийн ямар талыг тодруулах зорилгоор дүрсэлсэн байна вэ?
3. Өгүүллэгт дүрүүдийн зан төрх, үзэл бодол, амьдрал хөдөлмөрт хандах хандлага, хоорондын харилцааг хэрхэн дүрсэлснийг зохиолоос олж, тайлбарлаарай.

Дүрүүд	Хэлж буй үг	Хийж буй ажил
Сэвжидмаа		
Эмгэн		
Сэнгээ		

4. “...Гэтэл гадаа нь морин төвөргөөн сонсдож, нохой боорлуулсоор нэг хүн ирсэн нь ахлах ухуулагч байжээ. Сэнгээ, түүний юу хэлэхийг хүлээж:
  - Сонин сайхан юу байна, ухуулагч аа? гэж дурдан бүсээ тайлах зуур асуув...
  - Чи малчны хуралд явж амташчихаад дээлээ хүртэл зэхчихсэн бий. Харин энэ удаа чи биш эхнэр чинь явах болсон шүү гэхэд Сэнгээ үнэмшсэнгүй,
  - За чи хөгшин ахаараа битгий даажин хийгээрэй хө гэв...” гэсэн хэсгийн санааг зохиолч яагаад ийм нөхцөл байдал сонгосонтой холбон тайлбарлаарай.
5. Эмгэн болон Сэнгээгийн дүрийн үзэл бодол, үйл хэрэг гол дүрдээ хэрхэн үйлчилж байгааг хөөн олж, тайлан тайлбарлаарай.
6. Сэвжидмаагийн морь уургалж байгаа хэсгийг дахин уншаад, түүний зан чанарын ямар шинж илэрч байгааг дүгнэн бичээрэй.
7. Зохиол дахь ямар орчин, нөхцөл байдал хамгийн содон байсан бэ гэдгийг сонгон, яагаад гэдгээ баримтаар тайлан тайлбарлаарай.
8. Малаа маллаад, гэр орон, ахуй амьдралаа өнгөтэй өөдтэй явуулахын тулд зүтгэж байгаа Сэвжидмаа, орчны өөрчлөлтөөс дүрийн бодол санаа,



- үйлдэл, үзэл бодол хэрхэн өөрчлөгдөж байгааг үнэлж дүгнээрэй.
9. Дүрүүдийн зан чанарын илрэл, нөхцөл байдал, жишээг олж бичээрэй.

Дүрүүдийн зан чанарын илрэл	Нөхцөл байдал	Жишээ
Сэвжидмаа бол хүний арга эвийг эвтэйхэн олчихдог ухаалаг, наргиантай хүн	Эмгэний бэрээ өмөөрөх сэтгэлийн илрэл	
		“ - Ёстой баларсан юм болж байна даа. Одоо яая гэхэв, миний дээлийг өмсөөд явахаас даа!...”, “...Нээрээ балрах байх аа. За, сайн яваад түргэн шиг ирж үзээрэй...”

10. ...Эр нөхрий нь дээл

Элбэг хэлхгэр харагдана.

Эзнээ олсон одон

Энгэр дээр нь гялалзана... гэсэн хэсгийг дэлгэрүүлж, яагаад “Элбэг дээл”

гэж нэрлэснийг тунгаан бодож, дүгнэн бичээрэй.

### Зохиолын хэл найруулга, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг үнэлъе.

- Өгүүллэгээс өөрт таалагдсан үг хэллэг, уран дүрслэл, бичил дүрслэл бүхий түүвэрлэн бичиж, дүр, орчин, утга санааг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлан тайлбарлаарай.

	Дүр	Орчин	Утга санаа
Өөрт таалагдсан үг хэллэг			
Уран дүрслэл			
Бичил дүрслэл			

- Ялгаж түүвэрлэсэн үг хэллэг, өгүүлбэр нь өөрт чинь болоод бусдад хэрхэн нөлөөлж байгааг үнэлээрэй.
- Дүрийн болоод юмс үзэгдлийн мөн чанарыг илрүүлсэн, онож шигтгэсэн ямар бичил дүрслэлүүд байна вэ? Эдгээр нь уншигчдад хэрхэн нөлөөлөхийг тайлан тайлбарлаарай.
- Дараах дүрслэлийн утгыг тайлбарлаарай.  
“ганцхан атга болтол хурааж цуглуулсан адуу”, “Эмгэн зочдыг өтгөн шаргал цай, боов боорцог, зөөхий тосоор, эмгэнийг төлөөлөгч хүүхэн элдэв олон асуултаар дайджээ.”, “...Дүнхгэр хээр морь сум шиг суга үсрэн гарч гүрвэл мэт шалмаг хөдөлж...”, “...Ажил явдал ихтэй, хүн бүл цөөтэй айл...”



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

**Унших:** Ш.Гаадамба. “Элбэг дээл” өгүүллэгийн түүвэр. УБ., 1957

**Үзэх:** Б.Жамсран, Ж.Бунтар нарын найруулсан “Элбэг дээл” уран сайхны кино <https://youtube.com/>

## ЗОХИОЛЧ


**Сэнгийн ЭРДЭНЭ**  
 (1929-2000)

Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт төржээ. “Урин цаг ирэхэд”, “Тэнгэрийн хаяа энүүхэнд”, “Хулан бид хоёр”, “Хулан Цамба хоёр”, “Малын хөлийн тоос”, “Наран тогоруу” зэрэг уянгын өгүүллэгүүд, “Хөх хулгана жил” тууж, “Миний эх орон миний тоонот”, “Алтай” зэрэг уянгын нийтлэл, “Уянгын тойрог”, “Занабазар”, “Хойд насандаа учирна” зэрэг роман, “Хар хун шувуу”, “Зүүдний цагаан унага”, “Халхын заяат харгуй минь” зэрэг дурсамж, нийтлэлүүд, “Амьдралын тойрог”, “Баян бүрд”, “Хайрын нарсан төгөл”, “Алтан өргөө”, “Говийн нүдэн”, “Жаргал даахгүйн зовлон” зэрэг кино зохиол, “Эрдэмтний яриа”, “Сандал” зэрэг жужгүүд туурвисан байна.

1965 онд Монгол улсын Төрийн шагнал, 1994 онд Ардын уран зохиолч цол хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Хүүхдүүд ээ, та нар “Өвгөн шувуу хоёр” хэмээх монгол ардын харилцаа дууг олонтоо сонссон байх. Энэхүү дууны утга сургамж, агуулга санааг одоо унших гэж буй С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгийнхээ санаатай холбон харьцуулж, өөрсдийн санал бодлоо солилцоорой.



## УНШИХ ЯВЦАД

- Өгүүллэгт Жав өвгөн, түүний найзуудын нөхөрлөлийг хэрхэн дүрсэлснийг анхаарч уншаарай.

**ӨВГӨН ШУВУУ**

(Өгүүллэгийн хэсэглэл)

Жав гуай, нар ханын толгойд тусаж байхад нүдээ нээлээ. Зовхи нь хөх няц болон хавагнаж ухархайдаа хонхойн ширгэсэн гэрэлгүй нүдээр гэрийн доторхыг тойруулан харах гэж ихэд хүндэрсэн толгойгоо арайхийн эргүүлэв. Хянган хамрын самсааны мөгөөрс нэвт гэрэлтэн шанааны нь яс арьсаа цоо татах бий гэмээр ёрдойжээ. Царайны нь өнгө энэ нүгэлт ертөнцөд амьдрах өдөр тоотой хүн гэдгийг илтгэнэ. Яс арьс болсон гараараа орны хөлөөс уясан татуурганаас чангааж байж биеэ хагас эргүүлээд явган ширээн дээрх шаазантай цийдмээр амаа дэвтээв. Тэгээд ханын толгойд туссан нарны гэрлийг хэсэг ширтэв. Гадаа зуны сайхан өдөр. Жав гуай тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах төдий болсоор уджээ. Гэвч ханын толгойд туссан нарны гэрлийн шар толбонд бүхий л газар дэлхийг бас харж болно. Насаараа хөндлөн гулд давхисан тал нутаг, үзэж өнгөрүүлсэн амьдрал нь үүрд нүдэн анихаас нааш яаж балран арилах билээ. Өглөө болгон “Одоо ингээд зовлон дуусах цаг ирээгүй юу” гэж горьдох боловч өдөр хоног өнгөрсөөр л байна. Хүн гэдэг мөн ч бөх голтой юм. Утсан чинээхэн улаан амь гэвч тасарч өгөхгүй нь гайхалтай. Өвчин ойндоо хүрлээ. Жав гуай өнгөрсөн хаврын цагаан хагднаар хадан гэртээ харина гэж бодож байсан боловч бүтсэнгүй. “Би ер нь долоон голтой амьтан юм аа” гэж хүнд ярина. Үхэхийн тухай бодож яваагүй боловч үхэхээс нэг их айхгүй хүн байж. Үүнийгээ ойлгохдоо санаа амарсан бөгөөд элдэв зовлон гаслан



болж гиншигнэлгүй зоригтой тайвнаар үхлээ хүлээж байна. Сэтгэлээр машинд хатуужин чадахад биеийн шаналал хүртэл намдаад явчихна. “Ийм сайхан өдөр байтал үүдээ битүүлээд гардаг нь юу вэ?” гэж эхнэртээ уур хүрмээр аядсанаа “Жав чи бүү бухимдаад бай” гэж өөртөө тушаав. Тэгээд өвчинд нэрвэгдсэн биеийн ой гутам нялуун үнэрийг дарах гэж хажуудаа арц уугиулаад юм бодов. Гадаа болжмор жиргэж алсад адуу янцгаахад өөрийн эрхгүй сүүрс алдав. Хөгшнийхөө үнээ сааж байгааг сонсоод гар хуруу нь цуцдаг болж дээ гэж өрөвдөнө. Эхлээд үнээний хөхийг жигд шувтран шаагьтал сааж байснаа төдхөн гар нь цуцаж шор шор хийлгээд нэг хэсэг амарна. “Хөөрхий дээ. Хүүгийнхээ цэргээс халагдаж иртэл ганцаараа байх болох нь” гэж Жав гуай бодов. Хүүгээ иртэл тэсээд байя гэж бодож байсан боловч дахиад хагас жил тэсэх ямар ч ид шид байхгүй гэдгийг мэдсэнээс хойш хөгшнөө зовоолгүй эртхэн шиг талийж одох юм сан гэж бодох болжээ. Санаагаараа ч гэсэн үхлийг ойртуулж болох мэт бодогдоно. Өвчин нь ч нэгэнт газар авч нөгөө утсан чинээн улаан гол л аргагүй нэг цохиж байгаа нь илэрхий болжээ. Хоол унднаас ч гараад удав. Үхэх өдрөө хүлээнэ гэдэг өнгөрснөө бодож хэвт гэсэн үг байж. Жав гуайн голтой байгаагийн ганцхан учир утга л түүнд байна. Бусдаар бол хүний тооноос аль хэдийн өөрийгөө хасчээ. Бие үхэхээс наана ухаан үхчих вий гэдэг л ганц айх юм нь. Гэвч бие доройтох тусам ухаан улам саруул болж байлаа. Биеэ ухаанаар захирч ая таарсан цагт одоо ингээд амьсгаагаа хураах цаг боллоо гэж өөртөө тушааж болмоор санагдана. Гэвч тийм аяс нь хэзээ таарах тэгж таарсны тэмдэг чухам юу болохыг мэдэхгүй байлаа.

Өнөө өглөө өвдөх шаналах юм нь нэгэнт дууссан мэт хачин байх ажээ. Амаа дэвтээгээд арцны сайхан үнэр үнэртэж хөшиж чилсэн биеэ аргацааж хөдөлгөөд автал үргэлж горойж барайж байдаг дотор нь уужран толгой нь хөнгөрчих шиг болов. Зүрхээ чагнавал их удаан боловч дэрээр дамжин дуулдтал лүг лүг цохиж байна. Жав гуай үүдний баруун хатавчинд өлгөсөн хазаар ногт, хураалттай бараан дээр гөлмийг нь дэлгэж тавьсан эмээлээ харав. Эзэн нь мордох чадалтай юм шиг эмээл хазаар зэхээстэй байг гэсэн шиг хөгшин нь түүнийг ер хөдөлгөдөггүй билээ. Зуухан дээр загсаасан өрөм нарны туяа шиг шаргалтана. Хоймрын авдар дээр хөгшний бадраасан зул гал дохиуртай хар цэцэг мэт бадамлан бөхөж байна.

Өнгөрсөн зун зүмбэр хээ тавьж будсан унь нь нарны гэрэлд ярайна. “Манай гэрийн мод сайн. Хүү халагдаж ирээд бүрээсийг нь шинэчилнэ биз.” Зүүн хаяанд хөгшний орны толгойд улаан шунхан дэвсгэр дээр алтан хорол тавьсан нүүртэй хуучин цагийн намхан авдар байна. “Түүнийг сэргээгээд будчихдаг байж дээ. Хөгшин бид хоёрын анхны юм” гэж бодов. Тэр хуучин авдарнаас бусад юм цөм ёсоороо, бөхөж байгаа зул хүртэл ёсоороо бөхөж байх шиг санагдана. “Одоо ингээд болоо юм биш үү дээ. Хэчнээн болтол өөрийгөө ч, хүнийг ч зовоох вэ!” гэж гэнэт бодов.

Хөгшин нь үнээгээ саагаад орж ирэхэд айлын хүүхдийг давхиулаад нутгийн өвгөцүүлийг ирээч гэж хэлүүл гэв. Аргагүй цаг нь тулаад амин дээрээ байлгахыг бодож дээ гэж Жав гуайн үеийн гурван өвгөн яаран ирлээ. Урьд газар хонхойтол бууж мордож байсан уяан дээр нь бууцгааж юу гэж хэлж уулзана даа гэж зүрхшээн ороход Жав гуай харин сулхан дуугаар боловч үхэх гэж байгаа хүний амнаас гарамгүй хөгжилтэй наргиатай юм ярьж угтлаа. Хүрэн торгон дээл өмсөж, дөчин таван оны дайнд түр цэрэгт татагдан яваад авсан шар гуулин медалиа зүүчхээд өндөр дэр түшжээ. Жав гуайн багын түнш бөгөөд гээгт Найдан хэмээх (сая болтол гээгтэй явсан) хүдэр хар өвгөн, нутгийн их хүндтэй хүн, олон жил Жав гуайтай хамт баг сумын элдэв алба хааж явсан боргоцой Дорлиг, (Яагаад тийм хоч авсныг бурхан

л мэднэ) үеэл болох шумуул Жамц гэгч гонгиносон нарийхан дуутай өвгөн үхэлд тулсан нөхрийгөө ингэж наргиж наадаж байх юм гэж санасангүй. Хатуу эр гэдгийг мэднэ. Гэвч харахад нүд халтирмаар болсон гэж сонсоод аргагүй зүрхшээн орж гарах нь ч ховордсон байж. Нэг голын, нэг үеийн өвгөцүүл урт амьдрал туулж насан хэвийхийн жам ёсоор уван цуван цөөрсөөр боловч залуу зандан цагийнхтайгаа адил бие биеэ нэрээр нь биш хочоор нь дуудаж наануу цаануутай явах учир нэг нь ингэж тасраад талийчихна гэдэг амьдрал өм цөм үсэрнэ гэсэн үг. Жав гуай үлдэх хэдийнхээ сэтгэлийг засъя гэсэн шиг байлаа. Гээгт сүүлхэн шигээр ирээд нүд дальдран зуухны аманд сууж мод толгойтойгоо ноцолдоход Жав гуай түүнийг шоолж “Гээгт маань улам л өнгө ороод байна. Залуу эхнэр авах гэж байна гэдэг нь ортой дог оо. Тэгтэл энэ бид хоёр чинь анх нэг жил эхнэр авсан юм шүү дээ. Одоо энэ Должингоо босгох гэж яаж хөглөж явснаа санаж байна уу? Должингийн муу эмээлийг чингэлэгнээс авах гэж яваад нохойд хонгоо уруулчихсанаа, мөн ч ядуу байж дээ. Эмээлтэй морь хөтлөөд ирэх чадал байхгүй. Одоо харин жаргаад, аагаа багтаахаа байж. Бас залуу хүүхэнд санаатай” гэхэд гээгт дорхноо сэтгэл уужирч гаансаа өвөртлөн “Золиг гэж! Нохойд уруулсан сорви одоо ч бий шүү” гээд гэрээр дүүрэн инээдэм болов. Андынхаа амин дээр байж уй гашуу болно гэсэн чинь харин найр наадамд ирсэн юм шиг хөгжилтэй болдог байна. Жав гуай тэдэнд:

- Муу Дэвхэргийн (өөрийн нь хоч) чинь амьд явах хоног аргагүй гүйцэж байна. Та нарыгаа нэг хараад үхье гэж шийдлээ. Үхэхийн өмнө нэг сайн наргиж, та нарынхаа дуулах хуурдахыг сонсьё. Урьдын цагт юм сан бол хойд насандаа уулзаж юу магад гэх сэн. Намайг та нар эс мэдэх биш. Үхэлгүй мөнх хорвоо дээр төрсөн биш хойно яая гэхэв. Алив үеэлээ чи хамраа харж уруу царайлж суулгүй наадах архи айрагнаасаа хий. Жаахан шар тос хөвүүлээд над ч гэсэн хийгээд аль! Муу дэвхэргээ алсын замд үдэж байна гэж бодоод л ууцгаа! Заавал хөдөөлүүлж ирчхээд уй гашуу тайлж байна гэж уух алба уу? Ямар ч гэлээ ухаантай амьсгаатай байгаа дээр нь амьд Жавтайгаа урьдынх шигээ наргиж байна гэж бодоод ууцгаа! гэж шахаж байв. Тэгээд хэлсэн ёсоороо шар тос хийж халаасан архи жаахан уучаад нүд нь гэрэлтэж ёнтгор шанаанд нь хүртэл цус туяарав. Үхэлгүй мөнх хорвоо дээр төрөөгүйгээ сайн мэдэх тэр хэд түншийнхээ үгийг аргагүй дагаж архи айраг ууцгаан дуу шуу болов. Найрын гурван дуутай асан гээгтэд ая барих алба тулгарч, гээгт хөөрхий минь, хуучин бууны хугархай гэдгээ үзүүллээ. Хөө тортог болсон сөөнгө дуутай морин хуурыг хөглөж амьсгаа тасалданги боловч сүрхий эршүүд баргил хоолойгоор:

Зэ жигүүртэй төрсөн маньд чинь  
 Жигтэй сайхан орон байвч  
 Жаргал зовлон алинд ч бол  
 Заяаныхаа хүчээр болдог бус уу

гэж дуулахад Жав гуайн хөгшин эргэнгэгийнхээ хажууд нулимсаа арчин буруу харж суув.

“Гээгт ч нээрээ залуугаараа байна. Өвгөн шувуу буцна аа гэж...” гээд Жав гуай шүүрс алдсанаа түрхэн зуурын гунигаа хөөн зайлуулж “Боргоцой чи тэр жил намайг яаж чадсанаа яриач” гэв. Боргоцой Дорлиг бугуйндаа алтан цаг зүүж, нүдэндээ сүүдэр шил зүүчихсэн дэгжин шовгор өвгөн ярихаасаа түрүүн хээг хээг инээгээд:

- Би багийн дарга, Жав ухуулагч, тэр зун алба ширүүнийг хэлэх үү. Дайны урьд жил шүү дээ. Залуу ч байж. Цэргийн агт, ноосны ноогдол гүйцээх гээд л бид



хоёр өдөр шөнөгүй айл хэсдэг байлаа. Тэгэхэд баг гэдэг чинь одоогийн сум шиг нутагтай, явж барагдахгүй. Нэг өдөр доод Хүрэмт орж явсан чинь зам дээр морио барьсан хүн хэвтэж байна. Хүрээд очтол мань хүн хурхирч хэвтдэг байгаа. Ер нь бөх унтжээ. Тэгэхээр нь шогломоор санагдаад морийг нь хөтлөөд алга болж өглөө. Мөн ч дүрсгүй байж дээ. Мань хүн нэг сэрэхнээ явгарчихсан байдаг. Хагас өртөө шахам хөлөө холготол мацаж айлд хүрсэн байсан. Сүүлд тэгж явгаруулснаа хэлээд алуулах шахсан сан гэв. Энэ мэтээр идэр залуугийнхаа элдэв явдлыг дурсалцана. Шумуул Жамц согтохоороо уйлдаг, биеэ хэчнээн баривч тэссэнгүй шүлсээ савируулж байгаад гингэнэтэл уйлчхав.

- Чи битгий хүн уруу татаад бай! Уйлж байгаа нь хүртэл өнгөнээд яг шумуул шиг гэж Жав гуайн шоолоход инээдэм болж харин ч гомдож орхисон Жамц,

- Чи хэзээнээсээ чулуу шиг хатуу сэтгэлтэй хүн. Үлдэх биднийгээ ч зөөлөн дорой улс гэж мэдэхгүй гээд гарч явахыг завдсанд,

- Үеэл минь! Би чинийхээ уян зөөлөн сэтгэлийг мэдэлгүй яах вэ. Тоглосон юм. Чи адуу хураагаад ирэхгүй юу, би нэг харъя гэж гуйв.

Жамц адуу хурааж гэрийн гадаа авчирсан хойно хүмүүс Жав гуайг ширдэг дээр дамжлан гаргажээ. Жаран хэдэн жил амьдарсан хорвоо ертөнц зуныхаа нэг сайхан өдрөөр түүнийг үдэн гаргаж байна уу? Наран хэвийж, агь гангын үнэр анхилмал зөөлөн бөгөөд бүлээн сэвшээ үхлийн өмнө зоригтой тайван бай гэж аргадан илбэж байх шиг. Нутгийн хөх ногоон гүвээ толгод униар дунд замхран үзэгдэх нь уужим боловч хүний насан хязгаартай ямархан жамтай ертөнц билээ гэмээр. Энэ нар, салхи, тэнгэр, гүвээ толгодоо сүүлчийн удаа харж байна гэж Жав гуай бодож байлаа. Жамцын хурааж авчирсан адуу тургилян бөөгнөрч аагаа багтааж ядсан унага даага тангаралдан чарлалдах бөгөөд харин нэг хөгшин буурал азарга сүргээс зайдуу зүүрмэглэн байна. Жав гуай түүнийг харж омголтсон зийвгэр уруулаа муруйлган инээвхийлж,

- Тэр буурлыг хараач! Мөн ч ястай адгуус юм сан. Муусайн байдсуудад гологдож үрээ шүдлэнд хажиглуулаад одоо ч больж дээ хөөрхий. Гэхдээ надаас л түрүүлсэнгүй дээ гэв. Чингээд хэдэн мөч өнгөрөхөд нар салхинд цочирдсондоо ч юм уу амьсгаа нь дээр гарч нүд нь жигтэйхэн хурцаар гялалзав.

- Үеэл ээ, уурганы минь хуйвыг тайлаад аль! гээд хуйваа Гээгтэд өгч,

- Чи залуу эхнэр авах санаатайгаараа үүнийг ав! Оонын хүзүүгээр хийсэн сайн хуйв шүү. Чадлаа үзүүлэхэд чинь хэрэг болно гэв. Дорлиг түншдээ сийлбэр нь балартлаа элэгдэж мөлийсөн жижиг гартаам хөөргөө “Ганган хүнд гархи нэмэр” гэж өгөв. Чингээд сүүлийн үгээ хэлсэн нь:

- Та нарыгаа, нутаг усаа, адуу малаа харж авлаа. Хэчнээн сайхан салж болмооргүй ертөнц боловч Гээгтийн дуулдаг өвгөн шувуу шиг буцах цаг болжээ. Жаран хэдэн жил дэлхийн тоос хөдөлгөж их юм үзлээ. Гомдол алга. Сайн ханьтай, голомт залгах хүүтэй, сайхан нөхөдтэй жаргаж явлаа. Ийм тийм юм дутуу дунд байсан гэж гажрах юм алга. Олны дунд л явлаа. Жамц минь чи сэтгэлээ барьж үз! (Жамц уйлсаар холдов.) Бид чинь ингээд л уван цуван хойд энгэртээ гарах улс шүү дээ. Жам юм хойно. Ямар манай монголын удам тасрахаар биш! Та нар минь тэгээд үр ач өнөр өтгөн жаргаж дэгжиж яваарай! За одоо боллоо. Гэрт минь оруулаад аль!

Жав гуай үүр шөнө хагацахын алдад насан өөд болжээ. (1970)

**Эх сурвалж:** (С.Эрдэнэ. “Наран тогоруу”. УБ., 1972, 280-289-р тал)



## ҮГИЙН ТАЙЛБАР:

**Самсаа** - хоншоорын хоёр хажуугийн бяцхан хонхор

**Цийдэм** - сүү зэргийг хольж цэгээн болгосон ус

**Хазаар** - морины толгойд өмсгөх амгай, зуузай, жолоо, цулбуур бүхий хэрэгсэл

**Ногт** - морины толгойд зүүх гархи зуузайгүй оосор

**Гөлөм** - монгол эмээлд байдаг тусгай бэлтгэгдсэн олом жирмийн халхавч жийрэг

**Эргэнэг** - юм хум агуулан тавих хорго сав  
**Хуйв** - хуйв уях оосор



## УНШСАНЫ ДАРАА

## СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Өвгөн шувуу” өгүүллэгийн эдэлж өнгөрөөсөн амьдрал, сайхан эх орон, сайн хань, голомт залгах хүү, сайхан нөхөдтэй жаргаж явснаараа бахархаж, үлдэх амьдралаа хайрлаж буй Жав өвгөний дүр сэтгэлийн баялгаараа өвөрмөц юм.

Жав бол хар амиа бодох атхаг муу сэтгэлгүй хүн. Ийм ч учраас түүнд хагацаж саламгүй сайхан амьдрал, сайн хань нөхөд заяажээ. Хүний сэтгэлийн баялаг сайхныг харуулсан энэ зохиол хүнд үхэж хагацахын жамыг бус хүн шиг зөв амьдарч жаргах сэтгэл төрүүлэхээр болсон нь монгол занг харуулах гэсэн зохиогчийн бодол эрмэлзэл хэрэгжсэнийг харуулж байна...”

(С.Жачин. “Уран чадварын увдис”. УБ., 2013, 144-р тал)



## Унших чадвараа хөгжүүлье

### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгое.

- Өгүүллэгт ямар асуудлыг дэвшүүлэн тавьсныг судлахдаа хам сэдвүүдээс сонгон ярилцаж, тайлан тайлбарлаарай. Ингэхдээ:
  - Зохиолчийн гаргасан ил ба далд санаа
  - Судлаач шүүмжлэгчдийн гаргасан санал дүгнэлт
  - Үе үеийн уншигчдын санал сэтгэгдэл
  - Өөр өөрсдийн санаа бодол зэргийг харьцуулаарай.



- Өгүүллэгийн нэр нь сэдэв, утга санаатайгаа хэрхэн холбогдож байгаа, зохиолч ямар сэдвийн хүрээнд ямар мэдээллийг өгч, ямар утгыг илэрхийлэхийг зорьсон талаар өөрийн дүгнэлт гаргаарай.

### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.

- “Гомдол алга” гэж Жав өвгөн юуны учир өгүүлсэн юм бол?





2. Жав гуайд харагдаж буй ертөнц чамд харагдаж байна уу? Ертөнцийн гоо сайхныг харахыг хичээгээрэй.
3. Жав гуайн туулж өнгөрүүлсэн амьдралыг зохиолоос сэргээн ярилцаарай.
4. Өгүүллэгийн гол баатар Жав өвгөний амьдрал байдлаас хорвоогийн жам ёс, хүний амьдралын зовлон жаргал, баяр гунигийг эргэцүүлэн бодож, өөрийн бодол санаагаа илэрхийлээрэй.
5. С.Эрдэнийн өгүүллэгт дараах сэдвүүд голлон цогцолсон байдаг. Үүнээс сонгон, өөрийн болон найз нөхдийнхөө дэвшүүлсэн сэдвүүдийг харьцуулан “Өвгөн шувуу” өгүүллэгийн сэдвийг тодохойлоорой.
  - *Монгол хүн, үзэсгэлэнт байгаль, тэдгээрийн хэлхээ холбоо, хүний амьдралын утга учир, баяр гуниг, алдаа оноо, зан заншил, ёс дэг, мөс жудаг, хайр сэтгэл, үзэн ядалт, хүсэл мөрөөдөл, бэртээгчин авир төрх, байгаль экологи, эх оронч сэтгэлгээ, үндэсний шинж төрх хийгээд бусад улс үндэстний хүн зоны амьдрал, хувь тавилан гэх мэт*

**Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.**

**ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:**

Зохиолд бүрэлдэж буй зан төрх, хэв шинж, уран дүрийн бүтэц, дүрслэх аргын бүтэц-байгуулалтын тогтолцоог бүхэлд нь зохиомж гэж хэлж болно. Зохиомжийг тодорхойлогч гол хүчин зүйлүүдэд хүүрнэл, тодорхойлол, хөрөг дүр, захидал, байгалийн зураглал, зохиолчийн тэмдэглэл, онцолбор, оруулга, үглэл яриа, дотоод яриа, харилцан яриа, ганцаарчилсан яриа, өчил, цохолбор, орхилт, тусгай тайлбар, зүүд зэрэг багтана.

1. Гэээгт өвгөний сонгож дуулсан “Өвгөн шувуу” дуу Жав гуайд сэтгэлийн тэнхээ өгч чадах уу? Зохиолын өгүүлэгдэхүүнтэй хэр холбогдож байна вэ?
2. Гурван найз өвгөний дүр нь өгүүлэмжийн ямар, ямар хэсгүүдийг бүтээж байна вэ?

**Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.**

1. Жав өвгөн үхлийг яагаад ийм тайван хүлээнэ вэ? Үхэхээс биш юунаас айж байна вэ?
2. Жав өвгөний бодсон бодол, хэлсэн үгийг түүвэрлэн бичээд, дүрийн талаар дүгнэлт хийж, утга санаанд нөлөөлсөн гэж үзэж байна уу? Түүний биеийн зовуурь хийгээд сэтгэлийн тэнхээг нь бататган тэмдэглээрэй.

Биеийн байдал

• .....

Үг хэл

• .....

Сэтгэл санаа

• .....

3. Зохиолд монгол хүний зан заншил, сэтгэлзүйн өвөрмөц онцлогийг хэрхэн гаргасныг судлаачдын санал дүгнэлттэй харьцуулан дүгнэн бичээрэй.
4. Үеийн гурван өвгөний дүрийн үүрэг юу байв? Эдгээр дүрийн нийтлэг болон тус, тусын ялгарч байгаа шинж юу вэ?

Өвгөдийн дүр	Ялгаатай тал	Нийтлэг шинж
Шумуул Жамц		
Боргоцой Дорлиг		
Гэээгт Найдан		

### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.

1. Жав гуай хэний төлөө юуны учир, юунд санаа зовж, юунаас айж, юунаас айхгүй байна вэ?
2. Жав өвгөн үеийн нөхдөө уриад хөгжилтэй, наргиантай байсан нь түүний ямар зан чанарын илрэл вэ?
3. Зохиолч энгийн зүйлээс ургуулан бодож, бясалган тунгааж, дүрийн дотоод сэтгэлийн нарийн нандин руу өнгийн үзэж, уянгын аясыг зохих газарт нь шигтгэн, дүрийг амьдруулж чадсан байна. Үүнийг жишээгээр батлан, тайлан тайлбарлаарай.
4. Байгаль ба юмсын дүрслэлээс түүвэрлэн авч, дүрийг тодруулахад ямар үүрэгтэй орсныг тайлан тайлбарлаарай.

Дүрслэл	Жишээ	Үүрэг
---------	-------	-------

Байгалийн дүрслэл

Юмсын дүрслэл

5. Байгаль, цаг уурын байдал нь дүрийн сэтгэл зүйд нөлөөлж байгааг баримтаар нотолж, дүгнээрэй.
6. Орчны, юмсын дүрслэлээс бэлгэдлийн утгатайг түүж бичээд, тайлан тайлбарлаарай.

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.

1. Жав өвгөний удаан өвдсөнийг илэрхийлсэн үг хэллэгүүдийг олж бичээрэй.
2. Өгүүллэгээс хэлц үгүүдийг түүж бичээд, зохиолд ямар үүрэг, зорилготой ашигласныг тайлбарлаарай.
3. “Өвгөн шувуу” дуу, буурал азаргыг ямар үүрэгтэй дүрсэлсэн бэ?
4. Дараах үг хэллэг, дүрслэх хэрэглүүрүүд зохиолд ямар үүрэгтэй орсныг тайлан тайлбарлаарай.
  - *Тэнгэрийг тооноор, газрыг үүдээр харах, утсан чинээхэн улаан амь, хаврын цагаан хагднаар, хадан гэртээ харих, долоон голтой амьтан, хүний тооноос хасах, амьсгаагаа хураах, зул дохиуртай хар цэцэг мэт, загсаасан өрөм нарны туяа шиг, газар хотойтол сууж мордож байсан уяа, хатуу эр, нүд халтирмаар, найр наадамд ирсэн юм шиг, хөгжөөнтэй, хуучин бууны хугархай, чулуу шиг сэтгэлтэй хүн, ястай адгуус, өвгөн шувуу буцах цаг болжээ, хойд энгэртээ гарах.*
5. “Өвгөн шувуу” гэсэн нэрэнд бэлгэдлийн утга байна уу? Байвал жишээгээр батлан, тайлан тайлбарлаарай.

С.Эрдэнийн өгүүллэгийн зохиолоороо хайдаг нэг үндсэн эрэл бол амьдралын утга учир, хүн болохын хэрэг зориг, ертөнцийн тухай эргэцүүлэл, ухаарал, тайтгарал, мөн чанар бөгөөд үүнд илүүтэй ихээр ашиглагддаг нэгэн өвөрмөц дүр бол өвгөдийн дүр байдаг. Үүнийг “Өвгөн хүн чулуу хоёр”, “Өвгөцүүл” гэх мэт өгүүллэгээс харьцуулан дүгнэлт гаргаж болно.



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. С.Эрдэнэ. “Наран тогоруу”. УБ., 2013
2. С.Эрдэнэ. “Миний эх орон миний тоонот”. УБ., 2013
3. С.Эрдэнэ. “Нарангарвуу”. УБ., 2013

## ЗОХИОЛЧ



### Сормууниршийн ДАШДООРОВ (1936 - 1999)

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт төржээ. “Талд татсан солонго”, “Миний ард түмэн”, “Говийн магтаал”, “Хүлэг”, “Тал бид хоёр” зэрэг яруу найргийн түүвэр, “Улаан гэрийн Юндэн” өгүүллэг, туужийн ном, “Нар хиртсэн жил” кино зохиол туурвижээ. 1971-1980 онд Монгол кино үйлдвэрт редактор, 1980-1982 онд Батлан хамгаалах яаманд эрдэм шинжилгээний ажилтан, 1983-1995 онд “Цог” сэтгүүлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байв. “Говийн өндөр” роман, “Өндөр ээж” кино зэрэг шилдэг бүтээлүүдээрээ 1975 онд Монгол улсын Төрийн шагнал, 1998 онд Ардын уран зохиолч цол хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- “Хүний мөс чанар гэж юу вэ?” гэсэн өгүүлбэрийн утгыг дэлгэрүүлэн ярилцаж, хүн чанартай байх утга бүхий хэлц үгсийг жагсаан бичнэ үү.
- Харилцааны талаарх монгол сэтгэлгээ, монгол ахуй, монгол соёлын талаар тунгаан бодоорой.



## УНСИХ ЯВЦАД

- Өгүүллэгийг унших явцдаа хүн чанар, ахас ихсээ дээдлэх монгол ухаан, ялангуяа насны эрхээр хүний хорвоогоос мордон буй өвөг дээдсээ нутаглуулахад ямар бэлгэдлийг эрхэмлэдэг монгол уламжлал байдгийг эргэцүүлээрэй.

### БУУЖ МОРДОХ ХОРВОО

(Өгүүллэгийн хэсэглэл)

Малд яваа талын хүн өндөр газар хүлгийн дөр мулталж, хол ойрын бараа харж суух дуртай санжээ... Эл удаа хонин сүрэг хаашаа ч гэлээ хошууран явахыг хориглон дороо тархан тогтохыг захиран дуугарлаа гэдгийг ухааран мэдсэн мэт налайжээ...

Төгөө хээрийн хоймор түгдийн завилж суусан биеэ цэхлэн, тамхиа татаж ханасан бололтой, гаансныхаа толгой дахь цогтой үнсийг гарзшаасан янзгүй хий үлээн хүүдийтэй тамхиа аанай л дадсан зангаараа баруун ар нуруундаа тээгээр нь бүсээ тэмтчин бөх гэгч нь хавчуулж, үдийн тунгалаг зэрэглээ бөөн бөөнөөрөө цогих тэртээ урдах буурал талын дунд бөртөлзөн цаашилж яваа морьтой хүний хойноос хараа тавив. Тэгээд өөртөө “Ангаа өвгөн ингээд явчихдаг байж... Нутгийн нуруутай хэдэн өвгөний нэг байлаа даа...” гэж өгүүлснээ ийш тийш ямар нэг юм чимээ чагнаж бараа харж сэлбэлзэн харснаа, маанийн шад бувтнан уншив...

Тэр мэдээ дуулгасан хүнийг Самбаа гэнэ. Самбаа ч мориноосоо буув. Төгөө ч түүнийг андахгүй хэн хэн нь ааш зангаа мэдэх улс авай. Эхээс энэ л зэрэглээ наадсан талд төрж эрийн цээнд хүрсэн цагаас уугуул нутгийн бараа ил, сүрэг малын бэлчээр нийлэн явдаг айлын эзэд болсон санж. Өнөө хэн хэн нь жаран

нэгнийхээ жилийг ардаа хийчхээд явж байгаа, залуус харчуудад өвгөд настан гэж хүндлүүлэн налайж суудаг насандаа ирсэн улс ажээ...

Төгөө, Самбаа хоёр дуу дуугаа авалцан, Хангай өвгөний тухай яриад байвал хонины нэгэн хишиг өдөр багадах мэт байлаа... Самбаа мориныхоо жолоог хумин мордож, цулбуураа барин явуулын хүнийг хүндэтгэн босож зогссон Төгөө рүү хандаж:

- Энэ хойд дээгүүр гараад ирсэн чинь, далай цагаан хонь налайн харагдахаар нь баярлаж л байлаа. Тэгээд ажсан чинь чи явж харагдана гэж өгүүлэн унааныхаа толгойг өмнө зүг залав...

Самбаагийн далай цагаан сүрэг дайралдлаа гэсэн үг учиртай байлаа. Монгол хүн ямар нэг яаруу тулгуу ажил хэргээр явж байхад халуун хошуут хонин сүрэг юм уу, адуу дайралдвал бэлгэшээн явдал хэрэг сайн сайхан бүтэхийн өлзий дэмбэрэл гэж үздэг ажээ. Тэгээд, Самбаа бэлгэ дэмбэрэл бодон тэр үгийг хэлжээ. Төгөө ч учрыг нь ухааран урамтай үлджээ...

Төгөөг орь залуу явахад Ангаа хэмээх Хангай гэж нарийхан нуруундаа шар ногоон дурдан ч юм уу бажгар өргөн гэгчийн ороож, хошмогтой цагаан тоорцог чихийг нь сөхөн өмссөн ануухан өндөр хар хүн байлаа. Нүд булаахааргүй ч товхийсэн мөнгөн тоногтой эмээл хазаар хэрэглэхийн дээр зун бол бэлгүй хэт зүүн, өвөл бол ясан савхтай үйсэн иштэй хутга бэл сэлттэй нь бүрэн зүүнэ. Тэрбээр адуутай дайралдвал унага дааганаас нь аваад азарга морьдыг нь шинжиж байдаг зантай, адуунд хайртай, сайн морь унах дуртай гялалзсан эр байлаа. Харсан үзсэн мал, дэл сул алдуул тааралдвал андахгүй, эрэл сурлын хүнд тус хүргэхийг нэр төрийн хэрэг мэт мөрдөн, ядарч зүдэрсэн хүнд тус дэм болохыг ариун үйл гэж баримтална. Харин морь малдаа ширүүн хүнд нүүр өгөх дургүй. Түүний эдэлж унасан морь нь хэзээд өнгөлөг, гундаж эцсэн явах нь нүдэнд үл өртөнө. Хартал талын салхи сөрөн дээлийнхээ сугыг хөөрөгдөн давхивал давхиж л явдаг, сольж юулж амжихгүй хэд хонож байвч тэгтлээ унаширч гундсан байх нь ховор. Тэгээд ч тэр үү нутгийн ихэс багагүй хүндэлнэ. Бүр хөгшид настан Хангайг үнэхээр морь унаж, эдэлж сурсан хүн гэж магтана. Төгөө залуу насандаа, Хангай шиг үеийн харчууд залуустай, түүн шиг морь малаа эдлэх сэн гэж яриан дундуур хавчуулж, морин толгой алдахгүй уургаа шидэхийг нь хүртэл бахархан хөөрч байсан нь зөндөө. Өнөө эргэн санавал Хангай сайхан эр явсан ажээ... Түүгээр үл барам Төгөө тийн нас намбын бараагүй цагтаа Хангайд нэг их тус болж баярлуулах юм сан гэж цээжиндээ бат санаж явсан цаг ч бий ажээ...

Энэ нутгийнхан талийгсдаа “Хөх-Өндөр” хэмээх өнчин өндрийн өвөр залуу энгэрт нутаглуулдаг ажээ. Тэр газар Төгөөгийнхөөс хагас өртөө шахам зайтай. Нэгэн хадтай дэл, хоёр зузаан гүвээ давахад л бараа нь харагдана. Нэгдлийн төв бол түүнээс цааш, бас хагас өртөө зайтай. Тэндээс л Ангаа өвгөний сүүлчийн аян замын цуваа наашилж Хөх-Өндөрт ирнэ гэдгийг Төгөө дотроо бодон түрүүхэн өдөр жил тоохон үзэж байснаа санах. Төгөөгийн сувай хонь тэр Хөх-Өндөрийн чиг бэлчин яваа харагдана. Нөгөө суурь нь өөр зүг толгой хандуулжээ. Нөгөө хоёр сүрэг хониныхоо алийг нь түрүүлж эргүүлэхээ шийдэж ядан гэлдрүүлэв. Тэгснээ гэнэт нэгэн мэргэн сайхан санаа олж өөртөө олзуурхан морио давиран нялх бага төл бүхий хонь уруугаа холхон айлын хэр шийдмэгхэн цогиулснаа морио татан алхуулав...

...Өглөө нь бараг үүр хаяарч байхад Төгөө хээр орхисон сувай хониныхоо барааг харахаар морио барин мордов. Үнэхээр, санаснаар нь салхи зүүн хойд зүгээс сэвэлзэж байлаа. Тэр, Хөх-Өндөрийн бараа харагдах хэц, нэгэн гүвээ даван



замдаа бэлчиж байсан баахан адууг хөөн өчигдөр хониныхоо бэлчиж байсан гүвээн дээр гарч ирлээ...

Хоногийн дараа үд хэвийж байхад Самбаа эргэж ирэв. Тэр, Төгөөд Ангаа өвгөнийг хэрхэн нутаглуулсан тухай яриа дэлгэн аанай л хөөргөө зөрүүлэн тамхилцгааж саатав. Тэр өгүүллүүн:

- Хөөрхий Ангаа буянтай хүн байсан нь үнэн байжээ. Газар газраас бишгүй хүн ирж, ах дүү, үр хүүхэд нь ч цөмөөрөө л байж байна. Чамайг би гэрээс гарч чадахгүй байгааг хэлсэн... Үгүй хө, өвгөнийг хөдөөлүүлэх гээд Хөх-Өндөр лүү явж байтал Хүрэн нурууны ард яг улаан зам дээр олон хонь налайж байдаг юм байна. Хэн хүнгүй л бэлгэ дэмбэрэл бодож байлаа. Бас тэгээд, яг чимээгүй газар дээр нь баахан адуу байж байдаг гэж байгаа... гэж баяртайгаар сонирхуулан өгүүлжээ. Төгөө ч түүний яриаг ихэд олзуурхан сонсов. Тэр ийм ч нэг мэдээ дуулах болов уу гэж горьдож байсан тул бүр ч олзуурхав. Самбаа бас,

- Өвгөний сүүлчийн замд халуун хошуутай мал дараа дараагаараа дайралдлаа гэж зөндөөн баярлан бэлгэшээж байна билээ. Хэр шүү дээ. Тийм явдал ховор байдаг юм гэнэ билээ... гэж ярьжээ.

Энэ яриа Төгөөд тун таатай санагдаж байлаа. Тэр дотроо, “За яамай! Хөөрхий өвгөнийг баярлуулах гээд чадаагүй хүн би. Үлдэж байгаа улсыг нь бага ч болов баярлуулсан бол болох нь тэр. Хүн өөрсдөө мэдэхгүйгээс биш бие биендээ хэчнээн их өртэй байх юм бэ дээ. Өвгөний замд хонь мал байлгая гэж бодсон маань онох нь онож... Хэн намайг тийн хичээснийг минь мэдэв л гэж. Мэдээд ч яах юм билээ. Бас мэдүүлээд ч яах билээ” гэж бодож суув.

(1986)

**Эх сурвалж:** (С.Дашдооров. “Нуур нуурын шувууд”. УБ., 1991, 331-346-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Хошмог** - юмны зах хормойгоор янзалж хөвөөлсөн эмжээрийн дотуур нарийн хосолсон хош мөшгөөр

**Тоорцог** - чих, саравчгүй, бөмбөгөр оройтой малгай

**Хэт** - ган суулгасан саран сүхний хэлбэртэй төмөр дээр уул, цахиур агуулах зориулалт бүхий ширэн сав

хадаж, сэнж оосор гаргасан, гал ноцоох хэрэглэл

**Гүвээ** - уртлаг гүвгэр газар, намхан нуруу

**Цогиулах** - морь малыг цогио явдлаар явуулах

**Хэц** - уул нуруу, хад асгын цавчим өндөр, огцом налуу газар



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Энэ бол монгол сэтгэлгээнд байдаг, монгол ахуйд байдаг, монгол хүний сэтгэл зүйд тогтсон үзэл, бэлгэдэлт санаа юм. Халуун хошуутай мал орж ирэхэд ихэд бэлгэшээж тухайн үйл хэрэг, түүнийг дагалдан яваа хүмүүсийн сэтгэл зүйд туйлын амгалан тайван санагддаг байна. Ингэж монгол сэтгэлгээг ашиглан зохиолд дүрсэлж буй нь түүнийг жинхэнэ үндэсний онцлогтой, өвөрмөц сэтгэлгээтэй болгох гол баримжаа нь болж ирдэг юм...”

(XX зууны Монголын уран зохиол. УБИС. УБ., 2017, 418-р тал)





### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгое.

1. Өгүүллэгийг бүрэн эхээр нь уншаад, мэдэхгүй үг хэллэгээ тольчлон тайлбарлаж, өгүүллэгийн гол утга санааг тунгаан, үйл явдлын дарааллыг ярилцаарай.
2. Зохиолд ямар асуудал дэвшүүлэн тавьсныг судалж, тайлан тайлбарлаарай.
3. “...Өгүүллэгт хөдөөх ахуй орчин, тэнд амьдрах хүмүүсийн үзэл бодол, ёс зүйн хэм хэмжээ, итгэл үнэмшил, сайны хэмжүүр, тэдгээр нь амьдралын нь хэвшилд хэрхэн илэрдэг тухай тус хүргэх эрхэм үзэл санааны үйлдлээр илэрч байдаг...” (“XX зууны монголын уран зохиол”, УБ., 2017, 418-р тал) хэмээн дүгнэн бичсэнийг өөр өөрийн бодол санаатайгаа харьцуулан, жишээгээр батлаарай.

### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.

#### ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:

Сэдэв: Зохиолчоос тухайн зохиолыг бичих болсон үүдэл санааны товлогдсон хэлбэр, бичиж туурвихын шалтгаан нь мөн. Тодорхой нэг зохиол олон тооны жижиг сажиг явдлуудаас бүрддэг тул тэдгээр явдал бүрд өөр өөрийн гэсэн бичил сэдвүүд байхын зэрэгцээ бичил утгууд бүрэлдэн агуулагдаж байдаг. Сэдэв зохиол бичигдэхээс өмнө зохиолчийн сэтгэл санаанд бий болдог. Энэхүү тов төдий атлаа гүн бүтэцдээ өргөн агуулгыг хураасан амьд үйл явдлын цогцолбор ойлголтыг сэдэв гэнэ.

1. “Бууж мордох” гэсэн үгийн утгыг дэлгэрүүлэн, яагаад “Бууж мордох хорвоо” гэж нэрлэснийг ярилцаарай.
  - Буух, мордох гэдэг үгийн утга юу вэ?
  - “Бууж мордох” гэж ямар үед хэрэглэх вэ?
  - Буухын цаана, мордохын цаана ямар утга, ойлголт байна вэ?
  - Үдэлж, буухтай холбоотой ямар ойлголт мэдэх вэ, ямар зохиол уншсан бэ?
2. Зохиолын эхэнд малд яваа Төгөө өвгөний тухай хэрхэн хүүрнэн өгүүлсэн бэ?
  - Төгөө өвгөн хээрийн хойморт суугаа байдал
  - Төгөө, Самбаа хоёрын харилцан яриа
  - Ангаа өвгөний амьд сэрүүн үеийн агшнуудыг сэргээн босгож байгаа байдал зэрэгт дүгнэлт хийгээрэй.
3. Төгөө өвгөн яагаад чимээ чагнан, бараа харж байгаад маанийн хэдэн шад уншина вэ? Өвгөн ганцаараа овоон дээр сууж байж юуны учир тийм хянамгай байна вэ? Мөн “Ханцуй дотроо залбирлаа” гэдэг хэлцийн утга зэргийг ухааран бодож, хам сэдвийн далд утгыг тодорхойлоорой.
4. “... нугалж суусан өвдөгний ойр гарт өртсөн жижиг жижиг чулуу хэд гурваар нь түүн нойтон алган дотроо өнхрүүлэн эрих мэт нэг нэгээр нь имрэн сэлгэсэнээ, ганц ганцаар нь эрхий хуруун дээрээ гарган нясалж саатав...” гэсэн хэсгийн далд утгыг эргэцүүлэн тайлбарлаж, дүгнэлт гаргаарай.






5. Самбаагийн “Далай цагаан сүрэг тааралдлаа” гэж хэлсэн нь ямар учиртай вэ?
6. Өгүүллэгт монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээ болон зан үйлийн тухай өгүүлжээ.
  - Насан өөд болсон хүний тухай
  - Хөөрөг зөрүүлэх ёсон
  - Үрс гаргах ёсон гэх мэт ёс заншлын холбоотой зүйлүүдийг зохиолоос олж, дүрд хэрхэн нөлөөлж байгаа зэргийг дүгнээрэй.

**Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.**

1. Эшлэл өгүүллэрийг уншаад, зохиолчийн санааг дүрийн үзэл бодолтой холбон тайлбарлаарай.



2. Төгөө өвгөн “...Хүн өөрсдөө мэдэхгүйгээс биш бие биедээ хэчнээн их өртэй байх юм бэ дээ” гэж хэлсний утга учрыг тайлан тайлбарлаарай.
3. Төгөө өвгөнийг монгол өвгөдийн нийтлэг дүр гэж үзвэл ямар, ямар шинж байгааг баримтаар батлаарай.
4. Дараах асуултын дагуу ярилцаж Ангаа өвгөний дүрийн хэв шинжийг тайлбарлаарай.
  - Ангаа өвгөний насан туршийн гол зарчим юу байв?
  - “...Нэг их нэр заргүй хэрнээ, түмэнд нүүрийн буянтай хүн байж дээ...”, “...Төрийн нуруу төвшин хүн явж дээ гэснээ “Энэ малд мөн ч нүдтэй сэн...” гэсэн дүрслэлийн утга учир вү вэ?
  - Хангай Сад руу хандаж “...Адуу чинь өснө өө! Энэ сүргийг чинь эдлэх эзэн нь ирсэн байна шүү” гэжээ. Энэ үгэнд Төгөө Хангайд жигтэйхэн баярласны учир юу вэ? Энд Ангаа өвгөний дүрийн ямар чанарын илрэл байв?

**Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.**

1. Баян Садын эзлэн дээр өрнөж буй явдлыг, Төгөө өвгөний сэтгэл санааны хувирлыг ямар, ямар үг хэллэгээр илэрхийлснийг олж тайлан тайлбарлаарай.
2. “... Бид тэнд сүүлийн удаа хөөргөө зөрүүлэх учиртай байж дээ” гэж харууслаа илэрхийлэн үглэж, хангай өвгөнийг хүндэтгэн явдаг сэтгэлээ нээн мориноосоо буужээ...” гэсэн нөхцөл байдал, орчны дүрслэлээр Төгөө өвгөний дүрийг хэрхэн тодруулав?
3. Санаж сэдсэн сайн үйл нь бүтэх эсэхэд эргэлзсэн Төгөө өвгөний дотоод сэтгэлийг ямар үг хэллэгээр илэрхийлэв? Түүнээс үүдэн Төгөө өвгөн ямар

байдалтай байв? Төгөө өвгөний дүрийн хамгийн нандин тал юу байв? Баримтаар дэлгэрүүлэн дүгнээрэй.

- Ангаа өвгөнийг нутаглуулах гээд явах үеийн орчныг нүдэндээ төсөөлөөрэй.

### ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:

Зохиолын баатрын зан төрхийн давтагдашгүй шинж, онцлог хийгээд хэв шинжийг ялгаруулан товойлгох, бие даасан зан чанар, үүрэг зорилго бүхий амьд хүн буюу уран сайхны дүр болж төлөвшихөд нь шаардлагатай бүх зүйлс, бусад дүртэй харьцах, бусад дүрийн нийтлэг ба онцлог талыг тодруулахад чиглэсэн баатруудын холбоо хэлхээ, дүрийн өсөлт, зан араншин, үйл хэрэг, сэтгэл санааны байдал, амьдралын орон зай, зөрчил тэмцлийг өрнүүлж шийдэхэд тохирсон, уран сайхны аргаар бүтээсэн орчин ахуйн хүрээллийг нөхцөл байдал гэнэ.

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж, үнэлье.

- Төгөө, Самбаа хоёр өвгөн насаар ялимгүй ах Ангаа өвгөнд хандаж байгаа хандлага, ёс зүйг илэрхийлсэн бичил дүрслэлүүдийг олж, тайлан тайлбарлаарай.
- Өгүүллэгт “...Нүдэн дээр хэлтгий гишгэж, сонорт нь муруй зөрүү үг дуулгахаасаа эмээж явдаг” гэсэн үг ямар утга учрыг агуулж байна вэ? Санааг нь дэлгэрүүлж өөрийн зан чанарт дүгнэлт хийгээрэй.
- Төгөө өвгөн оршуулгын цувааг амдуулан хонин сүрэг, адуун сүрэг хоёроо тууж оруулдгийн утга учир юу вэ? Ямар бэлгэдэлт санаа байгааг тайлан тайлбарлаарай.
- Өгүүллэгээс хэвшмэл болон өвөрмөц хэлцүүдийг түүвэрлэж, ямар санааг товч илэрхийлэв? Утгыг нэмэн дэлгэрүүлбэл ямар санаа цаана нь байгааг тайлан тайлбарлаарай.



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

- С.Дашдооров. “Хөдөөгийн мөнгөн сар”. УБ., 1989
- С.Дашдооров. “Нуур нуурын шувууд”. УБ., 1991

#### ЗОХИОЛЧ



#### Лувсандоржийн ӨЛЗИЙТӨГС

1972 онд Дархан-Уул аймагт төржээ. 1996 онд “Монгол мэдлэгийн их сургууль”-ийг судлаач мэргэжлээр төгссөн.

“Тэргүүн бүлэг”, “Тэнгэрт ургадаг модод”, “Ганцаардлын дасгал”, “Төсөөллийн ерөөнд”, “Миний гунигийн түүх”, “Эрх чөлөөтэй байхын урлаг буюу Шинэ ном”, “Нүдний шилэнд үлдсэн зургууд”, “Үзэхийн хязгаар”, “Хотын үлгэрүүд”, “Толинд туссан будда” зэрэг номууд хэвлүүлжээ. Зохиолч, орчуулагч Г.Аюурзанатай хамтран “Монголын сонгомол өгүүлэг”, “Дэлхийн сонгомол яруу найраг”, “Дэлхийн сонгомол өгүүлэг” зэрэг хамтын бүтээл хэвлүүлжээ. 2002 онд “Эрх чөлөөтэй байхын урлаг буюу шинэ ном” номоороо “Алтан өд” шагнал, 2004 онд МЗЭ-ийн шагнал хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Зохиолчийн уран бүтээлийн арга барил, өвөрмөц онцлог гэж юу вэ? Харилцан ярилцаарай.
- Реалист бус өгүүлэмжтэй зохиол өмнө нь уншиж байв уу? Энэ талаар бодож уншаарай.
- Та нар өөрийгөө ямар нэгэн амьтанд хувирснаар төсөөлж байсан уу?



## УНШИХ ЯВЦАД

- Зохиолыг уншихдаа одоогийн нийгмийн амьдрал, хүмүүсийн дүр төрх, мөн чанартай харьцуулж, дүн шинжилгээ хийхдээ өөр өөрсдийн үзэл бодлоо илэрхийлээрэй.

## АКВАРИУМ

(Өгүүллэгийн хэсэглэл)

I.

Би энд яг нэг жил болж байна. Хүүхэн болгон атаархаж, хүн болгоны магтдаг байсан зөөлөн, булбарай арьс минь одоо хэдийнээ улаан ягаан толботой, хатуу хайрсан бүрхүүл болон хувирчээ. Жил, яг нэг жил... Хүмүүс намайг загас гэж бодох болсоор яг жил болж байна. Хүмүүс ч гэж дээ, үнэндээ бол төрсөн хүүхдүүд маань надаар зугаацах болсоор гурван зуун жаран таван хоног өнгөрөөд байгаа хэрэг.

Энэ аквариумыг худалдан авч байхдаа би өөрийнхөө авсыг бэлдэж байна гэдгээ мэдээгүй юм. Мэдээж, үүнийгээ хэрэв мэдсэн бол арай томхоныг сонгох байлаа. Би угийн бачимдуу хүн. Энэ жижигхэн аквариум байтугай дөрвөн өрөө сууц маань, хүн болгон саруулхан, томыг нь бахдан хэлэлцдэг албан тасалгаа маань, цаашлаад дуу шүлэг бүхэнд хязгааргүй хэмээн магтагддаг Монголын өргөн тал, дуусахгүй мэт үргэлжилдэг цэлийсэн уудам нутаг маань надад багадаад байгаа юм шиг санагдан үргэлж л давчдаж явдаг байлаа. Надад бусдаас илүү, хамаагүй илүү орон зай хэрэгтэй байсан юм.

Хүсээд байсан орон зай маань харин энэ бяцхан аквариум байж гэдгийг зөгнөж мэдэх нь байтугай зүүдлээ ч үгүй явтал бурхан миний өмнөөс бүгдийг шийдчихдэг байна шүү. Аквариум. Миний тэр орон зай, хүсэл гэдэг маань ийм л хэмжээний юм байж шүү дээ.

Охин маань аквариумаа гоёх гэж, миний хэдэн жил хичээн байж цуглуулсан гоёмсог дун хясаануудыг өөрийн минь дээрээс нэг нэгээр нь цүлхийтэл хийж эхлэхэд би анх сэргж, ухаан орсон юм. Урд нь бол миний алганд элбэгхэнээ багтдаг байсан далайн бяцхан яснууд одоо надаас хэдэн арван хувь том болжээ. Би сандарч, нуулгүй хэлэхэд үхтлээ айж, ийш тийшээ үсчиж эхлэв. Үсчих тусам миний жаахан охин өхөөрдөм хөөрхнөөр инээд алдан хясаануудаа дээрээс минь шиднэ. Ээжийнх нь айдас бүр хайртай охиныг нь баярлуулна. Бурхан минь! Та юу хийчхэв ээ?

Үгүй ээ, үгүй, үнэндээ бол энэ түүний хийсэн ажил биш. Бурхан үүнд ер хамаагүй угаасаа бурхан юунд л хамаатай байдаг билээ дээ. Энэ бүгд ердөө л Замзагийн хийсэн ажил. Би Кафкагаас ч илүү Замзад хайртай байдаг юм л даа. Хүүхэд байхдаа би Квазимодод хайртай байсан. Магадгүй Квазимодо намайг Замза руу ийм хүчтэй түлхсэн ч юм билүү. Аль эсвэл тэр Замза гэдэг нь ... Мэдэхгүй ээ, мэдэхгүй. Юутай ч би унтахдаа Замзагийн нэрийг шивнэж байснаа л санаж байна. Сэрээд хартал энэ. Энэ бүхэн.

Харин тэр намайг эмэгтэй юм болохоор, тэгээд бас нэлээдгүй сэжигч юм

болохоор жаран хөлт биш алтлаг хайрстай, бяцхан бүлтгэр загас болгочхож. Хорхой шавжаас учиргүй айдгийг минь ч бас бодолцоо биз.

Замзагаас ялгаатай өөр нэг юм бас бий. Манай гэрийнхэн намайг загас болсныг мэдэхгүй байгаа юм. Нэр минь сураггүй алга бологсдын дунд бичээтэй, цагдаагийнхан маш хүчтэй эрэл хайгуул хийсэн, хөөрхий нөхөр маань хамаг хөрөнгөө тэр эрэлд зарцуулсан, шөнө болгон тэр ганцаархнаа шил архи уудаг, уух болгондоо миний нэрийг шивнэн, шивнэн уйлдгийг би мэднэ. Бүр уйлдаг юм шүү. Энэ нь намайг бага ч атугай тайвшруулж байлаа.

Ах дүү нарын тухайд ч гомдолтгүй. Тэд урьд нь жилдээ нэг л удаа, тодруулбал, цагаан сараар л нэг үзэгддэг байсан бол одоо бараг өдөр бүхэн ирцгээдэг, бүр цагийн хуваарь гаргачихсан, ээлж ээлжээр ирж, хоёр хүүхдийг маань эргэж тойрч, асарч сувилдаг болсон...

Загасанд нулимс байдаггүй гэлцдэг нь огтоос худал шүү. Надад хайртай хүн өчнөөн олон бий, тэд миний төлөө юу ч хийхэд бэлэн гээд бодоход нулимс ч багадмаар юм билээ.

Үүнчлэн надад тайвшрах юм зөндөө. Гэсэн ч сэтгэл зовоох юм түүнээс олон байсан нь мэдээж. “Загас авч өг” гэж байнга шалдаг байснаараа охин л намайг асарч тойлно. Тэр зургаахан настай байсан болохоор усныхаа халуун хүйтнийг ч тохируулж мэдэхгүй. Бас нэг удаа хоолны оронд үзэгний хар бэх хийгээд арай л ээжийгээ алчхаагүй... Тиймээ, би загас болсон нь миний хувьд төдийгүй манай гэрийнхний хувьд жинхэнэ хувирал боллоо. Нөхөр маань хорин жил үхэн хатан зүтгэж байж хүрсэн өндөрлөгөөсөө буув. Өөрөөр хэлбэл, тэр намайг үргэлж бухимдуулдаг байсан өнөөх завгүй, даргын ажлаа бүрмөсөн орхив. Энэ үнэхээр, үнэхээр таатай, хамгийн таатай мэдээ байсныг нуугаад яахав. Тэр маань охиноо тэврэн сууж байгаад яг аквариумын дэргэд энэ тухай ярив. “Аав нь одоо охинтойгоо үргэлж хамт байна. Ахиж ажилдаа явахгүй” гэж хэлэхэд нь би арай л уснаасаа үсрээд гарчихсангүй.

Хүү маань хэдийнээ үймүүлэхээ больжээ. Тэр хэзээ ч миний үгэнд орж байгаагүй юм. Хэтэрхий дураараа, 12 настай хүүхдэд баймааргүй хэвлүүн яриатай хүүтэйгээ би огт таардаггүй байсан юм л даа. “Хичээлээсээ өнөөдөр оройтолгүй ирээрэй” гэхэд оройтно. “За яахав, өнөөдөр хичээлээ тараад гадаа тогловол тогло доо” гэхээр ороод ирнэ. Түүний зөрүүд зан намайг галзууруулах дөхдөг сөн. Гэтэл одоо тэр, Тэр биш болжээ. Нэг л биш...

Охин бол бүр ч өөрчлөгдсөн. Тэр өдөржин загастайгаа (хөөрхий, ээжтэйгээ л гэсэн үг) ярьж өнжинө... Харин одоо бол айл амьтны ах дүүсийн өрөвдсөндөө өгсөн хэдэн чихрийг огт идэхгүй, юунд ч юм хурааж цуглуулах болжээ. Энэ бүх хувирал, дандаа сайнаар эргэсэн хувирал надад даанч таалагдаж байлаа.

Аквариум маань эхэндээ нэг л давчуу, харанхуй, зэврүүн санагдаж байснаа сүүлдээ дасаад ирэв бололтой, давчуу биш, харанхуй биш, зэврүүн биш болоод ирэв... Нэг удаа би шилэн хоргонхоо хамгийн дээд хэсэгт очиж байгаад, уснаас хар чадлаараа толгойгоо цухуйлгаж байгаад, охиныхоо өөдөөс бүлтийтэл ширтэв. Намайг таньж магадгүй гэж горьдсондоо л тэр. Гэтэл тун санаандгүй юм болов. Охин өөдөөс минь учиргүй ширтэж байснаа “Алтан загас аа, чи миний гурван хүслийг биелүүлээд өгөөч!” гэж үнэн сэтгэлээсээ гуйх нь тэр.

Тэгээд, ийм гурван хүсэл шивнэлээ. Нэгдүгээрт, манай ээжийг авсан ах буцааж өгөөч! Хоёрдугаарт, ээжид миний цуглуулгыг аваачаад өгөөч! Гуравдугаарт, би ээжийнхээ өвөрт унтмаар байна!

Миний зүрх эмтрэх шиг болов. Тийм дээ, загас ч бас зүрхтэй байдаг юм шүү.

Тэр нэг ч удаа миний тухай ааваасаа асуугаагүй, бас намайг санаж уйлаагүй болохоор би санаа зовохгүй байсан юм. Гэтэл... Хөөрхий нялх үр минь...

Тэр намайг яагаад өөр ахтай хамт яваад өгсөн гэж бодсоны учрыг харин би бодоод, бодоод олсонгүй. Харин цуглуулга гэдэг нь өнөөх чихрүүд л дээ.

Би охиноо хэмжээлшгүй ихээр өрөвдөж байлаа. Гэвч загас бол загас шүү дээ.

Тэр ярьж чадахгүй. Ярилаа гэхэд, та бод доо, хэн нэгнийг өрөвдөж байгаагаа хэллээ, ярилаа, илэрхийллээ. Тэгээд? Тэгээд л болоо. Үнэндээ тэгээд л болдог шүү дээ. Ихэнх хүн өөрийнхөө зовлонгоос илүү гарч чаддаггүй. Тийм болохоор хэлэх хэлэхгүйн хооронд ямар ялгаа байна аа?...

Аквариумын загас юм боддог уу? гээд та өөрөөсөө асуу л даа. Инээд чинь хүрнэ. Бас тэр бяцхан амьтад гунигладаг, ганцаарддаг, уйддаг гэвэл таны бүр хөхөөс хөх инээд хүрнэ биз дээ. Би үнэхээр гуниглаж, ганцаардаж, уйдаж байв. Гэвч үүнийг маань хэн ч мэдэхгүй байгаа нь л хамгаас, хамгаас, хамгаас харамсалтай, хамгийн тарчлаантай байлаа.

Өдөр хоног өнгөрсөөр нэг л мэдэхэд би гунигтаа, хүмүүн бусын ганцаардалдаа, басхүү ер бусын уйдлалтандаа дасаж орхив. Ерөөсөө дасна гэдэг ганц хүний ч биш бүхий л амьтны зан бололтой...

(2002)

Эх сурвалж: (Л.Өлзийтөгс “Нүдний шилэнд үлдсэн зургууд”. УБ., 2004, 5-15-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Аквариум** - загас болон далайн амьтан өсгөж эржүүлдэг усаар дүүргэсэн шилэн хорго

**Кафка** - Австрийн зохиолч Франц Кафка  
**Замза** - Франц Кафкагийн “Хувирал”

өгүүллэгийн гол дүр Грегори Замза  
**Квэзимодо** - XIX зууны Францын алдарт зохиолч В.Гюгогийн “Парисын дарь эхийн сүм” романы дүр



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Л.Өлзийтөгсийн өгүүллэгт: “Би угийн бачимдуу хүн. Энэ жижигхэн аквариум байтугай дөрвөн өрөө сууц маань, хүн болгон саруулхан, томыг нь бахдан хэлэлцдэг албан тасалгаа маань, цаашлаад дуу шүлэг бүхэнд хязгааргүй хэмээн магтагддаг Монголын өргөн тал, дуусашгүй мэт үргэлжилдэг цэлийсэн уудам нутаг маань надад багадаад байгаа юм шиг санагдан үргэлж, давчдаж явдаг байлаа. Надад бусдаас илүү, илүү хамаагүй илүү орон зай хэрэгтэй байсан юм” хэмээн гарч буй нь монгол хүний тал нутагт эрх дураар өсөн хүмүүждэг онцлог хот суурин газар ирснээр өөрчлөгдөн бачимдаж үүнийгээ дагаад монгол хүний дотоод мөн чанар нь өөрлөгдөж байгааг тусгажээ.

Зохиолчоос энэ хэсэгт гаргасан үндсэн утга санаа нь орчин цагийн хот суурин газрын хүмүүс өөрсдийгөө аквариумд амьдарч дөрвөн ханан дунд хорьж, тэр нь яг л шилэн хоргонд хоригдсон баатрын нэг адил орчноо мэдрэх нь хагас дутуу, эрх, эрх чөлөө нь хаагдсан орон зайн тухай өгүүлэмж юм...”

(Б.Надмид “Ф.Кафкагийн “Хувирал” болон Л.Өлзийтөгсийн “Аквариум” өгүүллэгүүдийн харилцан хамаарал”. Монгол судлалын чуулган, УБ., 2016, № 21 (56), 185-186-р тал)





### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.

1. Өгүүллэгийг бүрэн эхээр нь уншаад, гол утгыг хүн бүхэн өөр, өөрийн итгэл үнэмшил, бодол санаагаа тайлбарлан ярилцаарай.
2. Өгүүллэгт нэр өгье гэж бодвол ямар нэр өгч болох вэ?
3. Зохиолч өнөөгийн монголын нийгмийн амин чухал асуудлыг хэрхэн хөндсөнийг зохиолоос эш татан, дэлгэрүүлэн тайлбарлаарай.
4. Өгүүллэгийн сэдэв, хам сэдэв юу бол? Хэдий үед бичигдсэн, тэр үеийн болон өнөөдрийн нийгэмд эмэгтэй хүний эзлэх байр суурь ямар байгаа талаар дүгнэн ярилцаарай.
5. Өмнөх ангид үзсэн постмодернизмын тухай ойлголтоо дэлгэрүүлэн ярилцаарай.

### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.

1. Ээжийг алтан загас болгож, загасны хэл яриа, дуу авиагүй шинжийг сонгосны учрыг тайлбарлаарай.
2. *"...Ямар нэгэн юмаа алдаад эргүүлэн олж авсан хүн түүнийгээ алдахыг хүсдэггүй шүү дээ..."* гэсэн өгүүлбэрийн утга санаа зохиолын агуулгатай хэрхэн холбогдож байгааг тайлан тайлбарлаарай.
3. Өгүүллэгээс ертөнцийг үзэх үзэл, гүн ухаарал бодролыг илэрхийлсэн санааг дүгнэн бичээрэй.

### Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.

1. Өгүүллэгт ээжийн зүүд зохиомжийн ямар үүрэгтэй орсныг тайлбарлаарай.
2. Зохиолын гол баатар бүсгүй өгүүллэгийн эхэнд *"...Энэ аквариумыг худалдан авч байхдаа би өөрийнхөө авсыг бэлдэж байна гэдгээ мэдээгүй юм. Мэдээж, үүнийгээ хэрэв мэдсэн бол арай томхоныг сонгох байлаа..."* гэж бодож байсан бол төгсгөлд *"...Би удаан бодлоо л доо. Тэгээд ахин загас болохоор шийдээд байна. "Аквариум жижиг байх тусмаа сайн" гэж би Замзад хэлсэн..."* –ний учир юу вэ? Үүнийг та бүхэн хэрхэн ухаарч байна вэ?
3. *"...Хүн болгон л хоёр дүртэй аж. Үнэндээ тэр хоёр дүрийнхээ нэгийг нь л бусдад харуулахад хангалттай. Хэн ч өөрийнхөө сайн сайхан гэж бодсондоо буй болгосон тэр дүрээ л бусдад харуулахыг хүсдэг, түүгээрээ л баг хийж явдаг. Хоёр дахь нь хэдий өөр байлаа ч, бусдад харуулахыг хүсч байгаа тэр багаар нь л хүнд хандах хэрэгтэй юм байна. Заавал багийг нь хуулах гээд, нөгөө, жинхэнэ дүрийг нь үзэх гээд байх хэрэг юу байна аа?..."* гэсэн хэсэгт зохиолч ямар санаа дэвшүүлсэн байна вэ? Хүнд хуурамч дүр хэрэгтэй юу? Дүгнэн хэлэлцээрэй.

### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжиле.

1. Зохиолын орчин ямар байна вэ? Зохиолд ямар, ямар орон зайг дүрсэлснийг баримтаар баталж, тайлбарлаарай.
2. Зохиолч дүрээ яагаад аквариумд хийв? Яагаад ийм орчин, нөхцөл байдлыг сонгосон талаар ярилцаарай.





3. Эмэгтэйг загас болон хувирсан хойгуур хүү, охин, нөхөр гуравт ямар өөрчлөлт гарсан бэ? Тэдгээр дүрслэл, зураглалын хэсэг та бүхэнд хэр итгэл үнэмшилтэй санагдаж байна вэ?
4. Жаахан охины цэвэр ариун, гэнэн хонгор зүрх сэтгэл, өрөвдөн хайрламаар байдлыг хэрхэн дүрсэлснийг баримтаар батлан тайлбарлаарай.
5. Зохиолын гол баатар эмэгтэйн жирийн амьдралын болон зүүдний орчныг харьцуулан дүгнэлт гаргаарай.
6. Орчны өөрчлөлтөөс дүрийн бодол санаа, үйлдэл, үзэл бодол хэрхэн өөрчлөгдөж байгааг баримтаар нотлоорой.
7. Зохиолч дүрүүдийнхээ дотоод ертөнц дэх хувирал өөрчлөлтийг хэрхэн дүрсэлсэн бэ?
8. Дүрүүдийн хоорондох сэтгэлзүйн уур амьсгалыг тодруулсан хэсэг хаана илэрч байгааг ялган тэмдэглээрэй.
9. Ээдрээтэй, зөрчил тэмцэлтэй орчин, цаг хугацааны хоёр өөр нөхцөл болоод зан төрхийн хамаарлыг харьцуулан тайлбарлаарай.

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.

1. Яагаад эмэгтэйг “...алтлаг хайрстай, бяцхан бүлтгэр загас” болгож дүрсэлсэн бэ? Зохиолчийн ямар санааг чухалчлан үзсэнийг таамаглан ярилцаж, батлаарай.
2. “...Би угийн бачимдуу хүн... Үргэлж, үргэлж л давчдаж явдаг байлаа... Надад бусдаас илүү, илүү, хамаагүй илүү орон зай хэрэгтэй байсан юм. Үгүй ээ үгүй... Мэдэхгүй ээ мэдэхгүй... Би үнэхээр гуниглаж, ганцаардаж, уйдаж байв. Гэвч үүнийг маань хэн ч мэдэхгүй байгаа нь л хамгаас, хамгаас, хамгаас харамсалтай, хамгийн тарчлаантай байлаа...” гэсэн хэсгээс үзэхэд Л.Өлзийтөгсийн хэл найруулгын уран чадварт уран давталт ямар үүрэгтэй, хэр зохимжтой байгаад дүгнэлт хийж, тайлбарлаарай.
3. Өгүүллэгийн хэл найруулга, дүр дүрслэлийн уран чадварыг илтгэх үг, өгүүлбэрийг сонгон авч, яагаад сонгох болсноо найз нөхөдтэйгөө ярилцаж, санаа бодлоо солилцоорой.
4. Зохиолын гол баатар эмэгтэйн үзэл бодол, амьдралд хандах хандлага, амьдралын утга учир, хорвоо ертөнцийн мөн чанарыг ухаарч ойлгох ойлголтод эргэлт гарсан уу? Та бүхэн юу гэж бодож байна? Өөр өөрийнхөө бодол санааг философичид, эрдэмтэн судлаачид, уран бүтээлчид, гоо зүйчдийн бодрол бясалгалтай харьцуулан үнэлээрэй.



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

Хүүхдүүд ээ! Та бүхэн, хичээлээс гадуур Г.Г.Маркесийн “Зуун жилийн ганцаардал”, М.Булгаковын “Мастер Маргарита хоёр” роман, И.Бродскийн “Хоёрдугаар Жюль Верн” найраглал, Ж.Роулингийн “Харри Поттер”, Стивен Мейерын “Бүрэнхий”, Стивен Спилбергийн “Аватар”, Жон Толкины “Бөгжний эзэн” зохиолуудыг уншиж, орон зай, цаг хугацааны дүрслэлүүд, тэдгээрийн гажилт, хувиралт гэх мэт туурвил зүйн онцлогтой танилцаарай.

1. Ф.Кафка “Хувирал” өгүүллэг
2. Л.Өлзийтөгс “Аквариум” өгүүллэг

## ЗОХИОЛЧ



### Донровын НАМДАГ (1911-1984)

1911 онд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт төржээ. 1934 оноос уран бүтээлээ эхэлж, “Алим”, “Их хурим”, “Цаг төрийн үймээн”, “Шарай голын гурван хаан”, “Сүрэг чоно” зэрэг олон ном хэвлүүлжээ.

“Шөнийн бороо”, “Туул”, “Алтан ширээт” зэрэг утга уянгын шүлгүүд, “Тогос хээр” найраглал, “Эрхэм зураг”, Чулуун хороо”, “Үрэгдсэнийг хүлээгч” зэрэг өгүүллэг, “Гомпилын бага хүү”, “Хөгшин чоно ульсан нь” тууж, “Тэмцэл”, “Шинэ зам”, “Сүрэг чоно”, “Амь ба амьдралын үнэ”, “Ээдрээ”, “Шинэ байшинд”, “Эрдэмтний яриа”, “Хярааны хонхорт”, “Оролмаа” зэрэг жүжиг, “Нүгэл буян”

кино туурвижээ. 1962, 1983 онуудад Монгол улсын Төрийн хошой шагнал, 1971 онд Урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- “...Энэ бол байгалийн хууль. Байгаль өгье гэсэндээ энэ хорвоогийн хамаг сайн сайхныг сэтгэл харамгүй өгөөд эцэст нь мөн л хайр найргүй буцаан авдаг нь энэ ээ. Нөгөө талаар байгаль, аливаа амьтныг амьдрахын төлөө ямагт зүтгүүлэхдээ амь биенд хүрэх аюулт бэрхшээлүүдийг цаг үргэлж тулган санах, бодох, болгоомжлох, аргалан залилах бүх ухааныг олгоод түүнээ эцэст нь мөн буцаан авдаг хуультай” гэсэн амьдралын мөнхийн, хэн бүгдийн мэдэх гүн ухааны чанарыг нээн гаргасан юм...”

(С.Байгалсайхан. “XX зуун тууж судлал”. УБ., 2014, 97-98-р тал)

### ХӨГШИН ЧОНО УЛЬСАН НЬ

(Туужийн хэсэглэл)

... Уг газрын байдал хангай говийн зааг, нам доор газар бөгөөд тэр дунд Дулаан хайрхан хэмээх гурван хэсэг огцом оргилтой уул өмнөө байгаа Таргатын тал гэгчийг нам тайвнаар ширтэх мэт бараагнан сүндэрлэнэ. Уг нь энэ уул төдий том биш боловч өвөл, хаврын цагийн хатууд адуу малыг нөмөрдүүлэн бараадуулахад таатай байдаг тул “Дулаан” гэж нэрлээд зогссонгүй “Хайрхан” гэдэг хүндэт цол өргөн алдаршуулсан ажээ.

Гэтэл бас Дулаан хайрханы дундах оргилын баруун энгэрт дээрээ үй түмэн жилийн турш хурц нарнаа шарагдан элэгдэж, хүрэн өнгөтэй болсон хэдэн том хадтай нэгэн сүрхий ганга байдгийг мөн нутгийнхан андахгүйгээр барахгүй, бага балчир насандаа ишиг хурга асаан, дээр нь эрхлэн тоглож байгаагүй хүн ховор юм. Гэвч эдгээр хаддын нэгний нь доор байдаг харанхуй хөндийн мухарт нэг чоно байрлаад хэдэн жил болж байгааг хэн нь ч мэддэггүй байлаа...

Төрж өссөн нутаг нь гэвэл энэ Дулаан хайрхан мөн. Анх төрөхдөө ар бэлд нь төрөв. Идэр залуудаа эгц цавчим ирмэгт нь орогноод, эцсийн гурван жил арга буюу авирах хөлийн чадал доройтсон учир өвөр энгэрт нь хоргодох болжээ...

Үдшийн цагаан гэгээ тасармагц чийг даасан хөндийнхөө мухраас сугаран гарав. Идэр залуудаа сайх чоно магнай тэнэгэр, хошуу урт, хөл шулуун, тавхай



том, биеийн ерөнхий байдал давилуун боловч толгой бөгс, цээж тэнцүү, тэр мөртөө араа соёоны талаар онцгой, хамар ба амны арьс тасан хар болж ирээд ар сэрвээ зоогоо дагасан хүрэн хар өнгийн гоц сайхан сахлаг сортой байсан бөгөөд, энэ бүхний нь хүний байдлаар жишээлэн өгүүлэхэд, гялалзсан царайтай, яралзсан шүдтэй, гунхсан нуруутай, суналзсан гээзгтэй, эрийн гурван наадамд очвоос түрүүлэх нь эс боловч, үзүүр булаалдах тэнхэлтэй хорвоод хорь гучаар биш, хоёр гурвын төдийхөн байдаг сайхан эрсийн нэг гэлтэй. Одоо гэвэл сайх хөгшинд тэр бүхнээс нь үлдсэн юм алга. Нүдний гал бууран, шүдний ир элэгдэж, үс зулбан, зүс зэгэл, эцэж турсны хувьд ясан хэдрэг ээ. Энэ бол байгалийн хууль. Байгаль бол өгье гэсэндээ энэ хорвоогийн хамаг сайн сайхныг сэтгэл харамгүй өгөөд эцэст нь мөн л хайр найргүй буцаан авдаг нь энээ. Нөгөө талаар байгаль, аливаа амьтныг амьдрахын төлөө ямагт зүтгүүлэхдээ амь биенд нь хүрэх аюулт бэрхшээлүүдийг цаг үргэлж тулган, санах, сэрэх, бодох, болгоомжлох, аргалан залилах бүх ухааныг олгоод түүнээ эцэст нь мөн буцаан авдаг хуультай. Энэ ёсоор хөгшин чоно үзэхийн ихийг үзэх завшаандаа ухаарахын ихийг ухаарав. Гэвч энэ ухаанаа байгаль авгайд алдаагүй байгаа бөгөөд алдахаасаа өмнө нас барах ч байж мэдэх юм...

\* \* \*

Одоогоос долоон жилийн өмнө билээ. Өвлийн идэр ес дундаа гялалзаж байх үеэр ар хойд зүгээс ардаа арван хэдэн омог чоныг дагуулсан нэг айхтар өлөгчин Дулаан хайрханд иржээ. “Өлөгчин” гэдэг үг хүмүүсийн сонорт ямагт олиггүй сонсогддог үгсийн нэг мөн боловч чонын хувьд “Үзэсгэлэн гоо” гэх мэтээр сонсогдох гоёмсог үгсийн нэг мөн. Уул өлөгчний хошуу шовх, хүзүү урт, хөл цэх болоод зэнзгэр, ер биеийн ерөнхий байдал урт бөгөөд бөгсөн бие бүдүүвтэр тул айван тайван гишгэлэхэд бүх бие нь аяндаа гулбилзана. Хурдлахын хувьд бүр ч онцгой, харвасан сум шиг сунайна. Иймд энэ өлөгчин ёстой үзэсгэлэн гоо өлөгчин мөн. Төрсөн нутаг ар хөвч хангай болох тул нам дор газрын Дулаан хайрханыг дов довцог төдийд үзсэн ч байж мэднэ. Араасаа дагасан арван хэдэн эрсийн хүчийг шавхан гурван хэц оргилоор дамжин харайлгахад уг нутгийн эрэлхэг эзэн (одоогийн хөгшин чоно) анх олж харан сэтгэл автагдав. Үнэн чанартаа гэвэл, үүрд үл хагацах үйлийнхээ үртэй уулзалдах нь тэр ээ.

Өлөгчнийг үүр шөнийн завсраар Дулаан хайрханаас зүүн урагш салхи сөрөн харайлгахад сайх чоно өөрийн эрхгүй дагав. Бусад дагагсад мөн дагасан хэвээр бөгөөд хоорондоо эв түнжин маш муу, өлөгчнөө булаалдан бие бие рүүгээ ямагт архиралдан дайралцана. Тэр мөртөө шинэ нэмэгдэж байгаа нэгийг тус бүрнээ ад үзэн бүүрэлхэх ажээ. Иймд мань эр тэр дунд ганцаараа, ёстой л нэгийгээ үзэлцэн нимгэн арьсаа уралцах цаг иржээ.

Эхний ширүүн тулалдаан өдөр дундын алдтай болов.

Анх өлөгчнийг Дулаан хайрханаас үүр шөнийн завсраар жавар сөрөн гарахад мөн өөр бусадтай ухаан жолоогүй тэмцэлдэн байж өлөгчний дараа орсоон...

Эцэж цуцахыг үл мэдэх нь ганцхан өлөгчин. Байгаль түүнд гоо сайхныг бэлэглэхийнхээ зэрэгцээгээр хүч чадлыг давхар хайрласан нь илэрхий. Нөгөө талаар мөн байгаль, чоно болгонд өвөл цагийн хатуугаар далимдуулан онгон сахиус мэтийг оруулахдаа хүч чадлыг эрхгүй нэмэгдүүлдэг боловч мань өлөгчинд хэт давууг олгосон ч байж мэдэх юм...

Гэтэл өлөгчин эднийг ийнхүү хэрэлдүүлэх боловч болиулахаа мөн чаддаг аж. Тэрээр өмнөх тулалдааныг ажиж байснаа гэнэт хаян мэл цагаан тал руу харайлгав. Энэ нь олны дунд өөрийн эрхгүй ганцаардсан Дулаан хайрханы хүүг аврах гэсэн сэтгэл

ч байж мэдэх юм. Овооролдсон чононууд улайрсан тэмцлээ даруй орхин өлөгчний хойноос дагав. Эцэст нь Дулаан хайрханы хүү, хэт үнгүүлсэн биеэ дааж ядан газраас арайхийн босож аваад мөн л хойноос нь зүтгэлээ. Саяын тулалдаанаас олсон шарх сорвио тэр үл анхаарна. Зарим газар арьс урагдан, мах тасарч, цус дусалж, цагаан цасан дээр улаан толбо бялтах аж... “Ингэхэд одоо өнөөх үзэсгэлэн гоо өлөгчин хаа яваа бол!” гэж бодон алсын барааг ширтэхэд бараа алга, түүний оронд мэл цагаан тал цэхэлзэн цэлийж, өдөр дундын цагаан шаргал нар нүд царгин гялбуулна...

Өдрийн турш харайлгаад мань эр өлөгчний барааг олж хараагүй билээ. Гэвч түүнийг орхих сэтгэл төрсөнгүй, яв явсаар нар шингэхийн алдтай алс тэртээд цэнхэрлэн сүүмэлзэх урт шилээр даван далд орохыг нь ашгүй нэг олж харлаа... Шөнө дундын алдтай өлөгчнийг бяцхан бор толгойн оройд гаран хоноглож бүхийд тэрбээр гүйцэн очив...



#### УНШИХ ЯВЦАД

- *Зохиолыг унших явцдаа зохиолчийн ертөнцийг үзэх үзлийн төлөвшил хэрхэн илэрч байна вэ, уран сайхны сэтгэлгээний давтагдашгүй өвөрмөц төрхийн нууц юунд байгааг, чухам энэ нууцыг нээхэд уг туужийн утга, агуулга хэрхэн тус болсныг анхаарч уншаарай.*

Цаашдын явдал гэвэл, эцэж цуцахыг хэзээ ч үзэмгүй, ямагт нумнаасаа мултарсан сум шиг харайлгадаг байсан өлөгчин өдрийн хагас аваад ядралын туйлд хүрч яг зогсов. Энэ зуураа хэд дахин зогсон амарсан бөгөөд амрах болгон дээрээ Дулаан хайрханы хүүг аль байдгаараа аргадаж байв. Өөрөөр хэлбэл, омогтой бүхнийг дороо сөгтгөдөг өнөөх үзэсгэлэн гоо бие нь яв явсаар эрэлхэг нэгний гарт орж, үнэнч хань чинь больё гэж байгаа нь тэр юм.

Гэтэл бас амрах бүрийд түгдгэр хөх гүйцэн ирж ширүүн тулалдаан болж байлаа. Эцсийн удаа зад хэмлүүлэн хөлдөө хүнд шарх олон хаягджээ... Энэ бүхэн бол байгалийн шалгалт мөн. Байгаль нь жилийн дөрвөн улирлын хамгийн хатуу хайрганаар өлөгчинд нь түр зуурын онцгой хүч чадал өгөөд, түүгээрээ азарган чононуудыг уралдуулан шалгах бөгөөд энэ шалгалтыг Дулаан хайрханы хүү нэр төртэй даван туулсан нь энэ байжээ. Нэмэн өгүүлэхэд, хэрэв байгаль ингэж шалгадаггүйсэн бол чонын удам угсаа доройтон доройтсоор аль хэдийн үнэг шиг дорой амьтан болсон байх буюу эс бол чоно гэдэг араатан энэ дэлхийгээс бүрмөсөн сөнөсөн ч байж болох юм...

Дулаан хайрханы хүү гэдэс өлсөх, ядрах хоёрт нэрвэгдэж эхлэв. Ингэхээрээ аль ч амьтан амьтны адаг болдог билээ. Гэлдрэх шогших хоёрын хооронд арай ядан явна...

Урьдтай нь нэгэн дэрст хонхорт хэсэг гөрөөс хэвтэж байсан бөгөөд түүнийг Дулаан хайрханы хүү харан сэтгэл нь сэрхийн сэргэв. Биеийнх нь ядрал дорхноо мартагдаж, булчин шөрмөс нь аяндаа эрчлэн зангирав. Гэвч бас гай! Ухасхийн үсрэхдээ ямар нэгэн юманд бүдэрч дугуйлдан унав. Үүндээ сарьсан хамраа шалба авсныг хэлэх үү, өвдөхийн эрхэнд нүд эрээлжлэн ухаан балартана. Гаслан гангинан босож, зээр гөрөөсний байсан газар руу харвал өлөгчин нэгийг нь аль хэдийн дарж авсан байлаа. Үүнд түүний баярласан нь жигтэйхэн. Тэгээд бас амтат сайхан хоолыг ганцаараа идсэнийг хэлэх үү, гэдэс цадаж сэтгэл тэниймэгц өлөгчнийг хайрлах сэтгэл шинээр төрсөн бөгөөд ер эдний амьдралын халуун бат холбоо эндээс ч эхэлсэн байж мэднэ.

Тэндээс Дулаан хайрханы хүү эм юугаа дагуулан өөрийн тааваар өнжин хонон явж өссөн төрсөн нутагтаа эсэн мэнд хүрчээ. Анх очсон даруйд ураг төрлүүдээс

нь аваад уг нутгийнхан өлөгчнийг нь үзэн ядан гадуурхах аж. Иймд мань эр юу юуны өмнө эм юугаа өмгөөлөн хамгаалах хэрэгтэй байлаа. Энэ талаар өдөр тутмын явган хэрүүл гарах болсон тул тэр бүхнээс аль болохоор зайдуу явахыг эрхэмлэсэн бөгөөд ингэснээр тэдний амьдрал бусдаас тасрав.

Хоёр бие нэгэн адил идэр залуу, эв түнжин маш сайн ан гөрөөнд хоёулхнаа явна. Олсон олзоо ёстой сэтгэл харамгүй хуваалцана. Ингэхэд хэн хэнд нь ийм сайхан амьдрал хэзээ ч байгаагүй аж...

(1965)

**Эх сурвалж:** (Д.Намдаг. "Түүвэр зохиол 3". УБ., 1988. 542-574-р тал)

#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Бараагнах** - барайн харагдах, барайх  
**Ганга** - хоёр этгээдээс шахагдсан ихээхэн хавчил суваг  
**Сондуул** - дов сондуул  
**Харгана** - ургамлын нэгэн төрлийн ерөнхий нэр, буурцагтан овгийн төрөл, модлог сөөг  
**Цахилдаг** - бут бутаар ургадаг нэгэн зүйл ургамал, цэцгийн өнгө ягаавтар  
**Хаяглах** - нохой зэрэг амьтан юман дээр сариад шээсээ булах мэт хойд хоёр хөлөөрөө шороо маажлан цацлах  
**Шинхэг** - шээс зэргийн шивтэр үнэр  
**Зэнзгэр** - бие гуалиг, цэвэр буюу ааль

төлөө хээнцэр янзлаг  
**Түгдгэр** - бөгтөр, бөгцөр, бөхгөр  
**Өлөгчин** - зарим араатан амьтны эмэгчин  
**Цуугилдах** - олноороо цуугиан үймээн гаргах, шуугилдах  
**Хомхой** - ховдог, шунаг  
**Долгонцог** - 1. Идэх уухад ховдог  
 2. Сувдаг шунахай  
 3. Зусарч, буялдууч  
**Сархиаг** - олон гүнзгий гуу жалга, хад асга, нугачаатай, энхэл донхол, хотгор гүдгэр газар  
**Цөө** - саад тотгор, бууралт доройтолт



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

"...Эл туужид зохиолч чонын амьдрал, үржил хорогдол, амьдралын төлөөх тэмцэл, ертөнцийн жам ёс тэднийг алгасдаггүйг эр, эм хоёр чонын явдлаар өгүүлсэн. Тэдний хайр сэтгэл, өшөө хорсол, зовлон жаргал, баяр гуниг цөм бусдынхтай адил байдгийг нэн уран тансаг өгүүлжээ. Дулаан Хайрханы хүү хэмээх эрэгчин чоно, үзэсгэлэнт залуу гичий чоно хоёрын идэр залуугийн адал явдалт амьдрал нас хөгширч үр удмаа үлдээх гэж чармайсныг сонирхолтой дүрсэлжээ..."

(“Утга зохиол шинжлэл”, МУБИС. УБ., 2005, 249-р тал)



#### Унших чадвараа хөгжүүлье

#### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.

1. Туужийг бүрэн эхээр нь ойлгож уншаад, бие биедээ асуулт тавьж, туужийн үг хэллэгийг ашиглан ярилцаарай.

Зохиолоос юу мэдэрч, ойлгож, ухаарав?

• .....

Аль хэсэгт нь догдолж, бахархав?

• .....

Аль хэсэгт нь харамсаж, өрөвдөж, халшрав?

• .....

2. Чоно хэмээх амьтны амьдралын онцлог, байгалийн зохилдлого, газарзүйн



байршил, хоол тэжээлийн онцлог, үр төл зэргийн талаар сурвалжлан ярилцаарай. Интернет, танин мэдэхүйн сэтгүүл, нэвтэрхий тол зэргийг ашиглаарай.

3. Өнөө цагт бид амьдралынхаа төлөө буюу өөрийнхөө төлөө, бусдын төлөө хэрхэн яаж зүтгэдэг билээ, аливаа саад бэрхшээлийг даван туулахын тулд “санах, сэдэх, болгоомжлох” арга ухаанаа хэрхэн гаргадаг вэ? гэх мэтээр асуудал дэвшүүлэн ярилцана уу.
4. Дараах асуултын дагуу тунгаан бодож, өөрийн өөрийн санаа бодлоор тайлбарлаарай.
  - Зохиолч чонын амьдралыг сонгон бичсэнийг чи юу гэж бодож байна?
  - Чонын амьдралыг хүний амьдралтай зүйрлэн бодож үзэв үү?
  - Хүнээр төсөөлбөл юу бодогдож, юуг ойлгож үлдэх вэ?

### **Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Туужийн санаагаар дамжуулан зохиолчийн юуг эргэцүүлж, ямар хандлага илэрхийлж, ямар санаа гаргасныг тунгаан бодож, дүгнээрэй.
2. Зохиолч туужид амьдралын мөн чанар, түүнийг цогцлоохын тулд хүнээс хэр зэрэг хүч, самбаа, амьдралын хар ухаан, дотоод сэтгэл дэх зоригийн байдал хэрэгцээтэйг тодорхойлохдоо ямар үг хэллэгээр, ямар дүрслэлээр урлан гаргасныг тайлан тайлбарлаарай.

### **Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.**

1. Зохиолд зохиомжийн бүрэлдүүлбэрээс хэрхэн ашигласныг жишээ татан тайлбарлаарай.

- |                 |                        |
|-----------------|------------------------|
| • Хүүрнэл яриа  | • Байгалийн зураглал   |
| • Харилцан яриа | • Зүүд                 |
| • Үглэл яриа    | • Дотоод яриа          |
| • Хөрөг дүр     | • Зохиолчийн тэмдэглэл |
| • Өчил          | • Эргэцүүлэмж          |

2. Зохиолч туужийн зохиомждоо дурсамжийг аль хэсэгт ямар зорилгоор ашигласныг олж тайлбарлаарай.
3. Зохиолоос хөгшин чоныг хөрөг зургийн аргаар хэрхэн дүрсэлснийг олж, тайлбарлаарай.
4. Хөгшин чонын залуу насыг болон өтөлж, чадал тэнхээ буурсан үеийг дотоод сэтгэл зүй болон гадаад төрх байдалтай нь хэрхэн уялдуулсныг эргэцүүлэн баримтаар нотлоорой.
5. Хөгшин чоно, азарган чоно хоёрын дүрийг ялгаруулахдаа зохиолч зохиомжийн ямар хэлбэрийг ашигласан бэ? Баримтаар батлан тайлбарлаарай.
6. Зохиолын эхлэл хэсэгт байгаа байгалийн зураглал ямар үүргээр орсон бэ? Уул, тал хоёрын зохицлыг ямар үг хэллэгээр, ямар дүрслэлээр илэрхийлснийг олж бичээрэй.

	Зохиолд дүрсэлсэн хэсэг	Ямар дүрслэл вэ?
Дулаан хайрхан уул		
Таргатын тал		

7. Зохиолоос үйл явдал өрнөж байгаа газар орон, орон зайг түүвэрлэн бичээд





үйл явдалтай холбон тайлбарлаарай. Жишээлбэл:

- Дулаан хайрханы хаддын нэгний нь доор байдаг харанхуй хөндийн мухарт орогнох нэгэн хөгшин чонын тухай танилцуулсан.

8. Туужийн өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо, хэсэг бүрийн агуулгыг дараах байдлаар гаргаж бичээрэй.

Эхлэл	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгшин чонын амьдардаг газрын тухай</li> <li>• Хөгшин чонын гадаад төрх байдал, дотоод ухааны тухай</li> <li>• Бусад чононуудыг дуудан олз хайн явах тухай хэсэг</li> <li>• Отгон охин бэлтрэг болон өлөгчин чонын тухай өгүүлсэн хэсэг</li> </ul>
Зангилаа	
Өрнөл	
Туйл	
Тайлал	
Төгсгөл	

9. Зүүдний тайлал нь зохиолын утга санааны тайлал болж чадах уу? Тийм бол жишээгээр батлан тайлбарлаарай.

**Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.**

1. Зохиолч чонын дүрийг урлахдаа хүншүүлж, хүнтэй адил боддог, ухаардаг, уярдаг, хайрладаг, жигшдэг, хорсдог гэх мэтээр хүний сэтгэл зүйн өөрчлөлт, хувиралтуудыг шингээжээ. Эдгээрийг илэрхийлсэн баримт жишээг олж тайлан тайлбарлаарай.
2. Өлөгчин чонын дүрийг тодруулж буй хэсгийг олж, дүрийн зан төрхтэй холбогдох дүгнэлтийг гаргаарай.

	Эшлэл	Дүгнэлт
Өлөгчин чоно	...Эцэж цуцахыг үл мэдэх нь ганцхан өлөгчин. Байгаль түүнд гоо сайхныг бэлэглэхийнхээ зэрэгцээгээр хүч чадлыг давхар хайрласан нь илэрхий...	
	...Эднийг ийнхүү хэрэлдүүлэх боловч болиулахаа мөн чаддаг аж, өнөөдөр өлөгчин, уралцах завдал өгсөнгүй, жавар сөрөн давхиж гарлаа...	
	...Эцэж цуцахыг хэзээ ч үзэмгүй, ямагт нумнаасаа мултарсан сум шиг харайлгадаг байсан өлөгчин...	
	...Омогтой бүхнийг дороо сөгтгөдөг өнөөх үзэсгэлэн гоо бие нь яв явсаар эрэлхэг нэгний гарт орж, үнэнч хань чинь больё гэж байгаа нь тэр юм...	

3. Хөгшин чоно, өлөгчин чонын дүрийг эцэг хүн, эх хүн болох талаас нь авч үзвэл ямар эцэг эх байх вэ гэдгийг жишээгээр батлан дүгнээрэй.
4. Нутгийн сайн анчин, хөгшин чоныг авлаж чадаагүй учраас “Ээ дээ, мөн ч тэнгэртэй амьтан шүү” гэсэн дүрслэлээр юу хэлэхийг зорьсон бэ? Чонын арга ухаан болон чоныг шүтэж ирсэн уламжлалт ойлголттой харьцуулан тайлбарлаарай.
5. Чоныг үйл явдлынхаа гол зүйл болгосон монголын болоод дэлхийн зохиолуудын утга санаа, дүр дүрслэл, бичлэг найруулгын хувьд харьцуулан үнэлээрэй.

6. Хөгшин чонын “Хөрөг” болох хэсгийг олж, харьцуулан бичээд, энэ нь ертөнцийн жам хууль гэсэн санааг батлаарай.

Чонын залуу цаг

Өтөлж хөгширсөн чоно

### ДҮГНЭЛТ

7. Өлөгчин чоныг зохиолд хэрхэн дүрсэлсэн бэ? Олж бичээд, “...Үнэн чанартаа энэ өлөгчин үүрд баясган баярлуулагч биш, харин энэ хорвоогийн хамаг хатуу ширүүнийг өмнө нь тулган үүрүүлэгч байж мэднэ...” гэсний учрыг тайлбарлаарай.

#### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.

1. Дулаан хайрханы хүүгийн дүрийг дүрслэхдээ өлөгчинг өөрийн болгохын тулд ямар аргаар, яаж тэмцэж байгааг хүний амьдралтай харьцуулан тайлан тайлбарлаарай.
2. Зохиолд чонын дүр байдлыг дотоод бодол, ярианаас хэрхэн тодруулсныг нөхөн олж, тайлан тайлбарлаарай.

Хэлц	Хэлцийн утгатай дүйх эшлэл	Тайлбар
Хажуу хавиргаа хадрахгүй	.....	Хаяа сайтай айл, хүнийг чоноор төлөөлүүлж, хэнтэй дайсагнаж, хэнтэй эвцэж явахаа мэддэг хашир хүний тухай бичжээ.
.....	“...Ээ тийм, үдээс хойш бие минь айхавтар чилээрхсэний учир энэ. Энэ далимд анд гарваас ам тосдох олз ч аяндаа шүү дээ...”	.....

3. Хөгшин чонын бодлоор дамжиж буй дотоод сэтгэл зүйн хувирал өөрчлөлт нь өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хэрхэн илэрч байгааг түүвэрлэн, тайлбарлаарай.
4. Зохиолд үйл явдал өрнөх орон зай, цаг хугацааг сонгосон шалтгаан нь дүрийн дотоод тал, зохиолын дотоод санаанд хэрхэн нөлөөлснийг тайлан тайлбарлаарай.

#### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.

1. Дулаан хайрханы хүү гэж яагаад нэрлэв? Уран дүрслэлийн ямар арга хэрэглэсэн бэ?
2. Дулаан хайрхан уулыг танилцуулахдаа “...өмнөө байгаа Таргатын тал гэгчийг нам тайвнаар ширтэх мэт бараантан сүндэрлэнэ...” хэмээн дүрсэлсэн нь уран дүрслэлийн ямар хэлбэрийг ашигласан бэ?
3. Зохиолч туужийг бичихдээ ашигласан бичлэгийн үндсэн арга, найруулга нь ямар байгааг баримтаар тайлбарлаарай.
4. “...Үнэндээ тэр чоно маш хашир, дээрээ ишиг хурга майлалдан тоглоход

идэхийг бодохоос илүү “За энэ ч яамай” гэж бодон мухартаа шигдэх бөгөөд ер нь хажуу хавиргаа хадрахыг цээрлэх тул...” гэсэн ишлэлээр зохиолч ямар утгыг илэрхийлэв? “Хажуу хавиргаа хадрахгүй” гэсэн хэлцийн үүрэг юу байсныг тайлан тайлбарлаарай.

5. “...Энэ бүхэн байгалийн шалгалт мөн. Байгаль нь жилийн дөрвөн улирлын хамгийн хатуу хайрганаар өлөгчинд онцгой хүч чадал өгөөд, түүгээрээ азарган чононуудыг уралдуулан шалгах бөгөөд энэ шалгалтыг Дулаан хайрханы хүү нэр төртэй даван туулсан нь энэ ажээ...” гэсэн хэсгийн утга санааг дэлгэрүүлэн дүгнэлт гаргаарай.



#### БИЕ ДААЖ УНШИХ ЗОХИОЛ

1. Д.Намдаг. “Хөгшин чоно ульсан нь”. УБ., 2014
2. Сонсохоор: Youtube.com, “Хөгшин чоно ульсан нь” (1, 2-р хэсэг өгүүлэгч О.Батсүх)

#### ЗОХИОЛЧ



#### Чинагийн ГАЛСАН

1944 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд төржээ.

МУИС-ийн монгол хэл, уран зохиолын анги, Герман улсын Хүмболтын их сургуулийг тус тус дүүргэсэн байна. Түүний анхны зохиол нь “Тува туужууд” нэрээр 1981 онд герман хэлээр хэвлэгдсэн. Хожим нь “Аянгат цагийн тууж”, “Арван сарын тэнгэр дор” тууж болон “Алаг хорвоогийн гэрэл, сүүдэр” аян замын тэмдэглэл, “Эр хар сур” яруу найргийн номуудаа монгол хэлээр хэвлүүлсэн. 2002 онд ХБНГУ-ын Холбооны гавьяаны загалмайн одон, 2003 онд ОХУ-ын Тува улсын Урлаг соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол тус тус хүртжээ.



#### УНШИХЫН ӨМНӨ

- “... Аянгат цагийн туужийн Жанибек өвгөн бас л бодит дүр юм. Жанибек өвгөнийг дагаж би анчин болсон. Хатуу чихтэй, ганц хар морьтой. “Аянгат цагийн тууж”-ийг чинь тэр өвгөн мах болохын өмнө надад ярьдаг. Өвгөн хүүгийнхээ тухай ахин дахин ярина. Ганц хүүгээ алдчихсан эцэг хүн тэр бүхнийг яаж мартахаав. Өвгөн тэр үед жаран нас л зооглож байсан байх. Би яахав, ес, аравтай хүүхэд. Би чинь морь аргамжиж өгөөд, аргал түлээд, завсар хооронд нь тарвага сахиад, хааяа нэг тарвага буудчихаад, тогооч маягтай л, тэр хүмүүсийн зараалаар л анхны аяндаа явж байгаа юм. Тэгж явахдаа тэр хүний түүхийг сонсоод маш их уйлсан. Маш их догдолж байгаа юм. Тэгээд л тэр туужийг бичсэн...” гэсэн ярилцлагаас улбаалан зохиол бичих санаа хэрхэн төрснийг харилцан ярилцаарай.  
(Ч.Галсан. “100 жилийн дараах зохиолч” ярилцлага <http://enkhhsolmon23.blogspot.com/>)
- Туужийг уншихдаа үг, өгүүлбэр бүрийг мэдэрч, ойлгож, яагаад “Аянгат цагийн тууж” гэж нэрлэснийг эргэцүүлээрэй. Өөрт таалагдсан, сэтгэлд нийцсэн, эсвэл гайхширал төрүүлсэн үг, өгүүлбэрийг тэмдэглэж уншаарай.

## АЯНГАТ ЦАГИЙН ТУУЖ (Туужийн хэсэглэл)

...Их талыг туулах морьтны заншлаар бид нэг нэгнийхээ бодолд саад бололгүй дуугүй явцгаана. Жанибекийн эмээл дээрээ нугдайн суусныг бодоход унтаж яваа юм шиг, үрчлээсээр дүүрсэн нүүр нь аль диван галавт орой дээрээс харван буусан хад чулуунд хүй яз татуулаад түүнээс нааш нар, салхи, усанд идэгдсээр байгаа уулын атираат хормойг санагдуулна. Уруулаа тас жимийсэн нь нууц алдахаас сэрэмжилсэн мэт, магнай дээр нь хоёр гүнзгий, гялгар сорви дамналдан тогтжээ... Үрчлээт царай, нууц хадгалан жимийсэн амтай энэ тува өвгөн цагийн нэгэн нугачаа, ертөнцийн нэгэн хязгаарт төрсөн морьтой хөшөө чухамдаа мөн байлаа. Түүнийг харах тутам цагийн аяар цээжинд минь хуралдсан нулимс ундрэн ундрэн гарав...

Дараа нь Жанибек ингэж ярилаа:

... Бодвол чи Баянакийг Доёбуу гэдэг хүний хүү гэж дуулаа биз ээ. Худлаа, миний, миний ганц хүү байсан юм. Доёбуугийнх гэдэг болсны учир нь тэр этгээд хүүгий минь эхийн хэвлийд байхад нь булааж авснаас гарсан хэрэг. Цаадах нь сайхан ч амьтан байсан юм. Үс гээг, нүд шүд гээд л хүнд байдаг бүхэн нь сайхан гээч...

1921 он манай бөглүү хязгаарт их шуурга шиг сүртэй бус, үүрийн гэгээ шиг зугуухан иржээ...

Төдөлгүй анхны ардын багш ирж, хэсэг хүнд бүлгэмээр бичиг үсэг заасны дотор нь би орж, унших, бичихийг сурахын хажуугаар Ленин, Сүхбаатар, дэлхийн улаан пролетари, Октябрийн хувьсгал болон бас бусад зүйлийн нэр дуулж авлаа. Бас хөрөнгөтэй хөрөнгөгүй хоёр анги байдаг, хөрөнгөгүй нь хөрөнгөтэйгөө устгах ёстой гэж мэдэж авлаа.

Бүлгэмээ дуусгатал надаар ардын багш тавьчихдаг юм байна... Эхийнх нь хэвлийд алдсан хүү минь төрөөд, бүр хөлд орчихсон цаг л даа. Өнөө чинь, Баянак... Доёбуугийн гэр хэзээ л хүн амьтнаас зайдуу уулын нэгэн мухарт явна. Тэр үед би үүнд нь баярладаг байж, одоо бодоход энэ л миний хүүд хожим гай болжээ. Учир нь Баянак шилийн ан шиг зэрлэг, зоргоороо өсчээ. Шилийн анг барьж ирээд саравчинд хашихад яадаг билээ? Тэр хоёрыгоо өөр дээрээ авчихгүй яасан юм бэ? гэж чи надаас асуух биз. Үүнийг би өөрөөсөө гучин жил асуугаад хариу олохгүй яваа юм...

Миний бие Баянак, Суяш хоёртоо заримдаа бүр аюулхай цээж хөндүүрлэм хайр хүрдэг байсан боловч биеэ тоох гэгч минь хэтэрснээс хүний эхнэртэй нэр холбогдохоос айсан минь түүнээс хүчтэй, ингэхлээр үнэндээ сүрхий хулчгар гайхал байжээ...

Баянак минь шөнийн хоногоор суга өсөн сайхан ч, галтай ч эр болов. Арван гуравтайдаа чоно намнаж, хаана л хүчрэгдээгүй эмнэг хангал байна, түүнийг бүр сураглаж очоод унадаг байсныг нь бод л доо...

Тийм дээ, хүү минь, албан тушаал, нэр алдрын донд нэг л автах юм бол хараастай сохор, мэдээстэй маанаг болж хувирах нь амархаан байдаг. Ийм хүн нэг ёсны эрхтэн дутуу, мэдрэл гажуу явсаар нэг л өдөр амьдралын хатуу торгуулийг голдоо ортол мэдрэхдээ сая л сэхээ ордог. Сэхсэний дараа ч бол юутай гайхалтай, юутай харамсам амьтан болчихоод явснаа харин нэг ойлгож авдаг юм билээ...

Гучин өсөн онд Суяш минь нас барлаа. Намрын нэгэн дүнсгэр өдөр хяруу татсан булшны овгор шорооны өмнө зогсч байхдаа бараг хоёр жил уулзаагүйгээ саналаа. Тэгтэл нүднээс минь доголлон нулимс бөмбөрөн унасанд би ичихээсээ илүү цочив. Миний нүднээс нулимс гарах юм гэж би мэдээгүй явжээ. Суяш минь гучин долоотой байлаа. Доёбуу тэр өвөл нь л нэгэн нударганы бэлбэсэн авгайтай гэрлэлээ. Урьдын



бүдүүлэг цагт хань нөхрөө чөлөөтэй сонгож авах эрх мэдэлгүй байсан бүсгүй хүн шинэ, боловсон цагийн буянаар тэр эрхээ ашиглаж байгаа юм гэнэ.

Баянак Доёбуугийн, Доёбуугийн ч гэж дээ, түүний нударган авгайн гэрийг орхин одсон байв. Нэг шөнө сүрхий унжирсан хурлаас тараад харьж ирвэл муу байшингийн минь үүдэнд нэгэн өндөр залуу зогсч байснаа намайг таньж амжаагүй явтал өөдөөс минь хүрч ирээд: “Аав аа” гэж сулхан дуугардаг байна. Баянак гээч! Суяш минь хүүдээ үнэнийг хэлж амжсан байж!”...

“Би гэдэг хүн баярлах мөртлөө айж хоцров. Харанхуй дундаас гэрэлтэх тунгалаг царайтай, өндөр сайхан залууг цээжиндээ тэврэн: “Би чинь ийм хүүтэй хүн юм байна шүү дээ!” гэж бахархан бодовч, сумын дарга, хоршооны дарга хоёр хоорондоо нэг хүүгийн будлиантай юм байх аа гэсэн яриа орон гүрнээр л нэг дэгдэх биз гэж бодохоос айдас хүрнэ. Эцэст нь айдас дийлж: “Орон гэр, эцэг, эхтэй хүн чи буц даа” гэж тэмүүлэн ирсэн хүүдээ хэлж орхилоо шүү... Баянак агзасхийн, надаас зайлж, харанхуйд дорхноо бараа тасран одоход яс, мах минь янгинах шиг болж хүйтэн цоожинд духаа наан хоцров оо, би. Харин буцаан дуудах, араас нь гүйх ухаан даанч төрсөнгүй.

Тэр намар Баянак цэрэгт мордлоо. Байдал түгшүүртэй байсан цаг.. Би байлдагчдын гарыг атгахдаа инээмсэглэн, эрс шийдэмгий байх юм шүү гэж дотроо бодсон билээ, гэтэл Баянактай харц тулгарахдаа сэтгэл хямран, толгой эргэх шиг болов. Хүү минь жагсаалын магнайд, тогтож ядан байгаа хөлгийнхөө жолоог энэхэн агшинд султган, гялхийн одоход бэлэн байгаа мэт дөрөөн дээрээ өндийсөн байв. Би өвдөгт нь хүрснээ ухасхийн, хүзүүдэж аваад ойртуулан татаж ирээд нүүр нүдгүй үнсэж гарсан бөгөөд ингэхдээ: “Миний хүү!” гэж хашхирах шивнэхийн хооронд ахин дахин хэлж байж. Тавиад харвал Суяший минь нүдийг хуулсан дүрлэгэр хар нүдэнд нь нулимс мэлтэлзэн, тэр нулимсны цаана “Намайгаа хөөж туугаагүй билүү, аав минь?” гэсэн асуулт дүрэлзэн байв. Энэ үед өөрийн минь ч нүдийг нулимс бүрхээд ирэхийг мэдэн ичихдээ бушуухан дараагийн хүн рүү хүрч очоод түрүүчийн санамсаргүй хийснээ одоо санаатайгаар давтав. Би байлдагчдыг бүгдийг хүзүүдэж, бүгдийг үнссэн боловч хэн дээр нь ч Баянактай зууралдсан шиг тийм удсангүй...

Тэгтэл хоёр дахь жил дүүрэхийн үед Баянакаас минь өөрийн гараар бичсэн захиа ирдэг юм байна. Миний баярласныг хэлээд яхав. “Уг нь ийм л байхаар сэргэлэн хүү сэн дээ!” гэж нулимс унаган байж өөртөө хэллээ. Гэтэл бас захиандаа юу бичсэн гэж санана. Ангидаа мэргэн буудагч, бага дарга болсон гэнэ! Би ч бүр хөл алдаж орхилоо. Үртэй хүний жаргал гэж ийм байдаг байж...

Гэтэл Арцатын Хамар даваан дээр гарч явтал хойноос минь зарлага гүйцэж ирээд сумын дарга одоохон замаас эргээд ир гэж байна гэлээ. Очвол сумын удирдах нөхөд даргын конторт цугларчихсан байж байв. Дарга дэлгээстэй цаас барьчихсан өөдөөс минь хүрч ирээд “Ийм юм болжээ” гэсэнд өнөөхий нь авч уншиж эхэлснээ давхийтэл цочоод дахин эхнээс нь уншив. Хэд дахин уншсанаа, дараа нь юу хэлснээ, яаснаа мэдэхгүй байна. Бодвол өнөө бичгийг сумын даргад буцааж өгөө биз. Нүдий минь гэнэт асар олон улаан, ногоон тойрог хаагаад тэр нэл улаан, ногооны дотроос гагцхүү арилшгүй хар үсгүүд цувран гарч ирэх нь бодоод байхад: ... Баянак оргосон ... даруй баривчлах ... эсэргүүцвэл буудах ... гэсэн санааг бүтээж байв. Үүний цаана: “Адилхан нөхөд нь цусаа урсган тулалдаж байхад нэг нь амиа хоохойлон оргож зугтаж явах ч гэж дээ. Нутаг усныхны маань нэрэнд яасан ч муухай юм бэ! Чамайг муу нохойг өөрийн гараар буудан алья!” гэж нэг хүн гаслах нь дуулдана, Доёбуу”...





- *Туужид монголын нийгэм ямар байдлаар дүрслэгдсэн бэ? Нийгмийн ёс зүй гэж юу байв? Хүний мөс чанар нийгмийнхээ ёс зүйтэй зөрчилдөж болох уу? гэх мэт асуултад багшийнхаа дэмжлэгтэй ярилцаарай.*

Намрын шөнийг нүд хараастай өнгөрүүлдэг болов, би. Харанхуй тэр чигээрээ Баянакийн нулимс мэлтэлзсэн нүд болж хувирна. Таван жил нэгэнт улиран өнгөрөөд таван хоногоос өөрцгүй санагдана. Өөдөөс минь ширтэх нулимс дүүрсэн нүдийг харж хэвтэхдээ: “Яав даа юунд ийм хэрэг хийв, хүү минь?” гэж санаандаа асууна. Заримдаа үнэхээр шивнэж орхиод өөрийнхөө дууг сонсохдоо нулимсаа барьж эс дийлнэ.

Аравдугаар сарын 29-нөөс 30-нд шилжих шөнө сөн. Аанай л нойргүй хэвтэж байтал үүдэнд хөлийн чимээ гарах шиг боллоо... Нохой бол яваад өнгөрөх учиртай гэж би бодлоо. Учир нь үүд хавиа би дөнгөж өмнөх орой нь цэвэрлэсэн байсан билээ. Чив чимээгүй болчихлоор нь өөрийгөө андуурч дээ гэж бодовч хэвтээд байж болсонгүй, эвтэйхэн босч хаалга хүрээд би чихээ ойртуулан чагналаа. Юу ч эс мэдэгдэв. Тэгэвч ор руугаа явах тэнхэл байсангүй, хаалгаа онгойлгоод өрөөсөн хөлөө босгон дээгүүр давуултал байшинтай чацуу өндөр хүн туурганд наалдан зогсч байгааг харахдаа аяархан дуу алдчихлаа. Айхтар харанхуй шөнө билээ, тэгэвч зүрх минь Баянакийг таньчихжээ. Хаалгаа угз татан хаагаад түгжих юм уу, гүйж ороод галтай буугаа шүүрээд ирэхийн оронд ухасхийн хүрч хүүгээ тэврэн аваад аль тааралдсан газрыг нь үнсч үнэрлэж гарахдаа өнгөнэтэл уйлж байж. Энэ бол баярласных байлаа. Учир нь ганцаардлын бэрхийг ясанд минь хүртэл мэдрүүлсэн энэ голгүй харанхуй шөнө ханьтай болж, тэр нь зуун гол, мянган уулыг туулан, алхам бүрд гэтэж байсан аюулыг ялан ялсаар төрсөн Алтайдаа хүрч ирсэн, яснаас минь хугарсан яс, махнаас минь тасарсан мах, миний үр байлаа. Намайг хөндийрөхөд хүү минь хөшчихсөн юм шиг зогсч хоцорсноо “Дуулаа биз дээ?” гэж сулхан хэллээ. Би түүнд хариу хэлэхийн оронд бушуухан татаж оруулаад, хаалгаа хааж, дэн асаав. Зөн совин гэгч нь тэр үү? Урьд тэгдэггүй би тэр орой таваг дүүрэн мах чанажээ, аваад урд нь тавьж өглөө. Бас данхтай хүйтэн цайнаас мэлтэлзтэл аягалж гарт нь бариуллаа. Энэ бүхэн нүд ирмэхийн зуур л болж өнгөрсөн хэрэг...

Баянакийн зажлах эрч нь намдах тусам миний сэтгэл түгшиж эхэллээ. Түрүүчийн баяр арилсан байлаа. Орон дээгүүр минь сумтай буу өлгөөстэй, эх орны өмнө гэмтэн болсон, гагцхүү тийм гэж итгэхэд даанч бэрх эцэж туйлдсан царайтай, төрсөн нутгаа тэмүүлэн гүйж ирсэн үлгэр судрын аргамгийг санагдуулам энэ хүний хувь заяаг үүр цайхаас өмнө шийдэх байлаа. Баянак цадав бололтой. Би зогссон чигээрээ: “За хө” гэлээ. Толгой нь гудайсхийв...

“Дөчин дөрвөн оны намар манай дарга урд хилд шилжлээ” гэж ярьж эхлэх нь тэр. “Орных нь ч хүн ирлээ. Ганцаараа ч биш дагуулсан нэг бүсгүйтэй юм. Эхэндээ охиныг нь л юм байх гэж бодож байлаа. Тэгэхнээ хожим нь дуулбал эхнэр нь юм санж. Цэрэг харахаар тушаах, тулгах юмаа олж ядан байдаг офицерын авгай нар байдаг. Саяын ирдэг бол тэд нартай төсгүй, өөр ертөнцөөс ирсэн юм шиг сайхан, чухамдаа хүүхдээрээ амьтан юм...

Наймдугаар сарын 3-нд дарга штабт дуудагдан очоод орой буцаж ирэв. Тэгээд л шөнөдөө манай анги дорныг чиглэсэн аяндаа гарч, үүр цайхад 280 км зам туулсан байлаа. Хаашаа л харсан морин цэрэг, танк, машины цуваа, бүгд л дорнын чигт. Тэгтэл зогсч үдшийг хүлээх тушаал ирлээ. Тунсаг дэргэдүүр өнгөрөхдөө ингэж шивэгнэдэг юм байна. “Цаадах чинь намайг замд хамаатнууд дээрээ орхих юм



байна. Тэгж танихгүй нутагт хаягдахаар хот орж, тэндээсээ цааш харья. Чи надад тусална шүү. Баянак!” Тэгээд хариу хэлэхийн завдалгүй яваад өглөө...

Тунсаг ердөө холдоогүй, харганы сүүдэрт хярсан болжмор шиг нугдайн сууж байв. Айсан дүрлэгэр нүдий нь хараад туслахгүй байж чадахгүйгээ мэдлээ. Гар буугаа тайлж гарт нь атгуулж өгөөд: “Алтан гадсыг л алдахгүй яваад бай. Үүр цайж”, нар гарахад зэвсгээ хаяарай. Тэгээд өдөржин явахад хүн, малын бараа харах бий гэлээ. Тунсаг намайг тэврэн авснаа: “Ачий чинь хэзээ ч мартаггүй” гэж цорхирон өгүүллээ. Тэврээс минь мултраад эргэтэл ард минь дарга зогсч байв. Гарт нь кинжаал гялалзана. Өрсөж бугуйн дээрээс нь шүүрч авлаа. Гуд татах гэсэн чинь барсангүй. Харин өөрийг минь өсгийдөж орхиж. Унахдаа бугуйгий нь тавьсангүй, часхийн хадах Тунсагийн дууг сонслоо...

Босч ирээд би Тунсагт “Цаадуулдаа хэл өг!” гэлээ. Гэтэл өнөөх чинь орь дуу тавьж цаашаа гүйхийн оронд түрүүхэн өөрт нь буцаан өгсөн гар буугий минь буцаан өгч: “Бушуухан зугтаж амь гарахаа бод!” гэх нь тэр. Би буугаа авсан боловч байрнаасаа хөдлөлгүй зогстол дарга хөдөлж, толгой нь өндийж ирснээ, хяхарган дуугаар “Дайны талбарт хүрээгүй байж үхэх аз муутай амьтан юм даа, чи!” гэлээ...

Би гүйчихлээ. Саргүй цэлмэг шөнө. Алтан гадсаар чиг барьж, гүйж гүйж нэг хэсэг алхаж амьсгаагаа дарж аваад л аанай гүйсээр. Үүр цайх үеэр бутан доогуур шургаж элсээр биеэ булаад хэвтчихлээ”...

Яаж зүдэрч яваад хүрч ирснийг минь мэдэж байна уу, аав аа?” гэж бууны голыг дагуулан харж хэлэв. Өдөржин нуугдаад шөнөжин явах гэгчийг? Далан хоёр өдөр, далан хоёр шөнө гээч! Нэг өдрийн хэчнээн уртыг, нэг шөнийн хэчнээн богиныг, чулууны хатууг, элсний халууныг та мэдэхгүй! Хэчнээн олон шөнө зүг чигээ алдаж, нүд минь од харахын, нүүр минь салхи мэдрэхийн хүслэн болж явахдаа, хэчнээн их айж, гутарч үзэв ээ, би! Тэгсээр арай гэж угаасан голынхоо усыг амтлахдаа, унасан нутгийнхаа шороог үнэрлэхдээ хэчнээн их баярлав аа, би.

Тэгээд тантай учрахдаа! Тиймээ, танаас хэдий айсан ч, орчлон дээр харж хандах орь ганц хүнээ гэж тэмүүлэн хүрч ирсэн билээ, би. Эцгийн зүсийг харж, дууг сонсов. Цаана нь бас эхийн булшийг олж, үнэрийг эрмээр, уултайгийн хэрэг юу билээ, оройд нь гарч талаа хармаар, антайгий нь хэрэг юу билээ, угалзы нь унагаж, тэхий нь намнамаар, өссөн газрынхаа өвсөнд нь хөлбөрч, шороонд нь тонгочмоор, өөрийн тэнгэрийн салхийг амталж, одыг тоолмоор, зуны бороонд нь шалба цохиулж навч цэцэгтэй цуг нарыг хүсмээр, өвлийн цасанд нэвс даруулж туурайтан жигүүртэнтэй цуг хаврыг хүлээмээр санж! Ашиг хайсан урвагч биш, амь бүрэлгэсэн алуурч биш, гагцхүү хүчинд хоригдсон хүний алаг үрд тус болох гэж яваад эндсэн, эндсэний эцэст эх орны даалгавар, эр цэргийн албанаас биш, оногдох ялаас, отох үхлээс зугтсан билээ, би!”... Цаашаа ярьж чадалгүй уйлж гарлаа. Нэг талаас үүрэг, нөгөө талаас хүү минь намайг хоёр тийш чангаасаар эцэст хүү минь дийллээ. Буугаа хаяад, Баянакийг үнсч: “Яв даа. Гэхдээ л хуулиас мултрах зам байдаггүй юм даа, бор туулай минь” гэлээ...

**Эх сурвалж:** (Ч.Галсан. “Аянгат цагийн тууж”. УБ., 1986, 7-74-р тал)



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

*Бугту* - Гириш, *Буга* - Жарын- тува туульсын гол баатрууд

*Нударган* - зарц, ядуусыг дарлан мөлжих баян этгээд

*Хоршоо* - санал хүчээ нэгдэн хавсарч, эд хөрөнгөө хамтруулан байгуулсан нэгдэл

*Пролетари* - капиталист нийгэмлэгт хөрөнгөтөн нарт мөлжигдөн дарлагдаж байдаг, үйлдвэрлэлийн хэрэгсэлгүй хөлсний ажилчин



## СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Зохиолын яруу хэл, гүнзгий сэтгэлгээ сэтгэлийг минь булаав” гэж ардчилсан Германы уншигч Клаус Өмихен “Нойес Дойчланд” сонинд удалгүй бичив. “Сэтгэлийг минь энүүн шиг хөдөлгөсөн номыг хамгийн сүүлд хэдийд уншсанаа санахгүй байна!...” гэж баруун германы уншигч Е.А. Толле гэгч гайхан бичжээ... Хэргийн учир ямар хэлээр бичсэнд биш, харин маш сайн бичсэнд л байгаа юм. Биднийг харь хол, ертөнцийн түм буман жижиг сажиг зүйлд төөрүүлж самгардуулахгүйгээр зохиолч цөөхөн, оносон, туйлдаа хүртэл цэнэгшсэн үгээр монгол эх орныхоо өнгөрсөн, ирээдүйн тухай цээжиндээ тээж явдаг бодлоо зураг болгон амилуулж байна. Тэрээр нурших дургүй шигээ бас ятгах дургүй, гагцхүү түүний хэлсэн бүгд нь сэтгэлийн үзүүрт сэрхийтэл хүрч, нүдэнд харагдаж, чихэнд дуулдаж, хамарт сэнгэнэж байх шиг санагдана...” гэж доктор Ирмтрауд Гучке “Нойес Дойчланд” сонинд гаргасан шүүмжиндээ Ч.Галсангийн уран бүтээлийг үнэлэн бичжээ... Их сэтгэгч Л.Түдэвийн хэлснээр “Жанибек, Баянакийн дүр бол манай уран зохиолд шинэ үзэгдэл юм...”

(С.Байгалсайхан. “XX зуун, тууж судлал”. УБ., 2014, 180-р тал)



## Унших чадвараа хөгжүүлэе

### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.

1. Туужийг бүрэн эхээр нь уншаарай. Зохиолд хэдий үеийн нийгмийн ямар асуудлыг хөндөж тавьсныг судалж, тайлбарлаарай.
  - Зохиолд юуны тухай өгүүлж байна вэ? Ямар асуудал хөндөж тавьсныг жишээ татан батлаарай.
  - Зохиолын сэдэв, утга санаатайгаа хэрхэн холбогдож байгааг дүгнээрэй.
  - Зохиолч ямар сэдвийн хүрээнд ямар мэдээллийг өгч, ямар утга илэрхийлэхийг зорьсон, зохиолчийн уншигчдад хэлэх гэсэн санааны талаар өөрийн дүгнэлтийг гаргаарай.
2. Зохиол дахь түүх, нийгэм, соёлын хүрээний үгс болон зохиолын хэсгээр дамжуулан сэдэв, хам сэдвийг тодорхойлоорой.
3. Монголын алс баруун хязгаарт, нэгэн угсаатны дунд 1921 он хэрхэн ирсэн, шинэ цагийн төрх, нийгмийн үзэл санааны их өөрчлөлт хэрхэн тусаж буйг загварын дагуу дэлгэрүүлэн тайлбарлаарай.

1921 он

- Үзэл санаа, амьдралыг хувааж ирсэн

- Эцэг үр хоёр, сэтгэлт эр эм хоёрын хоорондуур

- Уламжлалт ахуй, итгэл үнэмшил дээгүүр хөндөлсөж

- .....

- .....

- .....

4. Судлаачийн дүгнэлтийг өөрийн санаа бодолтойгоо харьцуулан ярилцаарай. “...Уран бүтээлийнхээ мөнхийн сэдвийг харсаар байтал мөхөж байгаа уугуул ард түмэн минь хэмээн өөрөө тодорхойлсон тэрээр бүр хожим 1992 онд нэгэн ярилцлагадаа “...Социализм бол их хатуу, гэхдээ сайн эцэг байсан юм. Нэг үгээр хэлэхэд намайг сайн хатааж өгсөн юм...” Ийм л үзэл бодлын ертөнцөөс “Аянгат цагийн тууж” төрсөн нь зохиолыг задлан авч үзэх явцад улам ч ил тод харагдана...”

(“XX зууны Монголын уран зохиол”, УБ., 2017, 375-р тал)

5. Жанибекийн дүрийн нийгмийн хүрээлэл, үүргийг судалж, уг хүрээлэл Жанибекийн дүрд хэрхэн нөлөөлсөн бэ? Өөр нийгмийн хүрээлэлд байсан бол яах байсан бол?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Туужийн сэдэв, утга санааг тодорхойлж, далд утгыг тайлбарлаарай. Тухайн үеийн нийгмийн үнэлэмж ямар байв? Нийгмийн “тунхаг уриа, үзэл суртал” нь хэний төлөө байсан талаар дэлгэрүүлэн ярилцаарай.
2. Яагаад “аянгат цаг” хэмээн утгаар туужаа нэрлэсэн бол? Аянга цахилгаан ямар байдаг билээ, харьцуулан тунгааж, зохиолын нэр, утгатайгаа хэр тохирч байгааг тайлан тайлбарлаарай.
3. Жанибек хэнд, юунд зориулж амьдарсан бэ? Тухайн үеийн нийгмийн ёс зүй, хүний мөн чанар хоёрын зөрчлийг баримтаар батлан, дүгнэлт гаргаарай.

**Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.**

1. Зохиолч туужаа бичихдээ зохиомжийн ямар хэлбэрийг ашигласан бэ?
2. Зохиолд байгалийн зураглалыг дүрийн сэтгэл зүйг тодруулахад хэрхэн ашигласан бэ?
3. Жанибекийн үзэл санаа зохиолын эхэнд, хүүгээ эрж байхад, хүүгээ алдсаны дараа хэрхэн өөрчлөгдсөн бэ? Баримтаар дэлгэрүүлэн тайлбарлаарай.
4. Хөгшин чоно, азарган чоно хоёрын дүрийг ялгаруулахдаа ашигласан дотоод яриаг түүж, утгыг задлан шинжлээрэй.

**Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.**

1. Зохиолын эхэнд тодруулсан хэсгийг уншаад, Жанибекийн хөрөг дүрээс түүний туулж өнгөрүүлсэн амьдрал болон юу бодож байгааг нь таамаглаарай.
2. Жанибек зохиолын эхнээс дуустал ямар, ямар ажил хийж, ямархуу байдалтай, яагаад тэгэж амьдарсныг жагсаан бичээд, тайлбарлаарай.
3. Жанибек хүүгээ ирэхэд баярлаж, бахархсан боловч юунаас айв? Хүүгээ яагаад явуулчлав? Зохиолын тодруулсан хэсгээс эцэг, хүү хоёрын бие, сэтгэл, харилцаан дахь уур амьсгалыг тайлан тайлбарлаарай.
4. Суяшийн дүр нь Жанибек болон Баянакийн дүрийг тодруулахад ямар үүрэгтэй байв?
5. Жанибек юу юуг нэгдүгээрт тавьж, түүний золиосонд юу, юуг амсав? Задлан шинжлээрэй.
6. Төрсөн үрээ гэх хүн ёсны сэтгэлийг нь, нийгмийн үнэлэмжид хүлэгдсэн ёс суртахуун нь дийлжээ. Үүнийг жишээгээр батлан, үнэлгээ дүгнэлт гаргаарай.

**ИТГЭЛ ҮНЭМШИЛ**

- Хувьсгалт үйл хэрэгт зүтгэх
- Шинээр тогтсон ёс суртахууныг сахих
- Хувийн нэр хүнд, итгэл үнэмшлээ хүндэтгэх
- Цэргийн хууль, нийгмийн тогтсон хэм хэмжээ
- .....
- .....

**АМЬДРАЛД НЬ ТОХИОЛДСОН ЗҮЙЛҮҮД**

- Амьдралын үнэний шорвог амт
- Хүн ёсны гэгээн ариун сэтгэл
- Төрсөн эцэг үрийн золгүй хувь заяа
- Хайр сэтгэл, төрсөн үр, аз жаргал
- .....
- .....

### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.

1. Эцэг, хүү хоёрын харилцаан дахь уур амьсгалд юу нөлөөлөв? Хэрвээ чи Баянакийн оронд байсан бол яах байсан бэ?
2. Доебуугийн дүрийг бүтээснээрээ зохиолч юу хэлэхийг хүссэн бэ?
3. Баянак яагаад дайны цагт цэргийн оргодол болон хувирсан бэ?
4. Туужид Жанибек, Доебуу, Суяш гурвын дунд Баянак хүүгийн амьдралын зам зовлон бэрхшээл дундуур өнгөрч байгааг зохиолоос эш татан тайлбарлаарай.
5. Зохиолд хүүрнэн өгүүлэгч буюу “Би” баатрын олж харсан зүйл болоод түүний сэтгэл хөдлөлийг төсөөлөөрэй.
6. Туужид өгүүлж буй хэрэг явдлын орон, цаг, нөхцөл байдлыг тодруулан тайлбарлаарай.

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.

1. Эрийн цээнд хүрсэн Баянак цэрэгт мордох үед “Сумын дарга” Жанибек үдэж байх үеийн зураглалд эцэг хүү хоёрын дотоод сэтгэл ямар байна вэ? *“Би байлдагчдын гарыг атгахдаа инээмсэглэн, эрс шийдэмгий байх юм шүү гэж дотроо бодсон бичлээ. Гэтэл Баянактай харц тулгарахдаа сэтгэл хямран, толгой эргэх шиг болов. Хүү минь жагсаалын магнайд, тогтож ядан байгаа хүлгийнхээ жолоог энэхэн агшинд султган, гялхийн одоход бэлэн байгаа мэт дөрөөн дээрээ өндийсөн байв. Би өвдөгт нь хүрснээ ухасхийн хүзүүдэж аваад, ойртуулан татаж ирээд, нүүр нүдгүй үнсэж гарсан бөгөөд ингэхдээ “Миний хүү!” гэж хашхирах шивэхийн хооронд ахин дахин хэлж байж. Тавиад харвал Суяший минь нүдийг хуулсан дүрлэгээр хар нүдэнд нь нулимс мэлтэлзэн, тэр нулимсны цаана “Намайгаа хөөж туугаагүй билүү, аав минь? гэсэн асуулт дүрэлзэж байв.”*
2. Зохиолд Жанибекийн гадаад дүр төрхийг хэрхэн зураглан дүрсэлсэн бэ? Зохиолчийн сонгон хэрэглэсэн үг хэллэг, бичил дүрслэлээс сонгон тайлбарлаарай.



Бичих чадвараа хөгжүүлье

### Зохиолын хэлбэр бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиё.

Уншсан өгүүллэг, туужаас сонгон зохиолын санааг тусгаж, хэл найруулга, уран дүрслэлээс ашиглаж санаагаа төгсгөн зохиож бичээрэй.

Бичихдээ:

1. Ямар сэдэвтэй, ямар асуудал дэвшүүлэхээ төлөвлөөрэй.
2. Уншигчид юу хэлэхийг хүсэж байгаагаа бодоорой.
3. Эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар, ямар үйл явдал гаргахаа төлөвлөөрэй.
  - Эхлэл хэсэгт дүрийнхээ зорилго, гадаад дүр байдал, зан чанарыг танилцуулж, дүрсэлж бичээрэй.
  - Гол хэсэгт баатруудад тохиолдсон явдлаа, тэдэнд тохиолдсон бэрхшээл, түүнийг даван гарсан тохиолдлууд, баатрууд боломжийг ашиглаж байгаа үйл явдлууд, баатруудын хоорондох харилцан яриа зэргийг зохиож, зохиосон үйл явдлаа цогцолборуудад хуваагаарай.
  - Төгсгөл хэсэгт уншигчид юу хэлэх гэж байгаагаа дүгнээрэй.





4. Төлөвлөсний дагуу ноороглоорой.
5. Нооргоо засах: Найруулгын засвар хийхдээ баримтын засвар, учир шалтгааны, гоо зүйн алдаа байгаа эсэх болон зөв бичгийн дүрмийн алдааг хянаарай.
6. Дахин сийрүүлж бичээрэй.
7. Хэрхэн бичсэнээ өөрөө үнэлж, бусдад илэрхийлээрэй.

**Жишээлбэл:**

**А.** Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь” тууждаа “Байгалийн амьтан байгальдаа хүчтэй, байгальтайгаа зохицож чаддаг нь хүчтэй байдаг гэдгийг чонын амьдралаар харуулахыг зорьсноос гадна хүн хэмээгч ухаант амьтан араатнаас дор, сул дорой, хүчгүй амьдарч болохгүй” гэсэн санааг уншигчид хэлэхийг хүсчээ. “Үүндээ: Ухаарч амьдрах хорвоо юм шүү”, “Энэ бол ертөнцийн жам хууль юм”, “Амьдрахын төлөөх, оршин байхын төлөөх тэмцэл”, “Амьдрах гэдэг алалцах дайснаас хэцүү гэсэн санаануудаас оруулан бичиж болно.”

**Б.** С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгээс төрсөн сэтгэгдлээ эргэцүүлж “Тус хүргэсэн хэн нэгний тухай бусдад бахархан ярьсан ч нэг л дутуу санагдаж байгаа бол, хэн нэгнийг баярлуулаагүй мэт санагдан, сэтгэл зовж байгаа бол” санаагаа төгсгөн зохиож бичээрэй.



**Сонсох-ярих чадвараа хөгжүүлье**

**Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэе.**

Уншсан өгүүллэг, туужаас сонгон зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгээрэй. Илтгэхдээ:

1. Зохиолуудаас уран дүрслэл, яруу хэрэглүүрүүдийг түүвэрлэж, тэдгээрийн үүргийг тайлан тайлбарлаарай.
2. Зохиол дахь уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ойролцоо утгатай үг хэллэгээр солин найруулах боломжийг судлаарай.
3. Орчин, дүрийг гаргахдаа өвөрмөц, содон ямар үг хэллэг хэрэглэснийг тайлан тайлбарлаарай.
4. Зохиолынхоо орчин, дүрийг сонгон авч, илтгэл бичих сэдвээ сонгоорой.
5. Уран сайхнаар илтгэх арга барилд суралцаарай.

**Илтгэл бичих дараалал:**

1. Сэдвээ сонгох
2. Зорилгоо тодорхойлох
3. Шаардлагатай материал цуглуулах
4. Төлөвлөгөө гаргах
5. Илтгэлийн бүтцээ гаргах
6. Бүтцэд ахмаарах агуулгаа багцлах
7. Агуулгад хамааралтай баримтаа цэгцлэх
8. Илтгэлээ ноороглох
9. Агуулгыг уран дүрслэл, яруу хэрэглүүрээр баяжуулж бичих
10. Бичсэн илтгэлээ нарийн нягталж, бусдад хүргэх арга замаа сонгоно.

## ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ:

**Мэдлэгээ үнэлъе.**

- Өгүүллэгүүдэд ялгаатай тал байна уу?
  - Зохиолчийн үзэл бодол уу?
  - Дүр бүтээсэн байдал уу?
  - Уншигчдыг татах үг хэллэг үү?
  - Үйл явдлыг өрнүүлсэн орчин, нөхцөл байдал уу?
- “Дэвхрэг” аль дүрийн хоч вэ?
 

а Сэнгээ       б Хангай       в Жав       г Жамц
- “...Ганцхан атга болтол хурааж цуглуулсан адууны дундуур хага зүсэж ороход нь...” гэж аль дүрийг дүрсэлсэн бэ?
 

а Самбаа       б Сэвжидмаа       в Төгөө       г Дорлиг
- Л.Өлзийтөгс “Аквариум” өгүүллэгт бүтэн нэг жилийн туршид гэр бүлийн гишүүд нь хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнэн бичээрэй.
- “Дулаан Хайрханы хүү” гэж аль дүр вэ?
 

а Жанибек       б хөгшин чоно       в Баянак       г гичий чоно
- Гол дүрийг сонгон тэмдэглээрэй.
 

а Суяш       б Доёбуу       в Жанибек       г Тунсаг
- “Нүдний гал бууран, шүдний ир элэгдэж, үс зулбан, зүс зэгэл, эцэж турсны хувьд ясан хэдрэг ээ...” гэсэн эшлэл бичлэгийн ямар хэлбэр вэ?
 

а дурсамж       б хөрөг зураг       в хүүрнэл яриа       г байгалийн зураглал

**Чадвар, хандлагаа үнэлъе.**

- Өгүүллэг, туужуудаа бүрэн эхээр нь уншсан уу?
- Зохиолын сэдэв, хам сэдвийн холбоо хамаарлыг тайлбарлаж чаддаг болсон уу?
- Өгүүллэг, туужийн дүрүүдээс юу суралцав? Тоочин бичээрэй.
- Сонсох-ярих чадварын ерөнхий шаардлагыг судалж, өөрийгөө үнэлээрэй.

Сонсох-ярих чадварыг үнэлэх шалгуур	Маш сайн	Сайн	Сайжруулах шаардлагатай
Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрийг таньж сонгож чадсан уу?			
Таньж сонгосон үг хэллэгээ дуурайн эсвэл шууд хэрэглэн илтгэж чадсан уу?			
Уран дүрслэлийн аргыг хэрэглэн илтгэж чадсан уу?			
Илтгэхдээ бусдын сонирхол, анхаарлыг татаж чадсан уу?			
Илтгэхдээ өөртөө итгэлтэй байж, дуу хоолойныхоо өнгө, хурдаа тохируулсан уу?			
Илтгэлийнх нь бэлтгэл, бичлэгийн байдал хэр байсныг үнэлээрэй.			

- Ярих чадвараа хэрхэн сайжруулах вэ?

## Гуравдугаар бүлэг

# МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН РОМАН

### ГУРАВДУГААР БҮЛГИЙН ЗОРИЛГО




Монголын орчин үеийн романуудаас уншиж зохиолын үйл явдал, үзэл санаа, сэдвийн уялдаа холбоог дүгнэх, далд утгыг задлан шинжлэх, зохиомжийн бүрэлдэхүүн хэсгийг олох, дүрийн зан чанарыг тодорхойлох, зохиолын гадаад, дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгаа болон эдгээр нь утга санаанд ямар үүрэгтэй буйг тайлах, нийгэм, цаг үеийн байдал, төрөл зүйлийн онцлогийг тогтоож дүрслэлийн яруу тансгийг мэдрэн өөрийн сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлнэ.



Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцаж хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэнэ.



Романыг уншсаны дараа үзэл бодол, байр сууриа илэрхийлэн ярихдаа зохиолд гарах уран дүрслэл, яруу хэрэглүүр, үг хэллэгийг ашиглан жишээ баримт, эшлэл үндэслэлтэй тайлбарлаж, бусдын үзэл бодлыг анхааралтай сонсож дүгнэлт хийнэ.



## ЗОХИОЛЧ



### Чадраабалын ЛОДОЙДАМБА (1917-1969)

1917 онд Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутаг Сүхийн гол гэдэг газар төржээ. Анхны “Малгайтай чоно” (1944) өгүүллэгээс хойш “Солонго”, “Чулуун”, “Хугараагүй ноён нуруу”, “Төмөр багана”, “Өргөдөл”, “Шаргачин” зэрэг хорь гаруй өгүүллэг, “Хэний буруу вэ?”, “Манай сургуулийнхан” зэрэг туужууд, “Соого хар” кино зохиол, “Гарын таван хуруу”, “Ёс ёмбогор, төр төмбөгөр”, “Итгэж болно” зэрэг жүжгүүд, “Тунгалаг Тамир” хоймсон роман бичжээ.

“Тунгалаг Тамир” романаа 1954-1967 он хүртэл 13 жил гурван сар бичсэнээ гар бичмэлдээ тэмдэглэн үлдээсэн бөгөөд эл роман нь Орос, Болгар, Вьетнам, Герман, Куба, Казах, Киргиз, Румын, Чехословак, Япон зэрэг оронд орчуулагдан хэвлэгджээ. 1954, 1971 онд Монгол улсын Төрийн хошой шагнал хүртжээ.



## УНШИХЫН ӨМНӨ

- Хүүхдүүд ээ, та нар “Тунгалаг Тамир” киног үзсэн үү? Хэдэн ангитай, ямар үйл явдал гардгийг сэргээн санаарай. Эх зохиол, дэлгэцийн бүтээл ямар ялгаатай болсныг хоорондоо ярилцан багшаасаа дэмжлэг, туслалцаа аваарай.
- Роман нь туульсын зохиолын бусад төрлөөс ямар ялгаатай вэ? Өмнөх ангид уншсан орчин үеийн сэдэвт романуудаа сэргээн санаарай.

### ТУНГАЛАГ ТАМИР (Романы хэсэглэл)

“Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв. Нар салхинд гандаж, хир хөлсөнд нэвтэрч урагдсан дээлээ есөн өнгийн юмаар нөхсөн болохоор ямар эдээр хийсэн нь мэдэгдэх аргагүй ажээ. Ханхар дөрвөлжин мөрөндөө утаа болсон цахиур буу хөндлөн үүрч, даахирсан бүдүүн хар гэзгээ дарайсан хуучин хөх ямбуу алчуураар шуужээ. Шороонд буурал болсон өтгөн хар хөмсгөн доорх том гэгчийн дүрлэгэр нүд нь удаан цавчилж, хөлс дааварласан хүрэн нүүрэнд нь урт замын алжаал илэрч, гүн бодолд автагдан хүрлийхийг харвал ядарсан буюу уурласан алин болох нь мэдэгдэмгүй ажээ...

Энэ хүнийг Эрдэнэ гэдэг. Засагт ханы хошууны Олгонууд отгийн хүн. Уулаас эцгээс ах дүү хоёул бөгөөд багадаа өнчрөн айл дамжин зарагдаж бор хоног өнгөрүүлэн явжээ. Дүү нь Төмөр гэгч хүн бий. Арван зургаан насандаа шилийн сайн эрчүүдтэй нийлж удалгүй эрмэг зориг, эр чадал ухаан санаагаар гайхагдсан «Засагт ханы цахиур Төмөр» гэж алдаршин халх дөрвөн аймаг, шавь тавд домог мэт яригддаг болжээ...

Эрдэнийн өөрийн нь хувьд гэвэл багадаа Доной тайжийн хонь хариулж, хурдан морийг нь унаж байхдаа хүү Чулууны нь бичиг заалгахын далимаар бичиг сурч, уулаас ухаан сэргэлэн болохоор «Оюун түлхүүр», «Цаасан шувуу», «Гурван улсын



бичиг», «Алтан товч»-оос эхлэн олдсон юм бүхнийг уншин гуйсан хүнд өргөдөл, захиа бичиж удалгүй «Бичээч Эрдэнэ» гэж нутагтаа алдаршжээ. Арван найман насандаа нутгийн Долгор гэдэг бүсгүйтэй дэр нийлүүлэн гэр барьж амьдрал. Бас арваад сарлаг, хоёр гурван унах морь, хэдэн хоньтой болжээ. Эрдэнэ бусад хүн шиг зовоходоо зовж, өлсөхдөө өлсөж, баярлахдаа баярлаад, хорсохдоо хорсоод амьдарч болох байжээ. Гэтэл шинээр ширээ залгасан засаг хаан Гомбожавын зан авир ширүүн, ард олныг зовоох нь хэр хэмжээнээс хэтрэхэд чуулган дарга, монгол манж зургааныг дамжин заргалдав.

Гэвч ноёнтон өшөөтэй бол хонгогүй, нохойтой өшөөтэй бол хормойгүй гэдэг дэмий үг биш болохоор Гомбожав хошууны хөрөнгөөр хөлөө хүрэх газар бүхэнд хээл хахууль цутгаж байгаад эзэн ноёнтонгоо харгалдсан тэрсүүд албатыг Улиастайн бат гүнд хорьж орхив...

Эрдэнийг нутагтаа очиход нь хорссон хааны хавчлага байж суухын аргагүй болоход нь албан татвар, аль нэгд өчүүхэн хөрөнгөө хамж өгөөд ганц морин тэргэнд юмаа ачиж Богдод мөргөхөөр эхнэр хүүхдээ дагуулан хүрээний зүг зам хөөжээ...



#### УНШИХ ЯВЦАД

- *Эл хэсгээс цааш томоохон ямар гол үйл явдал болсныг дараах зургаас ургуулан бодож тайлбар бичээд эх зохиолтой харьцуулаарай. Орхигдсон хэсгүүдийн агуулгыг товч төлөвлөгөө байдлаар нэгтгэн бичиж зохиолыг бүрэн болгоорой.*



Эх сурвалж: mass.mn

...Өмнүүрээ гарсан ялааг үмхэх гээд чадалгүй ангайж хоцорсон шувууны ам шиг голын баруун тал руу хойноос шааж орсон урт амны адаг, өргөн дэнж дээр дундаа хонины хашаатай чандманилан буусан гурван гэр хот айл харагдана. Баруун өмнөх том гэрээс хөх даалимбан дээлтэй хуучивтар луучин гутал өмссөн сийлмэл төмөр хэт бэлтэй, үйсэн иштэй хутга зүүсэн, гялалзсан дугуй бор царайтай, тогтож ядсан давхраа алаг хурц нүдтэй, бүдүүн хар гээгтэй хүн гарч ирээд дөнгөж тэмдэг орж байгаа үүрийн гэгээнд дөрвөн зүг найман зовхисыг ажиглан зогсов. Энэ хүнийг Итгэлт гэдэг. Одоо гучин хоёр настай. Итгэлт ямар ч язгуур угсаагүй. Эцгээс уламжилсан өв хөрөнгө бага боловч хайрга чулуу мэрэхээс бусдыг хийж байгаад Луу гүний хошууны тэргүүн баяны нэг болжээ. Арван есөн насандаа Далай чойнхор вангийн Лувсан тайжийн охиныг ёслол авч өмчид нь овоо мал авсан нь хөрөнгөжихийн эх сурвалж болжээ. Гаднаа цөөн мал байлгаж бусдыг хэдэн хошууны ядуучуудад суурилан өгч хариулгадаг ажээ.

Итгэлтийн бүл гэвэл эхнэр Должин, арван настай хүү Хонгор, долоон настай охин Солонго ийм дөрвөн халуун амь билээ. Итгэлт үүрийн гэгээ цайхаас эхлээд үдшийн бүрэнхий болтол борви бохисхийхгүй юм хийж байдаг. Хавь ойрын хүмүүсээ ч яг тийм байлгахыг хичээдэг...



Итгэлтийн нуруу намхан, туранхай боловч булчин шөрмөс болсон бие нь гүйж, үсэрч явахаар зориуд заяагдсан мэт бөгөөд нутгийнхан «Дэвхрэг Итгэлт» гэж хочилдог. Итгэлт шогшсоор гэрийнхээ гадна очиход хүү Хонгор нь нүдээ нухлан гарч ирэв.

- Муу хүний нойр, мулгуу хүний шүлс гэгчээр нойрмоглоод, заяа нь орхисон тархи. Бушуухан үнээгээ хураагаад ир гэж тэртээ хойт энгэрт идэх нь идэж, хэвтэх нь хэвтэж байгаа сарлаг хайнаг голдуу үхэр лүү заав. Хонгор бургасан шилбүүр авч мордон гүйх гэхэд нь «Мод битгий уна, заяа нь орхисон тархи» гэж эцэг нь зэмлэн зогсоов...

- Хонгор хүү гүйсээр гүн жалганы эхээр гарах гэтэл ёроолд ямар нэгэн дуу гарахад зог тусан зогсож харлаа.

- Дүү минь гүйгээд ир гэж тэртээ дороос бүдүүн дуутай хүн дуугарав.

- Ажиглавал тэр дор хүн гэхэд ч бэрх, биш ч гэхэд бэрх нэг юм хөдөлж байв.

- Дүү минь битгий ай. Ах нь нэг ядарсан хүн байна гэж паргисан дуугаар хэлэхэд Хонгор жалга руу орж ойртон очив.

- Ах аа, та хүн үү? гэж толгойгоо далжийлган нүдээ жартайлган ширтэж байгаад асуув.

- Би хүн. Дүү минь хүрээд ир. Тэр бол аргагүй л хүн байлаа. Чингэхдээ хоёр гаргүй хүн хэвтэж байв. Хир хөлсөнд баригдаж үс сахал нь ургаад эрэг мөргөж байгаад гарсан сарлагийн бух шиг болсон тэр хүний нүүрэнд хоёр нүд гялалзах ажээ.

- Эр хүн, эр хүнээсээ айх хэрэггүй гээд тэр хүн инээмсэглэв.

- Би айгаагүй гээд хүү эвгүй юм гарвал буцаад зугтахад бэлхэн алгуурхан ойртов. Хатсан ширэн хөнжил дотор зөвхөн толгойгоо гаргаад хэвтэж байгаа тэр хүний нүд гялалзан, цэлмэг хөх тэнгэр өөд цавчилгүй ширтэж байв.

- Ах аа, та бос л доо.

- Ах нь босож чадахгүй.

- Яагаад босож чадахгүй байгаа юм бэ? Тэр хүн хэсэг дуугүй болж, нүднийхээ булангаар Хонгорыг ширтэв.

- Ах нь ширлэгдсэн хүн. Луу гүний тамган дээрээс оргоод энд ирлээ. Хүн мэдвэл намайг барьж аваад ална. Гэвч эр хүн эр хүндээ хайртай байдаг болохоор ахдаа тус болох байх гэж итгэж байна гэлээ. «Эр хүн эр хүндээ хайртай» гэдэг үг Хонгорын сэтгэлд харван орж, баяртай инээмсэглэн, ихэмсгээр хоолойгоо түрж засаад,

- Би танд яаж тус болох вэ? гэж хиймэл бүдүүн дуугаар асуугаад хажууд нь тулж очив... Ширтэй хэвтэж байгаа энэ хүнийг цахиур Төмөр гэдэг. Өнгөрсөн намар Луу Гүний ноён сүргээс тасалж хөөгөөд гэнэт үерлэсэн Тамирын голд мориноосоо салж үхэхийн даваан дээр аврагдахын хамт баригдаж хэд хоног жанчигдан байцаагдсан боловч нутаг ус, нэр алдраа хэлсэнгүй...

Төмөр эр зааж, эрүү шүүлтийг шүд зуун давж, үг дуугараагүй боловч адуу хөөсөн хэрэг нь даанч ил болохоор ширлэгдэж жил шахам болоод хоёр хоногийн өмнө оргож бөмбөрсөөр урд шөнө энд иржээ...

(1967 оны 4 дүгээр сарын 6)

**Эх сурвалж:** (унших): Ч.Лодойдамба. "Тунгалаг Тамир" I, II дэвтэр (Сонгомол эх). УБ., 2015. Цахим сурвалж (сонсох): <https://www.youtube.com/>

#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Засагт хаан** - одоогийн Говь-Алтай аймгийн зүүн ба зүүн өмнөд сумд

**Олгонууд** - Говь-Алтай аймгийн Халиун, Тайшир сум



## СУДЛАЛ ШҮҮМЖ

“Хүний амьдралыг нэвт харж сэтгэлийн түмэн эгшиг авиаг нэгд нэгэнгүй сонгон ялгаж зүрхний тушаалаар бичдэг хүний үзгэн дороос “Тунгалаг Тамир” урсан гарчээ”.

(Л.Түдэв. “Сэтгэл эзэмдэн дуулагч”. Утга зохиол урлаг. 1967, №34.)

“Зохиолч Ч.Лодойдамба романыхаа бүлэг бүрийг биеэ даасан зохиол шиг болгож чадсанаар барахгүй бүлгийн дотор гарах зүйл бүр дээр ямар нэгэн шинэ соньхон үйл явдлыг гаргасан утга санаагаа нэвтрүүлжээ. Гэхдээ одоо цааш нь юу болох бол гэсэн сонирхол төрүүлсэн зангилааг романыхаа турш хадгалж чадсан байна. Хэдийгээр бүлэг бүр нь биеэ даасан янзтай боловч мөнөөхөн романы дотор авцалдаагүй буюу салангид болсонгүй. Ямагт нэгэн зүйл үргэлжилж яваа юм шүү гэсэн утга санааг хадгалан байсаар эцэстээ гол утгаа гаргасан байх юм”

(Б.Содном. “Тунгалаг Тамир романы зохиомжийн асуудалд”. Зохиол судлал-1. УБ., 2009, 828-р тал.)



## Унших чадвараа хөгжүүлэе

**Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.**

1. Романыг бүрэн эхээр нь уншиж ойлгоорой.
2. Нийгмийн анги, давхарга гэж юу вэ? Зохиолч аль ангийн төлөөллийг юуны учир дэмжсэнийг онцлон жишээ татан ярилцаарай.
3. Уг романыг ХХ зууны нийгмийн бүхий л амьдралыг томруунаар зурсан хөрөг болжээ гэдэгтэй санал нэг байна уу? Яагаад?
4. Романы үйл явдлаараа монголын нийгэм, түүхийн ямар цаг үе, асуудлыг хэрхэн хөндсөнийг дараах тулгуур үг, өгүүлбэрийн дагуу дэлгэрүүлэн ярилцаарай.
  - Нийгэм, түүхийн хувьд ямар, ямар онцлогтой байв, хэдий үеийн тухай өгүүлж байна вэ?
  - Монголын ард түмний, улс үндэстний хувь заяаг хэрхэн, яаж дүрслэв?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

1. “Тунгалаг Тамир” романд нийгмийн анги давхаргын талаар мартахааргүй тод содон дүрслэл, зөрчил, түүнд хандах баатруудын санаа бодлууд, зохиогч аль ангийн төлөөлөгчдийг дэмжиж байгааг эхийн онцлог

- дүрслэлээс сонгож тайлан тайлбарлаарай.
2. Зохиолч харгис түрэмгийлэгчид, хар, шар феодалуудын хар санаа, балмад явдлуудыг хэрхэн уудлан илчилсэн бэ?
  3. Лам, ноёд яагаад ардын хувьсгалын үйл ажиллагааг эсэргүүцэн тэмцэж байсан бэ? Тухайн нийгэм, цагийн нөхцөл байдлыг төсөөлөн бодож саналаа солилцоорой.
  4. “Тунгалаг Тамир” романыг судлаачид түүх хувьсгалын сэдэвтэй гэж дүгнэсэн байдаг. Яагаад гэдгийг батална уу?

### Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.

1. Романы өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлон, хэрэг явдлыг тоймлон гаргаарай.

Өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсэг	Гол үйл явдал
Эхлэл	
Зангилаа	
Өрнөл	
Туйл	
Тайлал	
Төгсгөл	

2. Романы үйл явдлаас зохиомжийн бүрэлдүүлбэрт тохирох жишээ олж, тайлан тайлбарлаарай.

- |                 |                        |
|-----------------|------------------------|
| • Хүүрнэл яриа  | • Байгалийн зураглал   |
| • Харилцан яриа | • Зүүд                 |
| • Үглэл яриа    | • Дотоод яриа          |
| • Хөрөг дүр     | • Зохиолчийн тэмдэглэл |
| • Өчил          | • Эргэцүүлэмж          |

3. Романд дүрслэгдэж байгаа байгалийн байдлыг зохиолын гол баатрын үйл хэрэг, бодол санаа, сэтгэл хөдлөл, амьдралын зорилго үйлтэй холбож дүрсэлсэн 3-аас доошгүй жишээгээг сонгон зан төрх, ажил үйлийн хосолмол хэв шинжийг тайлан тайлбарлаарай.
4. “...Намар гоёлоо өмсөж, ургамлын өнгө нь шар ногоон туяатай болчхоод өглөө үдэш өндөр уулын оройд хөхөмдөг манан тунаран, тарга хүч авсан мал налайн бэлчиж, өнтэй газрын сайханд өнгө жавхаа бүрдсэн шувууд дээдээхэйнүүдээ дагуулан ганганалдаж байгаа Тамирын голын хөндий нь саяхан суусан нөхрөө дагаад наадамд явах гэж үс гээгээ самнасан залуу бүсгүйтэй адил байлаа...” гэсэн дүрслэлийн утга, үүргийг тодорхойлоорой.
5. “Тунгалаг Тамир” романыг зохиолч “Хорвоо чи хүний зовлонд цадах болоогүй юу?” гэж яагаад төгсгөв?

### Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.

1. “Тунгалаг тамир” романд янз бүрийн зан төрх, төөрөг тавилантай олон уран дүр буй. Тэд нийгэм түүхийн гурван үеийн төлөөлөл юм. Иймд аль нэг



- үед хамаарах дүрийг сонгон зохиолд ямар үүрэг гүйцэтгэснийг зохиолын үйл явдал, цаг хугацаа, үйлдэл сэлтээр нотолж бичээрэй.
2. Хүүхдүүд ээ! Итгэлт баяны эхнэр Должингийн байранд өөрийгөө тавьж, Хонгорын гэрлэлтэд хэрхэн хандаж байгаа талаар өөрийн бодол санааг зохиолоос жишээ татан тайлбарлаарай.
  3. Ч.Лодойдамба Хонгорын дүрээр хүний ямар үнэ цэнт зан чанаруудыг онцолж, баатрын төөрөгдлийн үр дагаврыг хэрхэн шийдэв? Зохиолч Хонгорт хэрхэн хандаж байгаа баримтуудыг өөрийн байр сууринаас тодорхойлж бичээрэй.
  4. Та өөрийг Бат хэмээн төсөөл. Тэр, Хонгорт туслахаар цэргийн татлагын газар ирсэн. Гэвч... Та өөрт төрсөн сэтгэгдэлдээ түшиглэн хариулаарай.
  5. Зохиолын ямар хэсгүүдэд Итгэлтэд хандах зохиогчийн хандлага хэрхэн хурц илэрч байгааг тогтоож, дүгнэлтээ жишээгээр нотолж бичээрэй.
  6. Цахиур Төмөрт тусласан Хонгор хүүд ямар сэтгэгдэл төрөв? Цаашдын хувь заяа, үзэл бодолд нь нөлөөлсөн эсэхийг ургуулан бодож санал сэтгэгдлээ бусадтайгаа хуваалцаарай.
  7. Төмөрийн дүрийн зан төрхийг бусдын яриагаар хэрхэн тодруулж байна вэ?

**Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.**

1. Төрсөн ахыгаа гэр бүлтэй нь хээр явгалан мориор нь хөл залгасан Төмөрийн шийдвэр зөв үү? Буруу юу? Энэ хэсэгт Төмөрийн ямар зан чанар илэрч байна вэ?
2. Зохиолч Хонгорт хэрхэн хандаж байгаа баримтуудыг тодруулж тайлбарлаарай.
3. Эрдэнэ бичиг үсэг мэддэг нь амьдралд нь хэдэн удаа хэрхэн нөлөөлсөн бэ? Гол дүрүүдийн хэв шинжийг тоочин ярилцаарай.
4. Доорх хүснэгтэд байгаа эмэгтэй дүрүүдийн онцлогийг эх зохиолоос баримт жишээ татан бичээрэй. Дүрүүдийн зан төлөвийн онцлогийг харьцуулан ярилцаарай.

	Дулмаа	Долгор	Гэрэл	Должин
Зан чанар				
Нийгмийн хүрээлэл				
Хайр сэтгэлдээ хандах хандлага				
Тухайн үеийн нийгмийн өөрчлөлтөд оролцсон шалтгаан				

5. Төмөр энгийн ардад ямар, ямар тус хүргэсэн бэ? Харин Төмөрт хэн, хэчнээн удаа тус хүргэсэнтэй харьцуулан ярилцаарай.
6. Итгэлт баянтай уулзаж хөрөг найруулал бичих гэж байгаа сэтгүүлч гэж өөрийгөө төсөөлөөрэй. Найрууллынхаа баатрын зан төрхийг тод илэрхийлсэн хэсгээс авч нотлоорой.

**Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.**

1. Зохиолч энэхүү романаа анх монгол бичгээр бичсэн байна. Сонгодог монгол хэл, орчин цагийн монгол хэлний найруулгын ялгаа хэрхэн илэрч байгааг ажиглаарай.

2. “Тунгалаг Тамир” романд эрх мэдэлгүй, ядуу бүсгүйд сайн сайхан амьдрах боломж байгаа эсэхийг тогтоож, зохиолын аль нэг бүсгүйг сонгож түүний талаарх нарийн ширийн дүрслэлээр нотолж, өөрийн байр сууриа илэрхийлж бичээрэй.
3. Зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарлахдаа дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Эшлэл	Үгсийн уншигчид үзүүлэх нөлөө

4. Эмэгтэйчүүдийн дүрийг хэрхэн дүрсэлсэн хийгээд түүний байр байдлын тухайд зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарлахдаа дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Эшлэл	Үгсийн уншигчид үзүүлэх нөлөө

### ЗОХИОЛЧ



#### Лодонгийн ТҮДЭВ

1935 онд Говь-Алтай аймгийн Наран суманд төржээ. Соён гэгээрүүлэгч, зохиолч, нийтлэлч. 1956 онд УБДС, 1967 онд ЗХУ-ын нийгмийн ухааны академи төгсөж эрдмийн зэрэг хамгаалжээ. 1962 оноос “Утга зохиол” сонины эрхлэгч, 1968 оноос МЗЭ-ийн хорооны орлогч дарга, “Үнэн” сонины эрхлэгчээр ажилласан. 1950-иад оноос уран зохиол бичиж, роман тууж, өгүүллэг, нийтлэлийн 39 боть туурвин хэвлүүлээд байна. Түүний олон нийтийн болон утга зохиолын үйлсийг 1979 онд ЗХУ-ын Улс түмний найрамдлын одон, Болгар улсын Кирилл Мефодын одонгоор шагнажээ. 1971 онд “Уулын үер”, “Нүүдэл суудал” романаараа Төрийн шагнал, 1989 онд Соёлын гавьяат зүтгэлтэн цол, 1994 онд Ардын уран зохиолч, 1997 онд Хөдөлмөрийн баатар цол хүртжээ. “Дал” хэмээх монголын анхны зөгнөлт сониныг эрхлэн гаргаж энэ чиглэлийг хөгжүүлэх үйлсэд хүчин зүтгэж байна.

#### УНШИХЫН ӨМНӨ

- Монгол-Төвөд улсын түүх, соёлын харилцааны талаар сурагчид та нар юу мэдэх вэ?
- Романыг яагаад “Оройгүй сүм” хэмээн нэрлэсэн бол? Бодож уншаарай.
- Ишданзанваанжилын “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” зохиол уншсанаа сэргээн санаарай.





## ОРОЙГҮЙ СҮМ (Романы хэсэглэл)

*Аргагүйн эрхэнд даяанч буюу эхлэл  
Урьдын баян хожим үгүйрвэл хөөрхий  
Урьдын ноён хожим буурвал хөөрхий  
Урин тэнэгүүдийн дунд ганц цэцэн хөөрхий*

...Их говийн зэлүүд хязгаарт торойх бараагүй, анир чимээгүй дүнсгэр ажээ. Гагцхүү царцаа, голионы часхийх дуунаас өөр юу ч үл сонсогдох дүлий шар элсэн дунд гэв гэнэт нэгэн хар юм бүртэлзэн үзэгдлээ... Бүртэлзэн шовсхийсэн тэр нэгэн нь загийн үжир үндсээр таяг хийж тулсан, хижээл насны сохор хүн байлаа. Нүд нь шаравтар бөгөөд цэлдэн мэт өнгөтэй, хараагүй болсон ажээ. Зүс царай нь төдий л доройтоогүй мөртлөө сэтгэлийн их зовиуртай нь илэрхий үзэгдэнэ. Залуудаа цэвэр, цэмцгэр явсан хүний шинжийг хадгалсан хэвээр аж.

- ...За үүлэн бор минь, жолоогоо сунгая. Найман шаргьндаа очъё. Тэд чи бид хоёрт идээгээ зэхсэн байна. Хурдан очихгүй бол гомдчихно. Дунд Шаргын буян дэлгэрэй! гэж сохор эр таягандaa хандан бас л чанга дуугаар хэлэв. Таягаа үүлэн бор морьтой зүйрлэн нэрлэсэн бололтой. Гэтэл бас найман шаргынх гэж юуг хэлж байгаа юм бол доо! Нэгэн бодоход энэ хүн сохор төдийгүй бас ухаан гажсан мэт ажээ.

- ...Ай даа, хорвоо гэдэг бөөрөнхий юм даа. Намайг хүмүүс цөлж хатаан өлсгөж алахаар шийдсэн байдаг. Гэтэл хүний хэл үл мэдэх зэрлэг ботгоныхоо бор гэдсэнд багтаагүй сүүгээрээ амь голыг минь зогсоож, нас хайрлаж байдаг. Саяхан л би чинь тэмээг сэтэрхий уруултай хүйтэн хошуутай амьтан гэж боддог байж дээ. Саяхан л би “Шашны болоод хүнд хорыг хүргэгч хөлчин чөтгөр бүгд ес, түүний дотроос доройтуулагч хөлчин халзан тэмээ унана” гэж ирээд л ном буулгадаг байсан бил үү! Ха ха ха! Мөн ч бурж байжээ дээ. Одоо чи сохор даяанч лхаарамба Санждолбийчойжамтан болоод есөн олбогт суудал дээрээсээ “доройтуулагч хөлчин халзан тэмээ унаатай” гээд номлоод үз л дээ. Сохор даяанч би өмнөөс чинь “Битгий бур. Халзан тэмээ бол доройтуулагч хөлчингийн унаа биш харин тэнхрүүлэгч буянтан!” гэж хэлэх байна. Ха ха ха! гэж сохор эр ганцаараа ярив.



### УНШИХ ЯВЦАД

- *Шашин, соёлын тухай шинэ мэдлэг олж авах зорилт тавин уншаарай.*

Хорин гурав. Ном хаялцан цоорсон нь

Маргааш нь... Лхас зуугийн Бэрээвэний их дуганы өмнө олон лам нар цугларлаа. ...Ном хаядаг дэвжээг засаж бэлтгэсэн байв. Арван бэрхт гэдэг гавж цолтонгоос мигримба, жидримба, зогримба, егзэр, марамбаас эхлээд маш хэтэрсэн буюу равжамба, лавран хийдэд ном хаялцаж ялсан доорамба, таринын номд цайрсан аграмба, Лхас зууд ном хаяж ялсан төгсгөлгүй эрдэмт гэгдэх лхаарамба цолтонгуудыг хүртэл олон тооны эрдэмт лам нар цугларсныг хараад Санжийн зүрх үхэх шиг болж гэрэвшин бишүүрхсэн байдалтайгаар чулуун дэвжээнд гарч очлоо.

...Анхны асуултыг хэн бүхэн тайлж чадах хөнгөн юмаар гаргахаар Санж бодож байсан ёсоороо урагш нэг алхаж өмнө эгнээнд суугаа лам нарын нэгний өмнө очиж,

- Сансрын юм бүхэн угаас юунд бүтдэг вэ? Төрөн түгэхийн ёсноос гажуу нь юу вэ? гэж төвөдөөр асуулаа. Тэр лам залуухан хүн байлаа. Тийм л хүнд анхны асуултаа тавих зорилготой байснаа Санж биелүүлэв. Анхны асуулт амархан мөртөө хэн ч хариулж чадахгүй бол их учиртай байдгийг тэр туршлагаас мэджээ. Лам нар залуу

тусмаа гүн ухааны номлол цээжилдэггүй, ухаардаг ч үгүйг Санж зиндааныхнаараа баримжаалан мэднэ. Асуулт авсан лам хий л ангалзан царай нь улайхыг Санж ажиглав. Тэрнийг хариулж чадахгүйг мэдмэгц алгаа дахин нэг удаа чанга ташаад уул асуултаа давтаж самгарди хэлээр тавилаа. Самгардиар тэр бүр ч шонгүй нь тодорхой байлаа... Нөгөө лам самгардиар асуусныг самгардиар хариулах ёстой боловч юу ч хэлж чадахгүй нь илэрхий боллоо. Санж түүнийг хариулж чадахгүй байна гэдгийг олонд мэдэгдэхийн тулд баруун гарын алгаар зүүн алгаа нэг удаа чанга ташиж дохио өглөө. Тэгээд уул асуултыг түүнд гурав дахь удаагаа тавих ёстой тул сингал хэлээр дахин асуулаа. Сингалаар ярихад нь ном хаялцахаар ирсэн лам нар дуу алдан гайхацгаалаа. Санж сингал хэлийг дөнгөж л гадарлаж байгаа тул олон юм ярьж чадахгүйгээ мэднэ. Гэвч ном хаялцахаар ирэгсдийн дотор шашны бурхны эрдэмд өндөр цол хүртсэн айхтар амьтангууд олон байгаа тул тэдний довтлох зоригийг бууруулах зорилгоор сингал хэлээр хоёр гурван асуулт бэлджээ...

Сингалаар байтугай төвөдөөрөө нөгөөх асуултыг хариулж чадаагүй залуу лам ялагдлаа хүлээлээ. Санж түүний ялагдлыг хүлээлгэсний дохио болгож баруун мөрөн дээр нь гараа хүргэв. Ингээд дараагийн хүний өмнө очиж асуултаа дахин тавилаа. Тэр нь нөгөөх шүрэн улаан царайт равжамба ажээ...

- Бурхны чуулган хуран үйлдэх нь өндрийн язгуур олох буй. Буян түүний үр нь орчлонд эргэх мөн буюу. Хоосон чанарын ухаан бясалган үйлдэх нь нисванис бүхнийг барах, бурхны хутаг олох мөн буюу эсвээс биш буюу? гэж төвөдөөр асуулаа. Ламтан түүнд хариулж чадахгүй байлаа. Гурван хэлээр гурав давтан асуухад тэр үг хэлж эс чадав. Бусдын өмнөөс хариулах ёсгүй тул мэддэг нь халаглаж байлаа. Үүнийг ялагдсанд тооцож баруун мөрөнд нь гараа хүргээд дараах хүн дээр очив...

- Хүчээр идэгчийн арван нэгэн чадалтнаас лүнтэбадгасүмд юу хэрэг болох билээ? гэж Санж хамгийн энгийн шахам зүйлийг сингал хэлээр асууж орхисон чинь нөгөөх маарамба тэр хэлд тааруу байсны улмаас ч юм уу хариулж чадсангүй. Лам нар дургүйцэх мэт дүнгэнэлдэх нь сонсогдлоо. Манримба тэрээр олонд их алдаршсан хүн байлаа. Гэвч сингал хэлээр асуулт ирнэ гэж бодоогүй явжээ. Юу ч



Эх сурвалж: trends.mn

ойлгоогүй тул гурвантаа давтахад хариу хэлсэнгүй. Тэгэхээс тэгэх гэж сингалаар л асуугаад байжээ. Хэд хэдэн лам ном хаялцахаас татгалзан гарч явлаа. Тэд дургүйцлээ ингэж илэрхийлжээ...

Ийнхүү ном хаялцах нь талцам, зэнцам гэдэг нотлох, няцаах хоёр ээлжлэн түүнийг нэгтгэн цогломдох тэргүүтэн хосолж үдээс өмнийн турш

үргэлжиллээ. Ихэнх асуудал нь хариугүй үлдсэнд Санжийн сэтгэл өег байлаа. Ном хаях ажлыг төдий л анзаарч бэлтгээгүйдээ Бэрээвэн хийдийн том толгой лам нар таа муутайхан байлаа. Юунд тэрийг Санж мэдсэнгүй.

- Ном хаялцаж цоорон гарсанд баяр хүргэе! гэж аль хэдийний долиггор зантай Чогсон нялуухан дуугаар баяр хүргэлээ.

- Төгсгөлгүй эрдэмт буюу лхаарамба цол өгөхөд боломжтой хүн ойрдоо гараагүй. Энэ монгол яагаад ийм сүрхий болов? гэж Бэрээвэн хийдийн гяргачуул хоорондоо ярьж байхыг Санж бас чихнийхээ үзүүрээр сонсоод авлаа.

Билгийн их халуун очоор асар атгагын зөөлөн хур буухыг ерөндөглөнө! гэж нэг хүн чихэнд нь шивнэв. Эргэн харвал Пагсан байлаа. Тэр ер баярласан шинжгүй,

харин ч уурлан дургүйцсэн мэт царайтай харагдлаа. “Энэ Пагсан яасан атаархуу амьтан бэ? Зиндааныхан маань цөм л баяр хөөр болж байхад энэ л ганцаараа пад хар царайлчхаад бас юу гээд байгаа юм бэ? Бурхны номноос авсан үгээрээ над гайхуулах гэсэн юм болов уу?” гэж Санж дотроо бодлоо.

...Монголын нэг лам ном хаялцаж Бэрээвэн хийдийнхнийг паг суулгасан тухай модон улаатай цуу үг Лхас даяар тархав. Тэр үгийн цаана янз бүрийн юм нуугдаж байсныг Санж тэр өдөртөө ер гадарласангүй, харин ч нэр цуутай амьтадтай ном хаялцаж дийлсэндээ бахархах сэтгэл төрж, олон жил хүний газар ном шагайж суусныхаа хэргийг бүтээв гэж додигорхон бодолтойгоор шавар тагзандаа буцаж ирэв.

...Өнөөдөр ном хаялцсаны дараа гяргачуудын хоорондоо ярьсан юмыг би чамд хэлэхээр ирлээ. Тэд Линсрай гавьжийн өрөөнд зөвлөлдөж байхыг би сэмхэн сонссон юм. Чамд хэтэрхий их юм зааж сургажээ гэж тэд Линсрай гавьж Лүндэгжунайг зэмлэж байна билээ. Бурхан шажны хамаг нууцыг мэдсэн хүнийг Төвөд орноос гаргаж болохгүй нууц хуультайг чи яаж мэдэхэв дээ. Оройгүй эрдэм сурсан гадны хүнд хоёр зам байдаг. Нэг бол бүх насаараа Лхаст сууж эрдмээ эргээд Төвөд хүнд зааж байсаар ясаа тавих, нэг бол нутаг буцахынхаа өмнөхөн төвөд хүний гарт ясаа тавих, ийм л хоёрхон тавилантай юм. Чи алийг нь сонгож авахаа өөрөө мэд. Бүх насаараа Төвөдөд суухаар шийдвэл чамд айх юм байхгүй. Харин монгол газраа буцахаар завдвал чамайг явахын чинь урьд шөнө яг л өнөөдөр миний орж ирсэн шиг гэрт чинь орж ирээд оронд чинь дуусгана. Үүнийг л би чамд хэлэх гэсэн юм. Нэгэн зиндаанд нэгэн үеийг элээснийхээ учир үүнийг би хэлэхгүй байж чадсангүй. Чи намайг муу хүн гэж боддог байх. Тэгвэл би өөрийгөө чамд цагаатгах учиртай. Болгоомжтой бай! гэж Пагсан хэлээд шуудхан босч гадагшаа гарлаа. Санж яах ч учраа олсонгүй. “Хүүе Пагсан” гэж дуудсан чинь тэр аль хэдий нь хашаа даваад харанхуй гудамж руу живэн үзэгдэхгүй болов...

(1982-1983)

Зохиол хэрхэн төгсөх бол? Үргэлжлүүлэн бүрэн эхээр нь уншаарай.

**Эх сурвалж:** (Л.Түдэв. “Оройгүй сүм” (хоёр дахь хэвлэл). УБ., 2011)

**Цахим сурвалж:** <https://www.scribd.com/>



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

*Лхамгөй* - гутал

*Дагам* - орхимж

*Бэлээ* - мантуу

*Сингал хэл* - Энэтхэг-Европын язгуур хэлд багтдаг Энэтхэгийн нэг төрөл хэл



#### УНШСАНЫ ДАРАА

#### СУДЛАЛ ШҮҮМЖ

“...Амьдралын үзэгдэл юмсыг хөгжил хөдөлгөөн дунд нь бясалган сэтгэгч баатрууд бий болгох эрмэлзэл дунд оюун бодлын роман бий болжээ. Үүнийг Л.Түдэвийн “Оройгүй сүм”... зэрэгт дүрслэгдсэн баатруудтай холбон үзэж болно. Шашин хэдийгээр хуурамч боловч түүний эрдэм номд боловсрох гэгч оюун ухааны ихээхэн хүч зарцуулдгийг үзүүлж үүгээрээ хүний сэтгэлгээ, ой тогтоомжийн гайхамшигийг уран дүрээр нээн дүрсэлжээ. Үүнд л Түдэвийн романы үзэл санааны шинэчлэл оршино...”

(“Монголын орчин үеийн уран зохиолын түүх” IV (ШУА, ХЗХ). УБ., 2014, 198-199-р тал).



### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.

1. Хантайшир нурууны ар өвөрт Буянзалбирах хийдийг барьж байгуулаад оройг нь сайн гүйцээж чадалгүй орхисон түүхэн үйл явдлын тухай өгүүлэх “Оройгүй сүм” романыг уншаад хэрхэн ойлгосноо бие биедээ асуулт тавьж ярилцаарай.
2. Энэхүү романаар Санж гэлэнтэй учран золгож, түүний амьдралын мөрөөр мөшгиж, түүхийн дуранг сунган унших явцдаа бурхны шашны эдлэл хэрэглэл, домог бэлгэдэл, зан үйл, түүхийн тухай хэрхэн ойлгож мэдсэн бэ?
3. Тухайн үеийн Монгол Төвөдийн шашин төрийн харилцаа, түүхэн замнал, зан заншил, хэл соёл болоод сэтгэлгээ, сүм хийд, лам нар, эгэл ардын амьдрал ахуйг хэрхэн дүрсэлснийг баримтаар баяжуулан тайлбарлаарай.
4. “Оройгүй сүм” романд Монгол дахь шашны асуудлаар Төвөдөөс баримталж байсан төрийн бодлогыг хэрхэн дүрсэлснийг тухайн цаг үетэй нь холбон тайлбарлаарай.
5. Тухайн үеийн Төвөд нутгийн тухай хэрхэн төсөөлөв? Төвөд орон бурхны орон байсан уу, ядуусын орон байсан уу? Баримтаар дэлгэрүүлэн ярилцаарай.
6. Энэ роман нь нийгэм-улс төрийн том асуудлыг хөндсөн болохыг баталж тайлбарлаарай.
7. Романд бурхны шашны эдлэл хэрэглэл, домог бэлгэдэл, зан үйлийг хэрхэн дүрсэлсэн, ямар зорилготойг тайлбарлаарай.

### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.

1. *“Романд зөвхөн өөрсдийн эрх ашгийн төлөө бурхны шашны философи, номлол сургаалыг нь өөрчилж, хүмүүсийг төөрөгдөлд хүргэж, үнэн зөв мэдлэгийг түгээхгүй байгаа асуудлыг хөнджээ”* гэдэгтээ чи санал нийлэх үү? Яагаад?
2. Хүмүүсийн мэдлэггүй, харанхуй бүдүүлэг байгааг асуудал болгон дэвшүүлсэн гэж үзвэл юугаар баталж нотлох вэ?
3. Хүмүүс мэдлэггүйгээсээ аливаа зүйлийн золиос болдог гашуун түүх өнөө мэдрэгдэж байна уу? Мэдлэгтэй хүн бол хүчтэй хүн байж чадах уу? Зохиолч романаараа “Эрдэм мэдлэгт орой үгүй гэдгийг батлан харуулахыг зорьсон” гэж таамаглавал зохиогчийн санааг эргэцүүлэн тайлбарлаарай.
4. Санж “Үнэнч шударгын мөр хөөнө” хэмээнэ сэтгэл шулуудан явсан цаг, цагаан жимээр явж байна гэж бодож байсан түүний амьдрал, зам мөр хэрхэн төгссөнийг тайлбарлан ярилцаарай.
5. Өөрийн биш бусдын сонголтоор амьдрах нь хүмүүнийг юунд дүгнэн ярилцаарай.
6. Шашин, номын эрдэм амьдралд хэрэгтэй болсон уу, амьдралын ухаан шийдвэрлэх үүрэгтэй байсан уу? Тунгаан шинжлээрэй.
7. Мухар сүсэг, мунхаг харанхуйн ёсыг зохиол хэрхэн шүүмжилснийг илрүүлэн түүж бичээрэй.

### Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.

1. Романд зүүд гэх мэт бэлгэдэлт өгүүлэмж, дүрслэлүүд ямар үүрэг гүйцэтгэж буйг эргэцүүлэн ярилцаарай.
2. Санжийг юуны учир хороохыг завдав? Шалтгаануудыг тоочин бичээрэй.
3. Зохиомжийн ямар, ямар арга ашигласан байна вэ?
4. Романы өгүүлэгдэхүүний бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлоорой. Зангилаа хэсэг ямар үйл явдлаар тайлагдав?
5. Романд дүрслэгдсэн байгалийн дүрслэлээс 2-3-ыг сонгож, ашигласан дүрслэх хэрэглүүрийг тайлбарлаарай. Бичихдээ дүрслэх хэрэглүүрийг хэрхэн ашигласан ба эхэд ямар үүрэгтэйг тодорхойлоорой.
6. Буянзалбирах хийдэд шинэ хамба залрахад зөгий орж ирснийг бэлгэдлийн үүднээс юу гэж тайлбарлавал зохих вэ?
7. Эцсийн эцэст түүнд хэн ч бас юу ч үлдсэнгүй. Итгэл үнэмшил, үнэт зүйл нь нуран унасан “хөөрхий Санж” хэрэн тэнүүчилсээр... Зохиолч Санжийн дүрээр юу хэлэхийг зорьсон бэ?

### Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.

1. “Оройгүй сүм” романы янз бүрийн зан төрх, төөрөг тавилантай уран дүрүүдээс сонгож зохиолд ямар үүрэг гүйцэтгэснийг зохиолын үйл явдал, цаг хугацаа, үйлдэл сэлтээр нотолж тайлбарлаарай.
2. Романы дүрүүдээс сонгон хэв шинжит дүр болохыг батлаарай. Ингэхдээ дараах онолын ойлголтыг ашиглаарай.

#### • ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО: •

“Нийгмийн аж төрлийн жам хууль, зүй тогтлын үр дагавар болж олон хүнд түгээмэл үзэгддэг ижил төсөөт зан байдлын охь хандыг уран зохиолын баатарт шингээн илэрхийлснийг хэв шинж гэнэ.”

(Ш.Гаадамба “Уран зохиолын онолын үндэс”, УБ., 1989, 67 дугаар тал)

3. Өөрийн үнэт зүйлс, амьдралын зорилгоо алдсан дүрийн тухай ярилцаад, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлаарай.
4. Өлзийт бадарчин, Бэрээмэг эмгэн нарын амьдралын ухаан номын ухаанаас давж гарсан учрыг жишээ татан тайлбарлаарай.
5. Роман дахь дүрүүдийн үүргийг шинжлэн ярилцаарай.
6. Дараах асуултын дагуу ярилцаж, Санжийн дүрийг тодорхойлоорой..
  - Санжид бага насандаа сонголт хийх, зөв мэдлэгийг олж авах, хэн болохоо шийдэх эрх чөлөө байв уу?
  - Санжийн итгэл үнэмшил, үнэт зүйл хэрхэн нуран унасныг тайлбарлаарай.
  - Санжийн юм бүхнийг сурах гэсэн хүсэл тэмүүлэл зөв үү, буруу юу? Үүний үр дүнд юу, юу сурч хэн хэнд хэрхэн үнэлэгдсэн бэ?
  - Хэрэв та нар Санж хүүгийн оронд байсан бол зохиолын эцэст ямар шийдвэр гаргах байсан бэ?
  - Хэрэв Бөхмагнай дээрэмчин болоогүй байсан бол Санж нутагтаа эсэн мэнд ирж чадах байсан уу?
  - Санжийн төрөлхийн сониуч зан, эрдмийн оройд хүрэх гэсэн хичээл



зүтгэл эмгэнэлтэй төгссөн үү, эсвэл энэ орчлонгийн мөн чанарт нэвтэрч амирласан уу? Харьцуулан шинжлээрэй.

- Хар багаас номын мөр хөөж эрдмийн оройд хүрэхдээ жаргал хайрыг тэвчсэн хүү бурхан шашнаас татгалзахад хүрсэн шалтгаануудыг тоочин нэрлээрэй.
  - Санж яагаад ганлинчийн ажлыг үзэн ядах болов? Шалтгаануудыг жагсаагаарай.
  - Санж хүүд хүний нутагт хамгийн сайн найз нь ямар тус хүргэв? Хамгийн атаач нөхөр нь юу хийв? Чогсон, Пагсан хоёрын дүр ямар ялгаатай байв?
  - Ээжийнхээ төлөө ном уншихдаа үнэ өртөг авч эцгийгээ сүмийн ажилд тусалж яваад төрөл арилжихад Санж хамба юу юу бодож байсан бэ?
7. Хэрэв та нар Санж хүүгийн оронд байсан бол хийдэд шавилан суух байсан уу, эсвэл ээж аавдаа тусалж малчин болох байсан уу?
  8. Санж хүү төвөдөд шавилан суралцахдаа ямар ямар цол хэрхэн хүртэж юу юу хийж чаддаг, ямар гоц авьяастай байсныг тоочин хэлэлцээрэй.
  9. Хүний нутагт Санжийн бие чилээрхэж “найдваргүй” хэмээн эцсийн аргуудаа хэрэглэж байхад хэн өвчнийг зөв оношлон эмчилж амийг нь аварсан бэ?

### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.

1. *“... Дээрээс нар, доороос элс төөнөж Ингэнэ усны говьд жин үдийн халуун боллоо. Амьтан бүхэн сүүдэр хайж тарчилна. Халуун элсэнд амьдрах заяатай хонин гүрвэл хүртэл тэсэн ядан, амаа ангайн, бөөрөө түнхэлзүүлэн, загийн хожуул доогуур сүүдэр даган аахилж байлаа. Их говийн ээлүүд хязгаарт торойх бараагүй, анир чимээгүй дүнсгэр ажээ. Гагцхүү царцаа, голионы часхийх дуунаас өөр юу ч үл сонсогдох дүлий шар элсэн дунд гэв гэнэт нэгэн хар юм бүртэлзэн үзэгдлээ. Гэвч түүнийг сонирхох эсвэл түүнээс цочин бишүүрхэх нэгээхэн ч амьтан энэхүү илчилгүй их цөлийн дунд огтхон ч байсангүй. Бүртэлзэн шовсхийсэн тэр нэгэн нь загийн үжир үндсээр таяг хийж тулсан, хижээл насны сохор хүн байлаа. Нүд нь шаравтар бөгөөд пэлдэн мэт өнгөтэй, хараагүй болсон ажээ. Зүс царай нь төдий л доройтоогүй мөртлөө сэтгэлийн их зовууртай нь илэрхий үзэгдэнэ. Залуудаа цэвэр, цэмцгэр явсан хүний шинжийг хадгалсан хэвээр аж...”* гэсэн хэсэгт хэнийг, юуг хэрхэн дүрсэлсэн байна вэ?

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлье.

1. Зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарлахдаа дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Эшлэл	Уншигчид үзүүлэх нөлөө

2. Лам нарын дүрийг хэрхэн дүрсэлсэн хийгээд түүний байр байдлын тухайд зохиолчийн сонгосон үгсийн уншигчид хүрэх нөлөөллийг тайлбарлахдаа дараах хүснэгтийг хэрэглээрэй.

Эшлэл	Уншигчид үзүүлэх нөлөө

3. Хүний итгэл үнэмшил, уран дүрслэл хоёрт ялгаа бий юу?

 Сонсох-ярих чадвараа хөгжүүлье

### Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцье.

1. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир”, Л.Түдэв “Оройгүй сүм” романыг бүрэн эхээр нь уншаад, аль нэг зохиолыг сонгон мэтгэлцэхэд бэлдээрэй.  
Жишээлбэл: Л.Түдэв “Оройгүй сүм” романд нийгэм, соёл, түүх, шашны ямар хам сэдэв дэвшүүлснийг задлан шинжилсэн байх хэрэгтэй.
2. Мэтгэлцэх сэдэв: “Шашин, нийгэм, цаг үе”  
Дэмжлэг асуулт:
  - Хүний мунхаг сэтгэл, мухар сүсэг хоёр агаар нэгэн гэж бодвол чи яаж тайлбарлах вэ?
  - Хүн бурхан шашинд бус өөр, өөрийнхөө үйлдэлд итгэдэг байх нь зөв үү?
  - Хүн бүхий л зүйлээ бурханд даатгаж болох уу?
  - Бурхны ном, бодит амьдрал хоёр хэр зэрэг зөрөөтэй байна вэ?
  - Чи романыг уншаад “Миний сонгосон зам юу билээ, аль зам хэр үнэн бол, төгсгөл нь ямар байх бол?” гэх мэтээр бодсон уу?
  - Хүний “Итгэл” гэдэг ямар хүчтэй байна вэ?
3. Мэтгэлцэхдээ:

Дэвшүүлсэн шийдлийн хүрээнд нотлох баг илтгэлээ танилцуулна.

Няцаах баг илтгэлийг сонсон, нотолгоонуудыг жишээ татан няцаах, ямар учраас зөвшөөрөх боломжгүйгээ жишээ татан асуудлаа дэвшүүлэх

Нотлох баг харилцан мэтгэлцэж, байр сууриа хамгаалахад бэлтгэх

Шүүгч нь талуудын дэвшүүлсэн нотолгоонуудаас сонгон хамгийн үнэмшилтэй, үнэн зөв болсныг шийдвэрлэх

Шүүгч мэтгэлцээний талаар талуудад зөвлөгөө өгөх



#### ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬ:

#### Л.Түдэв “Оройгүй сүм” роман

#### Мэдлэгээ үнэлье.

1. Монгол хэлээр ном уншсанд хэрхэн шийтгүүлэв? Үүнээс үүдэн юу, юу ойлгож мэдсэнийг илрүүлээрэй.
2. Мэнгэртэй эр тоос, шороотой замаар уулын сүм тойрон гороолсноор нас нь уртссан уу, богиноссон уу?
3. Санж хүүгийн хүмүүжил, төлөвшилд өөрчлөлт орсон уу? Төрсөн эцэгтээ адис өгөхөөс бэргэшээсний учрыг тайлбарлаарай.
4. Төвөдүүд ямар амьтнаас өөрсдийгөө гаралтай гэж үздэг байв? Соёл, ёс заншлын онцлогийг жишээ баримтаар баталж хэлэлцээрэй.
5. Шашин соёлын зан үйл, дохио, зангаа, луу зэрэг амьтдын тухай авсан ойлголтоо өөрийн үгээр илэрхийлээрэй.

**Чадвар, хандлагаа үнэлье.**

1. Өөрийнхөө мэтгэлцэх чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.

	Өөрийгөө үнэлэх асуулт	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай
1.	Мэтгэлцэж байгаа сэдэвт тохирсон ихэвчлэн шинэлэг, оновчтой нотологоог гаргасан уу?			
2.	Гаргасан нотолгоогоо чадсан уу?			
3.	Нотолгоо нь илтэд буруу байгааг хүлээн зөвшөөрч чадсан уу?			
4.	Нотолгоог няцаахдаа үндэслэлтэй, үнэнд илүү ойр эшлэл, жишээг сонгож чадсан уу?			
5.	Тодруулга хийх үед тавьж байгаа асуулт нь учир шалтгааныг илрүүлэхэд чиглэсэн үү?			
6.	Бусдын гаргасан саналд хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж байв уу?			
7.	Бусдыг хүлээцтэй сонсож, үзэл бодлоо цэгцтэй, баримттай илэрхийлэв үү?			

2. Өөрийгөө үнэлээрэй.

	Чадвар	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Тайлбар
1.	Романаас нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг хэр ойлгосон бэ, өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэхэд оролцоотой байж чадав уу?				
2.	Романы сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог дүгнэхэд хэрхэн оролцсон бэ?				
3.	Уран дүрслэл, бичил дүрслэл, далд утгыг тайлан тайлбарлаж чаддаг болов уу?				
4.	Зохиолын дүрүүдийг харьцуулан задлан шинжлэх аргад суралцсан уу?				
5.	Үйл явдлын олон шугамыг тодорхойлж чаддаг болсон уу?				
6.	Зохиолоос өгүүлэгдэхүүний болон зохиомжийн бүрэлдэхүүн хэсгийг ялган тодорхойлж сурсан уу?				

## Дөрөвдүгээр бүлэг

# МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЖҮЖИГ

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ЗОРИЛГО




Монголын орчин үеийн жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх, зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах, зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүд болон дүрийн хэв шинж нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг задлан шинжлэх, зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлах, хэл найруулга нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх зэргээр мэдээллийг хүлээн авч боловсруулах.



Жүжгийн хэл, найруулгыг задлан шинжилж, нэгтгэж дүгнэн, тайлбарлаж бичихдээ оновчтой жишээ, нэр томъёог хэрэглэх, зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцаж уран дүрслэл ашиглан санаагаа төгсгөн зохиох.



Жүжгийг уншиж болон үзсэний дараа зохиолын төрөл зүйлийн онцлог, нийгэм, цаг үеийн байдалтай нь холбон үзэл бодол, байр сууриа илэрхийлэн мэтгэлцэх, зохиолын уран дүрслэл, яруу хэрэглүүр, үг хэллэгийг ашиглан жишээ баримт, эшлэл үндэслэлтэй тайлбарлаж, уран сайхан илтгэх.







### Дашдоржийн НАЦАГДОРЖ (1906-1937)

Д.Нацагдорж 1906 онд хуучин Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг Гүн Галуутай гэдэг газар ядуу тайжийн гэр бүлд төржээ. Д.Нацагдорж ЗХУ (1926), ХБНГУ-д (1926-1929) хэдэн жил суралцаж, өрнөдийн соёлын шилдэг өв сантай гүнзгий танилцжээ. “Миний нутаг”, “Од”, “Октябрь” зэрэг олон арван шүлэг, “Ушаандар”, “Сандо амбаны харгис явдал” жүжиг, “Учиртай гурван толгой” дуурь, “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс”, “Харанхуй хад” зэрэг олон алдартай өгүүлэл бичжээ. Бүтээлийг эмхэтгэн “Учиртай гурван толгой”(1934) “Зохиолын түүвэр”(1955), “Миний нутаг”(1963), “Ламбагайн нулимс”(1976), “Шувуун саарал” нэртэйгээр тус, тус хэвлэсэн байна.



#### УНШИХЫН ӨМНӨ

#### Эргэцүүлэн бодох асуулт

- Учиртай гурван толгой” жүжгийг уншихын өмнө зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар товч мэдээллийг уншаад, хосоороо ярилцаарай. Зохиолчийн талаарх өөрсдийн мэддэг зүйлийг нэмж яриад, баяжуулан судлаарай.
- Уран зохиолын бусад төрөл зүйлээс жүжгийн ялгагдах онцлогийг ярилцаж өмнөх ангиудад үзсэн ойлголтоо бататгаарай.
  - Үйл явдал нь одоо цагт болж байгаагаар өрнөдөг.
  - Амьдралын зөрчил тэмцэл, нийгмийн асуудлыг дүрүүдийн харилцан яриагаар илэрхийлдэг.
  - .....
  - .....

### УЧИРТАЙ ГУРВАН ТОЛГОЙ

(Эмгэнэлт, дуулалт жүжгийн хэсэглэл)

#### Тайзны засал

Хөдөө газар, зүүн баруун хоёр хажууд хоёр уул, зүүн талынх нь ногоон гэрэл туссан хадтай уудам, баруун талынх нь цэнхэр гэрэл туссан модтой бэрх, баруун талын уулын бэлд нэг хайлаас мод, түүний хажууд бараг тайзны гол чигт нэг том чулуу, тайзны ар талд нэг урт уул, түүний дор нэгэн бяцхан агуй ба агуйд нэг булаг урсан байна.

Хөгжим нь:

Морин хуур, хуучир, лимбэ, шударга энэ дөрөв ээлжилнэ.

#### НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ

Жүжиг эхлэхэд хуурын уянгат дуу, алия саарлын ая гарч байхад хөшиг нээгдмэгц дуу эхлэх бөгөөд Юндэн өнөөх чулууг түшин сууж, Нансалмаа, Юндэнгийн өмнө хажуулж, Юндэн баруун гараар Нансалмаагийн зүүн гарыг барьж харилцан их амраг байдалтай байна. Юндэн, Нансалмаагийн толгойг илбэн байх дээгүүр уул





усыг ажигласан янзтайгаар дуу эхлэхэд Нансалмаа хажуулдсан хэвээр түүний нүүр өөд ширтэн ажиглана.

Юндэн зүүн уул өөд харж:

*Ногоорон харагдах уул нь*

*Номин эрдэнийн уул аа!*

*Ноён сайхан нуруунд нь*

*Хүүтэйгээ зугаалмаар уул аа!*

*Хадтай өндөр уул нь*

*Хангай дэлхийн үзэсгэлэн*

*Хажууд суусан хүү минь*

*Ганцхан миний баясгалан.*

гэж дуулж төгсгөхдөө Нансалмаа руу харахад Нансалмаа цээжээ өндийж ийш тийшээ бяцхан харж байгаад баруун уулыг ширтэж:

*Цэнхэрлэн харагдах уул нь*

*Чандмань эрдэнийн уул аа!*

*Цэцэрлэг сайхан ойд нь*

*Чамтайгаа цэнгэмээр уул аа!*

*Модтой сайхан уул нь*

*Монгол газрын чимэг ээ.*

*Ерөөлтэй учирсан хүү минь*

*Ёстой миний амраг аа. (гэж дуулна)*

Юндэн бяцхан инээмсэглэж Нансалмааг хөдөлгөн мөрөн дээр нь гараа тавьж, ганц модыг харж:

*Хайлаас модны мөчир дээр*

*Харцага шувуу жиргэж байна.*

*Ханилсан бид хоёр*

*Хамтрахын үгийг ярих уу даа!*

*Уул ус нь цэнхэр бол*

*Жигүүртэн донгодох нь яруу*

*Уг сэтгэл нэг бол*

*Уг хэл найрамдуу.*

гэж дуулж Нансалмаа руу харахад Нансалмаа нэлээд ичсэн байдал гарган:

*Зөөлөн салхи найгахад*

*Цэцэг навч ганхана.*

*Цээжин дэх үгээ хэлчихвэл*

*Чихэнд аятай болов уу даа*

*Усанд живэх загас нь*

*Урсгалыг даган давхина.*

*Урамтай үгээ хэлчихвэл*

*Угтаж хүлээн авъя.*

Юндэн суниаж, Нансалмааг тэврэх шиг болоод:

*Сэтгэлийн амраг гэгч нь*

*Шижир алтнаас үнэтэй юм.*

*Шилж түүнийг авах нь*

*Хямдгүй хэрэг дээ.*

гэж дуулмагц Нансалмаа, Юндэнгийн толгойг илж:

*Үнэн сэтгэл гэдэг нь*

*Энэхүү ертөнцөд ховор юм.*

*Учирч түүнийг олох нь*

*Орчлон дээр чухаг юм.*

Юндэн, хааяа уул ус руу, хааяа Нансалмаа руу харж:

*Хоёр талын уул нь*

*Гоёмсог сайхан хосолжээ.*

*Саруул сайхан дэнж дээр*

*Цагаан гэрээ барих юм сан*

(Хоёул)

*Намрын шар нар нь*

*Над дээр чам дээр тусна.*

*Насан бага бид хоёр*

*Нийлэн суухаа төхөөрөү.*

Нансалмаа, Юндэн ба уул ус руу харж:

*Эргэн тойрны уулууд*

*Үзэсгэлэнтэй сайхан газар аа!*

*Өөрийн гэрээ бариач ээ.*

*Өрхийн оосрыг чинь татъя!*

*Ижил хоёр шувуу*

*Эелдэг дуугаар таньдаг юм.*

*Эртхэн нийлж суугаад*

*Ангир шувуу шиг явъя.*

гэж дуулж барсны хойно хоёул бие бие рүүгээ харалцан, их л бахтай янаг байдлыг гарган байх бөгөөд Юндэн, Нансалмаагийн гарыг барьж;

*Аав ээжид чинь хэлэх үү дээ*

*Ах дүү чинь юу гэх бол?*

Нансалмаа, баяртай царай гарган:

*Төрөл садан ч яах вэ дээ*

*Аян жинд явж*

*Авах юмаа төхөөрөх үү?*

*Дуртай дургүй ч ялгалгүй,*

Чиглэсэн санаа чам дээр  
Юндэн, Нансалмаагийн зүг ширтэж:

Эцэг эхдээ хэлье дээ,  
Өмч хөрөнгөө авъя даа,  
Нансалмаа, Юндэнг таалж:

Гэр орноо төхөөр дөө,  
Гэргий авахаа бод доо,  
Юндэн, Нансалмаа руу харж:

Янаг сэтгэл үнэхээр бол  
Яагаад болсон ч нийлнэ дээ.  
Нансалмаа, уярсан байдалтай

Амраг сэтгэл гэгч нь  
Аргалж болдоггүй юм аа.

гэж дуулсны дараа, дуу бяцхан завсарлан бие биесийг таалан янаглалцсан  
байдалтай байх бөгөөд Юндэн, Нансалмаагийн гарыг өвөр дээрээ тавьж:

Хайртай сэтгэлийн чинь тулд  
Хариад бушуухан ирье.

гэж дуулж босоход Нансалмаа, Юндэн рүү харж:

Миний сэтгэл чамайг гэсэн юм.  
Маргааш энд хүлээе.

гэж дуулж, мөн босох бөгөөд Юндэн баруун тийш, Нансалмаа зүүн тийш  
одно. Гэрэл унтарна. Бяцхан завсарлана. Гэрэл дахин ноцоход Нансалмаа мөнхүү  
чулууг түшин сууж Юндэнг хүлээсэн янзтай байх бөгөөд Юндэн, нөгөө талаас гарч  
ирэхдээ богц юмыг барьж аянд явахыг шийдвэрлэсэн байдалтайгаар гарч ирнэ.

Нансалмаа, Юндэнг харж:  
Амраг хүү минь ирэв үү дээ?

Аяндаа явах нь энэ үү дээ?

Юндэн ирэх замдаа:

Хонгор хүү минь хүлээж байна уу  
Хул морио сойгоод ирлээ.

Нансалмаагийн дэргэд сууна. Нансалмаа, Юндэнгийн богцыг түшиж:

Хуримын юмыг төхөөрөхөд чинь

Хувьдаа баярлан яарна.

Юндэн, Нансалмаагийн ханцуйнаас татаж (ярих нь):

Нийлж суухаа бодъё доо

Нэг хоёр сар шүү дээ,

Нансалмаа, нэг аяганы алчуурыг гаргаж Юндэнд өгнө.

Аяндаа мэнд яваарай.

Алсаас хурдан ирээрэй.

Алаглаж оёсон алчуурт

Аягаа хийгээд зүүгээрэй.

Юндэн, алчуурыг авч:

Мөшгөөд чимсэн алчууранд чинь

Мөнгөн аягаа хийе.

Мөрөөдөж хүсэх сэтгэлдээ

Мөнх чамайгаа агуулъя.

Нансалмаа, бас дахин Юндэнг ширтэж:

Тэртэй тэргүй дагана даа.

Хот газар очъё доо.

Хуримын юмаа бэлтгэе дээ.

Хэтийн газар яе л даа

Хэрэглэх юмаа авчир даа.

Явж хурдан ирвэл дээ

Ямар ч юманд саадгүй дээ.

Аяндаа түргэн явахыг

Өдөр шөнөгүй хүлээе

Хамаг яриа тогтов.

Гарахаас өмнө уулзъя

Морио унаж гараад

Намайг дайрч уулзана уу?

Аяарлан үдэж гаргахад

Алаг нүд минь мэлмэрнэ.

Хэдэн үгээ солиод

Хэтийн газар явъя даа гэж дуулж

Хот газар очиход чинь

Хоцроход хэцүү л байна шүү.

Намайгаа бодоод хүлээ дээ.

Чамайгаа бодоод явъя даа.

Зүсийг нийлүүлж оёхдоо

Зүрх сэтгэлээ барах юм.

Зүү хатгах бүрдээ

Зөвхөн чамайг бодсон юм.

Хөх торгон алчууры чинь

Хондлой дээрээ зүүе.

Холхи замын өдрүүдэд

Хонгор хүүгээ бодъё.

Угалзлан эсгэж хийхдээ  
Уран гараа гаргасан юм.  
Утас татах бүрдээ  
Учирсан чамайг санасан юм.  
Юндэн өнөөх алчуурт аяга хийж:  
Урлаад оёсон алчуурыг чинь  
Ууцан дээрээ зүүе.  
Үзэх харах бүрдээ

Энхрий чамайгаа дурсана.

аяганы алчуурыг бүсэндээ хавчуулах бөгөөд босоход Нансалмаа мөн босож:

Замдаа сайн яваарай, хүү минь  
Зүдэрч ядрах бол уу даа, хүү минь

Юндэн, Нансалмааг түшиж:

Мэнд явалгүй яах вэ дээ, хүү минь  
Идэр залуу байна шүү дээ, би чинь

Нансалмаа, Юндэнгийн богцыг авч өгөн:

Өөрөө сайн яваарай, хүү минь  
Өлсөж даарах бол уу даа, хүү минь

Юндэн, Нансалмааг тэвэрч:

Уул өндөр боловч

Үүл нүүхийг хорихгүй

Нансалмаа, бяцхан нулимс унагаан алчуураа гарган нүдээ арчиж:

Хойшоо зовох хэрэггүй

Хурдан ирэх хэрэгтэй.

Юндэн, Нансалмаагийн алчуурыг авч аргадан:

Алсын замдаа зүглэе дээ

Аль вэ хүүгээ үнсье дээ.

гэж Нансалмааг үнсээд богцыг аван одно. Нансалмаа хойноос нь харуулдан

зогсох бөгөөд Юндэнг далд ороход мөн чулуун дээр сууж нулимсаа арчин:

Хайртай сэтгэл зайгүй юм.

Хагацах гэдэг чинь хэцүү юм.

Ханилсан хүү минь далд оров.

Харуулдаад хоцрохоос яах вэ дээ.

Дассан сэтгэл гэдэг чинь

Тасдаж болдоггүй гинж юм.

дуулж байгаад муужран унасан мэт болоод толгойгоо тэврэн мөн л чулуу дэрлэж доошоо харан чимээгүй сууна.

Энэ үед дундад уулын дээгүүр Балган гарч ирэх бөгөөд буугаа барьж гөрөөс эрсэн байдалтайгаар ийш тийш ажиглан явж ийнхүү дуулна.

Арын өндөр уул нь

Асар сайхан уул аа!

Араатан гөрөөс сүрэглэж

Агнахад бахтай уул аа!

Өсөх бага насандаа

Өөрийн дураар явлаа даа.

тийш ажиглан байгаад дахин ингэж дуулна.

Эрээлээд оёсон алчуурыг

Энд битгий гээгээрэй.

Эргүүлж үзэх бүрдээ

Энэхэн намайгаа бодоорой.

Шаглаад оёсон алчууры чинь

Сайхан авч явъя.

Санаа сэтгэл хоёрыг

Түүний дотор хадгалъя гэж дуулж,

Жирийлгэн хүрээд ирэхийг чинь

Зүүд нойрондоо хүлээе, би чинь.

Миний захих үг нь

Янагаа сахиж суугаарай.

Үтэр түргэн ирэхий чинь

Өглөө үдэшгүй харуулдъя, би чинь.

Газар хол боловч

Хоёр сэтгэлийг халхлахгүй.

Хүрч ирсний дараад чинь

Хоёулаа нийлэн сууя.

Амраг гэдэг хэцүү юм.

Алчуур дүүрэн нулимстай

Дахиж хэзээ .уулзнам

Дагаад явах ч юм сан уу даа.

Хос алаг нүдэнд минь

Хонгор хүү минь үзэгдэхгүй

Хонгороосоо салсан зүрх минь

Хойноос нь тэмүүлэн гарах нь гэж

Хурдан морийг унаж

Хурц зэвсгийг барилаа даа.

Бага залуу нас минь

Бадарч байгаа л цаг даа.

Баатар эрэлхэг чадал минь

Барс чоноос ч буцахгүй гэж ийш

Үнэг чоно олон сон  
Өдөр бүр антай сан  
Өглөө эрт гарсан сан  
Өнөө яасан өдөр вэ?  
Гөрөөс мөрөөс ч үзэгдэхгүй  
Хэрэм зурам ч дайралдахгүй

гэж дуулж баруун уулын бэл дэх хайлаас руу буудахад чулуу түшин хэвтсэн  
Нансалмаа цочин өндийхөд Балган харж дахин буудахыг завдсанаа байжээ.

Араатан гөрөөс болов уу?  
Аль вэ хүн юм уу даа

Хөлийн гарз болсон  
Хаашаа уйтгартай өдөр вэ?  
Бүхэл өдөр яваад  
Буу дуугаргалгүй буцвал  
Булай ёр байгаа даа.  
Бургас мургаасыг буудах билүү?

Эзгүй хээр газар  
Элэнцэг нь энд байдаг юм бэ? гэж

дуулж Нансалмаагийн зүг очиход Нансалмаа айсан байдалтай зогсон хүлээж  
байхад Балган Нансалмааг ширтэн дуулна :

Хүн явдаггүй газар  
Хаанаас яваа хүүхэн бэ?  
Гоо үзэсгэлэнг үзвэл  
Хурмаст тэнгэрийн дагина уу?  
Урьд үзээгүй бүсгүй  
Огторгүй тэнгэрээс заяав уу?

Өв тэгш сайхныг чинь үзвэл  
Уул усны хувилгаан уу?  
Уулын гөрөөс олдохгүйд  
Урамгүй явсан юм сан.  
Зол заяа ирэхэд  
Лус охиноо хайрлав уу?

Нансалмаа, Балганы өмнөөс их харж:

Эрхэм залуу баатар  
Эндүүрч ташаарч байна уу даа.  
Энгийн нэг бүсгүй  
Энд явахад яадаг юм бэ?

Хөдөөгийн нэг хүүхэн байна.  
Гөрөө ангаа элд л дээ.  
Яасан зүрхтэй хар хүн бэ?  
Ядуу бүсгүйг үзээгүй юү?  
Ямар учраас тоглоно вэ?  
Явдаг замаараа л яв даа

Гөрөөчин анчин эрхэм минь  
Хөндөлдөж зогсоод хэрэггүй  
гэж дуулж шууд явах гэхэд Балган:

Наран гэрэлтэй охин оо  
Намайг юүнд тэнснэм?  
Эртний хувь зохиолоор  
Энд учрах ерөөлтэй байж  
Дээд орны дагина биз ээ?  
Өчүүхэн намайг тоохгүй юү?

Орхиод хаашаа явна вэ?  
Сар шиг гэрэлд чинь гялбаж байна.  
Сайхан өнгөнд чинь дурлаж байна.  
Саатаж энд сууж  
Санаа сэтгэлийг минь хангана уу?

гэж дуулж, Нансалмаагийн тохой дээрээс татахад Нансалмаа, уурласан  
байдал гарган:

Эрэлхэг баатрыг үзвэл  
Эрхэм дээд хүн шиг  
Ичгүүргүй ааш чинь  
Эргүү мунхаг адгуус шиг  
Айл аймгийн ах дүү бол  
Ааш зангаа татна уу?

Уул талын оргодол бол  
Алс замаа хөөнө үү?  
Харах царайгий чинь үзвэл  
Хад уулын хулгайч шиг  
Чамаас би айж байна  
Тавьж хурдан явуул

гэж дуулж бармагц гарыг алдуулан гэнэтэд зугадахад Балган ухасхийн  
Нансалмааг барьж аваад их чанга инээж:

Ахынхаа гарын дор чи  
Оготно хулганатай адилхан шүү.  
Ангүй өнөө явсан биш  
Аваад чамайг явна даа.  
Бага жаахан охин чи  
Балганы гараас гарахгүй,

Гэртээ чамайг аваачаад  
Гэргий болгож сууна даа.  
Эд хөрөнгөөр элбэг би  
Эхнэр авахыг бодсон юм аа.  
Эвээр эс болбол  
Эзний зарлигт хүргэнэ дээ.



Балган, Нансалмааг чирч зүүн уул өөд явна. Нансалмаа уйлах бөгөөд зүүн уулын хажууд Балганы гараас мултарч чадахгүй байх бөгөөд

<i>Хүний арьсыг нөмөрсөн</i>	<i>Хэлэлцээ сүйтэй нөхөр бий</i>
<i>Хээрийн галзуу чоно чи</i>	<i>Хэчнээн оролдовч тусгүй.</i>
<i>Хүзүү толгой үргэлж байхад</i>	<i>Зэвхий царайг чинь харахад</i>
<i>Чи намайг боолчлохгүй.</i>	<i>Зэрлэг араатан шиг үзэгдэнэ.</i>
<i>Омог зан чинь хэцүү ч</i>	<i>Чиний чадал их ч</i>
<i>Ойртуулж намайг чадахгүй.</i>	<i>Миний зориг хатуу.</i>

Нансалмаа, зайлах гэхэд Балган тавихгүй зууралдан байх үед зүүн уулын энгэр дээгүүр Хоролмаа гарч ирэх бөгөөд тэр хоёрыг хармагц сэмээр гэтэн ойртож Балган явж байгаа юм уу? гэж чанга дуугарахад, Балган цочин харж айсан мэт болон Нансалмааг орхиж уулын цаана орж нуугдана. Нансалмаа, Хоролмаа руу хараад дуугүй доош сууна.

Хоролмаа, Нансалмаагийн дэргэд ирээд дуулна:

<i>Хар хүнээ гаргаж өгөв үү, чи?</i>	<i>Яасан муухай амьтан бэ?</i>
<i>Харих замдаа завхайрч байна уу, чи</i>	<i>Хоёр нийлсэн амраг гэсэн</i>
<i>Амраг гэсэн чинь аль вэ?</i>	<i>Худал юм байж л дээ.</i>
<i>Амны хоосон үг үү дээ?</i>	<i>Юндэнгээ ирэхэд нь</i>
<i>Өөрийн эрээ явуулаад</i>	<i>Нүүрий нь яаж харах вэ?</i>
<i>Хүний эрийг эргүүлж явна уу?</i>	<i>Ичиж байна уу, чи?</i>
<i>Ичүүр сонжуураа алдсан</i>	<i>Илэг нүүртээ наалгав уу, чи?</i>

гэж Нансалмаагийн толгойг өргөхөд Нансалмаа уурлан нударч аваад дуулна:

<i>Зэрлэг чонотой нийлсэн</i>	<i>Ариун нэрийг минь бузарлаж</i>
<i>Золбин гичий ирэв үү, чи?</i>	<i>Алд биеий минь зовоож байна.</i>
<i>Зальхай Балганаа аваад,</i>	<i>Үхэвч журамтай үхнэ.</i>
<i>Зайлж хурдан өгөөч</i>	<i>Өшөөлөөд та нар чадахгүй.</i>
<i>Баавгай гөрөөс шиг Балган</i>	<i>Өлөгчин муусайн нохойнууд</i>
<i>Балмад хүүхэн та хоёр</i>	<i>Үтэр түргэн тонил!</i>

гэж Хоролмааг түлхэхэд Хоролмаа: «Айсан хүн айл эвдэнэ, ичсэн хүн хүн ална гэж чи бас надад хүрнэ гэнэ» гэж давшилж Нансалмааг татаж унагаахад Нансалмаа, түүний хүчинд дийлэгдэн дуу алдан унахад Балган цаанаас гарч ирнэ. «Чи надад хамаагүй, миний эхнэрт чи юунд халдана» гэж Хоролмааг уулын хажуу руу түлхэн унагаах бөгөөд энэ завсар Нансалмаа босон харайн явах гэтэл Балган Нансалмаагийн гар дээрээс барин авч «Одоо миний болсон» гэж чанга хэлж хөтлөн уулнаас буух үед хөшиг хаана.

#### ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ

Зүүн уулын энгэр дээр Нансалмаа нэг чулуу сандайлан сууж, баруун ба хойд уулын тийш байн байн ширтэж холын бараа харсан янзтай болоод уярсан байдлаар гиюурч ийш тийш харан дуулна:

<i>Өндөр уулан дээрээс ширтэвч</i>	<i>Болжмор шувуу ч болоосой.</i>
<i>Холын бараа харагдахгүй,</i>	<i>Хоёр жигүүр ч ургаасай.</i>
<i>Нулимстай нүд минь мэлмэрч</i>	<i>Хойноос нь нисэж очоод</i>
<i>Янагийн зүрх минь тэмүүлнэ.</i>	<i>Хамаг зовлонгоо тоочих сон.</i>
<i>Өдөр шөнөгүй хүлээвч</i>	<i>Хоёр сар ч шахлаа даа.</i>
<i>Сэтгэлийн хүү минь ирэхгүй.</i>	<i>Хонгор хүү минь яав даа?</i>
<i>Учирч уулзахыг яарахад</i>	<i>Хүний гарт орлоо шүү.</i>
<i>Уушги элэг минь догдолно.</i>	<i>Хурдан ирж аваасай</i>



гэж дуулж, алчуур гаргаж нулимсаа арчин бас өндийн ширтэж ийнхүү дуулна:  
*Хүссэн хүү минь харагдахгүй* *Зальхай жигшүүртэй Балган*  
*Хэзээ ирэх нь сураг үгүй* *Цаг ямагт эргүүлдэнэ.*  
*Хойноос нь явах чадалгүй* *Зовниж хүссэн Юндэн минь*  
*Хөөрхий би чинь яах билээ.* *Зүүдэнд эс үзэгдэнэ.*

*Мангас махчин шиг хүн* *Балмад араатан шиг Балган*  
*Намайг авах гэж байна шүү.* *Бас хүрээд ирэх болов уу?*  
*Санамсаргүй зовлонг* *Оготно мэт би чинь*  
*Санаандгүй явна уу, чи?* *Одоо хаачих билээ дээ?*

гэж дуулаад нэг зэрэг санаа алдаад уруу харан:

*Чонын аманд орсноос* *Уул ой дахь хэрэм нь*  
*Зуурдын замыг хөөмөөр* *Анчин учрахаар бүлтэлзэнэ.*  
*Чамтайгаа уулзалгүй үхэхэд* *Гачигдсан бүсгүй намайг*  
*Даанч түвдэж чадахгүй* *Ганцхан нулимс хөөрхийлнө.*

(дээш харж:)

*Намрын хонгор салхи нь* *Галуу шувуу хүртэл*  
*Найган ганхан салхилна.* *Ганганаж гунганаад буцаж байна.*  
*Насан бага би чинь* *Хайрт амраг Юндэн минь*  
*Түүний дотор гасална.* *Харьж ирэхгүй яав?*

гэж дуулан гуниглан, ийш тийш ажиглан байтал баруун ба хойд уулын завсраар Дамдин алгуураар сүүмэлзэн гарч ирэх холын барааг Нансалмаа хараад нэлээд сэргэсэн байдалтай болж дээш босон:

*Хоёр уулын хоорондох* *Алган замын дундах*  
*Холын бараа юу вэ дээ?* *Алсын бараа юу вэ?*  
*Юндэн минь биш болов уу?* *Амраг хүү нь ирнэ үү?*  
*Яасан аяархан явдаг юм бэ?* *Адилхан юм шиг ч харагдана*

гэж дуулаад малгай дээлээ засан хөдөлж:

*Малгайн орой нь адилхан байна.* *Миний нар ч гарлаа шүү.*  
*Магад хүү минь ирлээ шүү.* *Мэнд уулзахын ерөөл байжээ гэж*

дуулаад урагш алхалж даллан:

*Наашаа хурдан яваач* *Намайг бушуухан аваач*  
*Нансалмаа чинь хүлээж байна.* *Чамтайгаа түргэн харих юм сан гэж*

дуулан тосож ойртоход Дамдин цаанаас бас ойртон ирэхийг Нансалмаа үзээд харахан Юндэн биш мэт болоход цочих мэт болон урамгүйгээр ухран зогсов. Дамдин, дэргэд нь ирж «Эр хүний заяа эзгүй хээр гэгчээр энэ бүсгүй чинь юу вэ? Чи юунд дуудав? Яаж яваа хүн бэ?» гэхэд Нансалмаа айсан байдалтайгаар зогсож:

Би хүн андууран дуудав.

Хүрээнээс ирэх хүнийг хүлээсэн юм гэхэд Дамдин ихэд гайхсан байдалтайгаар ширүүн харж:

Тэгвэл би хүрээнээс явна.

Ямар хүнийг чи хүлээсэн юм бэ?

Тэр хүн чинь хаа яваа юм бэ?

Нансалмаа, хулган:

*Хаа явааг мэдэхгүй*

*Миний нөхөр юм.*

*Хүрээ ороод хоёр сар болж байна.*

гэхэд Дамдин толгой дохиж «Юндэн гэнэ ээ! Цэнд дархны Юндэн үү?» гэхэд

*Өнөө маргаашгүй ирэх болсон юм.*

*Юндэн гэж нэг залуу хар хүү бий.*

*Харин та тохиолдсонгүй юү дээ*



Нансалмаа сураг дуулах нь гэж санаж баярласан янзгайгаар «Тийм тийм, уулзсан уу? хаана явна вэ?» гэсэнд Дамдин муухай харж: «Чи чинь Надмидын хүүхэн биз дээ? Балганы эхнэр болсон гэж дуулдах ч билээ. Юндэнгээр яах гэсэн бэ? Тэр хаанаас мөд ирэх юм бэ?» гэж ширэв татан өөр үггүй шууд зүүн уулын араар орон одов.

Нансалмаа, хоцорч даруй өнөөх чулууг түшин сууж уйлан дуулна:

*Холын барааг хараад*

*Хөлгүй баярлан гүйсэн маань*

*Харийн хүн болоод*

*Харин жигтэй яриатай*

*Сэжигтэй үг дуулбал*

*Сэр сэр бодогдоно.*

*Саад тотгор тохиолдов уу?*

*Санаа сэтгэл нь хувирав уу?*

*Байсаар байсаар байгаад*

*Балганы эхнэр гэгдлээ.*

*Богтолж хэлэлцсэн хүү минь*

*Буцаж ирэхгүй болов уу?*

*Талд хоцорсон янзага шиг*

*Тарчилж үхэх нь энэ дээ.*

*Залуу бага насны минь*

*Заяа ерөөл яав?*

*Гэртээ хариад яах вэ дээ?*

*Хэнийг гэж очих вэ дээ?*

*Харгис Балганд баригдсанаас*

*Хээр үхсэн нь дээр дээ.*

*Амраг хүүтэйгээ нийлэх гэж*

*Уул жалганд тэнүүчилнэ.*

*Авлигач этгээдэд учирснаас*

*Араатан гөрөөсөнд идүүлье.*

Нансалмаа, зүүн уулын нэгэн жалганд муужран унана. Гэтэл Юндэн баруун уулан дээгүүр ирэх бөгөөд Нансалмааг эрсэн байдалтай ийнхүү дуулна:

*Аянаас ирэхэд*

*Амраг хүү минь үгүй шүү.*

*Ах дүүгээс сурвал*

*Алга болсон гэнэ шүү.*

*Үхэж үрэгдсэн бол*

*Өөрийн нь хүүрийг үзэх юм сан.*

*Хүнд дарлагдсан болбол*

*Хүч чадлаараа тэмцэх юм сан.*

*Алаг нүдний нулимсаа*

*Арчин байж салсан юм сан.*

*Ааш зан чинь хувирсан бол*

*Арав таван үгийг солих юм сан.*

*Холын газар явахад*

*Хүйтэн халуунд зудэрсэн юм.*

*Хурим найрыг хийгээд*

*Хүүтэйгээ жаргахыг бодсон юм.*

*Хосгүй хоёр амраг*

*Холдож салах учиргүй сэн.*

*Хувь заяа минь орхиод*

*Ийм хэрэг болдог уу?*

гэж дуулан, уулан дээгүүр буюу урьд Нансалмаагаас салсан газраараа явж байгаад зүүн уулын ёроолд орж, хойд уулын зүүн талаар явчина.

Энэ завсар Нансалмаа мөн жалганд унасан хэвээр байх бөгөөд гэтэл зүүн уулын модон дотроос нэг зэрлэг гахай ирэн Нансалмаа дээр очиж эргэн тойрон шиншин, таван минут хэртэй болоод идэхийг завдахад Нансалмаа сэргэн, цочин сандран өндийж айн байх үест Юндэн хойд уулын баруун дээгүүр гарч ирээд юуны урьд тэрхүү гахайг хармагц буугаа аван буудна. Гахай унамагц Юндэн буугаа барин хүрч ирэхэд Нансалмаа нэгд айсандаа, хоёрт Балганыг ирэв гэж бодсондоо зугатна. Юндэн таниад «Нансалмаа, Нансалмаа» гэж дуудахад сая эргэж гэдрэг харан Юндэнг таниад гараа сарвайхад Юндэн яаран очиж тэврэн авна. Нансалмаа бас муужран унана. Түүнээс Юндэн газар сууж Нансалмаагийн цээжийг түшиж толгойг илэн үлээх бөгөөд Юндэн ийн дуулна.

*Алга болоод олодохгүйд чинь*

*Амь тэмцэн явна шүү.*

*Аглаг хээр газар*

*Яагаад хүрч ирэв?*

*Гэр орондоо байхгүй*

*Хэл мэдээ орхихгүй*

*Хээр талд ирээд*

*Хэвтэж байх чинь юу вэ? гэж дуулж*

Нансалмаагийн гарыг барихаар Нансалмаа уйлан:

Эргэж ирэхгүйд чинь  
Элдвийн юм бодлоо.  
Энэлж шаналж гачигдахдаа  
Ингэж хээр хэвтэнэ.

гэж дуулахад Юндэн, гайхсан байдал гарган:

Эцэг эх чинь зовоов уу?  
Өвчин гамшиг тохиолдов уу?  
Энэ тэр эргүүлдэв үү?  
Эрээгүй надад хэлчих  
Нансалмаа:

Амраг чамайг явснаас  
Айхтар зовлонд учирлаа.  
Арга ядаж хүлээхдээ  
Уулан дээр ширтэн сууна.

Тэр хоёр харилцан тэврэлдэж нилээд тайтгарсан байдалтай байх бөгөөд  
Юндэн ингэж дуулна:

Хоёр бие учирлаа даа  
Хойчийн зовлон гайгүй биз  
Элдвээр дарлая гэвэл  
Эр чадлаар тэмцэнэ.

Нансалмаа, (Баярын байдал гарган):

Учирсан зовлон тоочвол  
Ухааран мэдэж аваад  
Чонын аманд хавхдуулахгүйг  
Чи мэдэх хэрэгтэй шүү.

Юндэн, Нансалмааг өвөр дээрээ суулган толгойг илж хоёулаа:

Нийлсэн хоёр сэтгэл нь  
Мянган лангийн алт шиг  
Зайгүй хатуу нягтад нь  
Зүүний үзүүр орохгүй.

сууна.

Нансалмаа:

Эгшин зуур хагацахад  
Мянган жил шиг санагдана.  
Өлссөн хөөрхий сэтгэл минь  
Чамайг үзэхээр цадна.

гэж дуулж байх үед тэр хоёрын хажуугаас Балган гэнэт гарч ирэн догшин  
байдлаар эсрэг хандан муухай харан Нансалмаа руу давшилж ингэж дуулна:

Эрээд эрээд олдохгүй  
Энд харин байна уу, чи?  
Орчлон ертөнцийн дээр  
Миний гараас гарахгүй, чи

гэж загнахад Юндэн бяцхан өндийж муухай харж тэмцэлдэхийг бодсон янзтай  
байх бөгөөд Нансалмаа уурлан ингэж дуулна:

Хүний арьсыг нөмөрсөн  
Чонын толгой дуугүйгээр  
Энэ хүнийг харж байна уу?

Хурдан нийлж суух гэсэн нь  
Хоосон болохоос айв.  
Хавчигдаж цухалдахдаа  
Хатуу зориглохыг шийдэв

Харь этгээд зовоосон бол  
Хариу өшөөг авъя.  
Хайртай хэвээр бол  
Хад чулууг хагална.

Гаргаж өгсөн өдрөөс чинь  
Харгис хүн тохиолдлоо.  
Гартаа оруулж авах гэхэд нь  
Ганцхан чамайг харуулдлаа.

Амраг сэтгэл байвал даа  
Уушги зүрх нэг шүү.  
Уужим тавиун байгаад  
Ургийн хэргээ гүйцэтгэе.

Хүсэл сэтгэл чам дээр  
Хүйтэн халуунд дагана.  
Өөрийн гэртээ аваачна.  
Одоо чамаас хагацахгүй.  
Алтан наран мандах нь  
Агаар тэнгэрийн дэнлүү  
Амраг хонгор хүү минь  
Ёстой миний дэнлүү. гэж тэврэн

Хас чулууны өнгийг  
Харлуулж юу ч чадахгүй,  
Хайртай амраг хүнийг  
Хагацуулж хэн ч дийлэхгүй

Энэ муу хүнийг дагаж  
Эзгүй хээр үхнэ үү, чи?  
Худалдаж чамайг авсан  
Хурдан бушуу явтугай

Чамд дарлагдахаас өнгөрсөн  
Түргэн бушуу далд ор!  
Хүний хажуугаас зайлж



### Чонын сүрэгтээ нийл!

Балган ухасхийн Нансалмаа руу дайрмагц Нансалмаа Юндэнгийн ар тийш бултана. Юндэн, Балган руу хөдлөхийг завдтал Балган хажууд байсан нэг модыг авч Юндэнгийн толгойг цохиход Юндэн унаж уулын хажуу руу ойчно. Балган Нансалмааг барин авч уйлуулан чирч одно. Түүнээс Юндэн, уулын бэлд унаад ухаангүй хэвтэж байх бөгөөд энэ үед зүүн уулын араас Хоролмаа хоёр хувин барьж алгуурхнаар булаг дээр очиж ус аваад буцах замдаа Юндэнг үзэж цочин зайлмаар болсноо байж, хувинтай усаа тавин, түүний дэргэд очиж «Юндэн, Юндэн! яасан бэ? гэж мориноос ойчсон юм уу? гэж өвчүүн дээр нь дарж үзэхэд Юндэн өчүүхэн хөдөлж байхад Хоролмаа даруй сууж, толгойн шархыг өврөөсөө цагаан дурдан алчуур гарган боож, толгойг нь өөрийн өвөр дээрээ тавьж ийнхүү дуулна.

*Эртнээс чамайг хүссэн сэн*

*Одоо учрахаа мэдсэнгүй*

*Ингэж уулзахыг үзвэл*

*Ерөөлтэй заяатай юм сан*

*Жавхлантай сайхан эр гэж*

*Засаг хошуугаараа хэлэлцсэн*

*Царай зүсийг нь үзвэл*

*Дамжиггүй үнэн юм л даа*

*Давхраатай хар нүдтэй*

*Тас цагаан шүдтэй*

*Дархан Цэндийн Юндэн чи*

*Давуу цэвэрхэн төржээ.*

*Өслөг гоолиг нуруутай*

*Өргөн хар хөмсөгтэй*

*Өөрийн нутгийн Юндэн чи*

*Үлэмж сайхан төржээ.*

*Барааг чинь хараад бахадсан юм.*

*Царайг чинь хараад баярлаж байна.*

*Ухаан орж сэргээч*

*Уг санаагаа илтгээ*

*Тавилан ерөөл байснаас*

*Тантай сайхан уулзлаа.*

*Дээшээ сэргэж босооч*

*Дурласан сэтгэлээ сонсгоё*

гэж дуулаад Юндэнг хөдөлгөн ядах бөгөөд даруй аятайхан хэвтүүлэн босож, нэг хувинтай ус авчран энгэрийг яран ус шүрших бөгөөд бас хажуугаар нь үнсэн байна. Гэтэл Юндэн алгуураар “аан уун” гэж ярагласаар сэргэж, нүд аниатайгаар дэрлэж хэвтсэн Хоролмаагийн гарыг барьж илэн Нансалмаа гэж дахин дахин тэмтрэх бөгөөд үүнд Хоролмаа их цочсон янзтайгаар дэмий л “Зүгээр зүгээр” гэнэ. Гэтэр Юндэн бүрмөсөн сэргэн өндийж Хоролмааг ширтэн “Та юун хүн бэ? Нансалмаа яасан бэ?” гэхэд:

Хоролмаа:

*Нансалмааг би мэдэхгүй*

*Харин таныг энд ухаангүй*

*Хэвтэж байхад нь*

*Тэнхрүүлэн сэргээлээ...*

**Эх сурвалж:** (Д.Нацагдорж “Зохиолын түүвэр”, УБ., 1955, 77-99 дүгээр тал)



Унших чадвараа хөгжүүлье

### Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар түүх, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.

1. Түүх, нийгмийн хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Ямар түүхэн тодорхой цаг үе дүрслэгдэж байна вэ?
  - Нийгмийн ямар орчны дүрслэлээр юуг илэрхийлж гаргав?
  - Жүжгийг эмгэнэлд хүргэж байгаа гол шалтгаан юу байв? гэх мэт
2. Соёлын хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Ардын язгуур урлагийн ямар хөгжмийн зэмсгээр ямар, ямар дууны ая

тоглож байна вэ?

- Ардын.... дууг сонгон эгшиглүүлэх болсон зохиолчийн зорилго юу вэ?
- Үндэсний уламжлалт ямар зан үйл дүрслэгдэв? гэх мэт

### **Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Юндэнг тэмцэлд хөтөлж байгаа хүчин зүйлийг дүгнээрэй.
2. Юндэн, Нансалмаа нарын эрх чөлөөтэй, шударга амьдралын төлөөх тэмцэл нь тухайн үеийн нийгмийн буруутай байдлаас болж биелээгүйн шалтгааныг тайлбарлаж, дүгнээрэй.
3. Тэмцлийн үр дүнд ялагч болсон дүрүүдийг нэрлэж, учир шалтгааныг тайлбарлаарай.
4. “Учиртай гурван толгой” жүжиг нь дуулалт, эмгэнэлт жүжиг болохыг батлаарай.

### **Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.**

1. Жүжгийн зохиолын зөрчил нь багаас их рүү шатлан өргөжиж байгааг бүдүүвчээр илэрхийлээрэй.



2. “...Жүжгийн зохиолын хоорондын яриа(диалог) нь дор бүрдээ нийцсэн байхаас гадна мөн өөр хоорондоо байнгын зөрчилд хөгждөг. Эс тийм бол юугаа ярьж, юуны учрыг олох гэж үг урсгаж байх билээ. Амьдрал тэр чигээрээ зөрчил, тэмцэл. Зөрчил, бэрхшээл тэмцэлгүй бол амьдрал урагшлахгүй. Маргаан дунд үнэн үүснэ гэсэн мэргэн үг байдаг...”  
Э.Оюун “Д.Нацагдоржийн жүжгийн зохиолын зөрчлийн асуудалд” гэснийг зохиолоор баталж тайлбарлаарай.
3. Балган, Юндэнг хутгалсан нь зохиолын туйл болохыг баталж дүгнээрэй.
4. Нансалмаа өөрийн амийг өгүүтгэж байгаа нь зохиолын тайлал болсныг батална уу.

### **Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая.**

1. Дарлагч ангийхны дотор өнгө мөнгө, эрх тушаалаар мулгуйдах явдал жирийн үзэгдэл байсан нийтлэг зүйлийг зохиолын дүрээр баталж тайлбарлаарай.
2. Феодалын нийгмийн бурангуйн эсрэг, толгой өндийн тэмцсэн эрэлхэг



- зоригтой хүмүүсийн хэв шинжийг дүрүүдээр баталж тайлбарлаарай.
3. “Учиртай гурван толгой” яруу дуут жүжгийн зөрчлийг ажиглахад хүн бүрийн дээд хүслэн, амьдралын ойлголтын зөрчлөөс эхлээд яв явсаар тэр нь феодалын Монголын дарлагч, дарлагдагч хоёр анги хоорондын тэмцэл болон хувирч зохиолын зөрчлийг болон дүрүүдийн ухамсрыг диалектик хөгжлөөр үзүүлсэн нь драмын зохиолын чанарын гол үзүүлэлт мөн байна” гэж эрдэмтэн Э.Оюун (“Д.Нацагдоржийн жүжгийн зохиолын зөрчлийн асуудал”) дүгнэснийг зохиолоор баталж дүгнээрэй.

**Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.**

1. Жүжгийн зохиолын эхлэл хэсэгт гарах гурван уулын дүрслэл нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг шинжлээрэй. Жишээ нь:
- Зохиолоо гурван уулын дундах хөдөө газар, алиа саарлын уянгалаг аялгуунд саахалтын хоёр хос, нэгэн чулууг түшин, бие биедээ хайрын сэтгэл илчлэн буй тайван байдлаар эхлүүлж байгаа нь ямар учиртай вэ?
  - Аль уулын талаар ямар дүр онцлон магтаж байна вэ? Яагаад?
  - Жүжгийн ямар, ямар үйл явдал аль ууланд өрнөж байна вэ? Яагаад?
  - Аль ууланд зохиолын үйл явдал түлхүү өрнөж байна вэ? Яагаад?
  - Энэ гурван уулын талаар зохиолын нэртэй холбон тайлбарласан судлаачдын тайлбарыг өөрийн тайлбартай харьцуулж дүгнээрэй.
  - Төрийн соёрхолт Д.Намдаг гуай бичихдээ “...бүх үйл явдлыг бид хөдөө талын гурван бяцхан толгойн дунд эргэлдүүлэв” гэсэн нь ямар учиртай вэ?

**Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж үнэлье.**

Жүжгийн зохиолд ашигласан чимэг үгийг

- Жүжгийн хэлийг уран яруу, товч тодорхой болгосон
- Утга агуулгыг ойлгомжтой гүнзгий болгосон гэх мэт тайлбарлаарай.

Жишээ нь:

Зохиолын эшлэл	Чимэг үг	Тайлбар
Ногоорон харагдах уул нь Номин эрдэнийн уул аа	Ногоорон харагдах	Ямар өнгөтэйг заасан төдий биш, эх орныхоо байгалийн үзэмж төгөлдрийг бахадсан сэтгэлээ илэрхийлсэн гэх мэт.
Мөшгөөд чимсэн алчууранд чинь Мөнгөн аягаа хийе	Мөшгөөд чимсэн	Зөвхөн оёх үйлийн ур төдийг биш харин нандин хайр сэтгэлээ хэрхэн шингээснийг илэрхийлсэн гэх мэт.

## ЗОХИОЛЧ


**Бавуугийн ЛХАГВАСҮРЭН**  
(1944-2019)

1944 онд Төв аймгийн Баян-Өнжүүл сумын нутагт төрсөн. 1963 онд Худалдааны техникум төгсөж 1973 онд Москва хотын КУДС-д суралцсан байна. Монголын радиод сэтгүүлч, Улсын хүүхэлдэйн театрын даргаар ажиллажээ. Яруу найргийн “Уянгын тойрог”, “Цагаан тэнхлэг”, “Ангир уураг”, “Гашуун өвс” зэрэг түүврүүд хэвлүүлж, “Тамгагүй төр”, “Бөртэ чоно”, “Атга нөж” гэх мэт жүжгүүд, “Бүлээн нурам”, “Хүн чулууны нулимс” зэрэг кино зохиол бичсэн байна. 1990 онд Монгол улсын Төрийн шагнал, 1998 онд Соёлын гавьяат зүтгэлтэн, 2003 онд Ардын уран зохиолч, 2017 онд Хөдөлмөрийн баатар цол хүртжээ.



## уншихын өмнө

## Эргэцүүлэн бодох асуулт

- *Эмгэнэлт жүжгийн гол онцлог юу вэ? Өмнөх ангиудад үзсэнээ сэргээн санаарай.*
- *Тамгагүй төр байж болох уу? Тамганы үнэ цэнийн тухай эргэцүүлэн бодоорой.*
- *Жүжгийн эхэнд дөнгөж нярайлсан хатад хар хэрээн дундах хун шувууд шиг харагдаж буйгаар дүрсэлсэн учрыг бүрэн эхээс анзаарч уншаарай.*

Дүрүүд:

**Арчуг** - Хүннү төрийн хаан

**Эгэрэг** - Хүннү төрийн түшмэл, Арчуг хааны өрлөг

**Цэцэр** - Хааны их хатан

**Гүргэл** - Хааны бага хатан

**Ачир** - Их хатнаас төрсөн Эгэрэгийн нууц хүү

**Хүчир** - Бага хатнаас төрсөн хааны нуган

Зар мэдээч, хэвтүүлүүд, хөлөг баатрууд, хөгжимчид,

Ордны үйлчлэгч эмэгтэйчүүд буюу Эхсүүд

**ТАМГАГҮЙ ТӨР**

(Эмгэнэлт жүжгийн хэсэглэл)

**Эхлэл**

Ганц саглагар модны дор. Оройн наран жаргах үе. Нурамшиж байгаа гал тойрон сууцгаасан хүннүчүүд. Есөн бөө хэнгэрэг дэлдэн есөн зэрэг бууж байна. Зээглэн суусан хүмүүс дунд цас цагаан өмсгөлт сая төрсөн хоёр эм, гөрөөсний арьсан өлгийтэй ихэр мэт хүүхэд нэг нэгээр тэврэн суух нь олон хэрээнүүд дундах хун мэт харагдана.

**Бөө нар:** - (хэц хэнгэрэг дэлдэн)

Дайван хөх тэнгэр

Дайрт бор газар хийгээд

Есөн, есөн, есөн

Ерөн есөн тэнгэр

Бууж хайрла.

Хүүе, хүүе, хүүе

(Хэнгэрэг нижигнэн намсах зуур хүмүүс навтас мөргөн сөгдөх нь өвс лугаа...  
 Бөө нар ухасхийн хоёр хатны гөрөөсөн өлгийт хүүхдүүдийг шүүрэн авч байхуйц,  
 нэг хэсэг бөө нь галд давс цацахуй дор гал удгалан улам дүрэлзэн асна)  
 Бөө нар хоёр хүүхдийг галын дээгүүр нар буруу эргэлдүүлэн ширгэлэх ину:  
 Хаан эзний нуган Төмөр зүрхэт хоёр үрийг  
 Хар сүлдний туган Түрэмгий галд амсуулья.  
 Барсын зулзага мэт хоёр үрийг Ширгэ...  
 Бачимдах галд амсуулья Ширгэ...  
 Ширгэ... Ширгэ...  
 Ширгэ... Ширгэ...  
 Ширгэ... (ширгэ, ширгэ... гэсэн дагасан уухай  
 нүргэлэн, гэрэл бүдгэрсээр...)  
 Сүлдээ эс мартах  
 Сүү хөхөснөө мартаж чадах

### Нэгдүгээр бүлэг

#### Нэгдүгээр үзэгдэл

Их цацарт Хаан Арчуг, Эгэрэг  
 түшмэл хоёр.

#### Арчуг:

- Эрхт тэнгэр төрд минь  
 Хэрүүлийн үр цацаж  
 Энэ барс жилд  
 Хоёр нуган үр заяав.  
 Тэнгэрийн сугыг чөтгөр гижигдэж  
 Тэднийг надад илгээсэн байлгүй  
 Хоёр гуравхан хоногийн зайтай  
 Хорвоод ирэхдээ яадаг байна аа  
 Хорин жил  
 Хормой нь нуруугүй их хатан  
 Сая нуган үр төрүүлэв.  
 Садар салхи л түүнтэй нөхцсөн биз  
 Үнгэж би түүнийг таалах нь битгий  
 хэл  
 Үнэрийг нь хүртэл мартаад олон  
 оныг үзэв.

#### Эгэрэг:

- Толгой чинь биш  
 Бие чинь дийлсэн өдрөө  
 Тоос цусан дунд, та  
 Мартсан байж мэднэ  
 Их хатнаасаа төрсөн хүүдээ  
 Итгэж нэг өгөхгүй л байна аа даа  
 Нүгэл баймаар юм  
 Нүдний салхинаас бусад юм  
 Хааны их хатанд  
 Хүрдэг гэж үү? Би мэдэхгүй юм

#### Арчуг:

- Билбүүр үг

Битгий ярь, Эгэрэг минь  
 Би мэдэж байна  
 Бие нь загатнасан эм хүн гэдэгт  
 Битүү нүх гэж үлддэггүй юм  
 Би мэднэ  
 Битгий намайг ховсод  
 Итгэе гэхэд  
 Итгэж болохгүй байна  
 Эгэрэг минь!  
 Инээмээр байна...  
 Хавирган завсраараа гараа оруулж  
 Халуун зүрхээ базлаа ч  
 Худлаагийн усан шүүс гарч  
 Хурууны үзүүрт үнэн юм торохгүй  
 байна  
 Биеэ мэдэхээ байснаа  
 Би хүлээн зөвшөөрлөө ч  
 Биед эргэх халуун цус минь  
 Толгой дохитол лугшихгүй байна

#### Эгэрэг:

- Уймарч байна, та!  
 Ургаа сэжиглэх болчхож  
 Арьсаа хазаж байж  
 Амьдаа мэдэх болох нь  
 Сүүдэртээ хүртэл итгэж чадахгүй  
 бол  
 Сүнс чинь гэрээ олохгүй болно  
 Хаантан минь  
 Арчуг:  
 - Таагдахгүй оньсого надаар  
 Таалгах гэсэн...  
 Тайлбарлаж өг гэж чамайг явуулсан

Тамлан тэнгэр чамд гялайлаа...  
 Өлгийтэй байхдаа мэдэгдэхгүй ээ  
 Өөдөс болгон жижигхэнээрээ  
 адилхан  
 Өссөн хойноо танигдана...  
 Өр өмөртөл танигдана...  
 Тэр цагт  
 Тэнэг миний  
 Гэнэдэх эртдэж  
 Гэмших оройтно  
**Эгэрэг:**  
 - Хүннү төр барих  
 Хүү чинь  
 Их хатнаас чинь гарсан  
 Итгээгүйн чинь хохийг дуудах  
 Хүү байх ёстой  
 Дагаж ирсэн хаан хуулийг  
 Хэрвээ зөрчвөл  
 Далай олон танд  
 Хилэгнэн зэвүүцнэ  
 Энэ хүүг хаан суулгана гэдэгт  
 Эргэлзэж байгаа юм байна, та  
 Эрэг дээрээс булгаран  
 Усанд унах гэж байгаа мод шиг  
 санагдаж байсан  
 Үр жимсээ танихгүй  
 Намар сэгсэрдэг  
 Үлгэртсэн модод шиг...  
**Арчуг:**  
 - Үнэнийг би бусдад харамлаж  
 чадахгүй ч  
 Энэ эгшинд өөрөөсөө ч харамлаж  
 байна  
 Хаан сэнтийд хоёр бөгс багтдаггүй  
 юм  
 Харин нэг толгой л багтдаг юм  
 Балгахан жаргалтай шөнүүдийг  
 Нэгэн дэрэн дээр шатаасан  
 Бага хатнаасаа гарсан үрийг  
 Хаан ширээнд суулгана  
 Мичид дээр минь түгэхээ болиг  
 яахав  
 Миний үнэн газарт бас буй  
 Цэцэг шиг ариухан түүний умайд  
 Цэнгэлийн үзүүр минь загас шиг их  
 жаргасан  
 Халгисан их хүсэл тачаал минь

Хаанаар гулгисанд би эргэлзэхгүй  
 Битгий толгойг минь эргүүлэх гэж  
 оролд  
 Биеэсээ урваж, нүүр ардаа  
 гардаггүй юм  
 Билүүдсэн үгийг хэчнээн удаан  
 хадгалсан ч  
 Хэлсэн цагт л аманд үлддэггүй юм  
**Эгэрэг:**  
 - Сүүтэй ямаа бараадсан өнчин  
 ишиг шиг  
 Сүр сүүдэрт таныг насаараа дагаж  
 Айдаг олныг бодвол  
 Арай л ойрхон оршиж  
 Алдаанд чинь золиос болж  
 Алдарт чинь ивээс болж  
 Өдий хүртэл явсандаа  
 Өөрт чинь санаснаа айлдчихлаа...  
 Өршөө намайг...  
**Арчуг:**  
 - Өөрийн бодлоосоо буцахгүй ээ, би  
 Өлгийтэй байхад нь би хаанд  
 өргөмжилнө.  
 Хааны дэргэд  
 Хаан өсөхийг  
 Хагацал, баярын  
 Хорвоо хараг!  
**Эгэрэг:**  
 - Аргиж дээ! гэхэд  
 Арай ахадмаар байна  
 Итгэлээ та надаас  
 Шоргоолж шиг зөөж байгаа бол  
 Энэ толгойгоо би  
 Тэдний чинь хоолонд өгмөөр байна  
**Арчуг:**  
 - Итгэдэг дээ! Чамд би  
 Эгэрэг минь  
 Үг болгоныг дагаж жиргэхийг  
 Итгэл гэдэггүй юм...  
 Үүн дээр л бид хоёр  
 Нэг юмыг зэрэг харж чадахгүй нь  
 Аранганд хэдрэгдүүлсэн мэт толгой  
 лугшиж байна  
 Амар байлгаж үзээч! Намайг  
**Эгэрэг:**  
 - Элчээр явуулсан захидлын хариу  
 шиг

Энэ явдлын хариу хурдан ирнэ

**Арчуг:**

- Элчийн эргэж ирэх ирэхгүйг  
Эрхэт тэнгэр л мэддэг шүү дээ!

Элч халиваас

Ирэх хариу нь хамт хальдаг бус уу?

**Эгэрэг:**

- Хяслын төлөө совинтож байгаад

Хүслээ өчихөө мартаж шахаж

Адилхан хоёр нуган үрийг

Алагчлахгүй үзэж

Илүү дутуугүй

Ижил өлгийд өлгийдөж

Идэр болохын цагт нь

Илдийг хүртэл адилхан агсуулахыг л

Хаан танаас гуйя!

**Арчуг:**

- Тэр харин бололгүй дээ!

Тэг гэж би зарлиг больё! (Эгэрэг  
мэхийн гарч одно)

**Арчуг:**

- Хорвоо надад яаж хорсохоороо

Хоёр гуравхан хоногийн зайтай

Хоёр нуган төрүүлж өгдөг байна

Хачин юм...

Хүссэний минь төлөө

Бялууруулж байхаар

Хяссанаараа гөлийж байхгүй  
яагаав.

Бяртай тэнгэр минь...

Би өөрийнхөө мэдэлд байна

Миний мэдэлд төр байна.

Эхний бодсон зөв байдаг

Эргэцүүлэх ихдэхээр тэнэг болдог

Ингэхэд би

Их хатантайгаа

Янаглаж, халаглах нь битгий хэл

Яаж инээдгийг нь хүртэл мартсан  
билээ.

Тоосоор хээлтэх, цэцэг шиг

Тэр яахлаараа нуган төрүүлдэг  
билээ.

Тэр миний үр биш,

Тэнгэр та харсан даа!

Бороотойгоо цуг асгарч надад хэлж  
өгөөч!

Буруу надад байвал ниргэж өгөөч!

(Арчуг алгаа гурвантаа ташихад  
шивэгчин эмч орж ирэн, хааныг  
хажуулуулан барьж өгөх ялдам  
зургаан ятгатай бүсгүй ятгална.  
Хөгжмийн эгшиг асар яруу уянгалаг  
ажаам...)

(Харанхуйлал)

Ганц саглагар модны дор Эгэрэг,  
их хатан Цэцэр хоёр үнгэлдэн  
ноололдож байна.

**Цэцэр:**

- Хүү уйлж байх шиг байна

Хөх ивлэчихлээ...

Эгэрэг:

- Ангир уураг гэдэг

Аав хүү хоёрт

Адилхан ивлэдэг юм (инээнэ)

**Цэцэр:**

- Явъя!

Янаг ихдэх дэмий...

Эгэрэг:

- Яараад яахав

Ярих юм байна

Хийх ч юм байна

Бие нь өтөлсөн чоно гэлээ ч

Бэлтрэгээ танихтайгаа байна

**Цэцэр:**

- Юу ярина, чи

Юун чоно

Эгэрэг:

- Чиш! Чанга битгий хашхир!

Чамтай отолдог чоныг хэлж байна

**Цэцэр:**

- Арай чи хааныг хэлээгүй биз дээ

Алдас болно

Эгэрэг:

- Цагаан санаат, хар явдалт минь

Цаадах чинь бүхнийг гадарлаж  
байна.

Миний хүүхэд биш гэж

Мэлзэж байхдаа, шүд нь шажигнаж  
байсан.

**Цэцэр:**

- Хаан гэдэг тэнгэр заяатай тул

Хардаг сүлд нь хажууд нь тул

Сар нарны

Совинтой буюу...



**Эгэрэг:**

- Эмийн тэнэг газарт яргаж  
Эрийн тэнэг тэнгэрт хадна  
Эхсийн цацарт бушуу очиж  
Эмгэдийн үүргэлэх хооронд амжиж  
Өлгийтэй хоёр хүүхдийг соль  
Өдийд л хийхгүй бол хожимдоно

**Цэцэр:**

- Яаж болох билээ  
Ядаж олдсон ганц үр минь

**Эгэрэг:**

- Бага хатныхаа хүүг ширээнд  
зална гэж  
Бараг л биеэ цавчин андгайлж  
байна  
Зөнтэй хаан  
Зөвийг нь барьж байна  
Балгардсан энэ үед нь  
Бодсоноо хийж авбал  
Бага хатны хүүгээ заллаа гээд  
Бид хоёрын үрийг залах нь тэр  
Бага хатан гэнэн  
Барагтай бол ялгахгүй  
Хөхөө амлуулж чадахгүй  
Уйлж суусан амьтанд  
Хүний минийхээ ялгах  
Ухаан сууна гэдэг өдий  
Цугаарыг захирсан их хааны  
Цус нь бид хоёрынх байх болно  
Амь ухаан суугаад ирэхийн цагт  
Аав чинь хэн бэ? гэдгийг чөмгөнд  
нь би хэлээд өгнө.

**Цэцэр:**

- Ойлгохгүй байна, би...  
Олны нүднээс айж байна  
Аймаар юм ярих юм  
Арай би чадмааргүй...

**Эгэрэг:**

- Хувь заяаны энэ боломжийг  
Хулчийхад битгий булаалга  
Эрийг битгий хэл төрийг дийлэх  
зоригийг  
Үүнд л чи гарга.

**Цэцэр:**

- Үрээ төөрүүлтэл чивчрэх сэтгэл  
Үнэндээ надад алга  
Өшөө атааны золиосонд

Өдий болсноо эс мэдэв, би...  
(Уйлна)

**Эгэрэг:**

- Хүнийг төрхөө олоогүй байхад нь  
Гөлгийг нүдээ нээгээгүй байхад нь  
төөрүүлдэг юм  
Хааш хаашаагаа хаанд дарагдсаны  
Хариуг авч бахаа хангамаар байна.  
Битгий нялхар, тэнэг эм минь  
Би дараачийн хааны эцэг...  
Эрт гундсан үзэсгэлэн чинь  
Хааны дурыг гутааж  
Элэгнээс чинь унасан үрд чинь  
Хаан болохын заяаг дутаасан  
Хяслын энэ орчлонгоос  
Хариугаа би авах гэж байхад  
Урт бодохгүй  
Усан нүдлээд...

**Цэцэр:**

- Чамаас би гуйя  
Чадахгүй нь, би...  
Чиний үр билээ  
Энэ хүүхэд... (Уйлан сөгдөнө)

**Эгэрэг:**

- Ээ чааваас... тэнэг эм.  
Эрх ямба, эд агуурс  
Эзэрхэн эдлэх эрх дархаа  
Эхүүн нулимсаараа угааж байна,  
чи . . .  
Үүнийг л чи хийхгүй юм бол  
Энхрий явснаа би мартана.  
Нуудгай үр минь хаан суух  
Нуур шиг их жаргал эдлэх  
Тэр цагийг би харж байна  
Тэмдгэрч байгаа үүрийн туяа шиг  
тод харж байна.  
Хормой дээрх алтнаасаа атган  
Хонь мал руу нүүлгэж  
Хөх газар дээр биш  
Хүн дээр гишиглэж яваа чамайг  
харж байна.  
Хорссон боолын шүд ярзайж  
Хотолзох нурууны нь яс шажигнаж  
байгааг ч сонсож байна (Тачаадан  
байж ядна).  
Энэ боломжийг  
Эс ашиглаваас



Их хатан  
Бага явдалт чамаас  
Үнссэн уруулынхаа мөрийг  
Биеэс чинь илдээр ухаж авч  
Үхсэн зовлогоор чинь  
Тасын тахилга үйлдэнэ

**Цэцэр:**

- Тэнгэр минь  
Чиний хаанаас чинь  
Энэ цус мэт үг урсаж  
Миний толгойг  
Будаж байна вэ?  
Тэнгэр минь (Ухаан алдан унана).

**Эгэрэг:**

- Андуурагдам байхад нь  
Амжиж солихгүй бол  
Алдана даа, чи...  
Амь чинь ч  
Алдааны чинь үнэд хүрэхгүй  
(Харанхуйлал)

**Хоёрдугаар үзэгдэл**

Эхэс, нялхсын цацарт, цэнхэр  
үдэш. Хойморт навчин шүхрийн  
дор их, бага хоёр хатан гөрөөсний  
арьсан өлгийтэй хоёр хүүхдээ  
хөхүүлэн нойрсуулан байна.  
Хоёр талд зээглэн суусан эхэс,  
эмгэд, эмс бүүвэйн дууг хөгжөөнө.  
Бүүвэйн дууны ая уянгалаг агаад  
зөөлхөн тул бүгд өөрсдөө ганхан  
дуулах бүлгээ...

**Цэцэр:**

- Тэнгэр минь  
Эгшигт согтож  
Алжаасан бие зовхи чинь  
Анилдаж байна...  
Гадаалж од харж  
Нүдээ сэргээтүгэй  
Гайхах явдал үгүй  
Бид хоёр хүүхдээ нойрсуулж байя.  
(Эхсүүд, ашгүй дээ гэсэн шиг  
шалавхийн гарч одоцгооно)

**Гүргэл:**

- Их хатантаан!  
Мэлрэг цэцэг хүртэл хаяагаар  
үнэртэн мансууруулж  
Миний сормуус хацар дээрээ байн

байн унах бүлгээ...  
Хүүг минь та ажирч байгаарай  
Хүйтэн салхинд нойроо хийсгэчхээд  
ирье.

**Цэцэр:**

- Тэг, дүү минь.  
Тэгэлгүй яахав (Гүргэл гарч одно)  
(Цэцэр ганцаар үлдэн нэлээд  
хавчиж байснаа, хоёр хүүхдийг  
сольсноо, тэвчиж чадахгүй дахин  
буцаана. Тэгснээ дахин сольж  
бага хатны хүүхдийг тэврэн авахад  
хүүхэд нь часхийн уйлна. Энэ үес  
эхсүүд болон Гүргэл орж ирмэгц  
сандран хөхөө бага хатны хүүхдэд  
үмхүүлнэ... тэгснээ Цэцэр ихэд  
чанга мэгшин уйлна)

**Гүргэл:**

- Хатан авхай юунд  
Хатгуулсан мэт  
Хайлав?...

**Цэцэр:**

- Олон та нарын араас гарч  
Одонд харагдъя гэтэл  
Орилон уйлав, энэ хүү...  
Үйлийн үрдээ гомдож  
Өөрийн эрхгүй хайлав, би...  
(уйлагнан)  
Та нарын минь нойр үргэв үү?

**Эхэс:**

- Тэглээ...  
Агь нарыг харж  
Анилгүй хонодог нүдэн  
Аргагүй хааяа чилэх юм...  
Эгэрэг өрлөг хилэгнэж  
Эхэс биднийг буримдаж  
Унтсан нүд байвал  
Ухаж хаяна гэдэг...  
Ээ тэнгэр минь...  
Гүргэл (солигдсон хүүгээ тэврэн)  
Хөх шөнийн үнэгтэй тоглон  
Бөх унтжээ, миний хүү...  
(Бүүвэйн дууны эгшиг улам  
уянгалаг яруу зөөлөн сонсогдох  
ажаам...) (Харанхуйлал)  
Ганц саглагар модны дор (өдөр)  
Ганц гоёмсог сэнтий, сүү мэт цагаан

өнгөт эсгийг дэвсчээ... Хоёр талаар зээглэн зогссон өрлөгүүд, хатад эмс, хөгжимчид, хааны магтуу өргөн байна. Арчуг хаан Гүргэл хатны хамт гөрөөсний арьсан елгийт хүүхдээ тэвэрсээр гарч ирэн хаан сэнтийд дөхөхүй дор их хэнгэрэг дэлдэнэ. Хаан сэнтийнээс адис авч гурвантаа мөргөөд сөгдөн сууж:

Дээр хөхрөгч тэнгэр  
Дээдсийн сүнс өршөө  
Цуутай дээдэстэй  
Цусны аргамжаатай хүүгээ  
Цугаарын хаанд өргөмжлөв.  
Өтгөс дээдсийн ёсыг урагшлуулж  
Өлгийтэй байхад нь их дор суулгав,  
би.

Амин хайртай бага хатнаасаа гарсан нуганг

Амьд ахуйдаа хаан болгов, би...

Төр самуурч

Гэр үймэхээс эмээхгүйг бодов, би...

Амь тавин аладддаг энэ их орыг

Амьд байхдаа эзэнтэй болгов, би

Хөлд орох анхны алхам нь хүртэл

Хүннү төрийн төлөө байг гэж бодов,  
би.

Хөлд орох анхны үг нь хүртэл

Хүннү гэж хэлэг гэж санав, би.

Хүннү төрийн хаанаар

Хүүгээ өргөмжлөв, би...

(Өлгийтэй хүүгээ сэнтий дээр тавихад хүмүүс баярлалдан урдах дудар мэт бяцхан бөмбөрийг нүдэн хашхиралдана. Энэ нь уухай мэт эмхтэй биш байх болно)

**Эгэрэг:**

- Хааны бага хатны нуган их ор суув  
Үсэрсэн цус тэнгэрт хүрэхийг үзэв,  
би...

Үнэндээ би азтай хүн бүлгээ...

(Ихэд баяр хөөртэй)

Хаан цусанд од унаж

Харгуйгаа сольж урсав

Тэр нь намайг дайрч урсав

Тэнгэр намайг татаж босгов

Арчуг:

- Эгэрэг чи

Утга юутай үг

Унагаж өнгөрөв?...

**Эгэрэг:**

- Баярласан хүний үг

Нулимс шиг дураараа унах юм...

Бага хатны нуганг их ор суухад

Бараг би зогсоогоороо нисэж  
байна, хаантан минь.

**Зар мэдээч:**

- Арчуг хааны нуган

Ачир хөвүүн хаан суувай.

Дагатугай...

Сөгдтүгэй...

Биширтүгэй...

(Хүмүүс бүгдээр, газар мөргөн сөгдөнө. Их хэнгэрэг, хөгжим дуурьсан харанхуйлна)

**Хоёрдугаар бүлэг**

**Гуравдугаар үзэгдэл**

Их цацарт

Арчуг хаан, Ачир хоёр...

**Арчуг:**

- Миний тэнэгхэн үр минь, би.

Хүний жамаас гадуур явсангүй

Улиран ирэх он тоололд

Ухааны минь зул дальдчиж

Төрийг сэтгэх нь битгий хэл

Гэрийг сэтгэж чадахаа болив

Хан хүү чи юу бодно?

**Ачир:**

- Хамаг хүн хайлж

Хаан эзэн халихад

Хасаг тэрэг хяхнан

Их хориог зориход

Энэ тухай бодно доо

**Арчуг:**

- Би чиний өсөхийг хүлээж

Чи миний үхэхийг хүлээж

Чамд жам хань болж

Надад тэнгэр хань болох нь дээ!

**Ачир:**

- Наад яриаг чинь би мэднэ.

Начигай онгон надад зөндөө ярьсан.

**Арчуг:**

- Амьгүй онгон ярьдаггүй юм, хүү  
минь.

Харин хардаг юм...

Нас нь тэнгэр мэт мөнхөрсөн тэд  
Надад яриагүй үгээ чамд л ярив  
гэж дээ.

**Ачир:**

- Ярьсан... ярьсан  
Ярьж байхдаа тэр амьсгаадаж  
байсан.

**Арчуг:**

- Надтай чи андуураад байна аа  
даа.

Алдрай нялхаас чинь эхлээд  
Амьсгаа минь хүртэл чамайг тойрч  
Хоточ нохой шиг

Хойно урд чинь гарч явсан...

**Ачир:**

- Унхиагүй хэвтүүлүүдээс болоод  
Унаганд өшиглүүлсэн минь  
хялуутаж

Тархи минь мансуурч  
Тайван байхаа би больсон  
Үүнээс л болж миний хүү унадаг  
тусдаг болсон гэж  
Ээж надад уйлж хэлсэн.

**Арчуг:**

- Зоргоороо эрх дураараа чинь  
Зовлон чамд авчирсан хэрэг...  
Тэнгэрийн хүлэг чам дээр  
Тэмдэг тавьж тамгалсан хэрэг...  
Тархин дотор чинь, хөлөө  
хийчихсэн биш  
Тэнэглэх гэдэг өөртэй чинь цуг  
төрдөг...

Ухаантай хэчнээн байх гэлээ ч  
Уг борви чинь багадах тул  
Гаднаас чам руу асгасан ухаан  
Гарз төдий болон замхарч  
Тэнэг эмийн нулимс шиг  
Тэр чигээрээ халж асгардаг...  
Харамсаж байна... би  
Харцын нулимсаар  
Хирийг чинь угааж өсгөсөн сөн...  
Бүсэлхийнээс чинь дээш толгойгоо  
гаргасан хүн

Би л ганцаараа байсан...

**Ачир:**

- Нуурын хөөс хөл долоох шиг  
Нуршихыг чинь би зөндөө сонслоо  
Яршиг!

Ядарч байна, залхаж байна.

Арчуг (уурсан):

Яршиг гэнэ ээ  
Яаж чи хэлж зүрхлээв.  
Чамайг үгүйд хаан байсан хаан  
Чиний урд амьд зогсож байна.

**Ачир:**

- Яг тийм байна.

Явах гэж  
Яарсан хүн  
Миний өмнө зогсож байна.

**Арчуг:**

- Өтгөсийн сүнс намайг залхааж  
байна.  
Өлгийтэй байхад нь хаанд  
өргөмжилдөг буруудаж...  
Хүн болохыг чинь харж байж  
болгодог байж  
Хүндэтгэл дэндүү эртдэж...  
Нүдээ нээгээгүй гөлгөнд хаан  
ширээ зааж өгч  
Нүгэл би үйлдсэн байна.

**Ачир:**

- Би  
Бие гүйцсэн хаан  
Их залхаж байна.  
Илдээр наадах цаг болчхож  
Хөгшин албат минь  
Хөөс сахруулан уурлаад яахав.  
Аав минь та  
Амьд хүн цавчиж наадахыг надад  
болгоо  
Олиггүй амьд сүгнүүд зөндөө байна  
Олдохгүй бол олзны хүмүүсээсээ  
өгчих

**Арчуг:**

- Юу гэнээ чи хө  
Юутай тэнэг аашилна, чи  
Толгойг  
Тоглоомд өгдөггүй юм.

**Ачир:**

- Цус гарахгүй юм цавчихаар

Бах ханахгүй юм.  
Цугаарын хаан шүү, би  
Би... би... гэснээ  
(Муужирч унан татна. Ачир  
уурсахдаа татаж унадаг хуучтай  
ажаам)

**Арчуг:**

- Хөөе! Зарцас!  
Ханхүү уначихлаа...  
Арчилж сэхээ!  
Алтан сэтгүүрээр шүдийг нь хөш  
Жагар зандан үнэртүүл!  
Заамыг нь ярж салхи амсуул!  
(Зарцас сандран орж, арчлан  
бөндөгнөлдөх дор Ачир сэхэж  
өндийж ирнэ)

**Арчуг:**

- Явцгаа! (Хүүгээ аргадан тэвэрч)  
Аавын нь хэлсэн үгийн  
Төвөргөө нь жаахан хатуудлаа...  
Архаг энэ өвчнөөс чинь салгаж  
Амьддаа би чадахгүй нь  
Юутай харуусал...

**Ачир:**

- Зүгээр би ингэдэг юм...  
Зүүдлээд өнгөрөх шиг...  
Дараа нь бие хөнгөрч  
Далавч ургах шиг болдог

**Арчуг:**

- Ашгүй дээ, үр минь  
Аядуу юм ярья, хоёулаа  
Аав хүү хоёр байна даа  
Эрэмдэг ужиг өвчтэй ч гэсэн чи  
Эр хүн болжээ.  
Хасын цагаан царайны нь гэрэлд  
Элчийн захиа уншиж болохоор  
Хатан авч өгье, аав нь.

**Ачир:**

- Энэ дэмий  
Эгэрэг өрлөг надад хэлэхдээ  
Эцгийгээ үхэхээр, чи  
Эхтэйгээ гэрлэнэ гэж хэлсэн  
Эрхт төрийн ёс тийм гэсэн

**Арчуг:**

- Ээ тэнэг минь  
Галзуурсан мунхгийн туйл минь  
Гаргасан умайдаа дахиж багтах нь уу?

Чиний амнаас үг биш  
Могой унах шиг...  
Зүглэж ирсэн тэр могой  
Зүрхийг минь хатгах шиг  
Даанч дээ! Даанч үр минь  
Дальгүй шувуу байж болно оо.  
Нисэхгүй л байна биз.  
Даанч ийм тэнэг байх гэж...  
Нусаа цэвэрлэж чаддаггүй амьтан  
Цусаа цэвэр байлгахыг яаж ч мэдэх  
вэ дээ.

**Ээ тэнэг**

Тэнгэр минь би таны өмнө  
Үе дамжин яллагдах  
Үйл юу хийсэн билээ...

**Ачир:**

- Хүний хэлснийг л хэллээ  
Хүн сүрдмээр ч юм биш

**Арчуг:**

- Хаан биш юм байна, чи  
Харах гэхэд зовхи даагдахгүй  
байна  
Эхийн чинь нүдний цагаан булан  
Их далайн сувд шиг цагаан сан  
Чиний нүдний булан  
Цус бударсан улаан  
Мунхгийн элч чөтгөрүүд намайг  
шоглож  
Муу бүхний өөдсөөр чамайг  
эвлүүлж  
Эндүүрлийн гэнэн сиймхийг  
ашиглан  
Эхийн чинь хэвлийд шургуулсан  
байх...  
(Хаан уурсан илдээ сугалан хүү  
рүүгээ дайрна)

**Ачир:**

- Нэг нь илдгүй байхад  
Нөгөө нь дайрдаггүй юм... эцэг  
минь  
Ингэдэг юм аа гэхэд  
Ид хав биш...  
Дарцаг салхинд хийсэх шиг  
Даанч даржин санагдаж байна  
Илдээ огшоочих!

**Арчуг:**

- Ингэнэ гэнэ ээ, чи





Идүүрээ олоогүй гөлөг!  
(Гүргэл хатан орж ирнэ)

Гүргэл:

- Яаж байна даа, та нар минь  
Яс булаалдан сэгэн дээр хэрэлдэх  
ноход мэт

Ачир:

- Ээж минь  
Эцэг надад  
Илд сугалахыг зааж дуусав (Гарч  
одно)

Гүргэл:

- Яагаав?  
Яасан их уурлаав? Хаантан минь!  
(Хаан илдээ газар хаян Гүргэл  
хатнаа тэврэн эхэр татан мэгшсэнээ)

Арчуг:

- Чи уул юм аа гэхэд  
Чиний цаана уул байхгүй юм шиг  
Чи ус юм аа гэхэд  
Чамаас өөр мөрөн байхгүй юм шиг  
Би чамайг хайрласан сан...  
Амь тавин хайрласан  
Ганц эмзэг минь...  
Алганы минь хээг дагаж бөмбөрсөн.  
Ганц сувд минь...  
Ийм хүүхэд чи бид хоёрын  
Хайр нийлэх уулзвараас  
Их хүслийн минь торгон үзүүрт  
Ургалаа гэж үү?  
Итгэмээргүй юм...  
Эргэж гүйцлээ толгой минь  
Тэнэг байж болно  
Тэгэхдээ ийм тэнэг байхдаа яахав  
дээ!

Энэ надад юу гэж хэлсэн гэж  
санана

Эх хүний чих бузартмаар үг хэлсэн  
Яавч би энэ үгийг чамд хэлж  
зүрхлэхгүй нь

Яс минь цайсан цагт, сүүжнээс  
минь асуугаарай

Гүргэл:

- Чиний дэргэд  
Цаадах чинь нялх  
Чигээ олоогүй  
Цадсан болхи шүү дээ, хаантан минь

Арчуг:

- Амраг хатан минь  
Арьс махаа урсан чиний зөв өө  
Амьдсан бол миний эх ч гэсэн  
Арчуг минь нялх амьтан гэж  
Тоог нь алдтал хүн цавчсан  
Гарыг минь илж  
Толгойг минь сүү ивлэдэг  
Цээжиндээ наах л байсан биз  
Хар толгойгоо бодвол  
Хүүгээ уучилж болно  
Хаан төрөө бодвол  
Уучилж үл болно  
Төрийн дор  
Хаан, хатан хоёр буй  
Тэнгэрийн дор  
Хилэнц – аврал хоёр буй  
Арав алхахад найм нь алдаа  
Адасга мэт араншинтай, бас  
хэрцгий зайдан  
Хүний нүд жавраар хайрсан  
Хүүтэй юм байна, чи бид хоёр...

Гүргэл:

- Атаа тэнгэр  
Заяасан нь энэ  
Алалтай биш дээ!  
Хаантан минь

Арчуг:

- Хэрэгтэй цагт цусаа цэвэрлэ гэж  
Хан эцэг минь хэлдэг байсан  
Би тэгэх цаг болжээ  
Битгий гомдоорой, хатан минь  
Билүү мэт бодол, шийдэл  
Бие ухааныг минь ирлэж дууслаа  
Өршөөгөөрэй, хатан минь  
Өнөөдөр ухаарсан ухаарал биш  
шүү энэ  
Би их бодсон  
Битүү бүхнээ онгойлгож бодсон

Гүргэл:

- Учир битүүлэг үг юунд ярина  
Ухаж би эс ойлгов, хаантан минь

Арчуг:

- Сүү минь халхлаад  
Чамайг ойлгуулахгүй юм шиг байна  
Сүнс минь ч тэг гэж хэлэхгүйг  
Би мэдэрч байна

Үйлийн үртэй хатан минь  
 Үзэж л байж чи мэднэ дээ  
 Үргэсэн гөрөөсний нүд шиг  
 Нүд чинь хоёр тийшээ бөмбөрч  
 Үг чинь эвлэж өгөхөө больж  
 Бие чинь салгалан чичирч байна  
 Цацартаа очиж нойрс  
 Цагаан зүүд зүүдлээрэй.

**Гүргэл:**

- Яах гэж байгаагаа  
 Ядахдаа надад хэлчих  
 Үгүй та...

**Арчуг:**

- Яв даа, хатан минь!  
 Ганцхан удаа би хааны авираар  
 аашилья!  
 Гарзыг нь хожим тэнгэр нөхнө биз

**Гүргэл:**

- Та нэг л хачин байна  
 Танаас би холдмооргүй байна

**Арчуг:**

- Цочирдож зовохын хэрэггүй  
 Цонхигор цагаан саран мандчихаж...  
 Ужиг өвчинд нэрвэгдсэн мэт саран  
 Уйтгар, гайхширал хоёрыг чинь  
 хуваалцана.

**Гүргэл:**

- Үгүй надад нэг л...  
 Хар совин толгойд хэрээчилж  
 Хажуунаас чинь явмааргүй ч юм шиг

**Арчуг (уурсан):**

Үзэгдэхгүй болоод өгөөч  
 Үйлийн үр минь... (хашхирч)  
 Гараад өгөөч, лай минь!  
 Ганцааранг минь бодож байгаатай  
 минь орхичих  
 (Гүргэл хатан шалавхийн гарч  
 одохуй дор Босуулууд орж ирнэ)

**Арчуг:**

- Намжирт Цацарын хормойгоор  
 шурган ирэх  
 Намрын цатгалан царцаа мэт та  
 нар юунд ирэв.  
 Амар баймаар байна. Намайг  
 битгий анзаар  
 Амь нас, бодол хоёр бие биеэ  
 хэмлэж байна.

Үхдэлийн хэвлий дэх өтнүүд мэт  
 Үймэлдэн язганаж дотроос зулгааж  
 байна.

Явцгаа (Босуулууд сандран  
 явцгаана)

**Арчуг (уйлан хайлан):**

Хархан нялхаас нь эхлээд  
 Хатуу үг хэлэх нь битгий хэл  
 Хялайж ганц хараагүй юм сан...  
 - Бурамд шигдсэн зөгий шиг...  
 Буурал болтлоо үнгэсэн юм сан...  
 Гомдоо биз надад  
 Гомдог яахав  
 Голдоо ортол гомдог!  
 Дуулгагүй толгой мөгөөрс байдаг  
 Дуулж үзээгүй үг мэс байдаг  
 Цугаар Хүннү гүрний төлөө  
 Цусаа би цэвэрлэнэ.  
 Хайртай бүхнийхээ цээжнээс  
 Халуун зүрхээ би татаж авна.  
 Өөртэй минь адилхан юмыг  
 хүүгээсээ  
 Өөдсийн чинээг ч олж үзсэнгүй  
 Өөрийгөө хүртэл сэжиглэж үнэртдэг  
 Өөнтөг сэтгэлий минь гай биз!  
 Ийм хаантай төр орхино гэхээс  
 Ичиж байна, би  
 Их хаадын цусан хэлхээ, булшнаас  
 нь хүртэл ичиж байна.  
 Ирэх өдрийн өглөө мандах нарнаас  
 би ичиж байна.  
 Хатан минь чиний буруу гэж ердөө  
 байхгүй ээ.  
 Халуун бие чинь алтан хундага шиг  
 цэвэрхэн  
 Бал, хорын алиныг ч хийж залгисан  
 Байдгаараа үлдэх мөнхийн шидтэй  
 тамлан  
 Чиний бүх юманд бузар байхгүй  
 Миний л бузар булай  
 Бузар нь ариунаа цэвэрлэдэг  
 Бусад нь сохроо дагаж амьдардаг  
 тэнэг хорвоо  
 Дур, зорго ухаан хоёроо хурааснаас  
 минь хойш  
 Дуртай болгон нь төр булаалдаж  
 Бие биеэ хөнөөж



Бишгүй их дайтах биз!  
Идэх гэж дурладаг  
Мэдэх гэж дурладаг  
Тэнэгүүдийн тоглоом болох төрийг  
Тэнгэрийн дор би орхиж чадахгүй  
Хүүгээсээ би маргааш хагацна  
Хүннү төр тэнэгээсээ хагацна  
Мянга мянган жилийн одод бие  
биедээ шивнэж  
Миний зөв гэсэн бурууг, нараар  
цагаатгана. (Харанхуйлал)...

### ТӨГСГӨЛИЙН БҮЛЭГ

(Тэнгэр газрын савслаганд тээр  
дээр хаан сэнтий халзалж дэвссэн  
цагаан эсгий авансценд тулжээ.  
Хоёр талаар нь газар одод буусан  
мэт түүдгийн гэрэл...)

...(Эгэрэг орж ирнэ)

#### Эгэрэг:

- Ёсолж нялганах зав алга, хаантан  
минь  
Ёр бэлгийн шувуу минь өнөөдөр  
өндөглөлөө  
Олон онд тэр дэгдээхэй байсан ч  
Одоо тэр тас боллоо  
Төрийн идээг тонших цаг нь болов  
**Арчуг:**  
- Хачин юм ярих юм, Эгэрэг минь  
Хажуугаар минь наад үгс чинь  
хийсэж байна.  
Харин би чиний нүүрнээс  
Хатгалдах тулааны үед ч үзээгүй  
Хачин их эр зориг, ид хавыг  
Харж байна.  
Чиний нүүрний баярын гялбаанд  
чинь  
Миний нүд гялбаж, тархи зангирч  
байна.  
Чиний тэжээсэн шувуу биш  
Миний тэжээсэн шувууны бие  
гүйцсэн бололтой юм.

#### Эгэрэг:

- Та бид хоёр үг таргалуулж суугаад  
яахав.  
Тамгаа өгчих!

Сэтгэлээ барихыг хүсье!  
Сэнтийг чинь бол бөгс минь олоод  
суучихна.

#### Арчуг:

- Юу? (Хүйтнээр инээнэ)  
Чамд тамгаа өгөх  
Газар алдах хоёрт ялгаа юу байна  
Гутал дээгүүр гүйж байсан  
шоргоолж  
Малгай дээгүүр гүйх нь...  
Эрүүл байна уу? Чи  
Эгэрэг минь

#### Эгэрэг:

- Таныг ингээд харж байхад  
Мухар нүдэнд амь хоохойлон  
шургасан  
Мий муурын бөгс тонтгонох мэт  
байна.  
Удам тасарсан төрийн толгойд  
Ухаантай цог зальтай нь л сууна  
биз дээ.  
Байдлын үнэн, он цагийн үнэн хоёр  
Багтаж ядан чихцэлдэж байгааг  
Мэдрэхгүй байгаа бол  
Миний таны өмнө  
Мэхийсэн бүхэн минь алдас болно  
Алив! Хаантан тамгаа өгчих  
Алган дээр тавьчаад мэхийн  
сөгдөхөө мартав аа!

#### Арчуг:

- Болоогүй ээ, Эгэрэг минь  
Чи дэндүү яарч байна  
Хаан хүн  
Сэнтий, тамга хоёроо өгдөг юм аа  
гэхэд  
Цаана нь үлдсэн хаан зүрхээ өгөх  
үү, үгүй юу гэдэг...  
Чи ганцаараа хариулчих асуулт  
биш  
Би  
Хүннү төрийн тамгыг барих  
Хүнгүй болчхоор нь  
Хоёр сүүн уулын цаана  
Хорин улаан горхины уулзах газар  
булчихсан  
Есөн үеэр сахиж  
Ерхөг өвсийг нь ч битгий хөдөлгө гэж

Нэгэн биеийн эрхтэн шиг итгэлт  
отогтоо

Захиад онголчихсон

Чи олохгүй

Чамд олдохгүй

Өөрийгөө идэх өт

Биен дотроос гардаг шиг

Төрийг идэх өт

Түшмэл дотроос гардгийг

Ихийн их мэддэг мөртлөө

Эгэрэг чамайг гэж мэдээгүй минь  
алдас болж

Хэн хаан суусныг

Тэнгэр бууж ирж үздэг юм

Хэрэггүй амьтан байвал

Түүнийг булчхаад буцдаг юм...

**Эгэрэг:**

- Адтай хөгшин араатан

Адармаа битгий гарга

Би Хүннү гүрний хаан, тамгаа аль

**Арчуг:**

- Гар чинь цустай

Тархи чинь устай

Төр барьдаггүй юм

Эгэрэг минь

Их амархаан!

Чи тамгатай болж болно

Ядуу боолын тойгны

Ясаар нь тамга сийлж

Цусанд нь дүрж тамгална биз!

(Арчуг илдээ Эгэрэгт дүрэхэд Эгэрэг илдээ Арчугт дүрнэ. Хоёр илдэнд сүлбүүлсэн хоёр хүний силуэт. Дундуур нь хаан сэнтий алтран харагдана. Хэрээний дуу тэгснээ хөгжим нүргэлэн эгшиглэнэ)

(1998 оны хавар-зун-намар)

**Эх сурвалж:** (Б.Лхагвасүрэн. "Тамгагүй төр". УБ., 2011)

Цахим сурвалж: <http://www.bibirbeh.mn/>



#### ҮГИЙН ТАЙЛБАР:

**Их цацар** - Ордон доторх нэг асарт өргөө

**Хэвтүүл** - Хааны ордон, өргөөг хамгаалах харуулын нэр

**Сэнтий** - Хааны суудал сандлыг өргөмжилсэн дээд найруулгын үг

**Хөх шөнийн үнэгтэй тоглох** - Жаахан хүүхдийн зүүд нойрон дунд үнэг орж ирж тоглоход нь хүүхэд инээдэг, үүнийг үнэгчлэх гэнэ

**Адис авах** - аливаа зүйлийг бишрэн шүтэх, дээдлэн өргөмжлөх

**Өрлөг** - Хааны дотно шадар туслах болон цэргийн хүн



УНШСАНЫ ДАРАА

**Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар түүх, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.**

- Түүх, нийгмийн хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Ямар түүхэн тодорхой цаг үе дүрслэгдэж байна вэ? Өнөөг хүртэл бидний сонирхлыг татсаар байгаагийн учир юу вэ?
  - Жүжгийн үйл явдал нийгмийн ямар хүрээллийн дунд өрнөж байна вэ? Яагаад?
  - Жүжгийг эмгэнэлд хүргэж байгаа гол шалтгаан юу байв? Яагаад?
  - ..... гэх мэт
- Соёлын хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Монголчуудын зан үйлээс юуг? Ямар зорилгоор дүрслэв?
  - Хүүхдийг яагаад гөрөөсний арьсан өлгийд өлгийдсөн юм бэ?
  - Бөөгийн зан үйлийг дүрсэлсэн нь ямар учиртай вэ?
  - Тэнгэрийг дээдлэн шүтэх уламжлал аль аль хэсэгт ямар үүрэгтэй байна вэ?
  - ..... гэх мэт

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

- Зохиолыг яагаад “Тамгагүй төр” гэж нэрлэв?
- Зохиолч яагаад энэ сэдвийг сонгон авч бичих болсон бэ?
- Төр улсын бүрэн бүтэн байдал, алтан ургийн ариун цусны төлөө тэмцэх хааны үйл хэргээр зохиогч юу хэлэхийг зорив?
- Арчуг хаан, Эгэрэг түшмэл хоёрын үнэ цэнтэй зүйлийн талаарх үзэл бодлын зөрүүг харьцуулж дүгнээрэй.
- Судлаачийн дүгнэлтийг уншаад сэдэв, утга санаа, хам сэдэвтэй холбож тайлбарлаарай.

**СУДЛАЛ ШҮҮМЖ**

Б.Лхагвасүрэнгийн шүлэг, дууль, жүжгийн зохиолуудад эмгэнэлт агуулга, түүхэн сургамжит үзэл санаа голлодог нь түүний туурвил зүйн үндсэн баримтлал гэж болно. Ингэхдээ хүмүүний гарвал угсаа, үнэнч зан, шударга ёс, нийгмийн зөрчилт үйл явдалд хандсан шүүмжлэлт агуулгаар жигүүрлэдэг онцлогтой. Харин “Тамгагүй төр” жүжиг нь хувь хүний эрх ашгаас хаан төр, ард түмний эрх ашиг ямагт илүү гэдгийг дэвшүүлэхдээ нэгэн хүний үйлдэл нийгэмд ямар ч үүрэг гүйцэтгэж болохыг хүн төрөлхтний төрт ёсны түүхэн сургамжтай холбон эмгэнэлт үйл явдал, үзэл санааны тайлал болгон харуулсанд үнэ цэн, ач холбогдол нь оршдог.

*(Д.Цэвээндорж. “Б.Лхагвасүрэнгийн уран бүтээл дэх эмгэнэлт үзэл санаа”. Хориг шүүмжийн бичиг. УБ., 2011, 55-р тал)*



### Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэе.

1. Жүжгийн үйл явдлын эхлэх шалтгаан, үр дагавар болоод үйл явдлын гэнэтийн эргэлтийг холбож тайлбарлаарай.
2. Жүжигт нууц далд явуулга бүхий ямар хэрэг явдлууд байгаа, тэдгээр хэрэг явдлаас ямар үр дагавар гарсныг дүгнээрэй.
3. Үйл явдал өрнөсөөр хамгийн оргил хурцадмал үедээ хэрхэн очсон хийгээд хурцадмал байдал хэрхэн намжиж тайлагдаж байгааг задлан шинжлээрэй.
4. Задлан шинжилгээ дээр тулгуурлан жүжгийн үзэгдлийг зохиолч хэрхэн зохион байгуулдгийг дүгнээрэй.

### Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжилье.

1. Ямар орчныг зохиолч сонгосныг тэмдэглэж унших, ямар үг хэрэглэсэн нь өвөрмөц байгааг тунгаан бодох
2. Сонгосон орчин нь дүрийнхээ ямар шинжийг тодруулж байгааг ажиглах, тусган хүлээж авах
3. Гадаад, дотод орчин нь дүр, зохиолын сэдвийг тодруулахад яаж нөлөөлж байгаад задлан шинжилгээ хийх. Жишээ нь:

Эхлэл хэсэгт	2 дугаар үзэгдэл		
Ганц саглагар модны дор. Оройн наран жаргах үе. Нурамшиж байгаа гал тойрон сууцгаасан хүннүүд...	Ганц саглагар модны дор (өдөр)		
	Ганц гоёмсог сэнтий, сууцгаасан хүннүүд...		
Дүгнэлт:			

### Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж үнэлье.

1. Жүжигт дүрслэгдсэн бичил дүрслэлүүд ямар үүрэгтэйг тайлбарлаарай. Жишээ нь:

Эхлэл хэсгийн горимд	Өрнөл хэсэгт	Төгсгөл хэсгийн горимд
...Зээглэн суусан хүмүүс дунд цас цагаан өмсгөлт сая төрсөн хоёр эм, гөрөөсний арьсан өлгийтэй ихэр мэт хүүхэд нэг нэгээр тэврэн суух нь олон хэрээнүүд дундах хун мэт харагдана...	...Үгүй надад нэг л Хар совин толгойд хэрээчилж Хажуунаас чинь явмааргүй ч юм шиг...	...Хоёр илдэнд сүлбүүлсэн хоёр хүний силуэт. Дундуур нь хаан сэнтий алтран харагдана. Хэрээний дуу тэгснээ хөгжим нүргэлэн эгшиглэнэ...
Дүгнэлт:		

2. Жүжгийн уран дүрслэлээс түүж дүгнээрэй. Жишээ нь:

Эшлэл	Зохиолчийн зорилго	Уншигчдад үзүүлэх нөлөө
Төрийг идэх өт Түшмэл дотроос төрдгийг Ихийн их мэддэг мөртлөө...		
Дүгнэлт:		



### Далхаагийн НОРОВ

1951 онд Говь-Алтай аймгийн Бугат суманд төржээ. 1967 онд АУДС, 1983 онд МУИС-ийг дүүргэжээ. Тус сургуулиудад багшилж байгаад 1990 оноос МЗЭ-д, 1995 оноос МҮОНРТ-д редактороор ажиллаж байна. 1975 оноос “Өнийн цэнхэр уулс”, “Уулынхны туужис”, “Цэцгийн гурван сар”, “Үхлийн тухай өгүүллэгүүд”, “Хөх туужис” зэрэг өгүүлэг, туужийн номуудаа хэвлүүлжээ. Мөн “Алтан богдын шил”, “Уулын хөх сүүдэр” роман, “Үнэ цэнэ”, “Их хатан” драмын жүжиг, “Үхэл хүлээх газар”, “Хүйтэн цуст”, “Зүрхэнд шивнэсэн үг” кино туурвижээ. 1992 онд МЗЭ-ийн шагнал, 2000 онд “Эцсийн тушаал” теле жүжгээрээ Д.Нацагдоржийн шагнал, 2004 онд “Хөх сайрын чулуу” номоороо Монгол улсын Төрийн шагнал хүртжээ.



#### УНШИХЫН ӨМНӨ

- 1937 оны үеийн хэлмэгдүүлэлтийн тухай “Монголын түүх”-ийн хичээлээр үзсэнээ сэргээн санаарай.
- Теле жүжгийг унших, үзэхийн өмнө дараах үгийг толь бичиг (цаасан болон цахим) ашиглан тайлбарлаарай.  
Зэхийрэх-  
Суман-

### ЭЦСИЙН ТУШААЛ

(Теле жүжгийн хэсэгэлэл)

...Бадрах: - За тэгээд уулзалт сайхан болов уу? Их юм үзэв үү, та. Олон хүн ирэв үү?

Лувсан: - Сайхан боллоо. Манай үеийнхэн ч барагдаж байгаа юм байна даа, хөөрхий. Ихэнх нь алга. Амар мэнд яваа нь бүгд цуглах шив дээ. Манай сумангаас гэхэд арав гаруй хүн, салаанаас гэвэл тавуул шив дээ. Харин танай салаанаас долоон хүн байсан шүү. Гуравдугаар салаанаас гуравхан хүн.

Лувсан: - Тэгээд суман дарга маань ирэв үү?

Лувсан: - Үгүй үгүй, дарга маань ирсэнгүй. Тэгээд, үгүй чи чинь хэн билээ гээд л. Алив чи наад хоол цайгаа идэж уугаач...

Цэрмаа: - Та хоёр чинь чацуу биш билүү? Бие биеэ та энэ тэр гээд байх чинь.

Бадрах: - Над мэт байтугай нь тэгж хүндэлж байгаа хойно тэгж ёс алдаж яаж болох вэ?...

Цэрмаа: - Таныг ирж уулз гэж хэлээгүй юм уу?

Лувсан: - Хөгшөөн наад цайгаа халаагаач. Зэхийрчих шиг боллоо.

Бадрах: - Намайг энд байгаа гэж яаж мэдэх аж дээ.

Цэрмаа: - Дахиад хэзээ ч уулзаа билээ. Байгаа нэгийгээ мартчихдаг бас хачин юм даа.

Лувсан: - За хэн мэдэв. Мартах юм, мартаггүй юм гэж байдаг юм байлгүй.

Цэрмаа: - Мартах хүн, мартаггүй хүн гэж байдаг л байх.

Бадрах: - Хүнийг буруутгах амархаан. Харин зөвтгөх л хэцүү. Тэд намайг мартаж нь аргагүй ээ, хөөрхий. Та нар ч буруугүй. Тэгэх учиртай юм.

\* \* \*

**Бадрахын бодол:** Цэргийн окоп. Ядарч зүдэрсэн олон цэргүүд нуувчинд түр амсхийж сууна. Энд тэнд буун дуу тачигнасаар байх нь сонсогдоно. Окопанд залуу Лувсан сууж байгаад цэргүүдийн дундуур явсаар Бадрахын дэргэд ирлээ. Бадрах түр зуурхан зүүрмэглэжээ. Түүнийг сэрээнэ.

Лувсан: - Чи Цэрмаатай суух уу?

Бадрах: - Юу гэнэ ээ?

Лувсан: - Зүгээр л.

Бадрах: - Нэгэнт саналаа хэлж тохирчихсон юм чинь. Ингэхэд ер нь Цэрмаа бид хоёр л чамайг зовоогоод байна аа даа.

Лувсан: - Чи айхгүй байна уу?

Бадрах: - (Захидал гаргаж) Цэрмаагийн захиа. Би яг цээжилчихсэн. Та нар самуурайг ялна. Би мэдэж байна. Гэхдээ чи минь амьд мэнд эргэж ирээрэй дээ. Та нарыг дайтаж эхэлсэн гэснээс хойш шөнө бүр зүүдэлдэг боллоо. Би чамд ийм сайн гэдгээ сая л мэдлээ. Би чам дээр очно. Оргоод ч болсон очно. Ингэж бичсэн байгаа юм. Тэгэхээр би үхлээс айхгүй байж чадах уу? Чи бод доо.

Лувсан: - Тийм ч юм даа.

Бадрах: - Хөөш Лувсаан, харин чи Бадрах алагдчихвал Цэрмаад би яаж дуулгана даа гэж айгаад байх шиг байна, тийм үү? Аан, яг үнэнээ хэлчих.

Лувсан: - Чи ямар аймаар юм боддог юм бэ.

Бадрах: - Муухай байна уу? Зүгээр, хө. Тоглож байна. Үнэн байсан ч чамд ямар буруу байх вэ. Сайхан бүсгүйд сэтгэл алдаж мөрөөдөж, шаналж, атаархаж явахад юу нь буруу байхав. Харин морь суллаж хөөсөн чинь буруу. Чи намайг Цэрмаагийн гадаа мөн ч олон явгалсан шүү. За тэр ч яах вэ. Найз нь ганцхан юмнаас их айж байна.

Бадрах: - Юунаас?...

Лувсан: - Намайг тагнаж туршаад байдаг хүн байгаа юм. Миний сахиусыг хэн аваачиж өгсөн байж таарах вэ? Бас энэ дарь эх уншиж саваагүйдэгийг минь.

Лувсан: - Чиний дэргэд чинь л байдаг хүн байна даа.

Бадрах: - Цааш нь ингээд бодоод байхад юм гараад байх бололтой.

Лувсан: - Хөөш, чи тэгвэл өөрийгөө илчлээч

Бадрах: - Үгүй шүү. Яасан ч үгүй. Миний дутагдал бусад цэргүүдэд ч зөндөө л байдаг юм чинь. Харин Цэрмаатай бол сууж чадна. Яасан ч алдахгүй дээ... (Тэр хоёр бодол болон сууна).

\* \* \*

### Бодол үргэлжлэл

Тор татсан нуувчинд хоёр гурван байлдагч нэг дарга дурангаар харж зогсоно. Буун дуу тачигнасаар бага даргын дуудсанаар хоёр цэрэг ирж ёслов. Энэ нь Бадрах, Лувсан хоёр.

Сумангийн дарга:

- За, та хоёр дайсны хүч, зэвсэг хэрэгслийг тагнаж ир (Зураг дээр заана). Энд дайсны нэлээд хүч нэвтэрч ирсэн мэдээ байна. Галын байдлын зургийг гарга. Амьд хэл олзлох хэрэгтэй байна. Үүр цайхаас өмнө эргэж ирсэн бай. Хугацаа сунгахгүй. Бичиг баримтаа үлдээ. Гар бөмбөг, гар буу, ус авч явахыг зөвшөөрнө. Тэр хоёр бичиг баримтаа ширээн дээр гаргаж тавина. Наад талд нь морзчин суугаад мэдээ дамжуулж байна. Сумангийн дарга ширээн дээрээс тэр хоёрын бичиг баримтыг



авч үзнэ.

Сумангийн дарга: - Явж болно.

Хоёр цэрэг (зэрэг): - Гүйцэтгээ гээд гарч явна. Буун дуу тачигнасаар. Сумангийн дарга тэдний хойноос харж бодолхийлнэ.

Модтой нэлээн ширүүн урсгалтай голыг хоёр цэрэг гаталж цаанаас наашлан айсуй. Энэ бол гартаа гар буу барьсан Бадрах, буу барьсан Лувсан хоёр. Их түгшүүртэй. Тэд явсаар үүр цайхад модон дотроос дурандаж хэвтсээр.

Бадрах: - Энд салаа гаруй л цэрэг байх шив дээ.

Лувсан: - Олон байх аа.

Бадрах: - Тэр техник хэрэгсэл дээр бужигнаж байхыг харахад, бас тэр майханд байгаа гээд бод. Дурандана. Бадрах цаад талд гурван майхан зэрэгцүүлж барьсан арваад цэрэг нааш цааш сандран гүйлдэж байна. Буунууд тавьчхаж. Хайрцагтай юмс зөөгөөд хэдэн цэрэг эхний майхнаас гараад сүүлчийн майхан руу орж байна.

Бадрах (дурандан): - Яаж тоог нь авах вэ?

Лувсан: - Нэг суман гээд мэдээлчихвэл яах бол?

Бадрах (дурангаа Лувсанд өгөхдөө): -Тэр хоёр майхнаас юу зөөгөөд байна аа, хараач

Лувсан: - Алив (камерийн өмнүүр нэг япон цэрэг цаашаа хараад яваад байна. Цаана нь хоёр майхан харагдана. Майхны цаад талд их гал гарсан байна. Наана камерийн өмнүүр өнгөрөөд байгаа цэрэг, цаана нь бас л цэргүүд бужигналдсаар... Бадрах дурангаар харсаар).

Бадрах: - Аяга шив дээ. Аанхаа болох нь тэр. Би явж очоод аягыг нь тоолчихоод ирье...



#### УНШИХ ЯВЦАД

- Дүрүүд хэдэн удаа бодож, ямар, ямар үйл явдал өрнөж буйг анзаарч уншаарай.

Лувсан: - Харуулууд ийм ойрхон байхад болохгүй байх аа. Тэгэж баларснаас эртхэн очиж мэдээгээ өгье.

Бадрах: - Чи дандаа л болохгүй гээд байх юм. Айгаад байгаа юм бол явж мэдээгээ хүргэ л дээ. Би үлдлээ.

Лувсан: - Айсан ч юм алга л даа.

Бадрах: - Тэгвэл барьж л таарна. За чи наанаа бэлэн байж бай. Болохоо байвал намайг хайрлах хэрэггүй адилхан л нидэрчхээрэй.

Лувсан: - Чамайг ийм зориг зүрхтэй гэж бодсонгүй.

Бадрах: - Үхсэнийх нь зориг зүрхтэй, арга барсан хүний л ажил. За би явлаа. (Бадрах дайсны тал руу мөлхөж явна. Араас Лувсан хараад үлдэнэ. Япончууд гэрлээ унтраалаа. Бадрах харуулыг аманд нь даавуу чихээд олзлоод аваад ирлээ).

Бадрах: - Энд жаахан амьсгаа даръя. Дайсан холдох шиг боллоо.

Лувсан: - Хүүш нөгөө аяганууд нь юу болсон бэ?

Бадрах: - 93 аяга байна. Майханд 5 аяга хоол оруулсан. Гадаа 3 офицер байсан. Харуулд 10 хүн бий гэж бодоход нийлээд зуун арван нэг үү?

Лувсан: - Чи яагаад ийм амархан бодож чадав аа?

Бадрах: - Аз аз, ёстой аз гэдэг л энэ. Нэг сумаар хоёр туулай буудах нь энэ. Чи бид ч өнөөдөр хийморьтой явна аа.

Лувсан: - Араас хүрээд ирэх юм биш байгаа.

Бадрах: - Одоохондоо мэдэхгүй байгаа

Лувсан: - Бушуухан явах юм биш үү?

Бадрах: - Дотоодыг хамгаалахын төлөөлөгч одоо надад итгэх болов уу?

Лувсан: - Итгэх байлгүй дээ.

Бадрах: - Би ерөөсөө буцлаа.

Лувсан: - Хаашаа?

Бадрах: - Саяны японууд руу

Лувсан: - Яах гэж?

Бадрах: - Хоёр майханд нь нэг нэг гранатаа тэсэлчхээд ирье.

Лувсан: - Дэмий, олон хавар нэгэндээ гэгчээр тэд одоо чамайг ална шүү.

Бадрах: - Албал алж л байг. Нэг үхэхээс ямар хоёр үхэх биш. Хоёр майханд нь нэг нэг гранатаа тэсэлж орхивол үхсэн ч яахав. Тэгсэн цагт тэр муу төлөөлөгч, салаан дарга нар намайг эсэргүү урвагч биш байх гэж итгэх байх.

Лувсан: - Тэд одоо чамд итгэнэ ээ

Бадрах: - Чи яаж мэдээв.

Лувсан: - Зүгээр л. Чи бид хоёр дайсныг үймүүл гэсэн тушаал байхгүй шүү.

Бадрах: - Энэ завшааныг зүгээр орхиж болохгүй. Энүүнд нэг их тушаагаад байх ч юм алга. За би явлаа. Чи наадхаа үүр. Морьдоо олмогц шууд цаашаа яваарай.

Лувсан: - Бадрхааа, Бадрхааа, би чамгаас гуйя. Чи битгий яв л даа.

Бадрах: - Чи монгол л юм бол монгол дүртэй байгаач. Өстөн дайсанд өлөн бар шиг догшин, өөр зуураа ижил бяруу шиг номхон яв гэдэг юм. Чи бид хоёр тэгээд унтаж байгаа дайсны дэргэдээс ижил бяруу шиг номхон буцах уу? Гонжийн жоо, хөө. Би ямар ч байсан явна. Чи наадхаа үүр.

Лувсан: - Би явахгүй ээ. Чамтай хамт явна.

Бадрах: - Чи явна уу, үгүй юу? Чамд тушаах эрхтэй шүү гээд буу тулгана.

Лувсан ухаангүй айж босоод дахин бугаа авч сууна. Бадрах шууд явна. Лувсан олзны цэргийг үүрээд яарч явна. Бадрах япончууд руу ойртсоор хоёр харуул зөрөх хооронд хоёр удаа гранатаа шиднэ...

### **Лувсангийн д.**

Бадрах (хөгшин): -Та тэр сурвалжлагч хүүд суман даргынхаа тухай сайн яриад өгөхгүй дээ. Ёстой тоогүй юм болж дээ, хөө. Тэгсэн бол юмыг яаж мэдэх вэ, нэг сураг гарах ч байсан юм билүү. За байз энэ чинь орой болж байгаа юм байна. Эртхэн хөдлөхгүй бол болохгүй ээ.

Лувсан: - Хоноод яваа, хө. Юундаа яарах вэ дээ. Хоночхоод яв.

Бадрах: - Болохгүй хөө, би чинь бас ардаа алба хашиж байгаа хүн. Нөгөө өвс рүү нь зэлүүд мал орчихвол сүйд болно шүү дээ. Явалгүй болохгүй.

Цэрмаа: - За, байзаарай, би нэг (Авдраа уудална). Май даа иймхэн юмаар сэтгэлийг чинь цайлгая даа. Тэр нь маш уран шаглаатай даалин аж. Лувсан гайхан харна.

Лувсан: - Хөгшөөн, чи чинь хаанаас гаргаад ирэв ээ.

Цэрмаа: - Чамд надаас насаараа нууж болсон юм байхад надад бас байлгүй дээ гээд нулимсаа арчив...1989 он

**Эх сурвалж:** <https://www.youtube.com/>





**Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар түүх, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгоё.**

1. Түүх, нийгмийн хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Ямар түүхэн тодорхой цаг үе дүрслэгдэж байна вэ?
  - Жүжгийг эмгэнэлд хүргэж байгаа гол шалтгаан юу байв? Яагаад?
  - Хэлмэгдүүлэлтийн хор уршгийг гол дүрүүдийн бие сэтгэлийн шаналал үргэлжилсээр байгаатай холбон тайлбарлаарай.
2. Соёлын хам сэдвийг тайлбарлаарай. Жишээ нь:
  - Монголчуудын зан үйлээс юуг? Ямар зорилгоор дүрслэв?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Зохиолын сэдэв, утга санааг тайлбарлахдаа судлаачийн бичсэнийг уншиж ашиглаарай.

**СУДЛАЛ ШҮҮМЖ**

Зохиолч Д.Норов 1980-аад оны монголын уран зохиолд эхлүүлсэн шинэчлэлээ дэлгэцийн жүжигтээ үргэлжлүүлсэн юм. Сэдвийн хувьд “Эцсийн тушаал” нь хэлмэгдүүлэлтийн хар сүүдрийг Халхын голын дайнаар дэвсгэрлэж нэгэн бүсгүйд дурласан нутгийн хоёр андын эсрэг тэсрэг үйлдэл, зан араншингаар нь сөргүүлэн үзүүлсэн ч угтаа монгол хүний уужуу цайлган сэтгэл, аливаад хүндэтгэлтэй ханддаг дадгал, төр засгийн шийдвэрийг дээдлэх үзэл буюу бүхэлдээ монгол хүмүүний язгуур чанарыг шударга бус үнэлэмж бүхий цагийн төрхөөс ялгаруулан дээжилсэн юм. Орчлон ертөнц, нийгмийн зүй тогтлыг эгээрсэн дүрийн ухаажил, үзэл санаа нь бодол эргэцүүллийн солбицлоор нээгдэн буй нь теле жүжгийн төрөл зүйлийн хувьд ч, туурвил зүйн уран чадварын хувиар ч сэтгэхүйн өгүүлэмжийн оновчтой шийдэл болсон билээ.

*(Д.Цэвээндорж. “Д.Норовын туурвил зүйн эрэл, олз”)*

2. Бадрах олзны хүнээ аваад шууд буцсан бол үйл явдал хэрхэн өрнөх байсан бэ? Яагаад?
3. Бадрах, Лувсанд ямар, ямар тус хүргэсэн бэ? Яагаад?
4. Жүжигт хэдэн удаа бодол өгүүлэмж гардаг вэ? Сэтгэхүйн өгүүлэмжийг голлон ашигласан учрыг тайлбарлаарай.
5. Лувсангийн дүрийг цагаатгах ямар үндэслэлүүд байна вэ? Яагаад?
6. Гол дүрүүдээр дамжуулж зохиолч ямар асуудлыг дэвшүүлэн тавьсан бэ?
7. Энэ жүжгийн сэдвийг тодорхойлохдоо дараах сэдвүүд хэрхэн хөндөгдөв? Аль нь давамгайлж гол болсныг тайлбарлаж, дүгнээрэй
  - Халх голын дайн
  - Хэлмэгдүүлэлтийн хор уршиг
  - Хайр сэтгэл, эмгэнэлт хувь заяа
  - Ёс суртахуун, шударга үнэлэмж



### Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг үнэлье.

1. “Тамгагүй төр” жүжигт Арчуг хаан, Эгэрэг түшмэл хоёрын дүрийг жүжгийн эхнээс тайлал хүртэл бие биеийнх нь үйл ажиллагаа, үзэл санааг тодотгон салгаж болшгүй холбоотой дүрсэлсэн. Дүрүүдийг тодотгож байгаа уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг үнэлж дүгнэж бичээрэй. Зөвлөмж: Үнэлж дүгнэж бичихийн өмнө дүр тус бүрийг дараах байдлаар задлан шинжилж үзээрэй. Үүнд:

Эшлэл	Бүлэг, үзэгдэл	Уншигчдад үзүүлэх нөлөөлөл
<p>Эгэрэг: - Сүүтэй ямаа бараадсан өнчин ишиг шиг Сүр сүүдэрт таныг насаараа дагаж Айдаг олныг бодвол Арай л ойрхон оршиж Алдаанд чинь золиос болж Алдарт чинь ивээс болж Өдий хүртэл явсандаа Өөрт чинь санаснаа айлдчихлаа... Өршөө намайг...</p>	Нэгдүгээр бүлэг, нэгдүгээр үзэгдэл	
<p>Эгэрэг: Бага хатны хүүгээ заллаа гээд Бид хоёрын үрийг залах нь тэр... Цугаарыг захирсан их хааны Цус нь бид хоёрынх байх болно Амь ухаан суугаад ирэхийн цагт Аав чинь хэн бэ? гэдгийг чөмгөнд нь би хэлээд өгнө...</p>		
<p>Эгэрэг: Ёсолж нялганах зав алга хаантан минь Ёр билгийн шувуу минь өнөөдөр өндөглөлөө Олон онд тэр дэгдээхэй байсан ч Одоо тэр тас боллоо Төрийн идээг тонших цаг нь болов...</p>	Гуравдугаар бүлэг, зургаадугаар үзэгдэл	
<p>Эгэрэг: ... Удам тасарсан төрийн толгойд Ухаантай цог зальтай нь л сууна биз дээ Байдлын үнэн, он цагийн үнэн хоёр Багтаж ядан чихцэлдэж байгааг Мэдрэхгүй байгаа бол Миний таны өмнө Мэхийсэн бүхэн минь алдас болно Алив хаантан тамгаа өгчих Алган дээр тавьчаад мэхийн сөгдөхөө мартав аа</p>		

2. “Тамгагүй төр”, “Учиртай гурван толгой” жүжгийн дүрүүдээ тодотгож байгаа уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг харьцуулан үнэлж дүгнэж бичээрэй.

**Зохиолын хам сэдвийн хүрээнд сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэе.**

1. Зохиолын хам сэдвийн хүрээнд сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэхдээ дараах даалгавраас сонгоорой.

А. Жүжгийн зохиолын үйл явдал нь шургуу зөрчил тэмцэлтэй байдгийг хам сэдэв, сэдэв, утга санаатай холбон дүгнэх

Б. Гол дүр нь тодорхой нөхцөл шалтгааны улмаас харамсмаар сүйрэлтэй, эмгэнэлт байдалд аргагүй эрхээр орж байгааг хам сэдэв, сэдэв, утга санаатай холбон дүгнэх

В. “Эцсийн тушаал” жүжгийн дууны үгийг хам сэдвийн хүрээнд тайлбарлах

Хөгжим Ц.Чинзориг

Үг Д.Норов

**Хүлээсэн сэтгэлийн дуу**

Хүлгийн сайныг унасан юм сан

Хүний дээд нь явсан юм сан

Хүүгээ үнсэж амжаагүй юм сан

Хүслээ гүйцээж чадаагүй юм сан

Наран зүгээс чамайгаа ирнэ гээд

Насаа марттал хүлээж сууна

Амьдралд мөнхөрсөн амраг минь ээ хө

Ээж аавын энхрийхэн юм сан

Эгэлхэн зөөлөн зантай юм сан

Эргээд уулзахаар болзсон юм сан

Элгээ дэвтлэл учирна гэсэн сэн

Халхын голоос чамайгаа ирнэ гээд

Хатуу орчлонг зөөлөж хүлээлээ

Хайранд мөнхөрсөн амраг минь ээ хө

Туулын уснаас амссан юм сан

Усны чулуунаас авсан юм сан

Уужим саруул ухаантай юм сан

Уртын дуундаа дуртай юм сан

Ялалтын морьтой чамайгаа ирнэ гээд

Янагийн дуугаа дуулж суулаа

Амьдралд мөнхөрсөн амраг минь ээ хө

Хайранд мөнхөрсөн амраг минь ээ хө

**Мэтгэлцэхдээ дараах зөвлөмжийг ашиглаарай. Үүнд:**

- Мэтгэлцээнд багийн зохион байгуулалтыг сайн хийж, гишүүдийн үүргийг тодорхой болгох
- Мэтгэлцээний бэлтгэл үед багууд маш сайн хамтарч ажиллах
- Мэтгэлцээний явцад илтгэгчийн чадвараас их зүйл шалтгаалах тул сайтар бэлтгэх
- Мэтгэлцээний явцад багийн гишүүд илтгэлүүдийн ба солбисон асуултыг анхааралтай сонсон тэмдэглэл хөтлөх, анализ хийх
- Няцаалтад хариу бэлтгэх, өөрсдийн санааг хамгаалахаар бэлтгэх, хэрэгжүүлэх зэрэг үйлдлүүдийг хамтран гүйцэтгэнэ.
- Бусдын саналыг хүлээцтэй сонсох



# تکسر

نځرېکون وېچلما .. څو تنېچ م مکنه مزل دد سدنو نځرېک

90 . . . . . ځو تنېکېچ « څو تنېچ لېسېن م کږېلما » . . . . .

70 . . . . . « ځو تنېکېچ و ځيړن » . . . . .

90 . . . . . « څو تنېچ د مکنېچ » . . . . .

06 . . . . . ځو تنېکېچ « مزل دد مکنېچ » . . . . .

۷۷ . . . . . ځو تنېکېچ « وډ چوڅن دد لېو » . . . . .

۷۷ . . . . . مکنه چوڅو مکنېچ « مېوشم دد ل » . . . . .

0۷ . . . . . کږې مکنېچ « مېوډ » . . . . .

۷۷ . . . . . چو تنېکېچ « مکنېچون دد م چوڅو » . . . . .

۴۷ . . . . . مکنېچ « مزل کږېلما » . . . . .

لېسېکېچ وېچلما .. څو تنېچ م مکنه مزل دد مکنېچېلما ، چوڅو

0۷ . . . . . ځو تنېکېچ « مېوډ چوڅو » . . . . .

9۷ . . . . . ځو تنېکېچ « مېوډ مېوڅو » . . . . .

۷۷ . . . . . ځو تنېکېچ « وڅو مېوڅو مکنېچ لېو » . . . . .

7۵ . . . . . مکنېچ مکنېچ « مزل مکنېچ » . . . . .

۹۵۰. چہ . نیکس «اے لوگو! خوف لے لیجئے، غز» . . . . .
۹۵۱. عد . تیسے! «سکھتے ہو کہ میں نے جھٹکے» . . . . .
- تتمتہ مکمل ہے . . . . .
۹۵۲. ع . چھوٹے بچے کی بات «چھوٹے بچے کی بات» . . . . .
۹۵۳. ع . چھوٹے بچے کی بات «چھوٹے بچے کی بات» . . . . .
- تتمتہ مکمل ہے . . . . .
۹۵۴. ع . چھوٹے بچے کی بات «چھوٹے بچے کی بات» . . . . .
۹۵۵. ع . چھوٹے بچے کی بات «چھوٹے بچے کی بات» . . . . .
۹۵۶. ع . چھوٹے بچے کی بات «چھوٹے بچے کی بات» . . . . .





- Бадарч П. “Түүвэр зохиол”. УБ., 2011.
- Байгалсайхан С. “XX зууны монгол өгүүллэгийн туурвил зүй”. УБ., 2010.
- Байгалсайхан С. “XX зуун, тууж судлал”. УБ., 2014.
- Болдбаатар Ж. “Монгол түмний сод хүмүүс”. МУИС, Улаанбаатар их сургууль. Дөтгөөр боть. УБ., 2014.
- Гаадамба Ш. “Утга зохиолын онолын товч, утга зохиолын онолын үндэс”. УБ., 2014.
- Гаадамба Ш. “Санаа сэтгэлийн орчлонг сайхан болгох хөдөлмөр” Илтгэл дурсамжийн эмхэтгэл. УБ., 2009.
- Галсан Т. “Жирмийн сүлжээ”. УБ., 2001.
- Галсан Ч. “Туужууд”. УБ., 2017.
- Дагвадорж Ч. “Ээж дуудна”. УБ., 2009.
- Дашдооров С. “Бууж мордох хорвоо”, МУЗД 34-р боть (Оосор бүчгүй орчлон). УБ., 2005.
- Dictionary of Literary Characters. Edinburgh: Chambers, 2004.
- Литературный энциклопедический словарь. Москва. 1987.
- Лодойдамба Ч. “Тунгалаг Тамир” (Сонгомол эх). УБ., 2015.
- Лхагвасүрэн Б. “Тамгагүй төр”. УБ., 2011.
- Монголын орчин үеийн уран зохиолын түүх IV (ШУА, ХЗХ). УБ., 2014.
- Мөнхбаяр Б. “Монголын уран зохиолын тайлбар толь”. УБ., 2011.
- Намдаг Д. “Түүвэр зохиол 3”. УБ., 1988.
- Нацагдорж Д. “Зохиолууд”. УБ., 1960.
- Нацагдорж Д. “Зохиолын түүвэр”, УБ., 1955.
- Одсүрэн П. “Эх зохиолын төрөл зүйлийн задлал”. УБ., 2011.
- Өлзийтөгс Л. “Нүдний шилэнд үлдсэн зургууд”. УБ., 2004.
- Содном Б. “Тунгалаг Тамир романы зохиомжийн асуудал”. Зохиол судлал-I. УБ., 2009.
- Сүрэнжав Ш. “Түүвэр зохиол”. УБ., 2011.
- Түдэв Л. “Оройгүй сүм” (хоёр дахь хэвлэл). УБ., 2011.
- The Johns Hopkins Guide to Literary Theory and Criticism. Baltimore: Johns Hopkins University Press, 2005.
- “Утга зохиол шинжлэл” МУБИС, Утга зохиолын тэнхим УБ., 2005.
- “Уран зохиол, соёмбо нэвтэрхий толь”. УБ., 2012.
- Хүрэлбаатар Л. “Огторгуйн цагаан гарди”. УБ., 2002.
- Цэвээндорж Д. “Хориг шүүмжийн бичиг” (Ред. Л.Түдэв). УБ., 2011.
- Цэрэнсодном Д. “Монгол уран зохиолын товч түүх”. (XIII-XX зууны эхэн). УБ., 2002.
- Энхбаяр С. “Утга зохиолын онол”. УБ., 2011.
- Эрдэнэ С. “Наран тогоруу”. УБ., 1972.
- “XX зууны монголын уран зохиол” Улаанбаатарын их сургууль, монгол хэл уран зохиолын тэнхим. УБ., 2017.